**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД**

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2023.01.13 № 01/74

танай________________-ны № ________________-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Тайлан хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 56 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний жилийн эцсийн биелэлтийг яамд, байгууллагуудаас ирүүлсэн материалд үндэслэн нэгтгэн боловсруулж, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, танилцуулга, холбогдох тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: ... хуудастай.

Ч.ХҮРЭЛБААТАР

230042

## “МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

**Нэг. Зорилго**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, бодлого, төлөвлөлт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

**Хоёр. Арга зүй**

Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний жилийн эцсийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасны дагуу үндсэн 6 бүлэг 23 зорилтын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1-т заасан аргачлалаар, төсөл, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг мөн журмын 6.2.2-т заасан аргачлалаар тус тус үнэлсэн.

Тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн сан /www.unelgee.gov.mn/-гаар баталгаажуулан, хяналтад авч нэгтгэсэн бөгөөд 16 яам, 6 агентлаг, нийслэл тайланг хугацаандаа ирүүлсэн.

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний жилийн эцсийн биелэлтийг дараах байгууллагууд ирүүлээгүй бөгөөд үнэлгээг “үр дүнгүй” буюу 0 үнэлгээгээр тооцсон. Үүнд:
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;
- Боомтын сэргэлтийн ажлын алба;
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

**3.1. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний жилийн эцсийн биелэлт**

Монгол Улсын Их хурлын 2021 оны 56 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого, Хүний хөгжлийн бодлого, Эдийн засгийн бодлого, Засаглалын бодлого, Ногоон хөгжлийн бодлого, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого гэсэн 6 бүлэг, 23 зорилго,

300 төсөл, арга хэмжээ туссан бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 73.45 хувийн биелэлттэй үнэлэгдлээ. Энэ нь 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилттэй харьцуулахад 25.78 хувиар өссөн байна.

"Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд үр дүнтэй буюу "100.0" хувийн биелэлттэй 124 төсөл, арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу "91-99" хувийн биелэлттэй 2 төсөл, арга хэмжээ, "90.0" хувийн биелэлттэй 30 төсөл, арга хэмжээ, "71-89" хувийн биелэлттэй 11 төсөл, арга хэмжээ, "70.0" хувийн биелэлттэй 39 төсөл, арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу "51-69" хувийн биелэлттэй 4 төсөл, арга хэмжээ, "50.0" хувийн биелэлттэй 41 төсөл, арга хэмжээ, "30.0" хувийн биелэлттэй 27 төсөл, арга хэмжээ, үр дүнгүй буюу "1-29" хувийн биелэлттэй 3 төсөл, арга хэмжээ, "0" хувийн биелэлттэй 19 төсөл, арга хэмжээ байна.

**Хүснэгт 1. "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан зорилго, төсөл, арга хэмжээний биелэлтийн үнэлгээ**

| дд | Бодлого | Зорилго тоо | Төсөл, арга хэмжээ | Биелэлтийн хувь | | | | | | | | | | Дундаж үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 100 | 99-91 | 90 | 89-71 | 70 | 69-51 | 50 | 30 | 29-1 | 0 | |
| 1 | "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого | 1 | 8 | 7 | - | - | - | - | - | - | 1 | - | - | 91.3 |
| 2 | Хүний хөгжлийн бодлого | 6 | 80 | 34 | - | 10 | - | 12 | - | 10 | 6 | - | 8 | 72.8 |
| 3 | Эдийн засгийн бодлого | 7 | 115 | 40 | 2 | 7 | 10 | 15 | 3 | 20 | 13 | 3 | 2 | 72.0 |
| 4 | Засаглалын бодлого | 6 | 53 | 23 | - | 6 | 1 | 3 | - | 7 | 6 | - | 7 | 69.1 |
| 5 | Ногоон хөгжлийн бодлого | 1 | 20 | 2 | - | 5 | - | 7 | - | 4 | - | - | 2 | 67.0 |
| 6 | Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого | 2 | 24 | 18 | - | 2 | - | 2 | 1 | - | 1 | - | - | 91.9 |
| | **Нийт** | **23** | **300** | **124** | **2** | **30** | **11** | **39** | **4** | **41** | **27** | **3** | **19** | **73.4** |

Батлагдсан 300 төсөл, арга хэмжээнээс 124 төсөл, арга хэмжээ үр дүнтэй, 82 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 72 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 22 арга хэмжээ үр дүнгүй үнэлэгдлээ.




### 3.1.1. "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд:

"Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр дэвшүүлэн тавьсан бөгөөд үйл ажиллагааны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 91.3 хувьтай, "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3.2-т заасны дагуу "тодорхой үр дүнд хүрсэн" байна.

**Хүснэгт 2. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах зорилгын биелэлтийн үнэлгээ**

| дд | Зорилго | Төсөл, арга хэмжээ | Биелэлтийн хувь | | | | | | | | | | Дундаж үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 99-91 | 90 | 89-71 | 70 | 69-51 | 50 | 30 | 29-1 | 0 | |
| 1 | Зорилго 1.1.“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 8 | 7 | - | - | - | - | - | - | 1 | - | - | 91.3 |
| | **Нийт** | **8** | **7** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **-** | **91.3** |

## 3.1.2. “Хүний хөгжлийн бодлого”-ын хүрээнд:

“Хүний хөгжлийн бодлого”-ын 6 зорилгын хүрээнд 80 төсөл, арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 72.8 хувьтай, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.2-т заасны дагуу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Зорилго тус бүрээр биелэлтийг авч үзэхэд, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд 32 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 57.2 хувьтай, нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжих хүрээнд 2 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 25.0 хувьтай, хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх хүрээнд 20 төсөл, арга хэмжээний биелэлт 91.5 хувьтай, эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд 5 төсөл, арга хэмжээний биелэлт 92.0 хувьтай, нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлэх хүрээнд 14 төсөл, арга хэмжээний биелэлт 74.3 хувьтай, үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болох хүрээнд 7 төсөл, арга хэмжээний биелэлт 87.1 хувьтай байна.

**Хүснэгт 3. “Хүний хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгын биелэлтийн үнэлгээ**

| дд | Зорилго | Төсөл, арга хэмжээ | Биелэлтийн хувь | | | | | | | | | | Дундаж үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 99-91 | 90 | 89-71 | 70 | 69-51 | 50 | 30 | 29-1 | 0 | |
| 1 | Зорилго 2.1.Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | 32 | 8 | - | 4 | - | 5 | - | 4 | 4 | - | 7 | 57.2 |
| 2 | Зорилго 2.2.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ. | 2 | - | - | - | - | - | - | 1 | - | - | 1 | 25.0 |
| 3 | Зорилго 2.3.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ. | 20 | 15 | - | 1 | - | 2 | - | 2 | - | - | - | 91.5 |
| 4 | Зорилго 2.4.Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна. | 5 | 3 | - | 1 | - | 1 | - | - | - | - | - | 92.0 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Зорилго 2.5.Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ. | 14 | 4 | - | 2 | - | 4 | - | 3 | 1 | - | - | 74.3 |
| 6 | Зорилго 2.6.Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно. | 7 | 4 | - | 2 | - | - | - | - | 1 | - | - | 87.1 |
| | Нийт | 80 | 34 | - | 10 | - | 12 | - | 10 | 6 | - | 8 | 72.8 |

### 3.1.3. "Эдийн засгийн бодлого"-ын хүрээнд:

"Эдийн засгийн бодлого"-ын 7 зорилгын хүрээнд 115 төсөл, арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 72.0 хувьтай, "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3.2-т заасны дагуу "тодорхой үр дүнд хүрсэн" байна.

Зорилго тус бүрээр биелэлтийг авч үзэхэд, санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах хүрээнд 9 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 74.4 хувьтай, ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх хүрээнд 21 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 70.0 хувьтай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд 20 төсөл, арга хэмжээний биелэлт 75.0 хувьтай, байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд 9 төсөл, арга хэмжээний биелэлт 59.4 хувьтай, эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангах хүрээнд 15 төсөл, арга хэмжээний биелэлт 61.5 хувьтай, эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах хүрээнд 35 төсөл, арга хэмжээний биелэлт 76.9 хувьтай, газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд 6 төсөл, арга хэмжээний биелэлт 81.7 хувьтай байна.

**Хүснэгт 4. "Эдийн засгийн бодлого"-ыг хэрэгжүүлэх зорилгын биелэлтийн үнэлгээ**

| дд | Зорилго | Төсөл, арга хэмжээ | Биелэлтийн хувь | | | | | | | | | | Дундаж үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 99-91 | 90 | 89-71 | 70 | 69-51 | 50 | 30 | 29-1 | 0 | |
| 1 | Зорилго 3.1.Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ. | 9 | 5 | - | 1 | - | - | - | 1 | 1 | - | 1 | 74.4 |
| 2 | Зорилго 3.2.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ. | 21 | 9 | - | 1 | - | 3 | - | 3 | 4 | - | 1 | 70.0 |
| 3 | Зорилго 3.3.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг | 20 | 6 | - | 3 | - | 4 | | 7 | - | - | - | 75.0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ. | | | | | | | | | | | |
| 4 | Зорилго 3.4.Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | 9 | - | - | - | 1 | 4 | - | 3 | 1 | - | - | 59.4 |
| 5 | Зорилго 3.5.Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана. | 15 | 3 | 2 | - | - | 2 | 2 | 1 | 2 | 3 | - | 61.5 |
| 6 | Зорилго 3.6.Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна. | 35 | 14 | - | 1 | 9 | 2 | 1 | 3 | 5 | - | - | 76.9 |
| 7 | Зорилго 3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. | 6 | 3 | - | 1 | - | - | - | 2 | - | - | - | 81.7 |
| | НИЙТ | 115 | 40 | 2 | 7 | 10 | 15 | 3 | 20 | 13 | 3 | 2 | 72.0 |

### 3.1.4 "Засаглалын бодлого"-ын хүрээнд:

"Засаглалын бодлого"-ын 6 зорилгын хүрээнд 53 төсөл, арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 69.1 хувьтай, "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3.3-т заасны дагуу "эрчимжүүлэх шаардлагатай" байна.

Зорилго тус бүрээр биелэлтийг авч үзэхэд, цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх хүрээнд 19 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 72.6 хувьтай, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах хүрээнд 4 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 45.0 хувьтай, иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангах хүрээнд 21 төсөл, арга хэмжээний биелэлт 63.3 хувьтай, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийх хүрээнд 1 төсөл, арга хэмжээний биелэлт 100.0 хувьтай, Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх хүрээнд 3 төсөл, арга хэмжээний биелэлт 83.3 хувьтай, Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх хүрээнд 5 төсөл, арга хэмжээний биелэлт 84.0 хувьтай байна.

**Хүснэгт 5. "Засаглалын бодлого"-ыг хэрэгжүүлэх зорилгын биелэлтийн үнэлгээ**

| дд | Зорилго | Төсөл, арга хэмжээ | Биелэлтийн хувь | | | | | | | | | | Дундаж үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 99-91 | 90 | 89-71 | 70 | 69-51 | 50 | 30 | 29-1 | 0 | |
| 1 | Зорилго 4.1.Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ. | 19 | 9 | - | 1 | 1 | 1 | - | 3 | 3 | - | 1 | 72.6 |
| 2 | Зорилго 4.2.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.. | 4 | - | - | 2 | - | - | - | - | - | - | 2 | 45.0 |
| 3 | Зорилго 4.3.Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана. | 21 | 8 | - | 3 | - | 1 | - | 2 | 3 | - | 4 | 63.3 |
| 4 | Зорилго 4.4.Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ. | 1 | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | 100.0 |

| дд | Зорилго | Төсөл, арга хэмжээ | 100 | 99-91 | 90 | 89-71 | 70 | 69-51 | 50 | 30 | 29-1 | 0 | Дундаж үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Зорилго 4.5.Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаага тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ. | 3 | 2 | - | - | - | - | - | 1 | - | - | - | 83.3 |
| 6 | Зорилго 4.6.Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ. | 5 | 3 | - | - | - | 1 | - | 1 | - | - | - | 84.0 |
| | **НИЙТ** | **53** | **23** | **-** | **6** | **1** | **3** | **-** | **7** | **6** | **-** | **7** | **69.1** |

### 3.1.5 "Ногоон хөгжлийн бодлого"-ын хүрээнд:

"Ногоон хөгжлийн бодлого"-ын хүрээнд 20 төсөл, арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 67.0 хувьтай, "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3.3-т заасны дагуу "эрчимжүүлэх шаардлагатай" байна.

**Хүснэгт 6. "Ногоон хөгжлийн бодлого"-ыг хэрэгжүүлэх зорилгын биелэлтийн үнэлгээ**

| дд | Зорилго | Төсөл, арга хэмжээ | Биелэлтийн хувь | | | | | | | | | | Дундаж үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 99-91 | 90 | 89-71 | 70 | 69-51 | 50 | 30 | 29-1 | 0 | |
| 1 | Зорилго 5.1.Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | 20 | 2 | - | 5 | - | 7 | - | 4 | - | - | 2 | 67.0 |
| | **НИЙТ** | **20** | **2** | **-** | **5** | **-** | **7** | **-** | **4** | **-** | **-** | **2** | **67.0** |

### 3.1.6 "Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого"-ын хүрээнд:

"Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого"-ын 2 зорилгын хүрээнд 24 төсөл, арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 91.9 хувьтай, "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3.2-т заасны дагуу "тодорхой үр дүнд хүрсэн" байна.

Зорилго тус бүрээр биелэлтийг авч үзэхэд, Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлэх хүрээнд 13 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 89.7 хувьтай, Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх хүрээнд 11 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 94.5 хувьтай байна.

**Хүснэгт 7. "Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого"-ыг хэрэгжүүлэх зорилгын биелэлтийн үнэлгээ**

| дд | Зорилго | Төсөл, арга хэмжээ | Биелэлтийн хувь | | | | | | | | | | Дундаж үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 99-91 | 90 | 89-71 | 70 | 69-51 | 50 | 30 | 29-1 | 0 | |
| 1 | Зорилго 6.1.Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ. | 13 | 9 | - | 2 | - | - | 1 | - | 1 | - | - | 89.7 |
| 2 | Зорилго 6.2.Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ. | 11 | 9 | - | - | - | 2 | - | - | - | - | - | 94.5 |
| | **НИЙТ** | **24** | **18** | **-** | **2** | **-** | **2** | **1** | **-** | **1** | **-** | **-** | **91.9** |

"Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний тайланг үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас авсан бөгөөд биелэлтийг байгууллага бүрээр гаргахад,

Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын биелэлтийн үнэлгээ бусад байгууллагаас өндөр гарсан бол ЗГХЭГ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Боомтын сэргэлтийн ажлын алба, Биеийн тамир, спортын улсын хорооны биелэлт "үр дүнгүй" үнэлэгдлээ.

**Хүснэгт 8. Үнэлгээ яамд, байгууллагаар**

| дд | Байгууллага | Төсөл, арга хэмжээ | Үнэлгээ | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 100 > >90 | 90 | 90> >70 | 70 | 70> >50 | 50 | 50> >30 | 30 | 30> >0 | 0 | Дундаж хувь |
| 1 | ЗГХЭГ | 5 | Тайлан ирээгүй | | | | | | | | | | 5 | 0 |
| 2 | ЭЗХЯ | 3 | 2 | | | | | | | | 1 | | | 76.67 |
| 3 | ЦХХХЯ | 13 | 6 | | | 1 | 1 | | 2 | | 3 | | | 72.31 |
| 4 | БОАЖЯ | 27 | 3 | | 4 | | 10 | | 7 | | 2 | | 1 | 65.56 |
| 5 | ГХЯ | 3 | 2 | | | | | | 1 | | | | | 83.33 |
| 6 | СаЯ | 5 | 4 | | 1 | | | | | | | | | 98.00 |
| 7 | ХЗДХЯ | 18 | 10 | | 3 | | 1 | | 3 | | 1 | | | 84.44 |
| 8 | ХХААХҮЯ | 19 | 5 | | 3 | | 4 | | 7 | | | | | 73.68 |
| 9 | БХЯ | 5 | 3 | | | | 1 | | 1 | | | | | 84.00 |
| 10 | БХБЯ | 21 | 16 | | 3 | | | | 2 | | | | | 93.81 |
| 11 | БШУЯ | 27 | 20 | | 2 | | 3 | | 2 | | | | | 92.22 |
| 12 | ЗТХЯ | 38 | 15 | | 1 | 9 | 3 | 1 | 3 | | 6 | | | 76.05 |
| 13 | УУХҮЯ | 21 | 9 | | 2 | | 2 | | 3 | | 4 | | 1 | 70.95 |
| 14 | ХНХЯ | 13 | 3 | | 2 | | 4 | | 3 | | 1 | | | 72.31 |
| 15 | ЭХЯ | 20 | 6 | 2 | | | 4 | 2 | 1 | | 2 | 3 | | 68.13 |
| 16 | ЭМЯ | 37 | 12 | | 4 | | 5 | | 4 | | 5 | | 7 | 61.08 |
| 17 | СоЯ | 7 | 4 | | 2 | | | | | | 1 | | | 87.14 |
| 18 | ОБЕГ | 1 | | | | | | | | | 1 | | | 30.00 |
| 19 | ШӨХТГ | 2 | 1 | | | | | | 1 | | | | | 75.00 |
| 20 | МХЕГ | 2 | Тайлан ирээгүй | | | | | | | | | | 2 | 0.00 |
| 21 | СХЗГ | 2 | 1 | | | | 1 | | | | | | | 85.00 |
| 22 | БТСУХ | 2 | | | | | | | 1 | | | | 1 | 25.00 |
| 23 | ТӨБЗГ | 2 | 1 | | 1 | | | | | | | | | 95.00 |
| 24 | НЗДТГ | 4 | 2 | | | 1 | | 1 | | | | | | 82.82 |
| 25 | БСААлба | 2 | Тайлан ирээгүй | | | | | | | | | | 2 | 0.00 |
| 26 | ЖҮХ | 2 | | | 2 | | | | | | | | | 90.00 |
| Нийт дүн | | 300 | 124 | 2 | 30 | 11 | 39 | 4 | 41 | 0 | 27 | 3 | 19 | |
| | | | Үр дүнтэй | Тодорхой үр дүнд хүрсэн | | | | Эрчимжүүлэх шаардлагатай | | | | Үр дүнгүй | | |

Хяналт-шинжилгээ, үнэлгээний /unelgee.gov.mn/ цахим мэдээллийн санд нийт 26 яамд, байгууллагууд тайлангаа байршуулсан бөгөөд 300 төсөл, арга хэмжээний 41.4 хувь нь үр дүнд хүрсэн, 27.3 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 24.0 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 7.3 хувь нь үр дүнгүй байна.

### 3.2. Санхүүжилтийн гүйцэтгэл

"Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-нд 300 төсөл, арга хэмжээг 11,714.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 4,141.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийсэн нь нийт төлөвлөсөн дүнгийн 35.4 хувийг эзэлж байна.

"Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-нд:

- Улсын төсвийн хөрөнгөөр 173 төсөл, арга хэмжээнд 2,155.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 87 төсөл, арга хэмжээнд 1,172.2 тэрбум төгрөг;

- Гадаадын зээл, тусламжаар 66 төсөл, арга хэмжээнд 2,725.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 43 арга хэмжээ (4 арга хэмжээ улсын төсвөөс, 1 арга хэмжээ тусгай сангаас давхар санхүүжсэн)-нд 1,796.5 тэрбум төгрөг;

- Концесс, төр-хувийн хэвшлийн түншлэлээр 21 төсөл, арга хэмжээнд 2,946.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1 төсөл, арга хэмжээнд 40.0 тэрбум төгрөг;

- Төр-хувийн хэвшлийн түншлэлээр 13 төсөл, арга хэмжээнд 3,761.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8 төсөл, арга хэмжээ (2 арга хэмжээ улсын төсвөөс, 1 арга хэмжээ гадаад зээл тусламжаас давхар санхүүжсэн)-нд 1,034.2 тэрбум төгрөг;

- Орон нутгийн төсвөөр 6 төсөл, арга хэмжээнд 126.3 тэрбум төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 2 төсөл, арга хэмжээ хэмжээ (1 арга хэмжээ улсын төсвөөс,1 арга хэмжээ гадаад зээл тусламжаас давхар санхүүжсэн)-нд 29.2 тэрбум төгрөг;

- Санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй 38 төсөл, арга хэмжээ байгаагаас жилийн эцсийн байдлаар 8 төсөл, арга хэмжээнд 126.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**Хүснэгт 9. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр**

| Санхүүжилтийн эх үүсвэр | Санхүүжилтийн тоо | Төлөвлөсөн /сая төгрөг/ | Санхүүжсэн тоо | Гүйцэтгэл /сая төгрөг/ |
|---|---|---|---|---|
| Улсын төсөв | 173 | 2,155,095.2 | 87 | 1,172,286.3 |
| Гадаадын зээл, тусламж | 66 | 2,725,264.6 | 43 | 1,796,523.8 |
| Концесс, ТХХТ | 21 | 2,946,099.1 | 1 | 40,000.0 |
| Төр-хувийн хэвшлийн түншлэл | 13 | 3,761,252.2 | 8 | 1,034,202.9 |
| Орон нутгийн төсөв | 6 | 126,290.0 | 2 | 29,199.9 |
| Тусгай сан | - | - | 4 | 69,063.3 |
| **Нийт** | **279** | **11,714,001.1** | **145** | **4,141,276.3** |

Төлөвлөгөөнд тусгагдсан 300 арга хэмжээнээс санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай 262 арга хэмжээний санхүүжилтэд давхардсан тоогоор 279 санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай байснаас 145 эх үүсвэрээс санхүүжсэн байна. Нийт санхүүжилтийн 43.4 хувь буюу 43 төсөл, арга хэмжээг гадаадын зээл, тусламжаар, 28.3 хувь буюу буюу 87 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр, 25.0 хувь буюу 8 төсөл, арга хэмжээг төр-хувийн хэвшлийн түншлэлээр, 1.7 хувь буюу 4 төсөл, арга хэмжээг Засгийн газрын тусгай сангийн эх үүсвэрээр, 1.0 хувь буюу 1 төсөл, арга хэмжээг концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн эх үүсвэрээр, 0.7 хувь буюу 2 төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвөөр санхүүжүүлсэн байна.

Эх үүсвэр тусгагдаагүй 38 төсөл, арга хэмжээнээс 8 төсөл, арга хэмжээг 126.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлснээс 66.3 хувь буюу 83.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөр, 32.9 хувь буюу 41.6 тэрбум төгрөгийг гадаадын зээл, тусламжаар, 0.8 хувь буюу 1.0 тэрбум төгрөгийг төр-хувийн хэвшлийн түншлэлээр санхүүжүүлжээ.

**Хүснэгт 10. Санхүүжилтийн гүйцэтгэл** */Хэрэгжүүлэгч байгууллагаар/*

| дд | Үндсэн хэрэгжүүлэгч | Арга хэмжээ | Төлөвлөсөн дүн | Гүйцэтгэл дүн | Төлөв/Гүйц |
|---|---|---|---|---|---|
| 1 | ЗГХЭГ | 5 | 4,500.0 | - | - |
| 2 | ЭЗХЯ | 3 | 380.0 | - | - |
| 3 | ГХЯ | 3 | 725.0 | 44.20 | 6.10 |
| 4 | СЯ | 5 | 296,020.0 | 296,000.00 | 99.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | ХЗДХЯ | 18 | 115,063.0 | 10,099.40 | 8.8 |
| 6 | БОАЖЯ | 27 | 319,493.7 | 91,397.80 | 28.6 |
| 7 | БХЯ | 5 | 22,830.0 | - | - |
| 8 | БХБЯ | 20 | 577,159.9 | 289,258.4 | 50.1 |
| 9 | БШУЯ | 27 | 559,591.8 | 219,624.6 | 39.2 |
| 10 | ЗТХЯ | 37 | 3,260,359.8 | 249,481.2 | 7.7 |
| 11 | СоЯ | 7 | 15,662.0 | 25,827.1 | 164.9 |
| 12 | УУХҮЯ | 21 | 2,535,477.7 | 1,652,841.6 | 65.2 |
| 13 | ХНХЯ | 13 | 44,380.0 | 69,645.7 | 156.9 |
| 14 | ХХААХҮЯ | 19 | 154,268.6 | 86,675.1 | 56.2 |
| 15 | ЦХХХЯ | 13 | 25,840.0 | - | - |
| 16 | ЭХЯ | 20 | 2,059,140.2 | 320,135.1 | 15.5 |
| 17 | ЭМЯ | 37 | 207,513.5 | 548,251.7 | 264.2 |
| 18 | ОБЕГ | 1 | 94,050.0 | - | - |
| 19 | ШӨХТГ | 2 | 16.0 | - | - |
| 20 | МХЕГ | 2 | 850.0 | - | - |
| 21 | СХЗГ | 2 | 800.0 | - | - |
| 22 | БТСУХ | 2 | 28,400.0 | - | - |
| 23 | ТӨБЗГ | 2 | 71.0 | 300.3 | 422.96 |
| 24 | НЗДТГ | 5 | 1,216,815.9 | 281,694.0 | 23.15 |
| 25 | БСАА | 2 | 174,533.0 | - | - |
| 26 | ЖҮХ | 2 | 60.0 | - | - |
| **Нийт** | | **300** | **11,714,001.1** | **4,141,276.25** | **35.4** |

## Дөрөв. Дүгнэлт

"Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-нд 6 бүлэг, 23 зорилго бүхий нийт 300 төсөл, арга хэмжээ туссанаас 2022 оны жилийн эцсийн байдлаар дунджаар **73.45** хувийн биелэлттэй үнэлэгдсэн бөгөөд "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3 заалтын ангилалд шилжүүлэн тооцвол, нийт батлагдсан төсөл, арга хэмжээний 41.3 хувь буюу 124 төсөл, арга хэмжээ үр дүнтэй, 27.3 хувь буюу 82 төсөл, арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 24.0 хувь буюу 72 төсөл, арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 7.3 хувь буюу 22 төсөл, арга хэмжээ үр дүнгүй үнэлэгдлээ.

"Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-нд 300 төсөл, арга хэмжээг 11.7 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 4.1 их наяд төгрөгийг зарцуулсан нь нийт төсөвлөсөн дүнгийн 35.4 хувийг эзэлж байна.

Төлөвлөгөөний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийн биелэлтээр салбарын яамдын үнэлгээг гаргахад Сангийн яам 98.0 хувийн биелэлттэй, Барилга, хот байгуулалтын яам 93.8 хувийн биелэлттэй, Боловсрол, шинжлэх ухааны яам 92.2 хувийн биелэлттэй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 95.0 хувийн биелэлттэй, Жендерийн үндэсний хороо 90.0 хувийн биелэлттэй, зорилт нь шалгуур үзүүлэлт, түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүнд хүрсэн байна.

Харин ЗГХЭГ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Боомтын сэргэлтийн ажлын алба тайлан ирүүлээгүй тул 0 хувиар үнэлсэн бөгөөд Биеийн тамир, спортын улсын хорооны хэрэгжүүлэх хэрэгжүүлэх 2 төсөл, арга хэмжээ үр дүнгүй үнэлэгдсэн.

**График 2. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний биелэлт, яамд, байгууллагуудаар**




“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө” нь суурь болон зорилтот түвшин бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлттэй батлагдсан бөгөөд тайлан ирүүлсэн байгууллагуудаас Эрчим хүчний яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа, холбооны яам болон НЗДТГ-аас зарим төсөл, арга, хэмжээний биелэлтийг журмын 6.2.1-т заасан аргачлалаар үнэлсэн бөгөөд бусад байгууллагууд журмын 6.2.2-т заасан аргачлалыг ашигласан байна.

## Тав. Санал

Төлөвлөгөөний санхүүжилтийн гүйцэтгэл болон шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

- Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn мэдээллийн цахим санд тайланг оруулахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхой тусгаж, нотлох баримтыг хавсарган, иж бүрэн тайлагнах, мөн хагас жилийн болон жилийн эцсийн тайланд санхүүжилтийн гүйцэтгэлийг оруулахдаа дүнг сайтар нягталж, жилийн эцсийн байдлаарх өссөн дүнг хагас жилийн гүйцэтгэлтэй сайтар тулгаж, зарцуулалтыг бүрэн гүйцэд тайлагнаж байх;

- Тайлангийн үг, үсэг, утга найруулгын алдаанаас гадна санхүүжилтийн гүйцэтгэлийн тооцооллыг сайтар нягталж, хянах (“сая төгрөг” гэж тооцсон тохиолдолд санхүүжилтийн дүнг саяар илэрхийлж, нэгжийг алдаагүй оруулах, цифр, оронгийн алдаа гаргахгүй байх);

- Төлөвлөгөөнд үндсэн хэрэгжүүлэгчээр батлагдсан бол хамтран хэрэгжүүлэгч байгууллага тус бүрээс биелэлтийн тайлан болон санхүүгийн гүйцэтгэлийг авч нэгтгэх, мэргэжлийн болон гадаад товчилсон үг хэллэгийг тайлбартайгаар ирүүлэхэд анхаарах;

- Төслийн явц, үйл ажиллагаатай холбоотой хяналт-шалгалт, мониторинг хийсэн бол хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд мониторингийн тайланг хавсаргаж ирүүлэх.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

--- 000 ---

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023.01.13 Улаанбаатар хот

“Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон түүний хэрэгжилтийн тайлан, танилцуулга болон “Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тайлан, танилцуулга, “Монгол Улсыг 2022 онд хөгжүүлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн тайлангийн хэрэгжилтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, танилцуулгын хамт 2023 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр 14.00 цагт яамны удирдлага болон газрын дарга нарт 3 давхрын хурлын өрөөнд ТЗУГ-ын дарга Б.Дашпүрэв танилцууллаа.

Тайлангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулгад Эдийн засаг, хөгжлийн сайд Ч. Хүрэлбаатар, дэд сайд Г.Түвдэндорж, Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ТЗУГ-ын дарга Б.Дашпүрэв, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Балчинлувсан, Макро, эдийн засгийн бодлогын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Эрдэнэбулган, Хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Анар, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Хөгжлийн санхүүжилтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч И.Батхүү, Хөгжлийн судалгааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Эрдэнэбаяр, ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн дарга О.Одончимэг нар оролцов.

***Хэлэлцүүлэх нь***: *“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон түүний хэрэгжилтийн тайлан, Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тайлан, “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний биелэлтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулга:*

***Хэлэлцүүлсэн нь: 1. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон түүний хэрэгжилтийн тайланд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн талаар:***

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” ийн баримт бичигт үндэсний нэгдмэл үнэт зүйл, хүний хөгжил, амьдралын чанар ба дундаж давхарга, эдийн засаг, засаглал, ногоон хөгжил, амар тайван аюулгүй нийгэм, бүс орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн үндсэн 9 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 9 зорилго 47 зорилтын хүрээнд 243 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2022 оны явцын дундаж үнэлгээ 84.86 хувийн хэрэгжилттэй гарсан. Үүнд:

- Үндэсний нэгдмэл үнэт зүйл 16 арга хэмжээг 85.0 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн;
- Хүний хөгжил 49 арга хэмжээ 90.2 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн;
- Амьдралын чанар ба дундаж давхарга 27 арга хэмжээ 92.2 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн;
- Эдийн засаг 35 арга хэмжээ 80.0 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн;
- Засаглал 25 арга хэмжээ 61.2 хувьтай буюу эрчимжүүлэх шаардлагатай;
- Ногоон хөгжил 18 арга хэмжээ 81.7 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн;
- Амар тайван аюулгүй нийгэм 23 арга хэмжээ 91.3 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн;
- Бүс, орон нутгийн хөгжил 29 арга хэмжээ буюу 88.3 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн;
- Улаанбаатар ба дагуул хот 21 арга хэмжээ 90.0 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн байна.

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 95 шалгуур

үзүүлэлт, хүрэх түвшнийг 2025 оноор тодорхойлж, шалгуур үзүүлэлтийн мэдээллийг 2025 онд гаргахаар баталсан.

"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу журмын 3в хавсралтаар нэгтгэн гаргасан бөгөөд 35 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний мэдээлэл 2023 оны 2 дугаар улирал болон түүнээс хойш гарахаар байна.

"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 76 арга хэмжээ (санхүүжилт давхардсан тоогоор 80)-нд хамаарах зарим үйл ажиллагааны санхүүжилт хийгдсэн бөгөөд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн хувьд улсын төсвөөс 3,969.1 тэрбум төгрөгөөр 53 арга хэмжээ, гадаадын зээл, тусламжаас 673.7 тэрбум төгрөгөөр 18 арга хэмжээ (4 арга хэмжээ улсын төсвөөс давхар санхүүжсэн), концесс, төр-хувийн хэвшлийн түншлэлээр 28.0 тэрбум төгрөгөөр 3 арга хэмжээ, Засгийн газрын тусгай сангаас 122.9 тэрбум төгрөгөөр 6 арга хэмжээ санхүүжигдсэн байна.

Баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд нийт 4 их наяд 793 тэрбум 639 сая 5 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Үүнээс Эдийн засаг зорилгын санхүүжилтэд 1,582.8 тэрбум төгрөг, Амьдралын чанар ба дундаж давхарга зорилгын санхүүжилтэд 2,632.4 тэрбум төгрөгийг зарцуулсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Үндэсний нэгдмэл үнэт зүйл зорилгод 200.0 сая төгрөг, Хүний хөгжил зорилгод 95.3 тэрбум төгрөг, Засаглал зорилгод 700.0 сая төгрөг, Ногоон хөгжил зорилгод 34.8 тэрбум төгрөг, Амар тайван аюулгүй нийгэм зорилгод 122.9 тэрбум төгрөг, Бүс, орон нутгийн хөгжил зорилгод 243.2 тэрбум төгрөг, Улаанбаатар ба дагуул хот зорилгод 81.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулагдсан байна.

### *1.1. "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн тайланд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн талаар:*

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 150 төсөл, арга хэмжээнд 2022 онд нийт төсөвт өртгийн 27.5 хувь буюу 13.6 их наяд төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 87 төсөл, арга хэмжээнд төлөвлөсөн дүнгийн 44.0 хувь буюу ойролцоогоор 6.0 их наяд төгрөгийн санхүүжилт хийсэн. Өмнөх онтой харьцуулахад санхүүжилтийн дүн 1.5 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд хийсэн санхүүжилтийн 6.5 хувийг улсын төсвийн хөрөнгөөр, 11.4 хувийг гадаадын зээл тусламжаар, 22.4 хувийг улсын төсөв болон гадаадын зээл тусламж, хөгжлийн банк хосолсон эх үүсвэрээр, 4.9 хувийг концессоор, 54.8 хувийг шууд хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн санхүүжилтээр шийдвэрлэсэн.

- Батлагдсан нийт 150 төсөл, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 45.7 хувийн биелэлттэй гарсан. Үүнээс амжилттай хэрэгжиж дууссан 25 төсөл байгаа бол хангалтгүй буюу 0-29 хувийн хэрэгжилттэй 57 төсөл байна. Мөн 2021-2022 онд хэрэгжиж дуусахаар батлагдсан ч санхүүжилт дутуу, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 40 төсөл, арга хэмжээ хугацаа алдан үргэлжилж байгааг эрчимжүүлэн дуусгах шаардлагатай байна.
- Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай 18,609.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 88 төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, 2021-2022 онд нийт 29 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн боловч 2021 онд 628.9 тэрбум, 2022 онд 679.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн нь нийлээд төсөвт өртгийн 7.0 орчим хувьтай тэнцэж байна.
- Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, арга хэмжээнээс 2021, 2022 онд нийт 49 төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулжээ. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажил нь тодорхой хэмжээгээр эхэлсэн 26 төсөл, арга хэмжээ байна. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2021 онд ойролцоогоор 41.4 хувьтай байсан бол 2022 онд 60.6 хувьтай болж нэмэгдсэн. Хэрэгжиж эхлээгүй 23 төсөл, арга хэмжээ үлдсэн байгааг анхаарах хэрэгтэй.

***2. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний биелэлтийн тайланд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн талаар:***

Монгол Улсын Их хурлын 2021 оны 56 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого, Хүний хөгжлийн бодлого, Эдийн засгийн бодлого, Засаглалын бодлого, Ногоон хөгжлийн бодлого, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого гэсэн 6 бүлэг, 23 зорилго, 300 төсөл, арга хэмжээ тусгасан бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 73.45 хувийн биелэлттэй буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна. Энэ нь 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилттэй харьцуулахад 25.78 хувиар өссөн байна.

Батлагдсан 300 төсөл, арга хэмжээнээс 124 төсөл, арга хэмжээ үр дүнтэй, 82 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 72 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 22 арга хэмжээ үр дүнгүй үнэлэгдсэн.

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд 300 төсөл, арга хэмжээг 11,714.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 4,141.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийсэн нь нийт төлөвлөсөн дүнгийн 35.4 хувийг эзэлж байна.

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд:

- Улсын төсвийн хөрөнгөөр 173 төсөл, арга хэмжээнд 2,155.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 87 төсөл, арга хэмжээнд 1,172.2 тэрбум төгрөг;
- Гадаадын зээл, тусламжаар 66 төсөл, арга хэмжээнд 2,725.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 43 арга хэмжээ (4 арга хэмжээ улсын төсвөөс, 1 арга хэмжээ тусгай сангаас давхар санхүүжсэн.)-нд 1,796.5 тэрбум төгрөг;
- Концесс, төр-хувийн хэвшлийн түншлэлээр 21 төсөл, арга хэмжээнд 2,946.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1 төсөл, арга хэмжээнд 40.0 тэрбум төгрөг;
- Төр-хувийн хэвшлийн түншлэлээр 13 төсөл, арга хэмжээнд 3,761.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8 төсөл, арга хэмжээ (2 арга хэмжээ улсын төсвөөс, 1 арга хэмжээ гадаад зээл тусламжаас давхар санхүүжсэн.)-нд 1,034.2 тэрбум төгрөг;
- Орон нутгийн төсвөөр 6 төсөл, арга хэмжээнд 126.3 тэрбум төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 2 төсөл, арга хэмжээ (1 арга хэмжээ улсын төсвөөс,1 арга хэмжээ гадаадын зээл, тусламжаас давхар санхүүжсэн.)-нд 29.2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн байна. Санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй 38 төсөл, арга хэмжээ байгаагаас жилийн эцсийн байдлаар 8 төсөл, арга хэмжээнд 126.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

***Шийдвэрлэсэн нь:***

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилт болон “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн тайлан, “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний биелэлтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлантай танилцаад, тайлан, танилцуулгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:

САЙД Ч.ХҮРЭЛБААТАР

ДЭД САЙД Г.ТҮВДЭНДОРЖ

ХЯНАСАН:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ДАШПҮРЭВ

ХӨГЖЛИЙН НЭГДСЭН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — Л.БАЛЧИНЛУВСАН

МАКРО, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — Л.ЭНХ-АМГАЛАН

БҮС НУТАГ, АЖ ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА — Д.ЭРДЭНЭБАЯР

ХИЛИЙН БООМТЫН ХӨГЖИЛ, ЧӨЛӨӨТ БҮСИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — Х.ЭРДЭНЭБУЛГАН

ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА, ХӨГЖЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — И.БАТХҮҮ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА — Б.АНАР

ХӨГЖЛИЙН СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — Л.ЭРДЭНЭБАЯР

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — О.ОДОНЧИМЭГ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН — М.СУВДАНЧИМЭГ

Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн 01/74 тоот албан бичгийн хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

| дд | Зорилго | Төсөл, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Санхүүжилт | | | | Хэрэгжилт | ЭЗХЯ Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төсөвлөсөн | | Гүйцэтгэл | | | |
| | | | | | Эх үүсвэр | Дүн /сая.төг/ | Эх үүсвэр | Дүн /сая.төг/ | | |
| **1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого** | | | | | | | | | | |
| 1 | Зорилго 1.1.“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1.1.1. Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлох, вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын байдлыг үнэлж, дархлаа тогтох хугацааг тодорхойлох | Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлсон байна. Вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын байдлыг үнэлж, дархлаа тогтох хугацааг тодорхойлох | Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлсон байна. Вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын байдлыг үнэлж, дархлаа тогтох хугацааг тодорхойлсон байна. | Гадаадын зээл, тусламж | 600.0 | - | - | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/620 дугаар тушаалаар Коронавируст халдвар (COVID-19)-ын судалгаар зохион байгуулах удирдах ажлын хэсэг, судалгааны тэргүүлэх 10 чиглэлийг батлуулж, судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2022 оны 11 дүгээр сард судалгааны ажлын үр дүнг хүлээн авч, хэвлүүлсэн. Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлсон. Үүнд: 1. Монгол Улсад КОВИД-19 цар тахал үүсгэсэн SARS-CoV-2 вирусийн геномын шинжийг судалсан судалгааны дүгнэлтэд манай улсад SARS-CoV-2 вирусийн Альфа, Дельта, Омикрон гэх 3 хувилбар, 25 PANGO линиайж тодорхойлогдсон. Цар тахлын эхний давалгаа үүсэн нь B.1.1, B.1.1.46 PANGO линиайжаар үүсгэгдсэн бол гурван давалгаа Альфа, Дельта, Омикрон хувилбаруудаар нөхцөлджээ. Манайд илэрсэн омгууд лавлагаа hCoV-19/Wuhan/Hu-1/2019 омгоос 4-48 аминхүчлээр ялгаатай байсан бөгөөд удмын нэг төрлийн дэд клэйдэд хамааралтай омгууд ORF1a болон S уургийн аминхүчлийн өвөрмөц өөрчлөлтүүдээс шалтгаалан шинэ бүлгүүдэд хуваагдаж байв. Монгол Улсад SARS-CoV-2 вирусийн гадаргуугийн S уургийн аминхүчлийн V143F, S640F өөрчлөлттэй шинэ хувилбар өвчлөл үүсгэсэн ба вирусийн генийн хувьсал үргэлжлэх хандлагатай байна гэжээ. 2. Монгол Улсад КОВИД-19 цар тахал үүсгэсэн Дельта хувилбарын SARS-CoV-2 вирусийн геномыг судалсан судалгааны дүгнэлтэд Монгол Улсад SARS-CoV-2 вирусийн Дельтагийн 10 хувилбар зөөвөрлөгдөн орж ирсэн ба 4 хувилбар нь дотоодын халдвар үүсгэсэн. Орчилд орсон Дельта хувилбарт геномын шинэ өөрчлөлт гараагүй байна гэжээ. КОВИД-19 вакцинжуулалт болон халдварын дараах SARS-CoV-2 вирусийг саармагжуулах идэвхийн судалгаа, КОВИД-19 эсрэг вакцины гурав дахь сэргээх тунгийн дараах дархлааны хариу урвал болон дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн судалгааны үр дүн гарсан байна. | 100.0 |
| 2 | | 1.1.2. Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэх | Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэх | Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдлын үнэлгээ хийгдэж, нөөцийг шинэчилж сэлгэсэн байна. | - | - | Гадаадын зээл, тусламж | 41,400.0 | Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх хүрээнд КОВИД-19, сармагчны цэцэг зэрэг өвчнийг Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005)-ийн дагуу олон нийтэд мэдээлж, “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал” хэмээн зарласан халдварт өвчний эрсдэлийн үнэлгээг Эрүүл мэндийн яамнаас УОК, ДЭМБ, ХӨСҮТ болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэвшсэн. 2022 онд КОВИД-19-ын эрсдэлийн үнэлгээ 1, сармагчны цэцэг өвчний эрсдэлийн үнэлгээ 3 удаа тус тус хийж, эрсдэлийг бууруулах зөвлөмж гарган хэрэгжүүлж байна. Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнд хэрэглэх нөөцийг гадаад эх үүсвэрээс бүрдүүлэхэд анхаарч, АХБ, Япон Улсын Засгийн газар, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан, Олон талт хамтын ажиллагааны КОВАКС механизмын хүрээнд нийт 41.4 тэрбум төгрөгийн эм, хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хүлээн авч, эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлж ажилласан. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 1.1.3. Зоонозын өвчин судлалын төвийг 2 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг тус тус байгуулах | Зоонозын өвчин судлалын төвийг 2 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг тус тус байгуулах | Зоонозын өвчин судлалын төвийг 2 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг байгуулсан байна. | Улсын төсөв | 1,220.0 | - | - | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Дорнод аймгийн Хавирга, Увс аймгийн Боршоо, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хилийн боомтод тандалтын нэгж байгуулах үндэслэл, танилцуулга, санхүүжилтийн тооцоог хийж хүргүүлсэн. Улмаар төслийн Удирдах хорооны хурлаар дэмжигдэж, АХБ-ны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд 2023 онд нийлүүлэхээр шийдвэрлэсэн. Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймагт ЗӨСТ байгуулах талаар үндэслэл, танилцуулга, шаардагдах төсвийг 2023 оны төсвийн төсөлд тусгасан боловч 2023 онд шинээр барилга байгууламж барихгүй байх шийдвэртэй холбоотойгоор хойшлогдсон. Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Төв аймагт 33 орон тоо бүхий "Зоонозын өвчин судлалын төв" болон хилийн 12 боомтод 8 орон тоо бүхий "Тандалтын нэгж"-ийг 2024 онд байгуулах, Ховд, Увс, Өмнөговь, Дундговь, Архангай аймгийн "Зоонозын өвчин судлалын төв"-д барилга, байгууламж барихад шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 1а/5053 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. ЗГХЭГ-аас 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн ХЭГ/2957 тоот албан бичгээр тандалтын нэгжийг хууль тогтоомжид нийцүүлэн байгуулах асуудлыг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргатай зөвшилцөх, Зоонозын өвчин судлалын төвийг тухайн аймгийн Эрүүл мэндийн газрын санал, дүгнэлт, хэрэгцээ, шаардлагад үндэслэн шийдвэрлэх нь зүйтэй гэсэн үндэслэлээр тогтоолын төслийг буцаасан. | 30.0 |
| 4 | 1.1.4. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийн агуулах шинэчлэн барих барилгын ажлыг эхлүүлж, 30 хувьд хүргэх | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийн агуулах шинэчлэн барих барилгын ажлыг эхлүүлж, 30 хувьд хүргэх | Агуулахын барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 1,000.0 | Гадаадын зээл, тусламж | 8,300.0 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ)-ийн эзэмшлийн газрын баруун хойд хэсэгт 0.58 га. талбай бүхий Улаанбаатар хотын төв цэгээс 10 км зайд, Сонгинохайрхан, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Сонсголонгийн замын дагуу газарт шинэчлэн барьж, ашиглалтад оруулсан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/331 дүгээр тушаалаар агуулахын тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн бүртгэлд авч хуваарилсан. АХБ-ны "Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5" төслийн "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн нэмэлт санхүүжилт" төслийн хүрээнд ЗӨСҮТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахын барилга барихад 6.7 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 1.6 тэрбум төгрөг, нийт 8.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн. | 100.0 |
| 5 | 1.1.5. 5 аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг полимеразын гинжин урвалын шинжилгээ хийх төхөөрөмжөөр хангаж, ашиглалтад оруулах | 5 аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг полимеразын гинжин урвалын шинжилгээ хийх төхөөрөмжөөр хангаж, ашиглалтад оруулах | Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг полимеразын гинжин урвалын шинжилгээ хийх төхөөрөмжөөр бүрэн хангаж, шинээр 5 аймгийн нэгдсэн эмнэлгийг полимеразын гинжин урвалын шинжилгээ хийх төхөөрөмжтэй болгож, лабораторийн чадавхыг нэмэгдүүлсэн байна. | Улсын төсөв | 1,500.0 | Гадаадын зээл, тусламж | 377.9 | Булган, Төв, Дундговь аймагт молекул биологийн лабораторийг шинээр байгуулж ашиглалтад оруулснаар нийт 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт молекул биологийн лаборатори байгуулагдаад байна. Молекул биологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 202 лабораторид 2022 оны 04 дүгээр сард Олон улсын гадаад чанарын хяналтыг явуулсан. Түүнчлэн 2022 онд Люксембургийн Их Гунт Улсын санхүүжилтээр "Цар тахлын үед эхийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах" төслийг хэрэгжүүлж, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, Өргөө, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт молекул биологийн шинжилгээ хийх иж бүрэн лабораторийг байгуулсан. Төслийн хүрээнд 109,726.76 ам.долларын үнэ бүхий 22 нэр төрлийн молекул биологийн оношилгооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслүүдийг лабораторийн стандарт тавилгын хамт хүлээлгэн өгсөн. Лаборатори нь КОВИД-ын халдвараас гадна нөхөн үржихүйн замын халдварууд, умайн хүзүүний хавдрын үүсгэгчийг илрүүлэх урвалж бодис, технологийн хамт нийлүүлэгдэж байгаагаараа онцлог. Нийлүүлэгч компани сургалтыг тоног төхөөрөмж болгоноор хийж, эмнэл зүйн сургалтыг ЭМЯ, Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан. | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | | 1.1.6. Ерөнхий боловсролын 100 сургуульд сургалтын удирдлагын системийг нэвтрүүлж, цахим хичээлийн сан сонголттойгоор бүрдүүлэх | Ерөнхий боловсролын 100 сургуульд сургалтын удирдлагын системийг нэвтрүүлж, цахим хичээлийн сан сонголттойгоор бүрдүүлэх | Ерөнхий боловсролын 100 сургуульд үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэн байна. | - | - | - | - | "Сургуулийн удирдлагын систем" /SMS/, "Суралцахуйн удирдлагын систем" /LMS/-ийг 2022-2023 оны хичээлийн жилд төрийн болон төрийн бус өмчийн 120 сургуулийн сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/111 дүгээр тушаалаар "Боловсрол сургалтын байгууллагын болон суралцахуйн удирдлагын системд тавих шаардлага", А/384 дүгээр тушаалаар "Ээлжит хичээлийн цахим контент сонгон шалгаруулах үнэлгээний аргачлал", 123 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын хичээлийн контентын сан бүрдүүлэх журам"-ыг тус тус баталсан. "Боловсрол сургалтын байгууллагын болон суралцахуйн удирдлагын системд тавих шаардлага"-д нийцүүлэн программ хангамж, мэдээллийн системийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгэгчтэй Ерөнхий гэрээ байгуулснаар цахим хичээлийн сан сонголттойгоор сургалтын үйл ажиллагаанд ашиглах зохицуулалттай болсон. Мөн "Ерөнхий боловсролын хичээлийн контентын сан бүрдүүлэх журам"-ын дагуу 5,977 багш холбогдож, 3,260 хичээлийг боловсруулж, 2,380 ээлжит хичээлийн цахим контентыг системд байршуулан ашиглаж байна. medle.mn цахим платформд 147 цахим сурах бичиг, 4,140 теле хичээл, 6-12 дугаар ангийн математик, физик, хими, биологийн хичээлд ашиглах 805 виртуаль лаборатори, эрүүл мэнд, замын хөдөлгөөний чиглэлээр 152 контент, суралцагчдад зориулсан 85 Microsoft 365 цахим хичээл, контент боловсруулах арга зүйн зөвлөмж, насан туршийн боловсрол, цахим ур чадварын 413 контентийн сан бүрдсэн. | 100.0 |
| 7 | | 1.1.7. Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх хүндрэлийг даван туулахад чиглэсэн хөтөлбөрийн зээлийг Азийн хөгжлийн банктай хэлэлцэн тохирч, идэвхтэй хамтран ажиллах | Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх хүндрэлийг даван туулахад чиглэсэн хөтөлбөрийн зээлийг Азийн хөгжлийн банктай хэлэлцэн тохирч, идэвхтэй хамтран ажиллах | Төсвийн тогтвортой байдлыг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх эх үүсвэрийг хүлээж авсан байна. | Гадаадын зээл, тусламж | 296,000.0 | Гадаадын зээл, тусламж | 296,000.0 | Азийн хөгжлийн банктай зээлийн гэрээнд 08 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурж, 09 дүгээр сарын 27-ны өдөр тус зээлийн гэрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Хууль зүйн дүгнэлт гаргаснаар зээлийн гэрээ хүчин төгөлдөр болсон. 09 дүгээр сарын 30-ны өдөр санхүүжилтийн эх үүсвэрийг Төрийн сангийн дансанд хүлээн авсан. | 100.0 |
| 8 | | 1.1.8. Улсын төсөв, Засгийн газрын дотоод үнэт цаасны эх үүсвэр, гадаад хөнгөлөлттэй зээлээс Засгийн газрын тусгай сан, төрийн өмчит хуулийн этгээдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон өр авлагыг барагдуулах | Улсын төсөв, Засгийн газрын дотоод үнэт цаасны эх үүсвэр, гадаад хөнгөлөлттэй зээлээс Засгийн газрын тусгай сан, төрийн өмчит хуулийн этгээдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон өр авлагыг барагдуулах | Засгийн газрын эх үүсвэрээр олгосон ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасыг банк, санхүүгийн байгууллагад худалдан эх үүсвэрийг төвлөрүүлэх, дампуурсан банкууд дээрх улсын төсвийн авлагын асуудлаар Монголбанк, банкуудын эрх хүлээн авагчидтай хамтран ажиллаж, хууль, журмын дагуу шийдвэрлүүлж, Төрийн орон сууцны корпораци болон Засгийн газрын тусгай сангуудаас улсын төсөвт төлөх өглөгийг бууруулсан байна. | - | - | - | - | Арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар нийт 318.7 тэрбум төгрөгийн өр авлагыг барагдуулаад байна. Үүнд: 1. Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хамтран хэрэгжүүлж буй "Орон сууцны ипотекийн зээлийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд Сангийн яамны эзэмшиж буй 228.7 тэрбум төгрөгийн үнэ бүхий давуу эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан бонд /ИЗББ/ болон 46.7 тэрбум төгрөгийн банкнаас авах ипотекийн санхүүжилтийн авлага, нийт 275.4 тэрбум төгрөгийн эзэмших эрхийг өнөөгийн үнэ цэнээр тооцсон дүнгээр Монголбанканд шилжүүлж, мөн дүнгээр Монгол Улсын Засгийн газраас Монголбанканд 2031 онд төлөгдөх хуваарътай "Сайн хувьцаа"-ны төлбөрөөс 277.4 тэрбум төгрөгийг хугацаанаас нь өмнө барагдуулсан. 2. Гадаад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс Төрийн өмчит хуулийн этгээдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон дамжуулан зээлийн хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 25-ны байдлаар нийт 109.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. 3. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас улсын төсөвт төлөх хугацаа хэтэрсэн өглөгийн үлдэгдэл 14.5 тэрбум төгрөгийг бүрэн барагдуулсан. 4. Засгийн газраас хэрэгжүүлсэн 4 мянга, 100 мянган айлын орон сууцны хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн эргэн төлөлт 8.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. | 100.0 |
| | | | **Бодлогын дундаж үнэлгээ** | | | **300,320.0** | | **346,077.9** | | **91.3** |
| **2. Хүний хөгжлийн бодлого** | | | | | | | | | | |
| 9 | 2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний | 2.1.1. Зүрх судасны төвийн барилгын ажлыг эхлүүлэх | Зүрх судасны төвийн барилгын ажлыг эхлүүлэх | Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 40,000.0 | - | - | Зүрх судасны төвийн зураг төсвийг Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжиж байгаа "Зүрх судасны төв байгуулах" төслийн 1.5 сая еврогийн буцалтгүй тусламжаар Испани Улсын "Идом" ХХК гүйцэтгэж, барилга угсралтын ажлын дүн 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажсан. Барилгын төсвийн эх үүсвэрийг 2022 оны улсын төсөвт тусгах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч батлагдаагүй, төсөвгүй гэх шалтгаанаар барилгын гүйцэтгэл гацсан байна. Төвийн барилгыг Улсын гуравдугаар төв эмнэлгийн хашаанд барихаар газрын асуудлыг шийдвэрлэсэн. Зүрх судасны төвийн барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй. | 0.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | ...чанар, хүртээмжийг сайжруулна | 2.1.2. Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлыг эхлүүлэх; Төв ашиглалтад оруулахад шаардлагатай нөөцийн тооцооллыг хийх | Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлыг эхлүүлэх; Төв ашиглалтад оруулахад шаардлагатай нөөцийн тооцооллыг хийх | Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна. Төв ашиглалтад оруулахад шаардлагатай нөөцийн /хүний нөөц, тоног төхөөрөмж, бусад/ тооцооллыг хийсэн байна. | Улсын төсөв | 40,000.0 | - | - | Эрхтэн шилжүүлэн суулгах төв нь Улаанбаатар хот, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хашаанд 60.2х30 м хэмжээтэй цоколийн 2 давхартай, 8 давхар барилгатай, шаардлагатай дэвшилтэт тоног төхөөрөмж, мэргэжилтнүүдээр бүрэн хангагдсан байхаар төлөвлөгдсөн. Тус төсөл арга хэмжээний ТЭЗҮ боловсруулагдсан бөгөөд 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг шаардлагатай. Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй. | 0.0 |
| 11 | | 2.1.3. Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх | Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх | Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 8,000.0 | - | - | Сүрьеэгийн эмнэлгийн барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажил Засгийн газрын тогтоолоор Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж, "Хар чоно" ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмж ирүүлсэн. Зөвлөмжийн дагуу гэрээний төсөл боловсруулах үед "Хар чоно" ХХК нь Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх тухай" 213 дугаар тушаалаар батлагдсан жагсаалтад бүртгэгдсэн тул гэрээ байгуулах боломжгүй болж, тендерийг 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдөр дахин зарласан. Дахин зарласан тендерийг "Захиргааны актын биелэлтийг түтгэлзүүлэх тухай" Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн шүүгчийн 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 128/ШЗ2022/7229 захирамжаар захиргааны хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл түр зогсоогоод байна. Барилгын ажлын төсөвт өртөг 18.5 тэрбум төгрөг бөгөөд 2022 оны улсын төсөвт 2.0 тэрбум төгрөгөөр суусан боловч ажил эхлээгүй. Сүрьеэгийн эмнэлгийн барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй тул барилгын ажил эхлээгүй. | 0.0 |
| 12 | | 2.1.4. Геронтологийн төвийн барилгын ажлын гүйцэтгэлийг 70 хувьд хүргэх | Геронтологийн төвийн барилгын ажлын гүйцэтгэлийг 70 хувьд хүргэх | Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 5,600.0 | - | - | Монгол Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдээс эрүүл мэндийн салбарт Геронтологийн төвийн барилга царцсан, барилга угсралтын ажил хийгдээгүй байна. Барилга угсралтын ажлын зураг төсвийг бүрэн болгож, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нэмэгдсэн. Төсөвт өртгийн нэмэгдлийг Сангийн яаманд 2020-2023 онуудын төсвийн тухай хуульд тусгуулахаар өргөн барьсан боловч төсөвт өртөг нэмэгдэж батлагдаагүй. Харин Сэргээн засах төвийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, 36 ор/-ын ажлын явц 46.0 хувьтай байгаа ба 2023 оны төсвийн хуулиар 4,616.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 828.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй батлагдсан. Иймд Сэргээн засах төвийн барилгыг 2023 онд бүрэн ашиглалтад оруулж Геронтологийн үндэсний төв болгон ашиглана. | 50.0 |
| 13 | | 2.1.5. Орон нутагт яаралтай тусламжийн 10 цэг байгуулах | Орон нутагт яаралтай тусламжийн 10 цэг байгуулах | Орон нутагт шаардлагатай 10 цэгт яаралтай тусламжийн цэг байгуулсан байна. | Гадаадын зээл, тусламж | 5,000.0 | Гадаадын зээл, тусламж | 307.2 | Осол, гэмтэл ихээр гардаг Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Хөвсгөл аймгийн Хатгал, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Булган аймгийн Хутаг-Өндөр, Архангай аймгийн Тариат, Ховд аймгийн Булган, Завхан аймгийн Их-Уул, Орхон аймгийн Баян-Өндөр, Өвөрхангай аймгийн Хархорин, Сэлэнгэ аймгийн Мандал сум зэрэг 10 цэгт яаралтай тусламжийн жишиг цэгийг байгуулахад шаардлагатай тоног, төхөөрөмжийн худалдан авалтыг ДЭМБ-ын санхүүжилтээр хийж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/502 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад тоног төхөөрөмжийг хуваарилсан (255.9 сая төгрөг). Яаралтай тусламжийн эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхийг сайжруулах зорилгоор 2022 оны 12 дугаар сарын 17-19-ний өдөр "Сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээ" сэдэвт сургалтыг зохион байгуулж, орон нутгийн 40 гаруй эмч, сувилагч хамрагдсан (51.3 сая төгрөг). | 50.0 |
| 14 | | 2.1.6. Баянзүрх дүүрэгт барих 300 ортой эмнэлгийн барилгын зураг, төсвийг хийж, барилгын ажлыг эхлүүлэх | Баянзүрх дүүрэгт барих 300 ортой эмнэлгийн барилгын зураг, төсвийг хийж, барилгын ажлыг эхлүүлэх | Зураг, төсөв хийгдэж, барилгын ажил эхэлсэн байна. | - | - | - | - | Баянзүрх дүүрэгт барих 300 ортой эмнэлгийн зураг, төсвийн зардалд Барилга, хот байгуулалтын сайдын багцад 268.9 сая төгрөгийн эх үүсвэр тусгагдсан бөгөөд зураг төслийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, "Татах хүч" ХХК-тай гэрээ байгуулан зураг төсвийг хийлгэж байна. Уг эмнэлгийн барилгыг барихаар олгогдсон 7,000 м2 газарт эмнэлгийн барилга багтахгүй байгаа тул газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй. | 30.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | 2.1.15. Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг холбож, мэдээллийн сан бүрдүүлэх | Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг холбож, мэдээллийн сан бүрдүүлэх | 21 аймгийн нэгдсэн эмнэлэг сүлжээнд холбогдож, нянгийн тэсвэржилтийн талаарх мэдээллээ өгч хэвшсэн байна. | Улсын төсөв | 500.0 | - | - | Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд нэгдэх бэлтгэл ажлыг хангаж, нянгийн тэсвэржилтийн WHO.NET программ дээр ажиллаж сургах сургалтад 21 аймгийн эмч, мэргэжилтнүүдийг хамруулах хөтөлбөр, төлөвлөгөөг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Нян судлалын лабораторитой хамтран боловсруулж байна. ДЭМБ-ын Номхон далайн Баруун бүсийн Нянгийн тэсвэржилтийн тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн манай улсад 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 14-ний өдрүүдэд ажиллан "Нянгийн тэсвэржилтийн тандалт, тэсвэржсэн нянгийн мэдээллийг боловсруулах нь" сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 40 хүн хамрагдсанаас цахимаар 21 аймгийн лабораторийн 25 хүн оролцсон. WHONET-ийн тухай ойлголт, хэрэглээ, дүгнэлт гаргах аргачлал, шинжлэлийн талаар олон улсын зөвлөх дэлгэрэнгүй мэдээлэл өгч, манай улсад WHONET программыг хэрхэн ашиглаж байгаа болон Монгол Улс тэсвэржсэн нянгийн мэдээллийг ДЭМБ-ын "GLASS" системд хүргүүлдэг болох талаар мэдээллийг түгээсэн байна. | 30.0 |
| 24 | 2.1.16. Эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийг эх орондоо үйлдвэрлэдэг болоход түүхий эдийг татвараас чөлөөлөх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх | Эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийг эх орондоо үйлдвэрлэдэг болоход түүхий эдийг татвараас чөлөөлөх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх | Хууль, эрх зүйн орчин бүрдэж, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийн дотоодын зах зээлд эзлэх хувь нэмэгдсэн байна. | - | - | - | - | 2022 оны 12 дугаар сарын байдлаар эмнэлгийн хэрэгслийн 83 хувийг импортлож, 17 хувийг дотоодод үйлдвэрлэсэн байна. ЭМЯ-наас 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр дотоодын үйлдвэрүүдтэй холбоотой тулгамдаж буй асуудлаар ЭЭХХЗГ, ЗӨСҮТ, НЭМҮТөвийн дарга, удирдлагуудтай уулзалт хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд: ЭЭХХЗГазраас эмийн-10, БИБ-7, уламжлалт эмийн-5, биобэлдмэлийн-1, нийт 23 үйлдвэрт үнэлгээ хийсэн. Үйлдвэрүүдийн зүгээс түүхий эдийн үнийн өсөлт, тээвэрлэлтийн зардал өссөн зэргээс хамаарч санхүүжилт хүндрэлтэй байгаа тул татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх хүсэлт гаргасан. Дотоодын үйлдвэр ханган нийлүүлэх байгууллагыг дэмжих үүднээс "Эрүүл мэндийн технологи-2022" үзэсгэлэнг 2022 оны 10 дугаар сарын 07-09-ны өдөр зохион байгуулж, тоног төхөөрөмж ханган нийлүүлэгч 14, Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх 41, БНСУ-аас 11 аж ахуйн нэгж оролцсон. Үүнээс эм, эмнэлгийн хэрэгслийн 5 үйлдвэр оролцож, өөрсдийн бүтээгдэхүүнээ танилцуулж, борлуулалт хийсэн байна. | 50.0 |
| 25 | 2.1.17. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг бий болгон, чадавхыг бэхжүүлэх | Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг бий болгон, чадавхыг бэхжүүлэх | Шинээр 3 бүсийн оношилгоо, эмчилгээний төвд төгсөлтийн дараах сургалт явуулдаг болсон байна. | Улсын төсөв | 250.0 | - | - | Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрлийг Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлын 5, 6, 7 дугаар тогтоолоор олгосон. 2022-2023 оны хичээлийн жилд Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн төгсөлтийн дараах сургалтад Өвөрхангай 3, Өмнөговь 1, Ховд 2 резидент, нийт 6 эмч элсүүлэн сургаж байна. Өмнөх онд сургалт эрхлэх зөвшөөрөл авсан Орхон 3, Дорнод 3, нийт 6 эмчийг элсүүлэн сургаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн төгсөлтийн дараах сургалтад дээрх 5 Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд нийт 12 резидент эмчийг сургаж байна. | 100.0 |
| 26 | 2.1.18. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний бацыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлэх | Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний бацыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлэх | Бүх өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд нэвтрүүлж эхэлнэ. | Улсын төсөв | 250.0 | - | - | Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн журмыг ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, 2022 оны 04 дүгээр сарын 01-нээс хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн ЭМДҮЗ-ийн 13 дугаар тогтоолоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын үлгэрчилсэн гэрээ, гэрээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг батлуулж сар бүр 80.0 хувийн урьдчилгаа санхүүжилт олгож, гүйцэтгэлээр 20.0 хувийг хянаж олгохоор зохицуулсан. Ингэснээр иргэн анхан шатны тусламж, үйлчилгээг хаанаас авч байгааг цахимаар хянаж, тусламж, үйлчилгээ үзүүлж буй анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх боломж бүрдсэн. Хэрэгжилтийн явцад эрүүл мэндийн байгууллагуудын программ хангамж хугацаандаа ашиглалтад ороогүйтэй холбоотой ЭМДҮЗ-ийн 09, 14 дүгээр тогтоолыг гаргаж санхүүжилтийг олгож ажилласан. | 100.0 |
| 27 | 2.1.19. "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлэх | "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлэх | Арга хэмжээний хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 3,000.0 | - | - | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар батлагдсан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд 5 зорилт, 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны эхний 11 сарын байдлаар 35.8 хувьтай байна. | 70.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | 2.1.20. "Хавдрын эсрэг" арга хэмжээг эхлүүлж, хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулах | "Хавдрын эсрэг" арга хэмжээг эхлүүлж, хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулах | Хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамралтын түвшин 30 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 600.0 | - | - | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/360 дугаар тушаалаар батлагдсан "Хавдрын эсрэг" арга хэмжээ төлөвлөгөөнд 6 зорилт, 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд 2022 онд 21 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 765,264 хүн хамрагдсанаас 351,006 буюу 45.9 хувь нь эрэгтэйчүүд, 414,258 буюу 54.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Үзлэгт хамрагдсан 18-60 насны хүн амаас хавдрын 409 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 18-30 насны ангилалд 7 тохиолдол буюу 1.7 хувь, 31-45 насны ангилалд 98 тохиолдол буюу 24.0 хувь, 46-60 насны ангилалд 304 тохиолдол буюу 74.3 хувийг эзэлж байна. 31-45 насныхны дунд элэг ба элгэн дэх цөсний сувгийн өмөн 22.4 хувь, хөхний өмөн 20.4 хувь, ходоодны өмөн 19.4 хувийг тус тус эзэлж байна. 61-ээс дээш насны ангилалд хорт хавдрын 454 сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, элэг ба элгэн дэх цөсний сувгийн өмөн 40.5 хувь, ходоодны өмөн 19.8 хувь, улаан хоолойн өмөн 10.1 хувийг тус тус эзэлж байна. Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралт 23.9 хувьтай байна. | 70.0 |
| 29 | 2.1.21. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, элэгний дельта вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах | "Элэг бүтэн Монгол" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, элэгний дельта вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах | Арга хэмжээний хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 13,000.0 | - | - | Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/577 дугаар тушаалаар "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөө 2022-2025 онд хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилт, 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна. Элэгний D вирусийн эсрэг Bulevirtide (Hepcludex) эмийг Хүний эмийн зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/347 дугаар тушаалаар 2 жилийн хугацаагаар өнчин эмийн жагсаалтад оруулсан. Гэвч D вирусийн эмийг манай улсад импортлон оруулж ирэхгүй байгаа тул иргэдийг эмийн эмчилгээнд хамруулах ажил удаашırсан. Шалтгаан нь Bulevirtide эм нь анх лиценз эзэмшигч MYR GmbH компанийн нэр дээр Европын эмийн агентлагт нөхцөлт зөвшөөрөл авсан бөгөөд эзэмшигчийн лиценз нь АНУ-ын Гилеад Сайенс компанид 2020 оны 12 дугаар сард шилжиж, улмаар АНУ-ын Хүнс эмийн агентлагт (FDA) Bulevirtide эмийг бүртгүүлэхээр хүлээгдэж байна. Эмийн эмчилгээний талаар Гилеад Сайенс компаниас 2022 оны 06 дугаар сарын 04-ны өдөр монголын эмч нарт сургалтыг зохион байгуулсан. | 0.0 |
| 30 | 2.1.22. "Харшлаас сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлэх | "Харшлаас сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлэх | Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 200.0 | - | - | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/816 дугаар тушаалаар батлагдсан "Харшлаас сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилт, 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны эхний 11 сарын байдлаар 50.3 хувьтай байна. | 70.0 |
| 31 | 2.1.23. Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангах | Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангах | Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавх бэхэжсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 8,100.0 | Улсын төсөв | 5,100.0 | Алсын зайн болон яаралтай тусламжийн үйл ажиллагаанд ашиглах туулах чадвар өндөртэй түргэн тусламжийн автомашиныг 21 аймаг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв зэрэг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад нийт 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгоод байна. Мөн түргэн тусламжийн УАЗ-фургон автомашиныг 11 аймгийн 22 сумын эрүүл мэндийн төвд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгож ашиглалтад оруулсан. Япон Улсын Засгийн газраас Хөгжлийн төлөвлөлтийн техникийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй "Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II-ийн коронавируст халдвар КОВИД-19-ийг эмчлэх, урьдчилан сэргийлэх, эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах" төслийн хүрээнд 8 ширхэг иж бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашиныг 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хүлээлгэн өгсөн. ОХУ-ын Москва хотноо тус улсын Эрүүлийг хамгаалах яамны харьяа Хүүхдийн анагаах ухааны эрдэм шинжилгээний үндэсний төвд "Хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх зарчмууд" сэдэвт сургалтад Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, Өргөө амаржих газраас нийт 15 эмч 2022 оны 07 дугаар сарын 11-22-ны өдрүүдэд хамрагдсан. БНХАУ-ын Хунань мужийн хүүхдийн эмнэлгээс зохион байгуулж, 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхэлсэн Яаралтай тусламжийн сувилахуйн 3 долоо хоногийн цахим сургалтад 21 аймаг, нийслэлийн яаралтай тусламжийн 25 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж байна. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | 2.1.24. Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах | Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах | Эрүүл мэндийн даатгалын цахим тоггολцоог бий болгож, бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг холбоно. | Улсын төсөв | 300.0 | - | - | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 02, 03, 06 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангах үүднээс Health.gov.mn мэдээллийн системд нэмэлт хөгжүүлэлт хийж, гэрээт төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн санхүүжилт олгох үйл ажиллагаа бүрэн цахимжсан. | 100.0 |
| 33 | 2.1.25. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цоцолбор салбар II-ыг байгуулах ажлыг эхлүүлэх | Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цоцолбор салбар II-ыг байгуулах ажлыг эхлүүлэх | Цоцолбор салбар II-ын барилга баригдаж эхэлсэн байна. | Улсын төсөв | 600.0 | - | - | Халдварт өвчин судлалын төвийн цоцолбор салбар байгуулах зураг төслийн ажлыг гүйцэтгэсэн. Төв аймгийн Сэргэлэн сумын 20 га газрыг Халдварт өвчин судлалын үндэсний төвд шилжүүлэн гэрчилгээг олгосон. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цоцолбор салбар-II барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй. | 0.0 |
| 34 | 2.1.26. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 933.0 | Улсын төсөв | 430,000.0 | Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор эрүүл мэндийн ажилчдын цалингийн доод жишгийг шинэчлэн тогтоож, эрүүл мэндийн байгууллагууд эмч, ажилчдын цалинг нэмэгдүүлсэн. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Хархорин сум нь эмч, ажилчдын үндсэн цалинг 10-25 хувиар нэмэгдүүлж, улирал бүр урамшуулал, Хавдар судлалын үндэсний төв эмч, ажилчдынхаа үндсэн цалинг 43.0 хүртэл хувиар нэмэгдүүлэхээс гадна 15.0 хүртэлх сая төгрөгийн урамшуулал, Гэмтэл, согог судлалын үндэсний төв эмч, эмнэлгийн ажилчиддаа 500.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, сувилагч нарын үндсэн цалинг 10-25 хувиар нэмсэн, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв 2021 онд нийт ажилчдынхаа цалинг 30.0 хувь нэмэгдүүлсэн бол 2022 онд гүйцэтгэлтэй нь уялдуулан 20.0 хувь нэмэгдүүлсэн байна. Амгалан амаржих газар 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эмч эмнэлгийн ажилчдын цалингаа 10-20 хувиар нэмэгдүүлсэн. УНТЭ гүйцэтгэлийн санхүүжилтийн үр дүнд 2022 онд 33 эмч, ажилтандаа орон сууцны урьдчилгаа болох тус бүр 30.0 сая хүртэлх төгрөг олгосон, УГТЭ нийт ажилчидынхаа үндсэн цалинг 40.0 хувиар нэмэгдүүлсэн. Эмч, ажилчдынхаа үндсэн цалинг нэмэхийн зэрэгцээ орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн ЭМТ-ийн 17 ажилтанд орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэхэд 30.0 сая төгрөг, 20 ажилтанд орон сууцны зээлийн хөнгөлөлтөд 20.0 сая төгрөг, 11 ажилтанд монгол гэр тус бүр олгосон байна. | 70.0 |
| 35 | 2.1.27. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах | Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах | Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг даатгалын санхүүжилтийн 8 хувиар байгуулсан байна. | Улсын төсөв | 40,000.0 | - | - | ЭМДҮЗ-ийн 2021 оны 10 дугаар тогтоолоор эрсдэлийн санг 40 тэрбум төгрөгөөр буюу 2022 оны даатгалын санхүүжилтийн 2.8 хувиар байгуулсан байна. Коронавируст халдварын үеийн эдийн засаг, санхүүгийн хүндрэл, инфляци, валютын ханшийн өсөлттэй холбоотой Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх орлого буурч, төлөвлөсөн зардлыг санхүүжүүлэхэд шаардагдах төсвийн эх үүсвэр дутагдсан тул эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн "Эрүүл мэндийн даатгалын 2022 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай" 13 дугаар тогтоолоор гаргажээ. | 30.0 |
| 36 | 2.1.28. Хавдар судлалын үндэсний төвийн салбар II-ыг байгуулах ажлын зураг, төсвийг боловсруулах | Хавдар судлалын үндэсний төвийн салбар II-ыг байгуулах ажлын зураг, төсвийг боловсруулах | Зураг, төсөв хийгдэж, барилгын ажлыг эхлүүлсэн байна. | Улсын төсөв | 3,000.0 | - | - | Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд Барилга, хот байгуулалтын сайдын багцад зураг төсөв боловсруулах төсвийг тусгасан бөгөөд Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын байгуулсан үнэлгээний хороо худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зураг төсвийн ажил 80.0 хувьтай үргэлжилж байна. Газрын асуудал шийдэгдэж, Баянзүрх дүүргийн Чулуутын аманд 10 га газарт барилга барихаар болсон. Хавдар судлалын үндэсний төвийн салбар-II барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй. | 30.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 37 | | 2.1.29. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох | Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох | 3 аймгийн нийт 15 сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгосон байна. | Гадаадын зээл, тусламж | 423.0 | - | - | Ус, ариун цэврийн байгууламжийн түргэвчилсэн үнэлгээний асуумжийг ЭМЯ, НЭМҮТ, МХЕГ хамтран 2022 онд боловсруулж, судалгаа авсан. Ариун цэврийн байгууламж, бохир ус зайлуулах систем, ус хангамж, гарын эрүүл ахуй, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн байдал зэрэг чиглэлээр асуумжийг 21 аймгийн нийт 358 сумын Эрүүл мэндийн төвөөс авч нэгтгэн улсын хэмжээний нөхцөл байдлын талаарх мэдээллийг боловсруулсан. Судалгаанд хамрагдсан сумын ЭМТ-ийн 76.5 хувь нь нүхэн жорлон тогтмол ашигладаг, 13.1 хувь нь хааяа ашигладаг, 2.0 хувь огт ашигладаггүй бол 8.4 хувь нь гадна нүхэн жорлонгүй байна. Нүхэн жорлон ашигладаг байдлыг бүсээр харахад баруун бүсийн сумын ЭМТ хамгийн их буюу 89.2 хувь, зүүн бүс 78.6 хувь, хангайн бүс 78.1 хувь, төвийн бүс 60 хувьд нүхэн жорлон тогтмол ашигладаг байна. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд 24,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй санхүүжих дүн 1.8 тэрбум төгрөгөөр батлагдсан. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжийн зураг төсөл хийгдэж байна. | 0.0 |
| 38 | | 2.1.30. "Ковид-19" халдварт вирусийн эмчилгээнд нэн шаардлагатай уушги орлуулагч ЭКМО аппаратын тоог нэмэгдүүлэх | "Ковид-19" халдварт вирусийн эмчилгээнд нэн шаардлагатай уушги орлуулагч ЭКМО аппаратын тоог нэмэгдүүлэх | Уушги орлуулагч ЭКМО аппарат худалдан авч эмчилгээнд ашигласнаар тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна. | Улсын төсөв | 750.0 | - | - | Уушги орлуулагч ЭКМО аппаратыг 2022 оны эхний 10 дугаар сарын байдлаар УНТЭ 22, УГТЭ 2, ХӨСҮТ 1, ЦТЭ 5, нийт 30 хүнд эмчилгээ хийхэд ашиглаж, 61.5 хувийн үр дүнтэй байсан. | 90.0 |
| 39 | | 2.1.31. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийн засвар шинэчлэлтийн ажлыг хийх | Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийн засвар шинэчлэлтийн ажлыг хийх | Тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | Улсын төсөв | 8,750.0 | Улсын төсөв | 62,766.6 | "Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-нд 387,573.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ тусгаснаас 2022 онд 72,898.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталжээ. Он дамжин хэрэгжиж байгаа 2022 онд дуусгавар болох ёстой 33 барилгаас 19 барилгын ажил бүрэн дуусгавар болж (100%), улсын комисс хүлээн авсан. Улсын комисс ажиллахаар бэлтгэл хангаж байгаа 2 барилга 90 хувийн гүйцэтгэлтэй байна. 11 барилгын ажлын явц 62.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь үнийн өсөлт болон төсөвт өртгийн нэмэгдлээс шалтгаалан 2022 онд ашиглалтад орохгүйгээр 2023 онд шилжсэн болно. Нэг барилгын гүйцэтгэгч шалгараагүй, учир нь төсөвт өртөг тохирсон компани тендерт оролцоогүй байна. 2022 онд шинээр эхлэх 36 барилгаас 31 барилгын ажлын явц 26.2 хувь байна. 5 барилга худалдан авах ажиллагааны шатанд байна. Барилгын ажил технологийн шаардлагаас хамааран зогссон байна. | 70.0 |
| 40 | | 2.1.32. Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барих | Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барих | Барилгын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийг 40 хувьд хүргэсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 5,137.5 | - | - | Энэхүү арга хэмжээг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл "Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах" төслийн хүрээнд хэрэгжүүлнэ. Уг төсөл нь 3 үе шаттай бөгөөд I үе шатын хүрээнд "Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл"-ийн зургийн зөвлөх компани "Татах хүч" ХХК шалгарч 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулсан. Ажлын явц 40 хувьтай байна. Түүнчлэн 2022 онд Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөлийн зураг төсөв хийхээр "Татах хүч" ХХК-тай 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулсан. Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын эскиз зургийг дуусган, ЭМЯ-ны ТАХ-аар 10 дугаар сарын 26-ны өдөр хэлэлцүүлж, аймгийн ерөнхий архитектороор батлуулахаар хүргүүлсэн. Барилга архитектурын зургийг 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор эцэслэн, ОБЕГ, МХЕГ, БХТ-д хүргүүлэн магадлалд оруулахаар ажиллаж байна. | 0.0 |
| 41 | 2.2. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх | 2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажлыг эхлүүлэх | Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажлыг эхлүүлэх | Барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 25,000.0 | - | - | Биеийн тамир, спортын улсын хорооны чиг үүрэгт хамаарахгүй учир хасуулах саналтай байна. | 0.0 |
| 42 | | 2.2.2. Нийслэлийн усан бассейн бүхий спортын цогцолборын ажлыг үргэлжлүүлж, Баянзүрх, Налайх дүүргийн спортын цогцолборыг ашиглалтад оруулах | Нийслэлийн усан бассейн бүхий спортын цогцолборын ажлыг үргэлжлүүлж, Баянзүрх, Налайх дүүргийн спортын цогцолборыг ашиглалтад оруулах | Спортын цогцолборыг ашиглалтад оруулсан байна. | Улсын төсөв | 3,400.0 | - | - | Налайх дүүргийн 700 хүний суудал бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажил 90 хувь, Баян-Зүрх дүүргийн спорт цогцолборын гүйцэтгэлийн ажил 70 хувь, нийслэлийн усан бассейн бүхий спорт цогцолбор гадна шугам сүлжээний зураг шинээр боловсруулах ажил 30 хувьтай хийгдэж байна. | 50.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | 2.3. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ. | 2.3.1. Төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөдөөгийн 113 цэцэрлэг, 176 сургууль, 121 дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах | Төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөдөөгийн 113 цэцэрлэг, 176 сургууль, 121 дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах | 113 цэцэрлэг, 176 сургууль, 121 дотуур байр төвлөрсөн болон бие даасан ариун цэврийн байгууламжтай болсон байна. | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 50,000.0 | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 9,541.5 | Сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлын хүрээнд 330 сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрын нөхцөл байдалд хийсэн судалгааны дүнд нийт 819 объектын гаднах нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжтай болгохоор төлөвлөсөн. Төслийг 4 ээлжээр хэрэгжүүлэхээр төлөвлөн, эхний 1, 2 дугаар ээлжид сонгогдсон байршилд түлхүүр гардуулах гэрээний нөхцөлөөр худалдан авах ажиллагааг 2021 оны 5 сард зохион байгуулсан. Төслийн 1 дүгээр ээлжид 16 аймгийн 53 суманд төсөл хэрэгжүүлэх 195 объектыг 15 багц болгон хуваарилан тендер зарлаж 14 компанитай, 2 дугаар ээлжид 16 аймгийн 49 суманд төсөл хэрэгжүүлэх 173 объектыг 16 багц болгон хуваарилж тендер зарлан 13 компанитай гэрээ байгуулан ажилласан. Төслийн 1, 2 дугаар ээлжид 26 багц 16 аймгийн 92 суманд 128 сургууль, 77 цэцэрлэг, 102 дотуур байрны төсөл арга хэмжээ, нийт 307 арга хэмжээг хэрэгжүүлэв. 3 дугаар ээлжийн зураг төслийн ажлын хэрэгжилт 98%, барилга угсралт 90 хувьтай. 3-р ээлжийн нийт 303 барилга угсралтын ажлаас Баян-Өлгий, Увс, Сэлэнгэ, Булган, аймгийн 29 сумын ажлын зураг төслийн гүйцэтгэгчээр Архидеа ХХК, Ховд аймгийн 6 сумын ажлын зураг төслийн гүйцэтгэгчээр Тэмжин ХХК, Хэнтий аймгийн 12 сумын ажлын зураг төслийн гүйцэтгэгчээр Нутаг консалтинг ХХК тус тус гэрээ байгуулж, ажлын талбайд хэмжилт судалгаа хийж, хэмжилтийн зураг, хөрсний судалгаа, дэвсгэр зураг боловсруулж байна. Ажлын гүйцэтгэл 80 хувьтай. Завхан, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай аймгийн 37 сумын ажлын зураг төслийн гүйцэтгэгчээр Нөёдын туурь ХХК гэрээ байгуулж, ажлын талбайн хэмжилт судалгаа хийгдэж, ажлын гүйцэтгэл 75 хувьтай. Архангай аймгийн 11 сумын ажлын зураг төслийн гүйцэтгэгчээр Мөнх консалтинг ХХК гэрээ байгуулж, ажлын талбайд хэмжилт судалгаа хийж, хөрсний судалгаа, дэвсгэр зураг боловсруулж, ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. | 50.0 |
| 44 | | 2.3.2. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, 50 гэр бүлэг байгуулж, хувилбарт сургалтад 500 хүүхэд нэмж хамруулах; 24 цагийн 10 бүлэг нэмж 250 хүүхдийг шинээр хамруулах | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, 50 гэр бүлэг байгуулж, хувилбарт сургалтад 500 хүүхэд нэмж хамруулах; 24 цагийн 10 бүлэг нэмж 250 хүүхдийг шинээр хамруулах | Шинээр 50 гэр бүлэг байгуулж, хувилбарт сургалтад 500 хүүхэд, 24 цагийн 10 бүлэг шинээр нэмж 250 хүүхэд нэмж хамруулсан байна. Хамран сургалтыг 95 хувьд хүргэсэн байна. | Улсын төсөв | 13,645.3 | Улсын төсөв | 499.8 | "Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт зохион байгуулах журам"-ыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/224 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсанаар дараах зохицуулалтыг хийж, хувилбарт сургалтын хүртээмж, чанар сайжрах боломж бүрдсэн. Үүнд:-Оршин суудаг газар болон хөгжлийн бэрхшээлийн улмаас цэцэрлэгийн үндсэн бүлгийн сургалтад тогтмол хамрагдах боломжгүй 3-5 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, -Аймгийн төвөөс бусад сум болон аймаг, нийслэлийн засаг захиргааны нэгжид хамаарах тосгоны цэцэрлэгт хувилбарт сургалтын үндсэн багш ажиллуулах Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд 15533 хүүхэд хувилбарт сургалтад хамрагдаж байгаа нь өмнөх жилээс 819-өөр, 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгийн 82 бүлэгт хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн 2063 хүүхэд хамрагдаж байгаа нь 567 хүүхдээр тус тус нэмэгдсэн байна. Нүүдлийн бүлгийн сургалтын орчныг сайжруулах зорилгоор 2022 онд 76 сургалт, гал тогооны зориулалт бүхий иж бүрэн гэрийг нийлүүлсэн. Хувилбарт сургалтын эрх зүйн орчныг сайжруулж, гэр цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэн, цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах цогц арга хэмжээ хэрэгжүүлсний үр дүнд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 90,4 хувьд хүрсэн.Үр дүн:1.76 гэр нийлүүлсэн, 2.Хувилбарт сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн тоо өмнөх жилээс 819-өөр нэмэгдсэн, 3.2022-2023 оны хичээлийн жилд 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгийн 82 бүлэгт хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн 2063 хүүхэд хамрагдаж байна. Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад бүлгийн тоо 3, хамрагдалт 567 хүүхдээр нэмэгдсэн байна.4.Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 90,4 хувь хүрсэн. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 45 | 2.3.3. Бага, дунд боловсролын чанарын болон суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийж, хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | Бага, дунд боловсролын чанарын болон суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийж, хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | Суралцагчдын сурлагын амжилтын өсөлт 10 хувь болсон байна. Бага ангийн суралцагчдын унших, бичих, математик чадварын, дунд ангийн суралцагчдын ерөнхий чадварын, ахлах ангийн суралцагчдын сонгон судалсан хичээлийн эзэмшилтийн түвшин өмнөх онтой харьцуулбал тус тус 5-10 хувиар өссөн байна. | Улсын төсөв | 600.0 | Гадаадын зээл, тусламж | 1,300.0 | Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийг үнэлэх, агуулгын хоцрогдлыг оношлох зорилгоор 2021 оны 10 дугаар сард суралцагчийн мэдлэг, чадвар эзэмшилтийн оношлох үнэлгээг хийж 2-12 дугаар ангийн суралцагчид түүврийн аргаар сонгогдон хамрагдсан. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх "Гүйцэтгэлийн үнэлгээ"-ний шалгалтыг бичгийн шалгалт, асуулгын хэлбэрээр 2022 оны тавдугаар сарын 24-27-ны өдрүүдэд зохион байгуулж 654 сургуулийн 30111 багш, давхардсан тоогоор 600000 орчим суралцагч, 350000 гаруй эцэг эх, асран хамгаалагч, 4000 орчим сургуулийн удирдах ажилтан хамрагдсан. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын амжилтын оношлох үнэлгээний мөрөөр хоцрогдол арилгахад чиглэсэн олон арга хэмжээг хэрэгжүүлснээр 2022 оны 5 дугаар сард хийсэн гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр сурлагын амжилт 8.3 хувиар буюу 41.1-ээс 49.4 болж өссөн байна. Үр дүн: Оношлох болон гүйцэтгэлийн үнэлгээний дүнг харьцуулж үзэхэд бага ангийн сурагчдын унших чадварын түвшин 22.5 хувиар буюу 37.5-аас 60.0 хувь, бичих чадварын түвшин 15 хувиар буюу 37.5-аас 52.5 хувь, математикийн чадварын түвшин 4 хувиар буюу 53.3 хувиас 57.3 хувь, дунд ангийн ерөнхий чадварын түвшин 9.9 хувь 37.5 хувиас 47.4 хувь, ахлах ангийн ерөнхий чадварын түвшин 6.1 хувиар буюу 36.4-өөс 42.5 болж тус тус өссөн байна. | 100.0 |
| 46 | 2.3.4. Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын /PISA/ үнэлгээнд хамрагдах | Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын /PISA/ үнэлгээнд хамрагдах | Үнэлгээнд 100 хувь хамрагдсан байна. | Гадаадын зээл, тусламж | 5,415.0 | Гадаадын зээл, тусламж | 1,700.0 | PISA 2022 Олон улсын үнэлгээний үндсэн судалгааг 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 13-ны хооронд УБ хотын 85 сургууль, хөдөө орон нутгийн 110, нийт 195 сургуулийн 7300 орчим сурагчийг түүврээр сонгож хамрууллаа. Суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэхдээ математик, байгалийн ухаан, унших, бүтээлч сэтгэлгээний агуулгаар компьютерт суурилсан хэлбэрээр шалгалтыг зохион байгуулсан. Шалгалт, судалгааны бэлтгэл ажлыг олон улсын стандартын дагуу хангаж, анги танхимд зохион байгуулах хянагч багшаар Боловсролын үнэлгээний төвийн 30 мэргэжилтэн ажилласан. Судалгааны мэдээлэл/дата/-ийг системд оруулах болон датаг цэвэрлэх ажлыг зохион байгуулж дуусган кодлолтын тайланг OECD байгууллагад хүргүүлсэн ба эцсийн үр дүн 2023 оны 12 дугаар сард гарахаар төлөвлөгдсөн. Үр дүн: Түүврээр сонгогдсон 195 сургууль үнэлгээнд бүрэн хамрагдсан. | 100.0 |
| 47 | 2.3.5. Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайжруулах | Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайжруулах | Монгол хэл, бичгийн сургалтын чанарын үнэлгээнд дунд, ахлах анги төгсөгчдийг хамруулсан байна. Монгол бичгийн хэвлэмэл болон цахим сурах бичиг, гарын авлагыг боловсруулж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байна. | - | - | - | - | Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдөөс авсан монгол хэл бичгийн шалгалтад 33138 шалгуулагч хамрагдсан ба шалгалтын гүйцэтгэл 63.2 хувь байсан. Оношлох үнэлгээний тайланд үндэслэн, монгол хэл бичгийн сул гүйцэтгэлтэй суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөмж боловсруулж Medle.mn сайтаар дамжуулан нийт багшид хүргэсэн. Монгол хэл, уран зохиолын хичээлийн жилийн жишиг төлөвлөлтийг medle.mn цахим платформд байршуулан багш нар хичээлдээ ашиглаж байна. ЕБС-д эхний болон 5 дахь жилдээ ажиллаж буй монгол хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад 375 багш хамрагдаж, монгол хэл, уран зохиолын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эх хэлний сургалтын чанарыг сайжруулах арга зүйн сургалтад хамрагдан батламж авсан. "Сурагчдын хоцрогдлыг арилгах" зорилтын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулж боловсруулсан монгол хэл, бичгийн хичээлийн "Дасгал ажлын дэвтэр"-ийг цахим платформд байршуулсан. Монгол хэл, бичгийн сургалтын чанарын үнэлгээнд 10-11 дүгээр сард дунд, ахлах ангийн суралцагчдыг хамруулсан. Дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр 2021 оны 10 дугаар сард зохион байгуулсан оношлох үнэлгээний дүнг 2022 оны 5 дугаар сард зохион байгуулсан гүйцэтгэлийн үнэлгээний дүнтэй харьцуулахад монгол хэлний хичээлийн сурлагын амжилт дунд, ахлах ангийн суралцагчдын хувьд 12.0-14.6 хувиар өссөн байна.Үр дүн:Ерөнхий боловсролын 200 сургууль монгол бичгийн кабинетыг шинэчлэн байгуулах, сайжруулах зэргээр сургалтын орчныг бүрдүүлсэн байна. Ерөнхий боловсролын сургуулийн 33138 хүүхдийг шалгалтад хамруулсан. Энэ хичээлийн жилд 2390 багш нийт 8227 цахим хичээл, 15502 цахим хэрэглэгдэхүүн, 5315 контентыг боловсруулж, эх хэлний сургалтад ашигласан. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | 2.3.6. Үндэстний цөөнх монгол хэл болон эх хэлээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх боломжийг бүрдүүлж, хос хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Үндэстний цөөнх монгол хэл болон эх хэлээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх боломжийг бүрдүүлж, хос хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Монгол хэл, эх хэлний сургалтын хөтөлбөрийг туршиж, хэлэлцүүлэн сайжруулж, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулсан байна. | - | Гадаадын зээл, тусламж | Гадаадын зээл, тусламж | 216.0 | БШУЯ Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Үндэсний цөөнхийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын зүгээс хэрэгжүүлж буй Төв Азийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэн хамтран ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Үндэсний цөөнхийн дээд комиссар ноён Кайрат Абдрахманов нар "Монгол Улсын олон хэлт, олон соёлын боловсролыг хөгжүүлэх тухай хамтын ажиллагааны санамж бичиг" -ийг 2021 онд байгуулсан. Энэхүү санамж бичгийн хүрээнд хамтран ажилласнаар Монгол Улсын хос хэлт боловсролын чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үйлажиллагаа үр дүнд хүрч байна. Тус хэлэлцээрийн хүрээнд Төв Азийн улс орнуудад хэрэгжиж буй СХИС (CLIL) арга зүйг туршсан. Энэ ажлын хүрээнд Үндэсний цөөнхийн хүүхдийн боловсролын чанарыг дээшлүүлэх сургалтын хэрэглэгдэхүүнээр суралцагчдыг хангах математик, биологи, байгалийн шинжлэл, дүрслэх урлаг, биеийн тамирын хичээлийн монгол-казах, казах-монгол, монгол-тува, тува-монгол хэл дээр толь бичиг боловсруулан сургалтад хэрэглэж байна. Үндэсний цөөнхийн сурагчдын хос хэлний боловсролын чанарыг ахиулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор "Агуулга ба хэлийг интеграцчилан суралцахуй"-г БСҮХ хичээлийн 2 улирлын турш туршсан. БСҮХ-ээс туршилтын өмнөх судалгаа, Баян-Өлгий аймгийн БШУГ-ын мэргэжилтэн, бага ангийн багш нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, хос хэл дээр хичээл заах туршилтыг 3 ба 5 дугаар сургуульд зохион байгуулж, туршлагыг баримтжуулсан. Туршилтаар 4 ба 6 дугаар ангийн сурагчдын эх хэл ба монгол хэлний ур чадвар ахисан үзүүлэлт гарсан. Тус ажлын хүрээнд монгол хэлний 2-5 дугаар ангийн сурагчдад зориулсан гарын авлага, дасгал ажлын дэвтэр ("Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх)-ийг боловсруулан Баян-Өлгий аймгийн бага ангийн сурагчдын тоогоор хэвлэн түгээсэн. Эх хэлээр боловсрол эзэмшээгүй Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын үндэстний цөөнхийн хүүхдүүд, иргэд (цаатан-тува)-д зориулсан эх хэл соёлын жишиг хөтөлбөр, гарын авлага боловсруулан сургалтад ашиглаж байна. | 100.0 |
| 49 | 2.3.7. Хүүхдийн ялгаатай онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох | Хүүхдийн ялгаатай онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох | Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн онцлог, суралцах чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулж, багш нарыг арга зүйгээр хангаж хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 60.0 | Улсын төсөв | 250.0 | "Сонсголын бэрхшээлтэй хүүхэд сурдаг сургуулийн сургалтын төлөвлөгөө"-г БШУ-ны сайдын 2022 оны А/311 дүгээр тушаалаар баталсан. Сонсголын бэрхшээлтэй хүүхэд суралцдаг тусгай сургуулийн сургалтын төлөвлөгөөг шинэчлэн, сурагчдын хэрэгцээ шаардлагад үндэслэн дохионы хэлний хичээлийн цагийг заавал судлах цагт оруулж долоо хоногт 2-4 цаг, технологийн хичээл долоо хоногт 8 цаг байсныг 2 цаг болгон өөрчилсөн. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах үйл явцыг дэмжих чиглэлээр 2022 онд дараах ажлууд хийсэн. Үүнд:1. "Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, бүрдүүлэх журам" БШУ-ны сайдын тушаалаар батлагдсан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2. Эрүүл мэндийн шалтгаанаар танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй хүүхдэд ганцаарчилсан сургалтаар хичээллэхэд дэмжлэг үзүүлэх монгол хэл, нийгэм ахуйн баримжаа хичээлийн хөтөлбөрийг боловсруулан БШУ-ны сайдын тушаалаар баталгаажуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.3.Харааны бэрхшээлтэй хүүхдийн сурах үйлийг дэмжих зорилгоор харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хэрэглийн зардал авах 250,0 сая төгрөгийн санхүүжилтийг Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоонд шилжүүллээ.4."Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд монгол хэлний хичээлийг хос хэлний арга зүйгээр заах арга зүйн зөвлөмж, монгол дохионы хэлний анхан, ахисан шатны хөтөлбөр боловсруулан 140,6 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.5."Виртуал дохионы хэлний хэлмэрч" аппликейшнийг 249,5 сая төгрөгийн санхүүжилтээр хийсэн.ЖАЙКА олон улсын байгууллагын "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн II шатны хүрээнд "Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах үйлчилгээний загвар"-ыг түгээн дэлгэрүүлэх нийслэлийн 25 цэцэрлэгт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг 2022 оны 4 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлсэн. | 100.0 |
| | | | | Гадаадын зээл, тусламж | - | Гадаадын зээл, тусламж | 390.1 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Гадаадын зээл, тусламж | - | Гадаадын зээл, тусламж | 1,455.0 | танхим байгуулсан. UNICEF олон улсын байгууллагын санхүүжилтээр нийслэлийн цэцэрлэгт хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ үзүүлэх бааз (тогтолцоо, төлөвлөгөө, хүний нөөц зэрэг) бүрдүүлэхээр нийслэлийн 27, бүсийн төвийн 5 аймгийн 11 цэцэрлэгийг хамруулсан. Азийн хөгжлийн банкны Тэгш хамран сургах төслийн хүрээнд Дундговь, Дархан-Уул, Дорнод аймаг, Сонгинохайрхан дүүргийн 4 сургууль, 4 цэцэрлэгийн хүүхэд хөгжлийг дэмжих танхимд 74,4 сая төгрөгийн тавилга, 217,3 сая төгрөгийн компьютер, цахилгаан хэрэгсэл, 287,7 сая төгрөгийн жижиг тоног төхөөрөмж, 10,9 сая төгрөгийн ном, 38,1 сая төгрөгийн тоглоом, 4 цэцэрлэгт 765,8 сая төгрөгийн санхүүжилтээр хараа, сонсгол, харилцаа, суралцахуй, хөдөлгөөн, зан төлөв, сэтгэл хөдлөлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах үйлийг дэмжих сургалтын хэрэглэгдэхүүнийг тус тус нийлүүлсэн. Мөн БШУ-ны сайд, аймаг нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээнд тусгай хэрэгцээт хүүхдийг боловсролд - тэгш хамруулахад сургууль, цэцэрлэгт дэмжлэг үзүүлэх чиглэлээр арга хэмжээ тусгасны дагуу тодорхой үр дүнтэй ажлууд хийгдэж, орон нутгийн 80 гаруй сургууль, 90 гаруй цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хэрэглэгдэхүүнийг нийлүүлсэн байна. | 100.0 |
| 53 | 2.3.11. Сонгинохайрхан дүүрэгт сувиллын цэцэрлэг, сургуулийн барилгыг шинээр барих, ерөнхий боловсролын 25 болон 63 дугаар тусгай сургуулийн барилгыг өргөтгөх ажлыг эхлүүлэх | Сонгинохайрхан дүүрэгт сувиллын цэцэрлэг, сургуулийн барилгыг шинээр барих, ерөнхий боловсролын 25 болон 63 дугаар тусгай сургуулийн барилгыг өргөтгөх ажлыг эхлүүлэх | -Сонгинохайрхан дүүрэгт сувиллын цэцэрлэг, сургуулийн барилгын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийг 70 хувьд хүргэсэн байна. -25 болон 63 дугаар тусгай сургуулийн барилгыг өргөтгөх ажлыг эхлүүлсэн байна. -25 болон 63 дугаар тусгай сургуулийн барилгыг өргөтгөх ажлыг эхлүүлсэн байна. | Улсын төсөв | 4,500.0 | Улсын төсөв | 23,200.0 | Улсын төсвийн 6,819.3 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сонгинохайрхан дүүрэгт баригдах 150 хүүхдийн ортой тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилгын барилга угсралтын ажлын гэрээг "Хүрэл ордон" ХХК-тай 2021 оны 10 дугаар сарын 12-нд байгуулсан. Барилгын каркас угсрах ажил бүрэн хийгдсэн. Зоорины давхрын дулаалгын болон өрлөгийн бэлтгэл хийгдэж байна. Гүйцэтгэлийн хувь 40%, санхүүжилтийн явц 36%-тай байна. Мөн улсын төсвийн хөрөнгөөр Сонгинохайрхан дүүрэгт баригдах тусгай хэрэгцээт 230 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн барилгын тендер зарлагдсан. Тус төсөл арга хэмжээг тус дүүргийн 5 дугаар хороонд хэрэгжүүлэхээр газар чөлөөлж байгаа бөгөөд 24 айлаас 11 айлын газар чөлөөлөгдсөн, 10 айлын газрыг чөлөөлөхөөр ажиллаж байна. Зарим айл нь үнэлгээ тохирохгүй байгаа учраас газраа чөлөөлөхгүй гэсэн хариу ирүүлсэн. Улсын төсвийн хөрөнгөөр Чингэлтэй дүүрэгт баригдах тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга барих гэрээг "Голдендрийм" ХХК-тай 2022 оны 07 дугаар сарын 29-нд байгуулсан. Газар чөлөөлөлт хийгдсэн, зураг төслийг боловсруулж байгаа бөгөөд гүйцэтгэл 15 хувьтай байна. | 50.0 |
| 54 | 2.3.12. Бүх насны иргэд насан туршдаа суралцах боломжийг дэмжих, тэдгээрийн бие даан олж авсан мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах чиглэлээр насан туршийн боловсролын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож өргөжүүлэх | Бүх насны иргэд насан туршдаа суралцах боломжийг дэмжих, тэдгээрийн бие даан олж авсан мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах чиглэлээр насан туршийн боловсролын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож өргөжүүлэх | Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. | - | - | Гадаадын зээл, тусламж | 64.2 | Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Боловсролын ерөнхий хуулийн төсөлд иргэдийн насан туршдаа суралцахуйг дэмжих тогтолцоо бүрдүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулах бие даасан зүйл, заалтыг тусгасан. Тухайлбал: 1.боловсролын бодлого, үйл ажиллагаа нь насан туршийн суралцахуйг дэмжсэн, мэргэшлийн үндэсний шатлалсан бүтцэд үндэслэсэн байх зарчим баримтлах; 2.иргэдийн насан туршдаа суралцах, хөгжих орчин нөхцөлөөр хангах чиг үүргийн аймаг, дүүргийн Засаг дарга хүлээх; 3.иргэний амьдралын орчноос суралцахуйг хүлээн зөвшөөрч, үр дүнг баталгаажуулах, суралцагч судалсан агуулга, хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, чадвараа үнэлүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх, дүйцүүлэх, баталгаажуулах;4.иргэдийн насан туршдаа суралцахуйг дэмжих хүрээнд бичиг үсгийн болон ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулах; 5.иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцан эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах. Мөн "Монгол Улсад насан туршийн суралцахуйг хөгжүүлэн дэмжих нь" төслийг ЮНЕСКО-гийн санхүүжилтээр 2022 оны 10 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд "Насан туршийн суралцахуйн үзэл баримтлал, бодлого" боловсруулж батлуулах, хүний нөөцийн чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах бөгөөд төсөл 2023 оны 11 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэл хэрэгжинэ. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 55 | 2.3.13. Боловсролын цахим шилжилтийн хүрээнд боловсролын салбарын мэдээллийн систем, тоног төхөөрөмж, дэд бүтцийг үе шаттайгаар сайжруулж, цахим сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэх | Боловсролын цахим шилжилтийн хүрээнд боловсролын салбарын мэдээллийн систем, тоног төхөөрөмж, дэд бүтцийг үе шаттайгаар сайжруулж, цахим сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэх | Багшийн үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна. Нийт ерөнхий боловсролын сургуулийг боловсролын салбарын нэгдсэн сүлжээнд холбож, өндөр хурдны интернэт үйлчилгээ үзүүлдэг болсон байна. -Төрийн өмчийн цахим сургууль байгуулж, гадаад улсад амьдарч байгаа иргэдийн хүүхдэд ерөнхий боловсрол эзэмшүүлнэ. -Цахим зөлжит хичээлийн 10000 контент бэлтгэсэн байна. -Төрийн өмчийн 500 цэцэрлэг интернэтэд холбогдсон байна. -Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цахим агуулга баяжсан байна. -Төрийн өмчийн цахим сургууль байгуулж, гадаад улсад амьдарч байгаа иргэдийн хүүхдэд ерөнхий боловсрол эзэмшүүлнэ. -Цахим ээлжит хичээлийн 10000 контент бэлтгэсэн байна. -Төрийн өмчийн 500 цэцэрлэг интернэтэд холбогдсон байна. -Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цахим агуулга баяжсан байна. | Улсын төсөв | 7,500.0 | Улсын төсөв | 2.4 | Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/75 дугаар тушаалаар "Багшийн үндсэн сургалтын нэгдсэн платформ хөгжүүлэх" гүйцэтгэгчийн гэрээнд заасан ажлын хэрэгжилт, үр дүнд дүгнэлт хийж, танилцуулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус платформыг ашиглан ЕБС-д 5, 10 дахь жилдээ ажиллаж буй газар зүй, физикийн багш нарын 4 цахим курс үүсгэн сургалт зохион байгуулж, амжилттай суралцсан 199 багшид цахим батламж олголоо. -Монгол Улсын анхны "Цахим сургууль"-ыг байгуулж, 9 дүгээр сард нээлт хийсэн. 2022-2023 оны хичээлийн жилд 10 дугаар ангийн 16 сонгон судлах хичээлийг цахимаар зохион байгуулах ажил 10 дугаар сарын 3-аас эхэлсэн. Нийт 14,552 суралцагчийг 620 бүлэгт хуваарилан 148 багш цахим хичээлийг явуулж байна. -Нэгдсэн сүлжээний өргөтгөлийн ажлын хүрээнд өнгөрсөн хугацаанд шинээр ашиглалтад орсон, сүлжээний дэд бүтэц очоогүй орон нутгийн болон шилэн кабель нь гэмтэж, тасарсан нийт 291 ерөнхий боловсролын сургуульд шилэн кабель татах, засварлах ажлыг зохион байгуулснаар бүх төрийн өмчийн ЕБС-ийн сүлжээний дэд бүтэц хэвийн ажиллагаатай болсон. -2022 онд цахим санд 2590 контентийг нэмж байршуулсан бөгөөд 5196 контент боловсруулалт, хяналтын шатанд байна. Тус платформд 147 цахим сурах бичиг, 4140 тэлө хичээл, 6-12 дугаар ангийн математик, физик, хими, биологийн хичээлд ашиглах 805 виртуаль лаборатори, эрүүл мэнд, замын хөдөлгөөний чиглэлээр 152 контент, суралцагчдад зориулсан 85 Microsoft 365 цахим хичээл, контент боловсруулах арга зүйн зөвлөмж, насан туршийн боловсрол, цахим үр чадварын 413 контент, хоцрогдол нөхөх арга зүйн зөвлөмжийг бүх ангийн бүх хичээлээр байршуулан багш нар хичээл сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. -Төрийн өмчийн цэцэрлэгийн 70 хувь нь буюу 680 цэцэрлэг интернэтэд холбогдсон. Цаашид боловсролын салбарын нэгдсэн сүлжээнд холбох ажлыг хийхээр суурь судалгааг хийж байна. | 100.0 |
| 56 | 2.3.14. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Насан туршийн боловсролын үндсэний төвийг шинэчлэн зохион байгуулж, боловсролын судалгаа, шинжилгээ, сургалт, үнэлгээний байгууллагын чиг үүргийг оновчтой болгох | Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Насан туршийн боловсролын үндсэний төвийг шинэчлэн зохион байгуулж, боловсролын судалгаа, шинжилгээ, сургалт, үнэлгээний байгууллагын чиг үүргийг оновчтой болгох | Боловсрол, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ, сургалт, үнэлгээ, насан туршийн боловсролын байгууллагын хууль, эрх зүйн орчин бүрдэж, үйл ажиллагаа хэрэгжиж эхэлсэн байна. Хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна. | - | - | - | - | Боловсролын эрдэм шинжилгээ, сургалт, арга зүйн болон үнэлгээний байгууллагын чиг үүргийг оновчтой болгох хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээ: 1.Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Насан туршийн боловсролын үндсэний төвийг нэгтгэн Засгийн газрын 2021 оны 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Боловсролын ерөнхий газар"-ыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, үйл ажиллагаа нь 2022 оны 1 сараас эхлүүлэв. Агентлаг нь боловсролын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. 2.Засгийн газрын 2021 оны 407 дугаар тогтоолоор "Боловсролын хүрээлэн"-г "Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн" болгон өөрчлөн зохион байгуулж, дүрэм, зохион байгуулалтын бүтцийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/10 дугаар тушаалаар баталлаа. Хүрээлэн боловсролын хөгжлийн онол, арга зүйн судалгааны ажил эрхлэх, боловсролын шинэчлэл, өөрчлөлтийн чиг хандлагыг тодорхойлох, боловсролын инновац хөгжүүлэх, судалгаа, шинжилгээний үр дүнгийн мэдээллээр үйлчлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. 3.Боловсролын үнэлгээний төвийн чиг үүргийг өргөжүүлж, дүрэм, зохион байгуулалтын бүтцийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/21 дүгээр тушаалаар шинэчлэн баталлаа. Төв нь боловсролын бүх түвшний үнэлгээ, шалгалт зохион байгуулах, үнэлгээний удирдлага, мэдээллийн цахим сан бүрдүүлэх; олон нийтийг мэдээллээр хангах зэрэг чиг үүрэг хэрэгжүүлнэ. Боловсролын мэргэжлийн байгууллагын чиг үүргийг оновчтой болгосноор боловсролын судалгааны хүрээ өргөжсөн; боловсролын бодлогын хэрэгжилтийг үндэсний хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах боломж бүрдсэн; үнэлгээний байгууллага зөвхөн ЕБС-ийн суралцагчийн үнэлгээнд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байсан бол боловсролын бүх түвшний суралцагч, багш, байгууллагын үнэлгээний асуудлыг цогцоор нь авч үзэх шийдэл, арга хэмжээ хэрэгжүүлдэг болсон зэрэг үр дүн гарч байна. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 57 | 2.3.15. Дээд боловсролын чанарын тогтолцоо, судалгааны чадавхыг олон улсын жишиг, туршлагад үндэслэн сайжруулж, хууль, эрх зүйн орчныг шинэчлэх | Дээд боловсролын чанарын тогтолцоо, судалгааны чадавхыг олон улсын жишиг, туршлагад үндэслэн сайжруулж, хууль, эрх зүйн орчныг шинэчлэх | -Хууль, эрх зүйн орчинтой уялдуулан 5 дүрэм, журмыг шинэчлэн боловсруулсан байна. -Судалгааны чадавхыг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулж, 200 багш, албан хаагчийг хамруулсан байна. -Судалгааны чадавхыг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулж, 200 багш, албан хаагчийг хамруулсан байна. | Улсын төсөв | 500.0 | - | - | УИХ-д өргөн барьсан Дээд боловсролын тухай хуулийн төсөлд дээд боловсролын салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчлэх зорилгоор Судалгааны их сургуулийн эрх зүйн орчин, зохицуулалт (судалгааны их сургуульд тавигдах шаардлага, шалгуур, тусгай зөвшөөрөл олгох, удирдах зөвлөл, удирдлага, санхүүжилт)-ын төсөл, судалгаа, эрдэм шинжилгээ, оюутны өмч, ёс зүйтэй холбоотой зохицуулалтын хувилбарыг тусгасан. Багш нарын судалгааны чадавхыг сайжруулах чиглэлээр "Инженер, технологийн дээд боловсрол" төслийн хүрээнд Япон Улсын 4 их сургуулийн докторын хөтөлбөрт 2022 оны 10 дугаар сараас 5 докторантыг суралцуулахаар илгээсэн. 2022 онд салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр дараах дүрэм, журмыг боловсруулан батлууллаа. Үүнд: БШУ-ны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулсан. БШУ-ны сайдын 2022 оны А/47, А/138 дугаар тушаалаар их сургуульд элсэлтийн ерөнхий шалгалтын 480, дээд сургуульд 440, коллежид 400, орон нутгийн их, дээд сургуульд 410 онооттой элсэхээр тогтоосон. БШУ-ны сайдын 2022 оны А/160 дугаар тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индексийг баталсан. Мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн баталсантай холбогдуулан 88 их, дээд сургуулийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт, шинжилгээ хийж, БШУ-ны сайдын 2022 оны А/296 дугаар тушаалаар 21 их, дээд сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. "Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм"-ийн төслийг боловсруулан их сургуулиудаас санал авсан. Дүрмийн төсөлд докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн чиглэлийг батлан зөвлөлийн чиг үүргийг тогтоож, зөвлөлийн түшиглэх сургуульд тавигдах шаардлагыг шинэчлэн тусгасан. Их дээд сургуулиудын сургалтын чанар, стандартыг баталгаажуулах, сайжруулах зорилгоор хэрэгжиж байгаа "Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоо хөтөлбөр"-ийн хүрээнд 5 багц сургалтад их, дээд сургуулийн 300 гаруй багш, судлаач хамрагдсан. | 100.0 |
| 58 | 2.3.16. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдыг сургууль дээр ундны ус уух боломжийг бүрдүүлэх | Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдыг сургууль дээр ундны ус уух боломжийг бүрдүүлэх | Нийт сургуулийн 50 хувьд ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулсан байна. | Улсын төсөв | 500.0 | Улсын төсөв<br>Гадаадын зээл, тусламж | 78.4<br>112.7 | 2022 онд улсын төсөв болон олон улсын байгууллагын санхүүжилтээр 128 сургуульд стандартын шаардлага хангасан ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлж үлдсэн сургуулиудад НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр ус цэвэршүүлэгч төхөөрөмж нийлүүлэхээр төлөвлөсөн. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургууль дээр стандартын шаардлага хангасан ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд 2022 онд батлагдсан төсвийн хүрээнд нийт 78.4 сая төгрөгийн үнэ бүхий ус цэвэршүүлэгч худалдан авахаар техникийн тодорхойлолтыг боловсруулж, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах захиалгыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлснээр 44 сургуульд 50.0 сая төгрөгийн 144 ширхэг, 30 сургуульд 78.4 сая төгрөгийн 80 ширхэг ус шүүгч төхөөрөмжийг тус тус нийлүүлсэн. Мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Завхан, Баянхонгор, Говь-Алтай аймгийн 98 сургуульд 112.7 сая төгрөгийн 145 ширхэг ус шүүгч төхөөрөмж нийлүүлсэн. Энэхүү ажлын үр дүнд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт ерөнхий боловсролын сургуулиудын 40 гаруй хувьд ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулсан. Дорнод, Увс зэрэг аймгийн сумдын ерөнхий боловсролын сургуулиуд эцэг эхийн оролцоотойгоор суралцагчид сургууль дээрээ ундны ус уух боломжийг бүрдүүлсэн байна. | 90.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 59 | 2.3.17. Цэцэрлэг, сургуулийн хүчин чадал, бүтэц, барилгын насжилт, байршлыг оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан ерөнхий боловсролын 50 сургууль, 60 цэцэрлэгийг барьж ашиглалтад оруулах | Цэцэрлэг, сургуулийн хүчин чадал, бүтэц, барилгын насжилт, байршлыг оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан ерөнхий боловсролын 50 сургууль, 60 цэцэрлэгийг барьж ашиглалтад оруулах | Шинээр ерөнхий боловсролын 50 сургууль, 60 цэцэрлэг ашиглалтад оруулсан байна. | Улсын төсөв | 417,008.5 | Улсын төсөв | 7,100.0 | Боловсрол, шинжлэх ухааны яамнаас салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хамран сурах тойрог, кластер системийг шийдвэр гаргах түвшинд оновчтой болгох зорилгоор Газар зүйн мэдээллийн системд тулгуурласан бодлого, төлөвлөлтийн системийг 2022 оны 3 дугаар сараас үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү ажлыг "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах" төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа бөгөөд систем хөгжүүлэгчээр "Зион" ХХК ажиллаж байна. Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд хүргүүлж буй салбарын хөрөнгө оруулалтын шинэ төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг энэхүү газар зүйн мэдээллийн системд тулгуурласан шинжилгээгээр боловсруулж, Сангийн яаманд хүргүүлсэн. 2023 оны улсын төсвийн төсөлд нийт 477 шинэ төсөл, арга хэмжээний санал ирүүлснээс GIS шинжилгээгээр 88 төсөл, арга хэмжээг нэн шаардлага, хэрэгцээтэй гэж шинжилгээ хийж, Сангийн яам болон Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 200 сургууль, 273 цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулах зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Боловсрол, шинжлэх ухааны салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 оноос эхлэн хэрэгжиж байгаа 74740 хүүхдийн суудал бүхий 162 сургууль, 29335 хүүхдийн ор бүхий 189 цэцэрлэгийн барилга байна. Үүнээс Төсвийн тухай хуулиар 2022 онд ашиглалтад орохоор 117 сургуулийн барилга, 138 цэцэрлэгийн барилга төлөвлөгдсөн боловч 2022 оны эцэст 33 сургуулийн барилга, 41 цэцэрлэгийн барилга тус тус ашиглалтад орсон. Гадаад зээл тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа 9 сургууль, 18 цэцэрлэгийн барилгаас 2022 онд 2 сургууль, 2 цэцэрлэгийн барилга ашиглалтад орж нийт 35 сургууль, 43 цэцэрлэг ашиглалтад орсон. | 70.0 |
| 60 | 2.3.18. Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлж, өдөрт авбал зохих илчлэг, шим тэжээлийн хэрэгцээг хангахуйц хоолоор үйлчлэх | Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлж, өдөрт авбал зохих илчлэг, шим тэжээлийн хэрэгцээг хангахуйц хоолоор үйлчлэх | Хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх боломж бүрдсэн байна. Цэцэрлэгийн 289144 хүүхэд, дотуур байрны 38000 хүүхэд хамрагдсан байна. | Улсын төсөв | 35,240.0 | Улсын төсөв | 72,400.0 | БШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын "Норматив батлах тухай" А/166, А/559, 222 дугаар хамтарсан тушаалаар "Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалт", "Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ", "Ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ"-г баталсан. 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд 35077, цэцэрлэгт 266024 хүүхэд хамрагдаж хоол хүнсээр үйлчилж байна. 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар ерөнхий боловсролын сургууль мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх асуудлыг хэлэлцэж дэмжигдэн "Хоолны зардлын норматив батлах тухай" Засгийн газрын тогтоол гарсан. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны ахлах ангийн нэг хүүхдийн хоолны зардлыг 4300 төгрөгөөр, бага, дунд ангийн хүүхдийн хоолны зардлыг 4000 төгрөгөөр тус тус тогтоосон. Хоолны зардал нэмэгдүүлсэнтэй холбон гарах нэмэлт зардлыг 2023 оны төсөвт багтаан санхүүжүүлэхийг БШУ-ны сайд, Сангийн сайдад тус тус даалгасан. Мөн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдийн хоолны зардлын нормативын тодорхой хувь хэмжээг эцэг эх, асран хамгаалагчаас төвлөрүүлэх, зарцуулах, хяналт тавихад баримтлах аргачлалыг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг БШУ-ны сайдад даалгасан. 2022-2023 оны хичээлийн жилд дотуур байранд 35077, цэцэрлэгт 266024 хүүхэд хамрагдаж хоол хүнсээр үйлчилж байна. Сургуулийн өмнөх боловсролд хүүхэд бүрийг хамруулах ажлыг амжилттай зохион байгуулж ажилласан. | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 61 | | 2.3.19. Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд хамруулах, нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативыг шинэчлэх, мэргэжлийн хүний нөөцөөр хангах | Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд хамруулах, нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативыг шинэчлэх, мэргэжлийн хүний нөөцөөр хангах | 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн суралцагчдыг, 2022-2023 оны хичээлийн жилээс дунд ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд бүрэн хамруулсан байна. | - | - | Улсын төсөв | 66,700.0 | 2022-2023 оны хичээлийн жилд бага ангийн 371480 сурагч үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж байгаа бөгөөд Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар дунд ангийн сурагчдын үдийн хоолны үйлчилгээнд шилжих хугацаар хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин бүрдэх хүртэл үе шаттайгаар эхлүүлэхээр шийдвэрлэсэн. ЕБС-ийн үдийн хоолны болон дотуур байрны нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативийг шинэчлэх ажлын хүрээнд хоолны бодит зардлыг тооцоолох, өртгийг тооцох, өрхийн ам зүй, нийгэм эдийн засгийн онцлогоос хамаарч эцэг эх, асран хамгаалагч зардлыг хариуцах хувилбар шинжилгээ хийх, зөвлөх үйлчилгээг зарласан. 2022 оны 11 сарын байдлаар төрийн өмчийн сургуулиудад 75 хоол зүйч /19 аймагт 47, нийслэлд 28 сургууль/, 1652 тогооч ажиллаж байгаа бөгөөд БШУЯ, Боловсролын дэлхийн түншлэл олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй "Тэгш боломжоор хангах замаар суралцахуйг дэмжих" төслийн хүрээнд орон нутгийн болон тусгай сургуульд ажиллах 28 хүнийг хоол зүйчийн хөрвүүлэх сургалтад хамруулж, 15 хүн тухайн сургуульдаа ажиллаж байна. - Мэргэжилтэй хүний нөөц бэлтгэх зорилгоор сургуульд ажиллаж буй мэргэжлийн үнэмлэхгүй тогооч нарын ур чадвахыг үнэлж, гэрчилгээ олгох ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институттэй, хоол зүйчийг хөрвүүлэн бэлтгэх богино хугацааны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн агуулгыг боловсруулах ажлыг ЖАЙКА олон улсын байгууллагатай тус тус хамтран хэрэгжүүлж байна.2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар ерөнхий боловсролын сургууль мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх асуудлыг хэлэлцэж дэмжигдэн "Хоолны зардлын норматив батлах тухай" Засгийн газрын тогтоол гарсан. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны ахлах ангийн нэг хүүхдийн хоолны зардлыг 4300 төгрөгөөр, бага, дунд ангийн хүүхдийн хоолны зардлыг 4000 төгрөгөөр тус тус тогтоосон. | 70.0 |
| 62 | | 2.3.20. Зориулалтын хоол үйлдвэрлэлийн байргүй ерөнхий боловсролын 18 сургуульд шинээр өргөтгөл барих, 225 сургуулийг стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангах | Зориулалтын хоол үйлдвэрлэлийн байргүй ерөнхий боловсролын 18 сургуульд шинээр өргөтгөл барих, 225 сургуулийг стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангах | Ерөнхий боловсролын сургуулиудад хоол үйлдвэрлэлийн аюулгүй орчин бүрдсэнээр эрүүл, шим тэжээллэг хоол хүнсээр хангах нөхцөл бүрдэнэ. | - | - | Улсын төсөв<br>Төр-хувийн хэвшлийн түншлэл | 1,170.0<br>1,000.0 | 2022 онд нийслэлийн Баянгол дүүрэгт 4, Баянзүрх дүүрэгт 2, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт тус бүр 1, Архангай, Булган, Завхан, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймагт тус бүр 1, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай аймагт тус бүр 3, Увс, Хэнтий аймагт тус бүр 2, Хөвсгөл аймагт 5, нийт 38 сургуулийн барилга бүрэн ашиглалтад орж, зориулалтын хоол үйлдвэрлэлийн байртай болсон. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн хоол үйлдвэрлэлийн стандартыг хангах ажлын хүрээнд 183 сургууль, цэцэрлэгийг 1,17 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 17 нэр төрлийн гал тогооны тоног төхөөрөмжөөр хангасан. Жайка олон улсын байгууллагын "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төсөл"-ийн хүрээнд Өвөрхангай аймгийн 2, Дундговь аймгийн 2, нийслэлийн 2, нийт 6 сургууль загвар сургуулиар сонгогдон загвар сургуулиудын гал тогооны тоног төхөөрөмж, хоол шим тэжээлийн судалгааг хийж төслийн хүрээнд дээрх сургуулиудыг хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр хангасан. БШУЯ, Боловсролын дэлхийн түншлэл олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй суралцахуйг дэмжих төслийн хүрээнд нийслэлийн 15 сургуульд гал тогооны нэмэлт болон иж бүрэн тоног төхөөрөмж олгосон. 2022 онд улсын төсөв болон олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр нийт 204 сургууль стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Үүний дүнд ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид аюулгүй орчинд эрүүл, шим тэжээллэг хоол хүнсээр хангагдах нөхцөл бүрдсэн. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 63 | 2.4. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна. | 2.4.1. Судалгааны үр дүнд бий болсон бүтээлийг олон улсад бүртгүүлэх, дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн чанарыг нэмэгдүүлэх шинжлэх ухааны үйлчилгээг үзүүлж, шилдэг бүтээлийг урамшуулах | Судалгааны үр дүнд бий болсон бүтээлийг олон улсад бүртгүүлэх, дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн чанарыг нэмэгдүүлэх шинжлэх ухааны үйлчилгээг үзүүлж, шилдэг бүтээлийг урамшуулах | -Судалгааны үр дүнд бий болсон шинэ мэдлэг, патентын мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, патент эзэмшигчид мөнгөн урамшуулал олгосон байна. -Олон улсын болон дотоодын судалгааны үр дүнд бий болсон шинэ мэдлэг, мэдээллийг ашиглах лицензийн гэрээний төлбөрийг төлсөн байна. -Эрдэм шинжилгээний байгууллагуудад эрх олгож, судлаачдын хандалтын тоог нэмэгдүүлсэн байна. -Олон улсын хянан магадалгаа хийгддэг сэтгүүлүүд дэх монгол эрдэмтдийн бүтээл, эшлэлийн тоо тус бүр нэмэгдэж, шилдэг бүтээл шалгаруулах журмын хэрэгжилтийг хангасан байна. | Улсын төсөв | 500.0 | Улсын төсөв | 323.4 | Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын гэрчилгээ 2022 онд нийт 123 патент, шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон 35 шинэ технологи, 76 шинэ биет бүтээгдэхүүнийг баталгаажуулсан. 2015 онд Springer хэвлэлийн газар, 2016 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Research 4Life хөтөлбөр, 2018 онд EBSCO хэвлэлийн газартай байгуулсан лицензийн гэрээний хугацаа дууссан байсныг 2021-2026 он хүртэл сунгаж шинэчилсэн. Ингэснээр их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд консорциум хэлбэрээр хөнгөлөлттэй үнээр гэрээ хийх нөхцөл бүрдэж 2022 онд нийт 4 мэдээллийн сангийн лицензийн төлбөрт 258,4 сая төгрөгийг төлсөн. Шинжлэх ухааны академи, салбарын хүрээлэнгүүд, МУИС, ШУТИС, ХААИС, АШУҮИС, СУИС гэсэн байгууллагын эрдэмтэн судлаачид олон улсын эрдэм шинжилгээний мэдээллийн сангуудаас хэрэгтэй мэдээлэл авч, судалгаа шинжилгээний ажилдаа ашиглах боломж бүрдсэн. Олон улсын эрдэм шинжилгээний цахим мэдээллийн санд Монголын судлаач эрдэмтэн, багш нарын хандалт өмнөх оноос 20 гаруй хувиар нэмэгдсэн байна. Гадаадаас Монголын эрдэмтдийн 7282 бүтээлээс 108572 удаа эшлэл авч Н индекс 118-д хүрсэн байна.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/141 дүгээр тушаалаар баталсан "Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулж, урамшуулах журам"-ын дагуу 2022 оны шилдэг бүтээлд 6 бүтээлийг шалгаруулж бүтээл тус бүрд 10,0 сая төгрөгийн урамшуулал олгосон. Эрдэм шинжилгээний өгүүлэл, сэтгүүлийг чанаржуулж, олон улсад өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/464 дүгээр тушаалаар эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн редакцын багийг чадавхжуулах дотоод, гадаадад өрсөлдөхүйц, хүлээн зөвшөөрөгдсөн Монгол улсын сэтгүүлийг тоог нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээний ажилтнуудыг олон улсад бүтээлээ нийтлүүлэхэд дэмжин чадавхжуулах, бүтээлийн хуулбарлалт, судлаачдын ёс зүйн чиглэлээр сургалтууд зохион байгуулж шинжлэх ухааны салбарын 68 эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн удирдах ажилтан, нийт 100 гаруй судлаач хамрагдсан. | 100.0 |
| 64 | | 2.4.2. Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, инновацын тэргүүлэх чиглэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи, судалгаа хөгжүүлэлтийн чанар, хүртээмжийг дээшлүүлэх | Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, инновацын тэргүүлэх чиглэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи, судалгаа хөгжүүлэлтийн чанар, хүртээмжийг дээшлүүлэх | -Төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилт, 11 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. -Инновацын тэргүүлэх чиглэлээр 10-15 инновацын төсөл хэрэгжүүлсэн байна. -10-аас доошгүй инновацын грант олгосон байна. | Улсын төсөв | 2,000.0 | Улсын төсөв | 930.0 | Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор "Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр" хүчингүй болсон. Инновацын тухай хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд 2020 оны 95 дугаар тогтоолоор баталсан инновацын үйл ажиллагааны тэргүүлэх 5 салбар, 11 технологийн чиглэлд судалгаа хөгжүүлэлтийн ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх, гүйцэтгэл үр дүнд суурилан санхүүжүүлэх ажлыг зохион байгууллаа. Энэ хүрээнд: Засгийн газрын 2018 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам"-ын дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/347 дугаар тушаалаар инновацын тэргүүлэх чиглэлийн 6 төсөлд нийт 360.0 сая төгрөгийн грант олгосон. Докторын зэрэг хамгаалсан залуу судлаачдад бие даан судалгааны ажил хийж шинэлэг, бүтээлч санал санаачилга дэвшүүлэн инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор туршилт, зохион бүтээх үйл ажиллагааг дэмжин Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/367 дугаар тушаалаар 10 инновацын төсөлд нийт 100.0 сая төгрөгийн грант олголоо. Мөн 2022 онд үргэлжлэн хэрэгжих технологийн туршилт зүгшрүүлэлтийн 7 төсөлд 120,0 сая төгрөг, шинээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн 2022 оны төсөл батлах, санхүүжүүлэх тухай" А/282 дугаар тушаалаар 22 төсөлд 350.0 сая төгрөгийн санхүүжилт олгож тухайн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн. Жилийн эцсийн байдлаар инновацын тэргүүлэх чиглэлээр 16 төсөл шинээр , 7 төсөл үргэлжлэн хэрэгжиж байна. Мөн инновацын 16 төсөлд грант олгосон. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 65 | 2.4.3. Нээлттэй, нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулж салбар дундын судалгааны ажлыг хэрэгжүүлж эхлүүлэх | Нээлттэй, нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулж салбар дундын судалгааны ажлыг хэрэгжүүлж эхлүүлэх | -Лабораториудын нэгдсэн сүлжээг байгуулж, үндсэний мэдээллийн санг бүрдүүлсэн байна. -Кластерын нутаг дэвсгэр дээрх лабораторийн зориулалтай барилгыг ашиглалтад оруулсан байна. -Шинжлэх ухаан, технологи, инновацын кластер, их сургуулиудыг түшиглэн нэгдсэн, төрөлжсөн 2 лабораторийг байгуулж хөгжүүлсэн байна. | Улсын төсөв | 5,000.0 | Улсын төсөв | 20,000.0 | Салбар дундын нээлттэй, сүлжээ лабораторийн итгэмжлэлийн техникийн шаардлага хангасан судалгааны нээлттэй, дундын болон сүлжээ лабораторийн стандарт, эрх зүйн байдлын судалгааг хийсэн. Судалгааны үр дүнд Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй 54 байгууллагын 311 лабораторийг хамруулж, лабораториудын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг боловсруулсан. Судалгааны хүрээнд нээлттэй, дундын болон сүлжээ лаборатори ажиллуулах журмын төслийг боловсруулж, санал авах ажлыг зохион байгуулсан. Баянзүрх дүүргийн 12 дугаар хороонд 4.8 га талбай бүхий газарт 72,000 м.кв ашиглалтын талбайтай, оффис, лаборатори, музей, хэвлэх үйлдвэр, агуулах, спорт цогцолбортой шинжлэх ухаан, технологи, инновацын кластерийн 7 блок барилгын ажил үргэлжлэн явагдаж байна. Гүйцэтгэгчээр "Нуттийн буян" ХХК ажиллаж байгаа бөгөөд гэрээ байгуулснаас хойш 2020 онд 3,0 тэрбум, 2021 онд 24,0 тэрбум, 2022 онд 20,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон. 2023 онд бүрэн ашиглалтад орсноор кластер /нэгдсэн цогцолбор/-ын барилгын 27,000 м.кв талбай бүхий лабораторийн 3 корпус бүрэн ашиглалтад орж, судалгаа хийх олон улсын стандарт шаардлага хангасан нэгдсэн сүлжээ лабораториудыг бүрэн хүчин чадлаар ашиглах нөхцөл хангагдана. 2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчийн 7 их сургууль /МУИС, ШУТИС, АШУҮИС, ХААИС, МУБИС, ҮБХИС, ХСИС/-ийн дэргэд 103 туршилт, судалгааны лаборатори шинжлэх ухааны салбар бүрээр судалгаа шинжилгээ, туршилтыг бүрэн хүчин чадлаар хийж байна. | 90.0 |
| 66 | 2.4.4. Шинжлэх ухаан, инновацын салбарын төсвийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар салбарын өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх | Шинжлэх ухаан, инновацын салбарын төсвийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар салбарын өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх | Эрдэм шинжилгээний байгууллагын нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах бодит хувь нэмрийг өсгөж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлсэн байна. Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувийг 0.54 хувьд хүргэсэн байна. | Улсын төсөв | 12,000.0 | - | - | 2022 оны төсвийн тодотголоор эрдэм шинжилгээний зардлыг төсвийн хэмнэлттэй холбоотойгоор 5,0 тэрбум, шинжлэх ухаан, салбарын хөрөнгө оруулалтыг 18,0 тэрбумаар танасан нь судалгаа хөгжүүлэлтийн ажлын чанар үр дүн, салбарын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл болон эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 0.54 хувьд хүргэх зорилтот түвшинд хүрэх боломжийг хязгаарласан. Хэдийгээр хязгаарлагдмал орсон ч салбарын зүгээс 2022 онд шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд чиглэсэн шинэчлэлийн 6 зорилт, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүллээ. Үүнд: Гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг тогтоож, "Шинжлэх ухаан технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам", "Эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, санхүүжүүлэх журам"-ын төслийг тус тус боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн батлуулсан. Энэхүү арга хэмжээний үр дүнгээр эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийг үр дүнд суурилан санхүүжүүлсэн нь шинжлэх ухаан технологи, инновацын тэргүүлэх чиглэлд судалгааны төсөл зарлан, сонгон шалгаруулах зарчмаар өрсөлдөөнт санхүүжилт бүхий судалгааны дэмжлэг авах нөхцөл бүрдсэн. Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувийг 0.11 хувь /Төсвийн хэмнэлт, салбараас үл хамаарах шалтгаанаар/ 2023 оны төсвийн хязгаарт зорилтот түвшинд хүргэх тооцоололд үндэслэн эрдэм шинжилгээ, судалгааны зардлыг одоогийн байгаа түвшнээс хамгийн багадаа 4 дахин нэмэгдүүлэхээр санал өгсөн ч улс орны эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан судалгаа хөгжүүлэлтэд зарцуулах төсвийн зардал 13,0 тэрбум төгрөгөөр батлагдсан. | 70.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 67 | | 2.4.5. Шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, эрдэм шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлэх | Шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, эрдэм шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлэх | Хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын болон гадаад улсын эрдэмтэдтэй мэдлэг, туршлага солилцох, хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлсэн байна. Судлаачдын эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх чадавх, судалгааны үр дүн сайжирсан байна. | Улсын төсөв | 2,500.0 | - | - | ШУА-тай хамтран хүрээлэнгүүдээс гадаадад сурч, ажиллаж буй эрдэмтдийн судалгааг гарган 3 зорилго 16 зорилт бүхий "Чадварлаг эрдэмтэн хөтөлбөр"-ийг боловсруулсан. БШУЯ-аас хилийн чанадад нарийн мэргэжлийн, академик ажил эрхэлж байгаа монголчуудын оюуны урсгалыг эргүүлэн татаж, Монгол Улсын эдийн засаг нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх зорилгоор Солонгос улсад 2 удаа, Франц улсад нэг удаа тухайн улсад сурч, ажиллаж, амьдарч буй эрдэмтэн судлаачдыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан.Засгийн газрын 2021 оны 299 дүгээр тогтоолоор 5 хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтны тоог шинээр улсын төсөвт оруулан баталснаар 2022 онд шинжлэх ухааны ажилтны тоо 108-аар нэмэгдсэн. Ахисан түвшний буюу магистр, докторын сургалтад хамрагдаж байгаа эрдэм шинжилгээний ажилтны эрдэм шинжилгээний багц цагийн 50 хувийг ажилласан цагт нь тооцож хөнгөлөх тухай санамж бичгийг Шинжлэх ухааны академи, МУИС, ШУТИС хамтран байгуулж, хэрэгжүүлж эхэлсэн. Тухайн 2 сургуулийн ахисан түвшний сургуульд 130 гаруй докторант эрдэм шинжилгээний ажилтан байгаагаас шаардлага хангасан 17 докторант хөнгөлөлтөд хамрагдсан. Орон нутгийн түвшинд шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр 4 аймагт "Шинжлэх ухаан, технологийг түгээн дэлгэрүүлэх аян" зохион байгуулсан, 2022 оны 9 дүгээр сард 21 аймаг, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга, шинжлэх ухаан, технологи, инновац, дээд боловсрол, мэргэжлийн боловсрол, сургалт хариуцсан мэргэжилтнүүдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх цахим сургалтыг зохион байгуулж 60 орчим албан хаагчийг чадавхжууллаа. | 100.0 |
| 68 | 2.5. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ. | 2.5.1. Нийгмийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх | Нийгмийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх | Нийгмийн даатгалын багц хууль батлагдсан байна. | - | - | - | - | Тэтгэврийн шинэчлэл хийх, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх, хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ дахь олонхийн бүлгээс "Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ" гэсэн бодлоготой уялдуулан нийгмийн даатгалын багц хуулийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн. Энэхүү чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлсэн болович Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн төслүүдийг дахин буцаан авч, үзэл баримтлал, тандан судалгааг боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн. Түүнчлэн хуулийн төслийг шинэчлэн боловсруулсан үзэл баримтлалд нийцүүлэн дахин боловсруулж, Засгийн газрын гишүүд болон холбогдох байгууллагуудаас санал авахаар хүргүүлээд байна. Нийгмийн даатгалын багц хуулийн төсөлд Монгол Улс олон давхаргат тэтгэврийн тогтолцоотой байхаар, одоо мөрдөгдөж буй эв санааны нэгдлээс хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих, нийгмийн даатгалаас олгох тэтгэвэр нь даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа, төлсөн шимтгэлийн хэмжээтэй уялдаатай байх, мөн санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байдлыг хангасан байх зэрэг зарчимд үндэслэн боловсруулсан. | 70.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 69 | 2.5.2. Ажилтныг бүтэн бус цагаар, зайнаас, уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалтыг бий болгох | Ажилтныг бүтэн бус цагаар, зайнаас, уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалтыг бий болгох | Ажилтныг бүтэн бус цагаар, зайнаас, уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалтыг бий болгосон байна. | - | - | - | - | УИХ-аас 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад ажилтныг бүтэн бус цагаар, зайнаас, уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалтыг шинээр тусгасан. Ингэснээр ажил олгогч, ажилтан хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлтэй тохируулан ажлын уян хатан зохицуулалтыг хэрэглэх боломж бүрдсэн. Тухайлбал ажлын бүтэн бус цагаар ажиллах ажилтны долоо хоногт ажиллах цаг 32-оос илүүгүй байна. Бүтэн бус цагаар ажиллах ажилтан нь бүтэн цагаар ажиллаж байгаа ажилтны нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин нөхцөлөөр хангуулах, цалингийн нэгжийн үнэлгээ ижил ажлын байранд бүтэн цагаар ажилладаг ажилтныхаас багагүй байх, ажилласан хугацаанд тохирсон ээлжийн амралт, нэмэгдэл хөлс авахаар заасан. Уртын ээлжийн хувьд ажиллах, амрах дээд доод хязгаарыг зааж, энэ хооронд ажилтан, ажил олгогч харилцан тохиролцох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр ажил, амралтын горим, уртын ээлжээр ажилласны нэмэгдэл зэргийг тогтоох боломжийг олгосон. Гэрээс, зайнаас ажиллах, иргэд хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулах шинэ зохицуулалт тусгагдсан. | 100.0 |
| 70 | 2.5.3. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэн цахимжуулж, e-job платформыг нэвтрүүлж, цахим хөдөлмөрийн биржийг бий болгох | Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэн цахимжуулж, e-job платформыг нэвтрүүлж, цахим хөдөлмөрийн биржийг бий болгох | -Хөдөлмөр зуучлалын цахим программ хангамжийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаатай холбосон байна. -Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллахад дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн биржийг бий болгоно. | Гадаадын зээл, тусламж<br>Улсын төсөв | 2,820.0<br>250.0 | Гадаадын зээл, тусламж | 755.7 | Дэлхийн банкны "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл"-ийн санхүүжилтээр Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем "Ejob" платформыг нэвтрүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/126 дугаар тушаалаар ажлын хэсэг, дэд ажлын хэсгийг байгуулсан. Үүний дагуу харьяа агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд, холбогдох бусад байгууллагын төлөөллийг оролцуулан нийт 32 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. Ажлын хэсгээс бизнес шинжилгээний өнөөгийн 85 зураглал, ирээдүйн 72 зураглалыг гаргаж баталгаажуулсан. "Ejob" платформ нь 3 дэд систем 13 модулиас бүрдэх бөгөөд программ хөгжүүлэлтийн ажлыг 2022 оны 02 сараас эхлүүлсэн. Дэлхийн банкны IT зөвлөх Ашиш 2022 оны 03, 09 саруудад манай улсад ирж ажиллах үезр програм хөгжүүлэлтийн ажил ерөнхийдөө ахиц гарсныг тэмдэглээд цаашид хийх үйл ажиллагааны хэрэгжилтийн эрчийг сулруулахгүй энэ хэвээр хадгалж үлдэхийг зөвлөсний дагуу нарийвчлан төлөвлөгөө боловсруулж, батлуулан, оролцогч талуудад 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01/1572 тоо албан бичгээр оролцогч талуудад хүргүүлсэн. Шинэ систем нь "ХУР", "ДАН" зэрэг төрийн бусад мэдээллийн системтэй холбогдож, хэрэглэгч бүрийн хэрэгцээнд тохируулан хөгжүүлж, хүндрэл бэрхшээлийг технологийн шийдлээр оновчтой шийдвэрлэхээр зорьсон. Уг системийг 21 аймаг, 9 дүүргийн сум, хороодын түвшинд ажил хайгчид, төрийн болон төрийн бус байгууллагуудын хүний нөөцийн 1 сая гаруй хэрэглэгч ашиглах юм. Системийн нэвтрүүлэлттэй холбоотойгоор Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газар болон аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн нийт 301 албан хаагчдыг хамруулсан 2 өдрийн сургалтыг 2022 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотод зохион байгуулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хөдөлмөр эрхлэлтийн цахим систем "Ejob" платформын эхний модуль буюу онлайн порталыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ашиглалтад оруулсан. | 90.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 71 | 2.5.4. Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үйлчилгээг ил тод, нээлттэй болгон цахимжуулах | Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үйлчилгээг ил тод, нээлттэй болгон цахимжуулах | ezuvshuurul.mn цахим системийг бүрэн нэвтрүүлж, нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийгдсэн байна. E-job платформд нэгтгэсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 150.0 | ХЭДС | 150.0 | Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Тус яам "Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл олгох" үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эхлүүлсэн. Уг ажлын хүрээнд цахим ажлын даалгавар, бүртгэлийн маягтыг батлуулж, холбогдох журмын төслийг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байгаа ба гүйцэтгэгч байгууллагаар Ezuvshuurul.mn/out цахим системийг хийлгэж, бүрэн ашиглалтанд оруулсан. Цахим системд тус яамнаас олгогдсон тусгай зөвшөөрөлтэй 71 байгууллага сунгалт хийхээр хүсэлт гаргах, тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагааны тайлангаа ил тод нээлттэй ирүүлж байх, Хүсэлт гаргагч байгууллагууд тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлт гаргах, зуучлуулагч иргэд дээрх байгууллагуудад хяналт тавих, мэдээлэл авах зорилгоор хандах юм. Ezuvshuurul.mn/out цахим системтэй холбоотойгоор Холбогдох дүрэм, загвар, заавар өөрчлөлт оруулж боловсруулан, ХНХсайдын 2021 оны 05 дугаар сарын 12-ны А/66 тоот тушаалаар батлуулсан. Цахим системийн хөгжүүлэлтийн ажил, мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийгдэж байна. Мэдээллийн санд сунгалтын 49 байгууллага хүсэлтээ цахимаар ирүүлж, байгууллагуудтай хийх QR код бүхий захиргааны гэрээг баталгаажуулан цахим санд оруулсан. Зуучлуулагч иргэдийн цахим мэдээллийн сан амжилттай бүрдсэн. Мэдээллийн санд 2042 иргэн бүртгэлтэй байна. Тайлан илгээх хөгжүүлэлтийг бүрэн дуусаж туршилт хийсэн. Шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. Хуртай холбогдох шаардлагатай хөгжүүлэлт хийгдэж байна. Цахим системийн зарим засварыг тухай бүрт хөгжүүлэгч нартай холбогдон даалгавар өгч, хэрэгжилтийг хянан ажиллаж байна. Мөн 2022 онд хугацаа дуусаж байгаа байгууллагуудын сунгалтын хүсэлтийг бүрэн цахимаар авч байна. Цахим систем ашиглах талаар шаардлагатай мэдээллийг цахим шуудан, утсаар өгч байна. Цахим системийн сургалтыг утсаар болон цахим шуудангаар өдөр тутам хийж байна. Мөн видео хэлбэрээр хийхээр төлөвлөж байна. | 90.0 |
| 72 | 2.5.5. Ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоог сайжруулж, 3-аас доошгүй төвд жишиг үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх | Ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоог сайжруулж, 3-аас доошгүй төвд жишиг үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх | Жишиг загвар үйлчилгээнүүдийг нэвтрүүлж, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 20-иос доошгүй хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 1,140.0 | Гадаадын зээл, тусламж | 124.7 | Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний шинэ загварыг туршин нэвтрүүлэхээр аймаг, сум, нийслэлээс дараах Сонгинохайрхан дүүргэт "Ачлалт хүүхдүүд" ТББ, Дархан-Уул аймагт "Ахмадын хөгжлийн төв", Сэлэнгэ аймгийн Мандал суманд Нэгдсэн эмнэлгийг түшиглэн 3 байршлыг сонгон хэрэгжүүлж байна. Дээрх 3 байршилд санхүү, хүний нөөц, үйлчилгээний чанар, стратегийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дэмжих стратегиудыг танилцуулж, хэлэлцүүлэг хийж, шинээр гарч буй шаардлагатай стратеги чиглэлийг хамтран тодорхойлох зорилго бүхий сургалтыг үе шаттай зохион байгуулсан. Эрүүл мэндийн яамтай хамтран 3 зорилтын хүрээнд 4 үйл ажиллагааны чиглэлтэй "Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 6 дугаар сарын 27-ний өдрийн А/127, А/333 тоот хамтарсан тушаал батлав. 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллаа.Тухайлбал : ТА9928 төсөл хэрэгжиж буй 3 байгууллага нь Идэвхтэй насжилтыг дэмжих төвийг хэрхэн байгуулах стратеги төлөвлөгөө, алсын хараа, зорилго зорилт, бизнес болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, аль байгууллагатай хэрхэн хамтарч ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэх зураглалаа тодорхойлон, орон нутгийн удирдах хороогоор хэлэлцүүлэн, хэрэгжүүлж байна. Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймгийн Мандал сум, Сонгинохайрхан дүүргийн Ачлалт хүүхдүүд төрийн бус байгууллагад амьдарч байгаа ахмад настны дунд хэрэгцээг тогтоосон үнэлгээг хийсэн. Мөн Т1 Т2 Т3 түвшиний ахмад настны тоо мэдээллийг гаргасан. Дээрх байгууллагууд нь өөрсдийн хүний нөөцийн чадавхиа үнэлж, түүнд нийцсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан. Хүний нөөцөө хэрхэн чадавхижуулах талаар үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна. Үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт 20 хувьтай байна. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 73 | 2.5.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг 6 аймагт байгуулах | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг 6 аймагт байгуулах | Архангай, Ховд, Дорнод, Дундговь, Дархан-Уул, Хөвсгөл аймгуудад хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв баригдсан байна. | Гадаадын зээл, тусламж | 4,360.0 | Гадаадын зээл, тусламж | 15,700.0 | -Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай 2018 оны 4 сарын 4-ний өдөр байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хүрээнд "Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах" төслийг хэрэгжүүлж байна. -"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд 6 аймагт байгуулахаар төлөвлөгдсөн. -АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл "Дархан-Уул, Дорнод, Дундговь, Хөвсгөл, Ховд аймгуудад Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барьж, эхнээс Хөвсгөл аймгийн барилга ашиглалтад орсон ашиглалтад орж, улсын комисс хүлээн авсан байна. Энэ онд багтаан Дархан-Уул, Дорнод, Дундговь, Ховд аймгуудын барилга бүрэн баригдаж ашиглалтад орно. -Архангай аймагт баригдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга 42%-ийн гүйцэтгэлтэй байна. Тус барилгын санхүүжилтэд -2022 онд 17,250,000,000.00 төгрөг санхүүжилт төсөвлөгдсөнөөс 15,795,439,082.7 төгрөгийн санхүүжилт хийгдээд байна. | 70.0 |
| 74 | 2.5.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулах | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулах | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн барилгын ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 1,940.0 | Гадаадын зээл, тусламж | 3,000.0 | Улаанбаатар хотод барих Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгын зураг, төсвийг 2021 оны 12 дугаар сард боловсруулан баталгаажуулсан ба барилга угсралтын ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулалтын дотоодын тендерийг 2022 оны 2 дугаар сард зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулж, гэрээ байгуулагдсан. Барилга угсралтын ажил 24% хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 2022 онд 3,0 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдээд байна. | 50.0 |
| 75 | 2.5.8. Орлого багатай өрхийн гишүүдийг мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх, хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулж, ажилд зуучлах, онцлог хэрэгцээнд нийцүүлсэн арга хэмжээ, төсөл хэрэгжүүлэх | Орлого багатай өрхийн гишүүдийг мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх, хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулж, ажилд зуучлах, онцлог хэрэгцээнд нийцүүлсэн арга хэмжээ, төсөл хэрэгжүүлэх | Мэргэжлийн ур чадвар олгох сургалтад 3000 хүнийг хамруулж, 80-аас доошгүй хувийг ажилд зуучилсан байна. | Улсын төсөв | 1,000.0 | ХЭДС | 2,931.5 | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолоор Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төслийг баталсан бөгөөд 2022 онд 4 ээлжээр 21 аймаг 9 дүүргийн нийт 1218 оролцогч тус төсөлд амжилттай хамрагдсан байна. Төслийн оролцогчдод хувь хүний суурь ур чадвар, залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, биеийн тамир сэтгэл зүйн бэлтгэл, соёл, спорт, чөлөөт цагийн үйл ажиллагаа, өнөөгийн монгол хүн, монгол ёс заншил зэрэг сэдэвчилсэн хичээлүүдийг давхардсан тоогоор 56 багш дасгалжуулагчид хамтран ажиллаж, 14 ААНБ, ажил олгогчид хөдөлмөрийн яармагт оролцсон байна. Мөн Оролцогчдын сэтгэл ханамж болон төсөлд хамрагдсанаар хүлээсэн үр дүндээ хүрч чадсан эсэхийг тодруулахад багц сургалтыг үр дүнтэй байсан гэж үзсэн залуучуудын ойролцоогоор гурван хүн тутмын нэг нь (31.6 хувь) сургалтад хамрагдсанаар өөртөө итгэлтэй, нээлттэй болж хувь хүний хөгжил сайжирсан, 22.0 хувь нь харилцаа, хандлага сайжирсан, 18.3 хувь нь ажлын байртай болсон, 6.3 хувь нь хамт олон, найз нөхөдтэй болсон, 4.8 хувь нь мэдлэгээ дээшлүүлсэн, 3.2 хувь нь ажлын чиг баримжаатай болсон нь давуу талтай байсныг илэрхийлжээ. Үүнээс үзэхэд вакумжуулсан багц сургалт нь оролцогчдын харилцааны ур чадвар, багаар ажиллах чадвар, дасан зохицох чадвар, хариуцлагатай байдал, зөрөг хандлага зэрэг зөөлөн ур чадваруудыг түлхүү хөгжүүлсэн нь сайшаалтай. Мөн оролцогчдын 53.8 хувь нь сургалтад хамрагдсанаар өөрт ямар мэдлэг, чадвар дутагдаж буйг ойлгосон, 52.8 хувь нь дутагдаж буй мэдлэг, чадвараа ахиулахын тулд хийх зүйлсээ ухамсарласан, 47.4 хувь нь сурсан зүйлсээ турших, хэрэгжүүлэх боломж бүрдсэн гэж хариулсан байна. Сургалтын явцад оролцогчдод хамгийн их таалагдсан, ач холбогдол бүхий хичээл нь сэтгэл зүй, харилцаа, хувь хүний хөгжлийн талаарх хичээлүүд, мөн бизнес санаагаа хөгжүүлэх, төсөл бичих хичээлүүд илүү сонирхолтой байсан бөгөөд, сургалтын бусад үйл ажиллагаанууд буюу бизнес аялал 33.1%, хөдөлмөрийн яармаг ажилд зуучлал 31.5%, байгууллага дээрх дадлага 26.6%, менторшип арга хэмжээ 11.1 % нь сэтгэл ханамжтай үр өгөөжтэй байсан гэдгийг онцолсон байна. | 70.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 76 | 2.5.9. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудын засаглал, удирдлагыг сайжруулах, багш, хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор цахим мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх | Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудын засаглал, удирдлагыг сайжруулах, багш, хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор цахим мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх | Системийн хоёрдугаар шатны хөгжүүлэлт хийгдэж 50 хувь нь цахимжсан байна. | Улсын төсөв | 2,153.0 | - | - | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн 7 дахь заалтад "Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх" асуудал Боловсрол шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудалд шилжиж ирсэнтэй холбоотойгоор Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хөгжүүлж, нэвтрүүлсэн "Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын мэдээллийн систем /mergejil.mn/"-ийг Боловсрол шинжлэх ухааны яам хүлээж авах ажлыг 2022 оны 4 дүгээр сард зохион байгуулж Боловсролын мэдээллийн технологийн төвөөс шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг хийж www.tvets.edu.mn болгон шинэчилсэн. Тус шинэчлэлийн хүрээнд Төрийн мэдээллийн солилцооны ХУР системээр дамжуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний мэдээллийн сангаас суралцагч, багш, ажилтны регистрийн дугаараар тулгалт хийх боломжтой болж бүртгэлийг сайжруулснаас гадна системд бүртгэлтэй суралцагчийн мэдээллийг Боловсролын салбарын мэдээллийн систем болон Дээд боловсролын удирдлага мэдээллийн системийн мэдээллийн сангуудтай холбосноор ерөнхий боловсролын сургууль, дээд боловсролын сургалтын байгууллагад давхар бүртгэлтэй эсэхийг хянах боломжтой болсон. Үүний дүнд регистрийн дугаар алдаатай буруу 1383, систем дотроо давхардсан 323, Боловсролын салбарын мэдээллийн системтэй давхардсан 570, Дээд боловсролын удирдлага мэдээллийн системтэй давхардсан 4121 суралцагчийн мэдээллийг залруулж, давхардлыг арилгаж, бүртгэлийг шинэчлэн 2021-2022 оны хичээлийн жилийн төгсөлтийн мэдээ тайланг системээр гаргасан. Мөн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын мэдээлэл, багш ажилтан, хүний нөөц, сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний баталгаажилт зэрэг мэдээллүүдийг цахимжуулсан.Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын систем бүрэн цахимжиж мэдээлэлд үндэслэн суралцагчийн тэтгэлгийг олгож байна. | 100.0 |
| 77 | 2.5.10. Нийгмийн халамжийн арга хэмжээг нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттай, үр дүнтэй, хүнд сурталгүй, албан тушаалтнуудын оролцоогүй болгох зорилгоор цахим хэлбэрт шилжүүлэх | Нийгмийн халамжийн арга хэмжээг нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттай, үр дүнтэй, хүнд сурталгүй, албан тушаалтнуудын оролцоогүй болгох зорилгоор цахим хэлбэрт шилжүүлэх | Нийгмийн халамжийн үйлчилгээний 60 хувь цахимжсан байна. | Гадаадын зээл, тусламж | 100.0 | - | - | Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг "Алсын хараа 2050"-д хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэх, "Шинэ сэргэлтийн бодлого"-д төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулах, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэх зорилго, зорилтын хүрээнд халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж Халамжийн нэгдсэн систем буюу ehalamj.mn цахим системийг хөгжүүлж байна. Системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх ажлыг Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв хамтран хэрэгжүүлж байна. Тус системийг 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтрүүлж, 2020 онд 6, 2021 онд 20, 2022 онд 36 төрлийн үйлчилгээг цахимжуулсан бөгөөд одоогийн байдлаар 72 нэр төрлийн үйлчилгээнээс 64 үйлчилгээг цахимжуулсан байна. Үлдсэн үйлчилгээний хувьд харьяалах яамдад шилжсэн 2 төрлийн үйлчилгээ, холбогдох журам гараагүйн улмаас хэрэгжихгүй байгаа 2 төрлийн үйлчилгээ, цахимжих боломжгүй 3, тусгай програмаар үзүүлж байгаа 1 төрлийн үйлчилгээ тус тус байна. Нийгмийн халамжийн үйлчилгээнд давхардсан тоогоор 1,2 сая иргэн хамрагдаж, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2022 оны 12 сард 520.9 тэрбум төгрөг зарцуулахаар санхүүжилт хийгдэж байна. /хүүхдийн мөнгөн хуримтлалыг тооцохгүйгээр/. Нийт хамрагдсан иргэний 89.8 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээг цахимаар авч байна. Мөн 21 аймаг 330 сум, 9 дүүргийн 204 хороонд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг цахим эрхийн бичиг (банкны карт)-ээр үзүүлж байна. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 78 | 2.5.11. Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төсөл боловсруулж, тогтолцооны шинэчлэл хийх ажлыг эхлүүлэх | Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төсөл боловсруулж, тогтолцооны шинэчлэл хийх ажлыг эхлүүлэх | Ажил, хөдөлмөр тогтвортой эрхэлж, нийгмийн даатгал төлдөг иргэн орон сууцны ипотекийн зээлд хамрагдах, эрүүл мэндийн үйлчилгээ авах, боловсролын хөрөнгө оруулалт хийх боломж бүрдүүлсэн, Монгол Улсын онцлогт нийцсэн хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцооны шинэчлэл хийгдэж эхэлсэн байна. | Улсын төсөв | 20.0 | - | - | Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьчилан тандсан судалсан тухай тухай тайланг боловсруулж дуусав. -Голланд, Сингапур, Казахстан, Норвеги, Чили зэрэг тэтгэврийн хуримтлалын тогтолцоотой орнуудыг сонгон авч судлав. -Сингапур улсын Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийг орчуулж судалгаанд ашиглаж эхлэв. -Бүгд Найрамдах Сингапур Улсын Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-тай 2021 оноос хойш удаа дараа харилцан санал солилцож, хамтран ажилласны үр дүнд Монгол Улсын Ерөнхий сайдын Бүгд Найрамдах Сингапур Улсад хийсэн айлчлалын хүрээнд 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-тай хамтран ажиллах санамж бичгийг гурван жилийн хугацаатай байгуулав. -Монгол Улсад Хуримтлалын нэгдсэн сан бий болгоход дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгаврыг боловсруулж Дэлхийн банкинд хүргүүлж батлуулсан. Энэхүү техникийн нөхцөлийн дагуу Сингапураас авах зөвлөх үйлчилгээний 1 ба 2 шатны тодорхой хэсгийг Дэлхийн банкнаас Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-тай 2022 оны 08 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан гэрээгээр санхүүжүүлэхээр болов. -Хуримтлалын нэгдсэн сантай хамтран ажиллах чиг үүрэг бүхий Удирдах хороог Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/153, уг Удирдах хорооны ажилд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/144 дүгээр тушаалаар батлуулав. -2022 оны 8 дугаар сарын 10-16-ны өдрүүдэд Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх үйлчилгээний 5 хүний бүрэлдэхүүнтэй баг Монгол Улсад ажиллав. Зүүн өмнөд Азийн газрын захирал ноён Тан По Тек, Сингапурын Хуримтлалын нэгдсэн сангийн ТУЗ-ийн гишүүн Юү Ёон Кан Дон, Со Чен Хэн, менежер Чиа Зао Рү, зөвлөх Лим Чи Киа нарын төлөөлөгчид Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яамны удирдлагуудтай албаны уулзалт хийж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, түүний харьяа агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газар, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс | 50.0 |
| 79 | 2.5.12. Хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх | Хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх | Ядуурлын түвшин буурч, өрхийн орлого нэмэгдсэн байна. | Улсын төсөв | 30,000.0 | ХЭДС | 46,800.0 | Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилт, үйл ажиллагааны хүрээнд хүн амын бүлгүүдийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, санхүүгийн дэмжлэг болон зээлд хамруулах, борлуулалтын дэмжлэг үзүүлэх, ажил олгогчийг дэмжих зэрэг арга хэмжээг "Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр", "Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр" "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих", "Ногоон ажлын байрыг дэмжих хөтөлбөр", "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-үүдийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01 тогтоолоор батлан 2022-2023 онд хэрэгжүүлж байна. ҮСХ-ны 2020 оны статистик мэдээгээр МУ-ын ядуурлын түвшин 27.8 хувь байна. ҮСХ-ны 2022 оны 3 дугаар улирлын мэдээгээр МУ-д хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56.0 хувь байна. Залуучуудын хөгжлийн төв 21 аймаг, 9 дүүрэг, 5 сум (Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Номгон, Булган)-д ажиллаж, амьдрах ухааны сургалт, сонирхлын клуб, зөвлөлийг ажиллуулах, хууль зүйн туслалцаа, эрүүл мэндийн зөвлөгөө үйлчилгээ, тусламж, гэр бүлийн зөвлөгөө, хөдөлмөр эрхлэлтийн сургалт, зөвлөгөө, зуучлалын үйлчилгээнд жилд дунджаар нийт залуучуудын 40 хувийг хамруулдаг бөгөөд 2022 оны 12 сарын байдлаар 627472 залуучууд буюу нийт залуучуудын 62 хувьд хөгжлийн үйлчилгээг хүргэсэн. Мөн Ховд аймгийн Манхан сум, Баян-Өлгий аймгийн Сагсай сум, Завхан аймгийн Их-Уул суманд Залуучуудын хөгжлийн төвийг шинээр байгуулаад байна. Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлэгч залуучуудын 30 хувь нь ажилд холбон зуучлах үйлчилгээнд хамрагддаг бөгөөд тэдгээрийн 57 хувь нь байнгын/түр ажлын байранд, 43 хувь нь цагийн ажлын байранд тус тус зуучлагдаж байна. | 30.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 80 | | 2.5.13. Халамжийн хөтөлбөрүүдийг хөдөлмөр эрхлэлттэй уялдуулах замаар нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлэх | Халамжийн хөтөлбөрүүдийг хөдөлмөр эрхлэлттэй уялдуулах замаар нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлэх | Халамжаас хөдөлмөрт шилжүүлэх зорилтын хүрээнд нийгмийн халамжийн хөтөлбөрүүд халамж хүртэгч иргэдийн идэвх, сонголтод тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдсан, уян хатан, чанартай, хүртээмжтэй болсон байна. | - | - | - | - | 1/Нийгмийн халамжийн одоогийн хуулийн хүрээнд зорилтот бүлгийн иргэд, өрхүүдэд зөвхөн мөнгөн тусламж үзүүлдэг хэт нэг талыг барьсан бодлогоос татгалзаж, нийгмийн халамж шаардлагатай өрх, иргэдийг чадавхжуулах, тэдний хэрэгцээнд нийцсэн шинэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлэхээр Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан. Тухайлбал, Зорилтот өрхийн гишүүдийн зан үйл, хандлагыг өөрчлөх зөвлөгөө, сэтгэл зүйн засалд хамруулах, бусад үйлчилгээнд холбон зуучлах, амьдрах ухаан, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, бие даан амьдрах чадвар дадлыг хэвшүүлэх зэргээр тухайн өрхийг чадавхжуулах, амьжиргааг дэмжихэд чиглэсэн урт хугацааны үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгасан. Нийгмийн халамжийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн бөгөөд УИХ-ын хаврын чуулганд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. 2/ 2021 оны 7 дугаар сараас "Хүнсний эрхийн бичиг олгох журам"-ыг шинэчлэв. Энэхүү шинэчлэлээр: Тухайн өрхийн мэдээллийг холбогдох төрийн байгууллагын мэдээллийн сантай тулгалт хийж 200-аас дээш малтай өрх, 2-оос дээш орон сууцны байшин, 2-оос дээш бие даасан тохилог сууц, 2-оос дээш авто машинтай өрхийг хамруулах эсэхийг нягтлан шалгаж, хэрэв өөрчлөлт орсон нь тогтоогдвол тус үйлчилгээнээс хасахаар зохицуулсан. Хүнсний эрхийн бичигт хамрагдах хугацааг 2 жил болгож, хөдөлмөрийн насны иргэнийг 2 буюу түүнээс дээш удаагийн тохирсон ажлын байранд зуучлах, татгалзсан тохиолдолд дэмжлэгээс хасах нөхцөлийг тавьж хэрэгжүүлж байна. Халамжаас Хөдөлмөрт шилжүүлэх бодлогын арга хэмжээний хүрээнд хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, сургах, зуучлах, бичил зээлд хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. -2021 оны 07 сараас /шинэчилсэн журам хэрэгжиж эхэлсэнээс хойш/ 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 17,3 мянган өрхийн 97,6 мянган иргэн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс хасагдсан байна. -2022 оны 11 дүгээр сарын байдлаар 126.0 мянган иргэн тус үйлчилгээнд хамрагдсан. | 70.0 |
| 81 | | 2.5.14. Нийгмийн халамжийн бодлогын шинэчлэлийг хийж, зорилтот өрх, иргэнийг тодорхойлох аргачлалыг сайжруулах | Нийгмийн халамжийн бодлогын шинэчлэлийг хийж, зорилтот өрх, иргэнийг тодорхойлох аргачлалыг сайжруулах | Өрхийн амьжиргааны түвшинйг тодорхойлох шинэчлэн баталсан аргачлалд үндэслэн 2022 онд өрхийн амьжиргааны түвшинйг тодорхойлох судалгааг нийт өрхийн 30 хувийг хамруулан зохион байгуулна. | Улсын төсөв | 2,600.0 | Гадаадын зээл, тусламж | 183.8 | Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлалыг 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэл болон холбогдох төрийн мэдээллийн санг ашиглаж, уялдуулан загварын үнэлгээ, тооцооллыг олон хувилбараар үнэлж, гүйцэтгэлийг сайжруулж буй хувилбаруудыг нэгтгэн, шинэ загварыг боловсруулан загварын үнэн бодит байдлыг шалгаж, эцсийн загварын төслийг боловсруулсан. Боловсруулсан хосолмол загварыг турших туршилтын судалгааг ТББ-тай хамтран УБ хотын 6 дүүрэг, Орхон, Булган, Хэнтий, Дундговь аймгуудын 400 өрхийг хамруулсан. Туршилтын судалгааны үр дүнд үндэслэн судалгааны үзэл баримтлал, аргачлал, маягт, нөхөх зааврыг шинэчлэн ҮСХ-ны арга зүйн байнгын зөвлөл болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ҮСХ-ны дарга, ХНХ-ын сайдын 2022 оны А/84, А/89 хамтарсан тушаалаар "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал" батлагдсан. Аргачлал батлагдсантай холбогдуулан дараах ажлуудыг хийсэн. Үүнд: -Өрхийн нэгдсэн мэдээллийн сангийн системийг шинэчлэх дотоодын 3 мэдээллийн технологийн зөвлөхийн хийх ажлын даалгаварт санал өгч, зөвлөхүүдтэй хамтран үйл ажиллагааны төлөвлөгөө, мэдээллийн сангийн системийн зохиомж, асуулгын өгөгдөл оруулах үеийн өгөгдлийн алдаа шалгах дүрмүүд, Захиргааны мэдээлэл хадгалагдах хүснэгтийн загвар, аргачлалын ашиглагдах тооцооллын бодлогын даалгаврын дагуу код бичиж, боловсруулсан. Мөн яамны саналын дагуу андройд болон IOS 2 үйлдлийн системд зориулсан судалгааны аппликейшнийг таблет болон гар утсанд зориулж хийсэн. - Аргачлалд тусгагдсан төрийн байгууллагуудаас мэдээлэл сервисээр солилцох гэрээ болон хөгжүүлэлтийг хийсэн. - Судалгааг зохион байгуулахад шаардлагатай санхүүгийн тооцооллыг ХХҮЕГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулсан. | 50.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 82 | 2.6. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно. | 2.6.1. "Чингис хаан" хаад, язгууртны музейн шилэн хорго, витрин, тоног төхөөрөмжийг суурилуулан тохижуулах | "Чингис хаан" хаад, язгууртны музейн шилэн хорго, витрин, тоног төхөөрөмжийг суурилуулан тохижуулах | Гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 1,000.0 | Улсын төсөв | 4,715.6 | Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн XIV.3.3-т "Чингис хаан музейн шилэн хорго, витрин, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/" төсөл, арга хэмжээний санхүүжих дүн 1,000,000.0 (нэг тэрбум) төгрөг батлагдсан. Соёлын сайдын 2021 оны "Эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай" А/108 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх эрхийг "Чингис хаан" музейд шилжүүлсэн. Соёлын яам, Чингис хаан музей, "Синема оф саунд" компанийн хооронд 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр СОЯ/202103028 дугаар 4,963,868,075 төгрөгийн "XIV.3.8 Чингис хаан музейн шилэн хорго, витрин, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ нийлүүлэх гэрээ"-г байгуулсан. "Чингис хаан" музейн захирлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/92 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн тоног төхөөрөмж хүлээн авах комиссын актаар 79 ш витринийг гэрээнд заасан шаардлага, техникийн тодорхойлолтын дагуу бүрэн хүлээн авч, Чингис хаан музейн захирлын 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 09/397 дугаар Санхүүжилт хүсэх тухай албан бичгээр үлдэгдэл санхүүжилтийг баталгаажуулж ирүүлснээр гэрээд заасан "Чингис хаан музейн шилэн хорго, витрин, тоног төхөөрөмж"-ийг бүгдийг хүлээн авсан байна. Тус төсөл арга хэмжээний санхүүжилтийг Засгийн газрын 2021 оны 397 дугаар "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолоор Төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд 2,510,839,578.00 төгрөг байршуулсан гүйцэтгэлээрээ санхүүжилтээ авсан бөгөөд гүйцэтгэгчид олговол зохих санхүүжилтийг бүрэн олгосон. Түүнчлэн Соёлын яам, Чингис хаан музей, "Синема оф саунд" компанийн хооронд байгуулсан СОЯ/202103028 дугаар гэрээнд заасны дагуу Соёлын Яамны барьцаа хөрөнгийн 100900034351 дугаар дансанд чанарын баталгааны 248,193,403.75 төгрөг байршиж байна. | 100.0 |
| 83 | | 2.6.2. Үндэсний номын сангийн шинэ барилгыг бүрэн ашиглалтад оруулах | Үндэсний номын сангийн шинэ барилгыг бүрэн ашиглалтад оруулах | Гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 11,340.0 | Улсын төсөв | 17,818.0 | Үндэсний номын сангийн барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр "Акми холдинг" ХХК-тай анх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам /хуучнаар/-аас 2014.08.21-нд 11,999.8 сая төгрөгөөр гэрээ байгуулж, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар барилгын нийт төсөвт өртөг 19,900.0 сая төгрөг болж, тухайн онд санхүүжих дүн 2,081.8 сая төгрөгөөр батлагдсан. 2022.12.07-ны өдөр барилгын зураг төслийн зохиогч "Эгэл зураг төсөл" ХХК-ийн захирал Д.Оюунчимэг, Архитектор С.Сэргэлэн нартай Соёлын дэд сайд, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга нар уулзаж, барилгын үлдэгдэл ажлын төсвийг хийх талаар ярилцсан. 2022.12.09-ний байдлаар Ажлын хэсгийн гишүүд Үндэсний номын сангийн барилгын ажлын гүйцэтгэсэн болон үлдэгдэл ажлын тоо хэмжээг гаргасан. 2022.12.13-нд Соёлын яам дээр Барилгын хөгжлийн төвийн хяналтын инженер, "Акмихолдинг" ХХК-ийн захирал Ганбилэг, ерөнхий инженер Дамдиндорж, Соёлын яамны хяналтын инженерийн бүрэлдэхүүнтэй баталгаажуулах хурлыг хийж, барилга дээр очиж тоо хэмжээг тулгаж хянасан. Үүний үр дүнд гүйцэтгэлээр гаргасан тоо хэмжээ барилга дээр хийсэн ажлын тоо хэмжээ зөрсөн, давхацсан асуудал илэрсэн тул чиглэл тус бүрийн хяналтын инженерүүд /цахилгаан, сантехник, барилга/ тухайн үед гаргасан гүйцэтгэл 1-19 хүртэлх холбогдох материалтай нэг бүрчлэн танилцан, тоо хэмжээг нарийвчлан тулгах ажил хийгдэж байна. 2022.12.20-ны өдөр "Акмихолдинг" ХХК-тай байгуулсан 2014 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 3/206 дугаартай Үндэсний төв номын сангийн барилга угсралт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/-ын ажил гүйцэтгэх гэрээг цуцлахтай холбоотой ажиллагаа болон тус ажиллагаатай холбогдон гарсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах, хууль зүйн туслалцаа авах зорилгоор Өмгөөллийн "Жэй Эн Ти партнерс" ХХН-тэй 2022/27 дугаар гэрээ байгуулсан. | 30.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 84 | 2.6.3. Соёлын өвийн бүртгэл, хяналтын системийг хөгжүүлж, мэдээллийн санг бүрдүүлэх | Соёлын өвийн бүртгэл, хяналтын системийг хөгжүүлж, мэдээллийн санг бүрдүүлэх | Мэдээллийн санд оруулахаар төлөвлөсөн соёлын өвийн мэдээллийн 10 хувийг бүрдүүлсэн байна. | Улсын төсөв | 850.0 | Улсын төсөв | 1,275.0 | Соёлын салбарын мэдээллийн технологийн дунд хугацааны бодлогын баримт бичиг "Цахим соёл" арга хэмжээний төслийг боловсруулан Соёлын сайдын 2022 оны А/91 тоот тушаалаар батлуулсан. Соёлын өвийн бүртгэлийн нэгдсэн цахим сан, Улсын санд худалдан авах хөгжмийн том хэлбэрийн шилдэг бүтээлийн цахим сан, Тусгай зөвшөөрөл лавлагааны систем, Музейн цахим хөтөч, тайлбарлагчийн систем, Соёлын үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, GLAM системийн ажлын даалгавар болон урын сан, уран бүтээлийн бүртгэл мэдээллийн сангийн ажлын даалгавруудыг ТНБД-аар, энэхүү ажлуудын хүрээнд зарцуулах зардлын тушаалыг соёлын сайдын 2022 оны 8 сарын 30-ны өдрийн А/304 тоот тушаалаар батлуулан ТНБД-ын 2022 оны 9 сарын 01-ний өдрийн А/61 тоот тушаалаар үнэлгээний хороог байгуулан гүйцэтгэгч сонгон шалгаруулалт зарлан баталгаажуулж гэрээ байгуулагдсан. Соёлын өвийн үндэсний төвийн бүртгэл мэдээллийн санд RICH 3.0 программ хангамжид нийт Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн 330 сумын нутаг дахь 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгалыг хамрагдсан. Уг Rich программд бүртгэсэн өвийн бүртгэлийг шууд шинэ системд хөрвүүлэх боломжтойгоор программчлахаар ажлын даалгаварт тусгасан тул одоо ашиглагдаж байгаа программд өвийн бүртгэлийг бүртгэх ажил амжилттай хийгдсэн. | 100.0 |
| 85 | 2.6.4. Алтайн өндөр уулыг ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн жагсаалтад, Наурызын баярыг ЮНЕСКО-ийн соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлэх | Алтайн өндөр уулыг ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн жагсаалтад, Наурызын баярыг ЮНЕСКО-ийн соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлэх | Алтайн өндөр уул, Наурызын баярыг ЮНЕСКО-д нэр дэвшүүлэхээр баримт бичгийг хүргүүлсэн байна. | Улсын төсөв | 75.0 | Улсын төсөв | 86.5 | 1."Алтайн өндөр уулс"-ыг холимог өвийн ангиллаар Дэлхийн өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх баримт бичгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран бэлтгэж, бүртгүүлэх саналын хамт 2021 оны 01 дүгээр 20-нд конвенцын удирдамжид заасны дагуу Дэлхийн өвийн хороонд хүргүүлсэн. Дэлхийн өвийн төвөөс IUCN /Байгаль хамгаалах олон улсын холбоо / болон ICOMOS /Олон улсын хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах зөвлөл/-оос томилогдсон шинжээчдэд өвийн газар нутгийн танилцуулах ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс, МУИС-ийн Археологийн судалгааны төв, Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа болон төрийн бус байгууллагын төлөөлөл хамтран зохион байгуулсан. 2. Соёлын яамнаас "Наурызын баяр" өвийг ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад нэр дэвшүүлэх баримт бичгийг төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтран бэлтгэж, өвийг бүртгүүлэх саналын хамт 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр өвийн оролцогч 12 улсыг тэргүүлж байгаа Исламын Бүгд Найрамдах Иран Улсын Байнгын төлөөлөгчийн газарт хүргүүлсэн. Үүгээр "Наурызын баяр" өвийг конвенцын үйл ажиллагааны удирдамжид заасны дагуу баримт бичигт үнэлгээ хийж, оролцогч талуудын саналыг цуглуулан конвенцын нарийн бичгийн газарт өргөн мэдүүлэх боломж бүрдсэн. Өвийг бүртгүүлэх чиглэлээр оролцогч талуудын төлөөлөлтэй Марокко улсад зохион байгуулагдсан Соёлын биет бус өвийг хамгаалах конвенцын Засгийн газар хоорондын хорооны хурлын үеэр уулзалт зохион байгуулж, өвийн өнөөгийн нөхцөл байдал, үнэ цэнэт байдлын талаар танилцуулсан. | 90.0 |
| 86 | 2.6.5. Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамгаалуулах | Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамгаалуулах | Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 50 хувийг гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдээр хамгаалуулна. | Улсын төсөв | 200.0 | Улсын төсөв | 5.0 | Засгийн газрын 2020 оны 13, 2021 оны 179 дүгээр тогтоолоор улсын хэмжээнд улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг тус тус шинэчлэн баталсан. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.4, 45.2, 58.5 дугаар зүйлд заасны дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах үүргийг Соёлын сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан 2022 онд хамтран ажиллах гэрээний 4.1-т тусган иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн. 21 аймаг, нийслэлийн газар нутагт орших улсын хамгаалалтын зэрэглэлд орсон нийт 197 дурсгалаас өнөөдрийн байдлаар нийт улсын хамгаалалттай дурсгалын 173-ыг нь буюу 87,8 хувийг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан хамгаалуулж байна. | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 87 | | 2.6.6. Баримтат өвийн бүртгэлийн нэгдсэн системийн үйл ажиллагааг шинэчилж, иргэн, сум, хийдийн өмчлөл, эзэмшилд байгаа 1000 баримтат өвийн бүртгэлийг хийх | Баримтат өвийн бүртгэлийн нэгдсэн системийн үйл ажиллагааг шинэчилж, иргэн, сум, хийдийн өмчлөл, эзэмшилд байгаа 1000 баримтат өвийн бүртгэлийг хийх | Иргэдийн гар дээрх 1000 баримтат өвийг бүртгэн баримтжуулсан байна. | Улсын төсөв | 197.0 | Улсын төсөв | 227.0 | "Соёлын сайдын аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан ЗГ-ын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд уг арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 18 аймгийн соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд иргэн, сум хийдийн өмчлөлд байгаа 2106 баримтат өвийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд гэрэл зураг болон дүрс бичлэгийн хамт хадгалсанаар 2022 оны зорилтот түвшинд хүрсэн. Хувийн өмчлөлд байгаа баримтат өвийг соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд бүртгэснээр иргэн хуулийн этгээдэд өвийг хамгаалах арга зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлэх, баримтат өвийн эх төрх, бүрэн бүтэн байдлыг хянах, хууль бус эргэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, ахуйн шинжтэй сөрөг нөлөөллийг бууруулах боломж бүрдсэн. | 100.0 |
| 88 | | 2.6.7. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх "Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II", "Монгол соёл, Монголын баялаг" цогц арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх "Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II", "Монгол соёл, Монголын баялаг" цогц арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх | "ISO Research Standard-20252" стандартад нийцүүлэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын чанарын судалгаар хийж гүйцэтгэсэн байна. -Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн загвар, зураглал, экосистемийн суурь загвар, салбарын хамрах хүрээ, тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байна. -Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор болон академи байгуулах техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн байна. | Улсын төсөв | 2,000.0 | Улсын төсөв | 1,700.0 | Соёлын тухай хуулийн 34.1 дэх хэсэг, "Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II" арга хэмжээ болох дунд хугацааны бодлогын баримт бичиг батлуулж, хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 316 дугаар тогтоолоор "Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээ"-г батлуулсан. 2. Соёлын бүтээлч үйлдвэрлэл арга хэмжээг 1 дүгээр үе шатыг бүрэн хэрэгжүүлэх, үйл ажиллагааны хүрээнд тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний боломжит зах зээлийг тэлэх, экспортод чиглүүлэх зорилгоор "Соёлын бүтээлч сар" аяныг 2022 оны 11 дүгээр сард соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 салбарыг хамааруулан 1-р долоо хоногийг "Үндэсний нэгдмэл үнэт зүйл",2-р долоо хоногийг "Бүх нийтийн соёлын боловсрол", 3-р долоо хоногийг "Соёлын аялал жуулчлал", 4-р долоо хоногийг "Соёлын бүтээлч үйлдвэрлэл" гэсэн сэдэв агуулгын хүрээнд тус бүр зохион байгуулсан. Энэ жилийн аяныг өөрийн онцлог, өнгө төрхтэйгөөр зохион байгуулахыг зорьж "Монгол цам"-ыг онцолж соёлын өвийн үнэт зүйлс учир түүний утга бэлгэдлийг ухамсарлан ойлгож, баяжуулан хөгжүүлж, хойч үедээ өвлүүлэх зорилгоор сурталчилсан. 3.Энэхүү аян нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогод соёлыг хөгжүүлэхтэй холбоотойгоор туссан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд агуулга, хэлбэрээр баяжиж, цар хүрээний хувьд өргөжиж, соёл, урлагийн олон талт үйл ажиллагаагаар дамжуулан ард иргэдийг соён гэгээрүүлэх, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, оролцогч талуудын хамтын ажиллагааны түншлэлийг хөгжүүлэх, соёлын салбарын эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглүүлж Улаанбаатарт хотноо 161, 21 аймгийн хүрээнд 1245 арга хэмжээнүүдийг тус тус зохион байгуулсан. 4.Түүнчлэн "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн форум-2022" болж форумд соёлын бүтээлч үйлдвэрлэлд хамаарах 12 салбар, 90 гаруй чиглэлийн 400 гаруй төлөөлөл оролцож, хэлэлцүүлгээс гарсан саналыг үндэслэн форумын нэгдсэн зөвлөмж гаргасан. | 90.0 |
| | | | **Бодлогын дундаж үнэлгээ** | | | **851,227.3** | | **813,271.2** | | **72.8** |
| **3. Эдийн засгийн бодлого** | | | | | | | | | | |
| 89 | 3.1. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ. | 3.1.1. Төсвийн хөрөнгө оруулалтын PIMIS системийг хөгжүүлж, хөрөнгө оруулалтын талаарх цогц мэдээллийг олон нийтэд хүргэх | Төсвийн хөрөнгө оруулалтын PIMIS системийг хөгжүүлж, хөрөнгө оруулалтын талаарх цогц мэдээллийг олон нийтэд хүргэх | Үйл ажиллагааны үе шат болгон хэрэгжүүлнэ. | Гадаадын зээл, тусламж | 20.0 | - | - | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үе шатуудыг олон нийтэд ил тод, нээлттэй болгох зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /publicinvestment.gov.mn/, гар утасны аппликэйшныг хөгжүүлж, ашиглаж эхэлсэн бөгөөд системийн талаарх мэдээллийг олон нийтийн сүлжээ, Сангийн яамны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд сар болгон мэдээлж байна. Засгийн газар, АХБ-тай хамтран "Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл"-ийг хэрэгжүүлэх хүрээнд татварын удирдлага, төсвийн хөрөнгө оруулалтын ил тод, үр дүнтэй байдлыг бэхжүүлэх, төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, татварын мэдээлэл болон хяналтын системийн дэд бүтцийг сайжруулах ажил хийгдэж байна. PIMIS 3.0 шинэ системийн хөгжүүлэлт дээр төрийн 8 системүүд тухайлбал, и-Хуулга (e-huulga) системээр дамжуулан Төрийн сангийн (GFMIS) систем, ГТСМТ Төвийн Эрхийн бүртгэлийн систем, Тендерийн систем, Барилгын хөгжлийн төвийн систем, Газрын кадастрын (egazar.gov.mn) систем, CamService -ээр дамжуулан Монгол банкны систем, Шилэн дансны системтэй холболт хийгдсэн. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 90 | 3.1.2. Зах зээл дэх хэт төвлөрлийг сааруулах, монополь, давамгай байдлаа урвуугаар ашиглахын эсрэг бодлогын арга хэмжээг авах | Зах зээл дэх хэт төвлөрлийг сааруулах, монополь, давамгай байдлаа урвуугаар ашиглахын эсрэг бодлогын арга хэмжээг авах | Төмөр замын суурь бүтцийг ашиглан тээврийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг төмөр замын тээврийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий бусад аж ахуй эрхлэгчдэд нээлттэй болгох замаар төмөр замын тээврийн салбарт өрсөлдөөнийг бий болгоно. | - | - | - | - | Засгийн газрын 298 дугаар тогтоолын дагуу 2022 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолоор дагнасан хэрэглээний төмөр замын зах зээлд "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХК-ийг "Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгч"-ээр, 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолоор хөнгөн бетоны зах зээлд "Монголын алт МАК" ХХК-ийг "Давамгай байдалтай аж ахуй эрхлэгч"-ээр, 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор Хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны ипотекийн хөрвөх зах зээлд Монголын ипотекийн корпораци ОССК" ХХК-ийг "Давамгай байдалтай аж ахуй эрхлэгч"-ээр тус тус тогтоож, үйл ажиллагаанд нь хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж ажилласан. Дараахь зах зээлийн судалгааг хийж байна.Үүнд: -Агаарын зорчигч тээврийн зах зээлийн судалгаа -Улаан буудайн гурилын зах зээлийн судалгаа -Үл хөдлөх, эд хөрөнгийн зах зээлийн судалгаа - Хайпермаркет дэлгүүрийн зах зээлийн судалгаа Агентлагийн даргын 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 01/26 дугаартай удирдамжийн дагуу цементийн үнэ өсөлтөд хяналт шалгалт хийсэн. "МАК Цемент" ХХК нь 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар задгай цементийг 283,600 төгрөгөөр, савласан цементийг 335,600 төгрөгөөр тус тус борлуулж байсан боловч 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр гэрээт борлуулагч нартаа 1 тонн тутамд задгай цементийг 529,500 төгрөгөөр, савласан цементийг 550,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн нь давамгай байдалтай аж ахуй эрхлэгч өөрийн давамгай байдлаа хууль бусаар ашиглаж хуулиар хориглосон ноёлох үйл ажиллагаа явуулсан байж болзошгүй зөрчлийн шинжтэй үйлдэл тогтоогдсон тул Зөрчлийн тухай хуулийн 10.7 дугаар зүйлийн 9 дэх заалтад зааснаар "МАК Цемент" ХХК-ийн өмнөх жилийн борлуулалтын орлогын 4 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр буюу 5,370,546,910 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан. Монголбанканд "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-д өөрчлөлт оруулах замаар зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлсэн. | 100.0 |
| 91 | 3.1.3. Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, сайжруулах | Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, сайжруулах | Алтанбулаг, Боршоо, Гашуунсухайт, Бичигт, Замын-Үүд, Ярант, Хавирга, Ульхан хилийн боомтуудаар нэвтрэх тээврийн хэрэгслийн тоо 3 дахин нэмэгдсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 173,533 | - | - | Тайлан ирүүлээгүй. | 0.0 |
| 92 | 3.1.4. "Алтанбулаг" чөлөөт бүсийг гаалийн төлө хяналтын нэгдсэн системд холбох | "Алтанбулаг" чөлөөт бүсийг гаалийн төлө хяналтын нэгдсэн системд холбох | Гаалийн төлө хяналтын нэгдсэн системд холбогдсон байна. | Улсын төсөв | 130.0 | - | - | "Алтанбулаг" чөлөөт бүсийн Захиргааны ажлын албанаас төсөлд шаардагдах төсвийг бусад шаардлагатай дэд бүтцийн төслүүдэд шаардагдах хөрөнгө оруулалтын саналын хамт Монгол Улсын 2023 оны төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсөвт тусгагдаагүй. Гаалийн ерөнхий газарт гаалийн бүртгэлийн системд цогц шийдлийг олж нэвтрүүлэх, бүсийн зорчигч, тээврийн нэвтрэлтийг хурдасгахад холбогдох арга хэмжээ авах тухай албан бичгийг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/1697 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 30.0 |
| 93 | 3.1.5. Зээлийн хүүг бууруулах стратегийг эрчимжүүлж, зээлийн хүүг үргэлжлүүлэн бууруулах | Зээлийн хүүг бууруулах стратегийг эрчимжүүлж, зээлийн хүүг үргэлжлүүлэн бууруулах | Банкны салбарын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж зээлийн хүүг жилийн 13.8 хувьд хүргэсэн байна. | - | - | - | - | Зээлийн хүүг бууруулах стратегийг УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дугаартай тогтоолоор батлан, Монгол улсын Засгийн газар, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран хэрэгжүүлж, стратегийн хэрэгжилтийг хагас жил тутам тайлагнан ажиллаж байна. Тус стратегийн баримт бичиг нь 4 зорилт, 4 дэд зорилтын хүрээнд тодорхойлсон 19 арга хэмжээ, 47 дэд арга хэмжээнээс бүрдсэн бөгөөд дараах үндсэн 4 чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд: зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро эдийн засгийн тогтвортой орчин бүрдүүлэх; зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах; банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах; хөрөнгийн захыг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах зэрэг байна. Монголбанкнаас КОВИД-19 цар тахлын үед нийгэм, эдийн засаг тулгарч буй санхүүгийн хүндрэл, дарамтыг зөөлрүүлэх, эдийн засгийн сэргэлтийг дэмжих ажлын хүрээнд бодлогын хүүг 2020 онд 5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэсэн бөгөөд 2021 оны туршид хэвээр хадгалсан. Үүний үр дүнд шинээр олгосон зээлийн дундаж хүү 2019 оны 2 сард 16.9 хувь байсан бол 2020 оны төгсгөлд 14.8 хувьд хүрч, 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 15.3 хувьтай байна. Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хагас жил тутам гаргадаг бөгөөд 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 2023 оны 1 дүгээр сард гаргахаар хүлээгдэж байна. | 90.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 94 | 3.1.6. Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх | Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх | Хүн амын 70-аас доошгүй хувийг дархлаажуулсан байна. Томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг идэвхжүүлж эдийн засаг тогтворжсон байна. | - | - | - | - | Төлөвлөгөөний хэрэгжилт 60.0 хувьтай байгаа ба үүнээс Ажлын байрыг дэмжих зээл олголт 93.5 хувь, ХАА-г дэмжих зээл олголт 87.4 хувьд хүрсэн бол репо санхүүжилтийн зээл олголт 2021 оны төлөвлөсөн хэмжээний 165.1 хувь, 2022 онд 139.6 хувь нийт гүйцэтгэл 76.2 хувь, орон сууцны ипотекийн зээл олголт 2021 онд төлөвлөсөн хэмжээний 101.2 хувь, 2022 онд 67.9 хувь нийт гүйцэтгэл 84.6 хувьд д тус тус хүрсэн байна.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжид 500 сая төгрөг хүртэл, бизнес эрхлэгч иргэнд 50 сая төгрөг хүртэл жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай зээлийг банкуудын өөрийн эх үүсвэрээр 2.0 их наяд төгрөгийг олгосон.Коронавирусын үед хэрэгжүүлж буй улс, орнуудын төв банкуудын туршлагыг судалж, зээлийг багцлан үнэт цаасжуулан репо нөхцөлөөр санхүүжилт олгох механизмын хүрээнд Монголбанкнаас 2 жил хүртэл хугацаатайгаар банкнуудад репо нөхцөлөөр санхүүжилт олгож, банкууд эцсийн зээлдэгчид 10.5 хувийн хүүтэйгээр шинээр зээл олгох, дахин санхүүжүүлж байна.Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж тус зээлийн хүүг жилийн 6 хувь болгон бууруулан, Монголбанк болон банкуудын холимог эх үүсвэртэйгээр хэрэгжүүлж байна.Хөдөө аж ахуйн салбарын хаврын тариалалтад 100.0 тэрбум төгрөг, ноос, ноолуур, арьс шир бэлтгэлийн үйл ажиллагаанд 200.0 тэрбум төгрөгийг 1 жилийн хугацаатай 3.0 хувийн хүүтэй, малчдыг дэмжсэн зээлд 250.0 тэрбум төгрөгийг 3 жилийн хугацаатай 3 хувийн хүүтэй зээлийг олгож байна.10 их наядын цогц төлөвлөгөөний үр дүнд 2022 оны өдрийн байдлаар 69,221 иргэн, аж ахуйн нэгжид 6,003.7 тэрбум төгрөгийн зээлийг олгосон.ТЕГ-аас ирүүлсэн мэдээллийн дагуу зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 33.4 хувиар өссөн зэрэг өөрчлөлт гарсан байна.Зээлийн батлан даалтын сангаас 208 зээлдэгчид 28.3 тэрбум төгрөгийн зээлийн батлан даалт гаргав.Төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндээ хамгаалах зорилтын хүрээнд цар тахлын эсрэг вакцинжуулалт 2021 оны байдлаар 2,283,523 иргэнийг 1-р тунд, 2,184,678 иргэнийг 2-р тунд хамруулсан. | 100.0 |
| 95 | 3.1.7. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, гомдлыг шийдвэрлэх цогц тогтолцоог бүрдүүлэх | Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, гомдлыг шийдвэрлэх цогц тогтолцоог бүрдүүлэх | Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй холбоотой гомдлыг шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна. | Улсын төсөв | 50.0 | - | - | 1. Хөрөнгө оруулагчийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд: - Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөрөнгө оруулалтын хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг хамгаалах асуудал хариуцсан зөвлөлийн эрх үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон төрийн байгууллагуудаас хөрөнгө оруулагчдын гомдол, маргааныг шуурхай шийдвэрлэх талаар тусгах арга хэмжээний зохицуулалтыг шинээр тусгасан. - Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 сарын 23-ны өдрийн хуралдаанд гадаадын хөрөнгө оруулагчдаас гаргасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор "Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоол гаргуулсан. 2. Хөрөнгө оруулагчдад учирч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх хүрээнд: - Гадаад улсаас Монгол Улсад суугаа 13 Элчин сайдын яамнаас ирүүлсэн гомдол, тулгамдаж буй асуудлын талаар судалгаа; -20 хуулийн фирмээс гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч иргэдэд хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэхэд холбоотой тулгамдаж буй хүндрэл, бэрхшээл болон эрх зүйн зохицуулалт, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой судалгаа; -SIRM системд ирүүлсэн 20 гомдолд анализ хийж, улмаар "Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 413 дугаар тогтоол гаргуулсан. 3. Бусад: - МУ-ын Ерөнхий сайдын 2021 оны 3 дугаар захирамжаар байгуулсан Швейцарын Холбооны Улсад бүртгэлтэй "Даблью Эм Майнинг АГ" компани, түүнийг төлөөлж "Мэйэр Браун Интернэшнл" хуулийн фирмтэй маргааныг хэлэлцээ хийх замаар шийдвэрлэх үүрэг бүхий Ажлын хэсэг, 2021 оны 87 дугаар захирамжаар байгуулсан Америкийн Нэгдсэн Улсын "Даблью Эм Майнинг" компанийн гаргасан нэхэмжлэлтэй, Монгол Улсын Засгийн газарт холбогдох арбитрын маргааны хууль зүйн үндэслэлийг судалж, холбогдох тайлбар, нотлох баримтыг гарган нэхэмжлэлийн шаардлагыг няцааж, Засгийн газрын байр суурь, чиглэлийг хамгаалах үүрэг бүхий Ажлын хэсэгт Хөрөнгө оруулалтыг хөхиулэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр болон холбогдох танилцуулга, саналыг хүргүүлж ажилласан. | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 96 | | 3.1.8. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж батлуулах | Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж батлуулах | Холбогдох судалгааг хийж, хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулсан байна. | Улсын төсөв | 16.0 | - | - | МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш нарын бүрэлдэхүүнтэй хуулийн баг Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг шинэчлэн батлагдсан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын дагуу эцэслэн боловсруулаад байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг иргэд, олон нийт болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагуудын хууль, эдийн засгийн чиглэлийн эрдэмтэн, судлаач багш нарын хүрээнд, Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоо ТББ (MORA) түүний гишүүдийн хүрээнд тус тус онлайнаар хэлэлцүүлсэн бөгөөд нийт 3 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Мөн төрийн захиргааны төв байгууллагуудаас саналыг авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажилласан. | 50.0 |
| 97 | | 3.1.9. "Замын-Үүд" чөлөөт бүсэд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, экспортод чиглэсэн үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулах | "Замын-Үүд" чөлөөт бүсэд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, экспортод чиглэсэн үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулах | Хөрөнгө оруулалт нэмэгдэж, чөлөөт бүсэд аж үйлдвэрийг хөгжүүлэх таатай орчин бүрдэнэ. | Улсын төсөв | 200.0 | - | - | Замын-Үүд" чөлөөт бүсэд хөрөнгө оруулах аж ахуйн нэгжүүдийг найдвартай эрчим хүчээр хангах ажлын хүрээнд "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд хийгдсэн цахилгаан дамжуулах 16 ш 10/0.4 кВт-ын дэд өртөөний 0,4 кВт талын тоноглол угсрах, шалны засварын ажлыг Эрчим хүчний яамны захиалгаар "Улаанбаатар электро мантаж" ХХК гүйцэтгэсэн. Тус ажлын гүйцэтгэл бүрэн дуусаж Эрчим хүчний үндэсний төв болон БЗӨБЦТС ТӨК-аас 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр техникийн комисс ажилласан. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 280 дугаар тогтоолоор Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн хамтарсан зохицуулах зөвлөлийн Монголын талын бүрэлдэхүүнийг, Гадаад харилцааны сайдын 2022 оны А/69 дүгээр тушаалаар Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монголын талын бүрэлдэхүүнийг тус тус баталж хятадын талд дипломат шугамаар мэдэгдэн анхдугаар хуралдааныг товлон хуралдуулахаар бэлтгэл ажлыг хангах байна. "Замын-Үүд" чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах бэлтгэлийг хангаж ажиллаж байна. "Замын-Үүд" чөлөөт бүсэд 7 аж ахуй нэгж үйл ажиллагаагаа эхлүүлж, 11 аж ахуй нэгж барилгын ажлын бүтээн байгуулалтыг гүйцэтгэж байна. Өнгөрсөн 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 2.2 сая төгрөгийн бараа оруулж, 2.1 сая ам.долларын борлуулалт хийсэн. | 100.0 |
| 98 | 3.2. Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, | 3.2.1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47 хувийг хамруулах | 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47 хувийг хамруулах | Гүйцэтгэл 45 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 11,166.4 | Улсын төсөв | 10,783.7 | Сүүжийн говь-50, Шүтээн улаан уул-50, Норовлин-50, Чулуун хороот-50, Галбын говь-50, Бүрхтэй уул-50 төслүүдийн үр дүнгийн тайлантай танилцаж ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2022.06.02-нд хэлэлцэж хүлээн авсан. Ингэснээр 17,787.84 км2 талбай буюу 1.13%, нийтдээ 43.1%-ийг тус судалгааны ажилд хамруулаад байна. Эдгээр 6 төслийн судалгааны үр дүнд Мангирт (өнгөт металл Р2 зэргээр Cu-2298.94 тн, мөнгө-7.248 тн, алт-2.352 кг, цайр-210 тн, хартугалга-315 тн), Эрдэнэ овоо (Алт шороо Р1 зэргээр 65.5 кг), Хуурай сайр (Р2 зэргээр алт-224.19 кг), Угалзын худаг (Р2 зэргээр алт-1524.1 кг), Дэшийн ам (Р3 зэргээр алт-80 кг), Баян тохой, Цагаан толгой, Их Номгон, зэсийн Урт булаг, Ил худаг, холимог металлын Буйлст, элсний Угалзын ам, шаврын Зуух булаг (Р1 зэргээр 232.8 мян.тн), Ширээ тэг (Р1 зэргээр 26.1 сая тн), Далан шар уул (Р3 зэргээр хром-526526 тн, никель-171515 тн), Дөш уулын төмөр зэрэг ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайг илрүүлсэн. 2022 онд 33 төслийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд: 1. Үргэлжлэн хэрэгжих болон шинээр эхлэх нийт 33 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулсан. 2. Үргэлжлэн хэрэгжих 27 төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЭБМЗ-ийн төсөл тус бүрийн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2022 оны тушаалаар баталгаажуулсан. 3. Шинээр хэрэгжүүлэх Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мэст уул-50, Ямбат уул-50, Овоот шар-50 нийт 6 төслийн геологийн даалгаврыг боловсруулан 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн дэд сайдаар батлуулан, төслүүдийн гүйцэтгэгчийг холбогдох хуулийн хүрээнд шалгаруулан зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулж ажлыг эхлүүлсэн. 4. Үр дүнгийн тайлантай болон хээрийн судалгааны ажилтай 33 төслийн 2022 онд гүйцэтгэсэн ажлыг баталгаажуулан хүлээн авсан. | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 99 | холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ. | 3.2.2. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулах | Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулах | Гүйцэтгэл 66 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 163.7 | Улсын төсөв | 163.7 | 1. Монгол Улсын баруун, баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны 2022 оны хээрийн шалгах ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан. 2. Ховд-2020 төслийн 2022 оны хээрийн ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 3. 2020-2021 онд нийт 104,044.0 кв.км буюу нутаг дэвсгэрийн 6.6%-д агаарын геофизикийн хэмжилт хийх нислэгийг дуусгасан. Нислэгийн ажлыг дуусгаснаар нутаг дэвсгэрийн 66%-ийг агаарын геофизикийн хэмжилтийн ажилд хамруулсан. 4. Төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг ҮГА-тай хамтран 2022 оны 11 дүгээр сарын 22-нд хүлээн авсан. | 100.0 |
| 100 | | 3.2.3. Геохимийн 1:1000000-ны масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулах | Геохимийн 1:1000000-ны масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулах | Гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 100.9 | Улсын төсөв | 125.5 | 1. 2009-2011 онд МУ, БНХАУ-ын хилийн дагуу 501,909 км2 талбайг буюу 32.1%-ийг 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд хамруулсан бөгөөд 2019 оноос Монгол орны нутаг дэвсгэрийн үлдсэн хэсгийг уг судалгааны ажилд бүрэн хамруулахаар хэрэгжүүлж эхэлсэн. 2019-2021 онд нутаг дэвсгэрийн үлдсэн 1,062,197.0 км2 буюу 67.9%-д хээрийн судалгаагаар хамруулан холбогдох дээжлэлтийг авч дууссан. 2. 2019-2021 онд гүйцэтгэсэн хээрийн судалгааны ажлын үр дүнгээр боловсруулах тайлангийн суурин боловсруулалтын ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулж ажлыг эхэлсэн. 3. Төслийн 2022 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 4. Төслийн 2022 оны суурин боловсруулалтын ажлын анхдагч баримт, материалыг ҮГА-тай хамтран 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүлээн авсан. | 100.0 |
| 101 | | 3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах | Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах | Гүйцэтгэл 60 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 500.0 | Улсын төсөв | 656.8 | 1. 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх Геологийн баримт-1-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдаар батлуулан, геологийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.07.08-нд гүйцэтгэгчтэй байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. 3. Төслийн 2022 оны суурин болон хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүлээн авсан. | 100.0 |
| 102 | | 3.2.5. Бүс нутаг болон хотуудын геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийх | Бүс нутаг болон хотуудын геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийх | 6 төсөл | Улсын төсөв | 1,300.0 | Улсын төсөв | 2,938.3 | 1. 2022 онд үргэлжлэх Эрдэнэт, Дархан, Ховд хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлыг хэрэгжүүлэхээр ЭР геоэкологи-2019, ДА геоэкологи-2020, ХО геоэкологи-2021 болон Хангай, Хөвсгөл, Хэнтийн районы халуун рашааны геотермийн Гүний хагарал-1, Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух нутгийг хамарсан геологийн орчин, тогтоцын судалгааны Гео орчин-2022 нэртэй төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталж, ажлыг эхлүүлсэн. 2. Төслүүдийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 3.2022 онд Улаанбаатар болон Эрдэнэт хотын эзэмшил газарт хийгдсэн судалгааны ажлын үр дүнг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. 4. ХО геоэкологи-2021, Гүний хагарал-1 төслүүдийн хээрийн судалгааны ажилд 8-р сард шуурхай хяналтыг хийсэн. 5. ДА геоэкологи-2020, ХО геоэкологи-2021 төслүүдийн 2022 оны суурин болон хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2022.11.28-нд, Гео орчин-2022, Гүний хагарал-1 төслийн материалыг 2022 оны 12 дугаар сарын 01-нд хүлээн авсан. | 100.0 |
| 103 | | 3.2.6. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлвийн үнэлгээ өгөх | Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлвийн үнэлгээ өгөх | 2 төсөл | Улсын төсөв | 1,000.0 | Улсын төсөв | 969.7 | 1. 2022 онд хэрэгжүүлэх өндөр технологийн түүхий эд /газрын ховор элемент/-ийн ӨТТЭ-1-2021, ӨТТЭ-2-2022 төслүүдийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан. 2. ӨТТЭ-1-2021 төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 3. Шинээр хэрэгжүүлж эхлэх өндөр технологийн түүхий эдийн судалгаа /ӨТТЭ-2-2022/-ны геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 4. ӨТТЭ-2-2022 төслийн гүйцэтгэгчтэй зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.06.10-нд байгуулан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. 5. Дээрх 2 төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг ҮГА-тай хамтран 2022.11.15-17-ны өдрүүдэд хүлээн авсан. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 104 | 3.2.7. Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах | Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах | Гүйцэтгэл 60 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 1,000.0 | Улсын төсөв | 271.1 | 1. 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх Чулуун дээжийн сан-1-2022 болон Цахим архив-1-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 2. Чулуун дээжийн сан-1-2022 болон Цахим архив-1-2022 төслийн гүйцэтгэгчтэй геологийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг 2022 оны 11 дүгээр сарын 30-нд байгуулж судалгааны ажлыг эхлүүлсэн. | 70.0 |
| 105 | 3.2.8. Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх | Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх | 3 төсөл | Улсын төсөв | 1,450.0 | Улсын төсөв | 1,749.1 | 1. 2022 онд Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан Мезозой, Кайнозойн насны хурдас чулуулгийн тархалт, тогтоц, түүнтэй холбоотой үүссэн ашигт малтмалын минерагенийн судалгааны Мезо-Кайнозой-2021 болон шинээр хэрэгжүүлэх Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух нутгийг хамарсан геологийн орчин, тогтоцын судалгааны Гео орчин-2022, Баруун Монголын шатах ашигт малтмалын хэтийн төлөвийг тогтоох БМШАМ-2022, Монгол орны алтны металлогенийн зураг зохиох Мета-алт-500 төслийг төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн дэд сайд баталсан. 2 Мезо-Кайнозой-2021 төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 3. БМШАМ-2022, Мета-алт-500 төслийн гүйцэтгэгч хуулийн этгээдтэй геологийн судалгааны ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.06.10, 2022.07.08-нд байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. 4. БМШАМ-2022, Мета-алт-500 төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлыг 2022.11.16-20-ны өдрүүдэд хүлээн авч, баталгаажуулсан. | 100.0 |
| 106 | 3.2.9. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлвийн үнэлгээ өгөх | Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлвийн үнэлгээ өгөх | 4 төсөл | Улсын төсөв | 3,566.8 | Улсын төсөв | 8,560.0 | 1. Эрэл үнэлгээ-1-2020, Эрэл үнэлгээ-2-2021, Эрэл үнэлгээ-3-2021, Эрэл үнэлгээ-4-2022 болон БӨМ-Алт-2019 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөө УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-өөр хэлэлцсэн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 2. Төлөвлөгөөт онд шинээр хэрэгжүүлэх Эрэл үнэлгээ-4-2022 төслийн геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 3. Эрэл үнэлгээ-4-2022 төслийн гүйцэтгэгчтэй геологийн судалгааны ажлын ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.06.10-нд байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. 4. Төслүүдийн 2022 оны хээрийн судалгааны ажилд шуурхай хяналтыг 8-9 дүгээр сард хийсэн. 5. Эрэл үнэлгээ-2-2021, Эрэл үнэлгээ-3-2021, Эрэл үнэлгээ-4-2022 төслүүдийн 2022 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2022.11.15-21-ны өдрүүдэд хүлээн авсан. | 100.0 |
| 107 | 3.2.10. Газрын тос дамжуулах хоолой барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, инженер техникийн зураг төслийг боловсруулж батлан, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах | Газрын тос дамжуулах хоолой барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, инженер техникийн зураг төслийг боловсруулж батлан, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах | Дамжуулах хоолойн инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. Хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна. | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 530,100.0 | - | - | Дорноговь аймагт 1334.66 га, Дорнод аймагт 1386.2 га газрыг дамжуулах хоолойн хэрэгцээнд зориулан "Улсын тусгай хэрэгцээ"-нд авахыг тус аймгийн ИТХ-аар дэмжсэн шийдвэр гарсан. Сүхбаатар аймгийн ИТХ-ын 12-р сарын хурлаар тус аймагт хамаарах дамжуулах хоолойн газрын асуудлыг хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, Халзан сум, Дорноговь аймгийн Дэлгэрэх сум, Дорнод аймгийн Матад сумын ИТХ-ын шийдвэрээр халаах-өргөх станцуудын хэрэгцээнд газар олгохыг дэмжсэн шийдвэр гарсан. Газрыг гэрчилгээжүүлэхээр газар эзэмших хүсэлт, дагалдах баримт бичгийн бүрдэлийг хангаж тус сумдын Засаг дарга болон газрын албанд хүргүүлээд байна. Барилга угсралтын үеийн түр кемпүүдийн барилгын ажлыг эхлүүлээд барилга угсралтын ажил -35%, түр замын ажил -15%, Геодезийн цэг тэмдэгт суулгах ажил -100%, байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -60%, геотехникийн судалгааны ажил -80%, дээжлэлт шинжилгээ -80%. Тосон-Уул 19, Тамсаг XXI талбайн нэгдсэн байгууламжаас 17,5 л ба 16,7л дээж авч тосны дээж авсан. Тус дээжийг БНХАУ-ын Шанхай хот дахь Intertek компанийн лабораторт илгээсэн, хариу хүлээгдэж байна. Канад улын Ворлэй Инженеринг компани дамжуулах хоолойн Суурь Инженерчлэлийн Загвар (FEED) боловсруулах ажлыг 10-р сарын 15-ны өдрөөс эхлүүлээд ажил -25% байна. БОАЖЯ-аас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт хийгдсэн. БОННҮ хийх ажил 90 хувь хийгдсэн. | 50.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 108 | 3.2.11. Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх | Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх | 2020-2021 онд хийж эхэлсэн барилга угсралтын ажлуудыг дуусгаж, лицензтэй байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийг 60 хувьд хүргэсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 288,456.9 | Гадаадын зээл, тусламж | 288,456.9 | Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.12.16-ны өдрийн байдлаар 77.0%-тай байна. Эдгээрт Түүхий ус хадгалах сав-98,69%, Оффис, сургалтын төв-81%, Хоолны газар-90%, Лаборатори-90%, Эмнэлгийн барилга-84%, Агуулах-63,7%, Нэвтрэх хаалга-1-82,80%, Нэвтрэх хаалга-2-56,32%, Гал унтраах ангийн барилга-68,29%, Засварын цех-57%, Үерийн ус цуглуулах талбай-82,5%, Ус зайлуулах хоолой-53,0%, Ус дамжуулах хоолой-95%, 17км авто зам-60,63%, Ус дамжуулах хоолой-/Бор хөөвөр/-72,65%, Худгийн барилга-79,74%, Цахилгаан дамжуулах агаарын шугам-96,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /EPC-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.06.06-ны өдөр зарласан ба 2022.09.19-ны өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /EPC-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.05.04-ний өдөр зарласан ба 2022.07.04-ний өдөр тендер хүлээн авсан. EPC-2, EPC-3 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын "Megha Engineering & Infrastructure Limited" (Мега инженеринг инфраструкчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК, "Megha Engineering & Infrastructure Limited" компани хооронд 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /EPC-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Үсэрэгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс текнолоджи компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжийн Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичиг боловсруулж байна. | 70.0 |
| 109 | 3.2.12. Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах | Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах | Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг шийдвэрлэсэн байна /20 хувь/. | - | - | - | - | Засгийн газрын 2017 оны 92 дугаар, ТӨБЗГ-ын 2017 оны 108 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн өдөр тутмын үйл ажиллагаар хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит компанийг байгуулсан. ЗГХЭГ-ын дарга болон УУХҮСайд нарын 2021 оны 16 А/32 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлын хэсэг ажилласан. Үүнтэй холбогдуулан газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит "Эрчис Ойл" ХХК, "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ, "Эрдэнэс метан" ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийг нэгтгэн зохион байгуулж, газрын тосны хайгуул, судалгаа ашиглалт, боловсруулалт, хангамжийн үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг ажлын хэсгийн дүгнэлт болон Засгийн газрын шийдвэрийн төсөлд тусгуулах саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн хуралдааны 47 дугаар тогтоолоор өгсөн үүрэг даалгавартай холбогдуулан УУХҮСайд 2021 оны 03 дугаар сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагатай хийсэн уулзалтын ярианы сэдэвт газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудыг нэгтгэн зохион байгуулж, төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг тусгуулан, хэлэлцүүлсэн. Газрын тосны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох зохицуулалтыг тусган боловсруулж байна. | 30.0 |
| 110 | 3.2.13. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хэрэгнэ оруулалтын асуудлыг шийдвэрлэх | Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх | Гүйцэтгэл 20 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 1,500.0 | - | - | Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 7 хувьтай хэвээр байна. | 30.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 111 | 3.2.14. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн "Ул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд дэд бүтэц барих | "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд дэд бүтэц барих | Үйлдвэрлэл, технологийн паркийн авто зам, дулаан, ус хангамж, төмөр зам, ариутгах татуургын сүлжээ барих ажлыг гүйцэтгэнэ /100 хувь/. | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 128,663.0 | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 128,663.0 | Үйлдвэр технологийн паркийн (ҮТП) авто зам, төмөр зам, ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төсөл, төсвийг гүйцэтгэж, Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан. Цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг 100% гүйцэтгэж, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. Батлагдсан зураг төсөл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу дэд бүтцийг барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтын ажлыг эхлүүлээд байна. Үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц барьж байгуулах ажлын хүрээнд: - Автозам барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 3 дахь удаагийн тендер хүчингүй болсон, 4 дэх тендер зарлахаар ажиллаж байна. - Төмөр зам барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 2 дахь удаагийн тендерийг 2022.11.07-нд зарласан бөгөөд 2022.12.12-ны өдөр нээсэн бөгөөд үнэлгээ хийгдэж байна. - Ус хангамж, ариутгах татуургын системийг барьж байгуулах ажлын тендер хүчингүй болсон. Дахин тендер зарлахаар ажиллаж байна. -Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах ажлыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Зураг төслийн хүрээлэн гүйцэтгэхээр болж, ажлын төсөвт өртгийг батлуулах ажил хийгдэж байна. "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" Засгийн газрын 2022 оны 171 дүгээр тогтоолын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк барих зориулалтаар 1217.4 га газар ашиглах 2022/185 дугаартай гурвалсан гэрээг УУХҮЯ, ГЗБГЗЗГ, Орхон аймгийн Засаг дарга нар 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр №000000019 дугаартай газрын гэрчилгээг Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны нэр дээр авсан. | 50.0 |
| 112 | 3.2.15. "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлэх | "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлэх | Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, инженерийн зураг төсөл боловсруулж, үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, гүйцэтгэлийг 10 хувьд хүргэсэн байна. | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 670,451.0 | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 670,451.0 | Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь БНХАУ-ын "China ENFI Engineering" компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр 2022.06.23-нд хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Зэсийн үнэ 8340 $/тн-ны түвшинд 762 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан. Тус ТЭЗҮ-г үндэслэн Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн төслийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгаврыг "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ"-ын "Үйлдвэрлэл, технологийн парк төслийн нэгж" боловсруулсан. Үүний дагуу "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Худалдан авах ажиллагааны газарт 2022.09.22-ны өдөр хүргүүлсэн ба Үнэлгээний хороо байгуулагдаж тендер зарлахаар ажиллаж байна.Валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан тус ажлын төсөвт өртөгт өөрчлөлт оруулсан бөгөөд Эрдэнэт үйлдвэрийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахаар ажиллаж байна. Зэсийн баяжмал хайлуулах үйлдвэрээс гарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinxin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулахаар төлөвлөсөн. Туршилт явуулах үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламжийн нарийвчилсан зураг төслийн ажлууд 98%, тоног төхөөрөмжийн захиалга, худалдан авалт 96%-ийн гүйцэтгэлтэй байгаа ба үлдсэн тоног төхөөрөмжүүд үйлдвэрлэгдэх шатанд байна. Барилга байгууламжийн суурийн ажил 2022 оны 8 дугаар сараас хийгдэж эхэлсэн. Үндсэн тоног төхөөрөмжүүдийн үйлдвэрлэлийн хяналт шалгалтуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн ба үйлдвэрлэгчийн агуулахаас тээвэрлэхэд бэлэн болоод байна. Гэвч БНХАУ-д үүсээд буй Ковид-19 цар тахлын хорио цээрийн улмаас үйлдвэрлэгдсэн тоног төхөөрөмжүүдийг төсөл хэрэгжүүлэх талбай руу тээвэрлэх боломжгүй байгаа тул туршилтын ажлын гүйцэтгэлийн хугацааг 2023.11.10-ны өдөр дуусгах төлөвлөгөөг гүйцэтгэгчээс ирүүлсэн. | 30.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 113 | 3.2.16. "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологийн катодын зэсийн үйлдвэр барих | "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологийн катодын зэсийн үйлдвэр барих | Үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэсэн байна /100 хувь/. | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 167,371.0 | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 167,371.0 | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын захиалгаар "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-ийн боловсруулсан "Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор катодын зэс боловсруулах үйлдвэр"-ийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдааны 2022.06.24-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Гэвч "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөлийн 2022.10.13-ны өдрийн хурлаас "Гүйцэтгэгч компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын техникийн зөвлөлөөр хэлэлцэх"-ээр шийдвэрлэсэн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Техникийн зөвлөлийн 2022.11.04-ний өдрийн хуралдаанаар тус ТЭЗҮ-ийг хэлэлцэж, Эрдэнэт үйлдвэрийн мэргэжилтнүүдийн өгсөн санал, шүүмжийн дагуу ТЭЗҮ-ийг засварлан боловсруулах, үүнд шаардлагатай хугацааг харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгах, ТЭЗҮ-ийг засварласны дараа Техникийн зөвлөлөөр дахин хэлэлцүүлж дэмжсэн тохиолдолд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу гэрээний хугацааг 2023.03.31-ний өдөр хүртэл сунгах саналыг Эрдэнэт үйлдвэрийн ХОХААБГ-т, Техникийн зөвлөлийн шийдвэрийг гүйцэтгэгч компанид тус тус албан бичгээр хүргүүлж, гүйцэтгэгч компаниас 2022.11.22-ны өдрийн 038/22 дугаар албан бичгээр Эрдэнэт үйлдвэрийн мэргэжилтнүүдийн өгсөн санал, шүүмжид өгсөн тайлбарыг ирүүлсний дагуу гүйцэтгэгч компанийн төлөөлөлтэй 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр цахим хурлыг зохион байгуулж ТЭЗҮ-ийг шинэчлэн засварлахаар тохиролцсон. ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 30 хувьтай байна. | 30.0 |
| 114 | 3.2.17. Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлыг үргэлжлүүлэх | Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлыг үргэлжлүүлэх | Гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж<br>Төр-хувийн хэвшлийн түншлэл | 292,181.8<br>348,006.2 | Гадаадын зээл, тусламж | 292,181.8 | Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн гүйцэтгэл 20%-тай байна. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7 хувьд хүрсэн. Ачилтын нэгдсэн төвийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 46.1 хувь, байна. Загийн усны хоолой усан хангамжийн төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн бөгөөд төслийн нийт гүйцэтгэл 69.7 хувьд хүрсэн. | 50.0 |
| 115 | 3.2.18. Үнэт металлын сорьцын хяналтын газрын сорьц тогтоох лаборатори байгуулж үнэт металлыг сорьцлох, эрдэнийн чулууг тодорхойлох үйл ажиллагааг өргөжүүлэх. Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх | Үнэт металлын сорьцын хяналтын газрын сорьц тогтоох лаборатори байгуулж үнэт металлыг сорьцлох, эрдэнийн чулууг тодорхойлох үйл ажиллагааг өргөжүүлэх. Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх | 3 лаборатори | Улсын төсөв | 500.0 | - | - | Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 48 дугаар тушаалаар "Үнэт металлын сорьц тогтоох салбар лаборатори байгуулах" үүрэг бүхий ажлын хэсгийг Стандарт, хэмжил зүйн газар, Монгол банк, УУХҮЯ, АМГТГ-ын төлөөллийг оролцуулан байгуулсан. - 2022 онд тус ажлын хэсгээс салбар лабораторийг Зүүн бүсэд буюу Хэнтий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дэргэд байгуулахаар санал боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн. Хэнтий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн байранд тус лабораторийг байрлуулахаар 89.23 метр квадрат 3 өрөөг бэлтгэсэн. - Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан бөгөөд тус хуульд Үнэт металлын сорьц тогтоох үйл ажиллагааг зөвхөн сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтоох нь зохимжгүй гэж үзэж сорьц тогтоох эрх бүхий хуулийн этгээд мөн хийж гүйцэтгэж болохоор заасан. Иймд эрх бүхий байгууллагаас шийдвэр гарах ажил хүлээгдэж байна. (Эрдэнэсийн сангийн тухай хууль: 15.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт эрдэнэс эзэмшигч хүн, хуулийн этгээд, бусад байгууллага нь эрдэнэсийн санд худалдах эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлийг сорьц тогтоох эрх бүхий хуулийн этгээд, эсхүл сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар сорьц тогтоолгон баталгаажуулсан байх үүрэгтэй.) | 70.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 116 | | 3.2.19. Баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулан, хэрэгжүүлж эхлэх | Баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулан, хэрэгжүүлж эхлэх | Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу төрийн нийтийн өмч болох газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг үндэсний баялгийн санд төвлөрүүлж, байгалийн шавхагдах баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар байгалийн баялгийн үр өгөөжийг өнөө болон ирээдүй хойч үедээ тэгш, шударга хуваарилах боломжтой болно. | - | - | - | - | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас санал авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн хуралдаанд танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022.06.17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг хангаан хүргүүлсэн болно. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл, холбогдох бусад албан бичиг, материалуудыг Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад хүргүүлсэн. | 100.0 |
| 117 | | 3.2.20. Зүүн Цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах | Зүүн Цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах | Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 27,650.0 | Гадаадын зээл, тусламж | 27,650.0 | Зүүн цагаан дэлийн далд уурхайн эхний ээлжийг 2022.09.28-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн. Зүүн Цагаан дэлийн хайлуур жоншны далд уурхайн 2 налуу гол амны малталт нэвтрэлтийн ажлыг гүйцэтгэж, 2022 оны 12 дугаар сарын байдлаар 1199.5 у.м нэвтэрч, /9894,7 м3 улын цул нураасан улын ажил хийж 78.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Уурхайн доод түвшин 1150 м. Уурхайн дэд бүтэц цахилгаан дамжуулах агаарын шугам барих болон кэмпийн барилга байгууламжийн ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байна. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах бэлтгэл ажил 50 хувьд хүрсэн. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100 хувь. | 90.0 |
| | | | | | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 11,850.0 | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 11,850.0 | | |
| 118 | | 3.2.21. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах | Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах | Гангийн үйлдвэрийн барилгын ажил, тоног төхөөрөмжийн татан авалт, угсралтын ажлыг гүйцэтгэж, түүхий эдийн татан авалт 88 хувьтай байна. | Концесс, ТХХТ | 9,000.0 | - | - | Дорноговь аймагт "МДМУ" ХХК-ийн хэрэгжүүлж буй хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах төслийн ажил цар тахал, хилийн хорио, үлдэгдэл хөрөнгө оруулалт шийдэгдээгүйн улмаас 2022 оны 12 дугаар сарын байдлаар зогсонги байдалд байна. Төслийн нэмэлт хөрөнгө оруулалтын хувилбаруудыг судалж байна. | 0.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 119 | 3.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ. | 3.3.1. Байгаль орчин, нийгэмд ээлтэй, ногоон төслүүдийн санхүүжилтийг дэмжих үндэсний тогтолцоо, ногоон зээлийн сангий болгоход бодлогын дэмжлэг үзүүлэх | Байгаль орчин, нийгэмд ээлтэй, ногоон төслүүдийн санхүүжилтийг дэмжих үндэсний тогтолцоо, ногоон зээлийн санг бий болгоход бодлогын дэмжлэг үзүүлэх | Байгаль орчин, нийгэмд ээлтэй, ногоон төслүүдийн санхүүжилт бий болсон байна. | - | - | - | - | 1. Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж БОАЖЯ, НҮБ-ын Уур амьсгалын ногоон сан /УАНС/ болон холбогдох бусад талуудтай хамтран төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан үндэсний ногоон санхүүгийн тогтолцоо буюу Монголын ногоон санхүүгийн корпорац /МНСК/ байгуулахаар хөрөнгө оруулалтын төслийн саналыг УАНС-ийн Удирдах зөвлөлийн 2020.11.11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. МНСК-ийн хувьцаа захиалгын гэрээ болон хувьцаа эзэмшигчдийн гэрээний төслийг холбогдох талуудтай хамтран боловсруулж, байгуулах бэлтгэл ажлыг 2022 оны 01-р сарын байдлаар бүрэн хангасан. 2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2022 оны 03-р сард зохион байгуулагдсан "Ногоон санхүүжилт-Бүс нутгийн чуулган"-аар байгаль хамгаалах итгэлцлийн сан байгуулах асуудлыг хэлэлцүүлсэн. Монгол Улсад БХИС байгуулах чиглэлээр хамтран ажиллах 5 талт харилцан ойлголцлын санамж бичиг 2022.05.19-ний өдөр гарын үсэг зурсан. БОАЖСайдын 2022 оны А/193 тоот тушаалаар Сангийн яам, Монгол Банк, Санхүүгийн зохицуулах хороо, холбогдох олон улсын байгууллагын төлөөллийг оролцуулан БХИС байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлыг хэсгийг нийт 3 удаа хуралдуулж, сан байгуулах ажлын төлөвлөгөө 2022 оны 11-р сард баталсан. 3. "Шинэ сэргэлтийн бодлого"-ын ногоон хөгжлийн сэргэлтийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэхэд чиглэсэн ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Европын Холбоо хооронд "Ойн хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн төслийг Гадаад харилцааны яамтай хамтран зөвшилцөж, 2022 оны 11-р сард байгуулсан. 4.Орчны бохирдлыг бууруулах, ногоон төсөл хөтөлбөрийг дэмжих, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж, 2021 оныхтой харьцуулахад ногоон зээлд хамрагдах бүтээгдэхүүний тоог 9-өөр нэмэгдүүлж нийт 34 бүтээгдэхүүн болгосон. 2022 онд 1.7 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаасын эх үүсвэрийг төсөвлөн 320 иргэн, аж ахуйн нэгжид жилийн 3-8 хувийн хүүтэй ногоон зээл олгосон. | 100.0 |
| 120 | | 3.3.2. Энгийн болон инженерийн хийц бүхий услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлах замаар усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх | Энгийн болон инженерийн хийц бүхий услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлах замаар усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх | Усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 1500 га-гаар нэмэгдүүлсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 11,368.0 | Гадаадын зээл, тусламж | 15,246.0 | 1. Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж БОАЖЯ, НҮБ-ын Уур амьсгалын ногоон сан /УАНС/ болон холбогдох бусад талуудтай хамтран төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан үндэсний ногоон санхүүгийн тогтолцоо буюу Монголын ногоон санхүүгийн корпорац /МНСК/ байгуулахаар хөрөнгө оруулалтын төслийн саналыг УАНС-ийн Удирдах зөвлөлийн 2020.11.11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. МНСК-ийн хувьцаа захиалгын гэрээ болон хувьцаа эзэмшигчдийн гэрээний төслийг холбогдох талуудтай хамтран боловсруулж, байгуулах бэлтгэл ажлыг 2022 оны 01-р сарын байдлаар бүрэн хангасан. 2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2022 оны 03-р сард зохион байгуулагдсан "Ногоон санхүүжилт-Бүс нутгийн чуулган"-аар байгаль хамгаалах итгэлцлийн сан байгуулах асуудлыг хэлэлцүүлсэн. Монгол Улсад БХИС байгуулах чиглэлээр хамтран ажиллах 5 талт харилцан ойлголцлын санамж бичиг 2022.05.19-ний өдөр гарын үсэг зурсан. БОАЖСайдын 2022 оны А/193 тоот тушаалаар Сангийн яам, Монгол Банк, Санхүүгийн зохицуулах хороо, холбогдох олон улсын байгууллагын төлөөллийг оролцуулан БХИС байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлыг хэсгийг нийт 3 удаа хуралдуулж, сан байгуулах ажлын төлөвлөгөө 2022 оны 11-р сард баталсан. 3. "Шинэ сэргэлтийн бодлого"-ын ногоон хөгжлийн сэргэлтийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэхэд чиглэсэн ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Европын Холбоо хооронд "Ойн хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн төслийг Гадаад харилцааны яамтай хамтран зөвшилцөж, 2022 оны 11-р сард байгуулсан. 4.Орчны бохирдлыг бууруулах, ногоон төсөл хөтөлбөрийг дэмжих, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж, 2021 оныхтой харьцуулахад ногоон зээлд хамрагдах бүтээгдэхүүний тоог 9-өөр нэмэгдүүлж нийт 34 бүтээгдэхүүн болгосон. 2022 онд 1.7 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаасын эх үүсвэрийг төсөвлөн 320 иргэн, аж ахуйн нэгжид жилийн 3-8 хувийн хүүтэй ногоон зээл олгосон. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 121 | 3.3.3. Таримлын үрийн аж ахуйг хөгжүүлж, үрийн чанар, хангамжийг сайжруулах | Таримлын үрийн аж ахуйг хөгжүүлж, үрийн чанар, хангамжийг сайжруулах | Улаан буудайн супер элит үрийн хэмжээг 150 тн-оор, элит үрийн хэмжээг 1000 тн-оор, төмсний бичил булцууны үйлдвэрлэлийг 210.0 мянган ширхгээр, хүнсний ногооны 6 нэр төрлийн үрийн үйлдвэрлэлийг 11000 кг-аар, тэжээлийн таримлын үрийг 1000 тн-оор тус тус нэмэгдүүлсэн байна. | Улсын төсөв | 2,000.0 | Улсын төсөв | 2,037.4 | Таримлын үрийн аж ахуйг хөгжүүлэх үрийн чанар хангамжийг сайжруулах чиглэлээр "Шинэ сортын улаанбуудайн супер элит үр гаргах" зөвлөх үйлчилгээ зарлан улсын төсвийн 260.0 сая төгрөгийн санхүүжилтээр Дархан Уул аймаг дахь Ургамал газар тариалангийн хүрээлэн зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхээр шалгарч 05 сарын 04-ний өдрийн 220505/05-237 дугаар гэрээ байгуулсан ба 11 дүгээр сарын 26 ны өдөр ажлын хэсэг гэрээт ажлыг хүлээн авав. Үржүүлгийн анхдагч 9 тн буудайн үр, бөөний сонголтын аргаар гаргасан 56 тн үржүүлгийн үрийг гарган гэрээт ажлыг Дархан-уул аймаг дахь ХААДС-нд хүлээн авлаа. Үүний үр дүнд 2023 оны үр үржүүлэх тариалалтад тариалснаар 2024 оны тариалалтад 350 тн супер элит үрийн нөөц бүрдүүлэх юм. 2022 оны ургацаас аж ахуйн нэгжүүд өөрийн тариалалтын үрийн хэрэгцээнд 48.0 мянган тн , Онцгой байдлын ерөнхий газар, ХААДС-нд нийт улаанбуудайн үр 5.0 тн үр нөөц бүрдүүлсэн. Төмсний үр үржүүлэгч Шар чулуут ХХК, Хонгор буудай ХХК, Ньюкроп ХХК, Шандас өгөөж ХХК аж ахуйн нэгжид 37.5 тн элит үрийг Засгийн газрын тогтоолоор хөнгөлөлттэй олгосон бөгөөд 15 га -д тариалж 270 тн үрийн ургац хураан авч 2023 оны тариалалтад нөөцөлсөн. Аж ахуйн нэгж, өрхүүд 45.0 мянган тн үрийн нөөцтэй байна. УГТХ болон үр үржүүлэгч Элит үр ХХК вирусгүй бичил булцуу 180.0 мянган ширхэг үр хураан авч нөөц бүрдүүлэв. Хүнсний ногооны 35.0 тн үр нөөцөлсөн. | 90.0 |
| 122 | 3.3.4. Тариалангийн талбайн хог ургамал, хортон шавж, ургамлын өвчин, мэрэгч гэх мэт хөнөөлт организмын тархалтын судалгааг хийх, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх | Тариалангийн талбайн хог ургамал, хортон шавж, ургамлын өвчин, мэрэгч гэх мэт хөнөөлт организмын тархалтын судалгааг хийх, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх | -Төвийн бүсэд тариалангийн судалгааг хийсэн байна. -Хөнөөлт организмын тархалтын судалгааг 645.6 мянган га-д хийсэн байна. -Технологийн зөвлөмж, сургалтыг 4 удаа хийнэ. -Урьдчилан сэргийлэх технологийн зөвлөмж гаргасан байна. | Улсын төсөв | 100.0 | Улсын төсөв | 100.0 | Ургамал хамгааллын тухай хуулийн дагуу жил бүр тариалангийн талбайн хөнөөлт организмын тандан судалгаа, хөнөөлийг тодорхойлох, тэмцэх арга хэмжээ боловсруулах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд 2023 онд "Төвийн бүсийн Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Орхон, говийн бүсийн Говь-Сүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын тариалангийн талбайн ургамлын өвчин, хог ургамал, хортон шавж, мэрэгчийн /хөнөөлт организм/ тархалт, олшролт, хор хөнөөлийн судалгаа" зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр УХЭШХ-тэй гэрээ байгуулсан. УХЭШХ -ээс ажил гүйцэтгэсэн тухай албан бичиг болон ажлын тайланг ирүүлсний дагуу Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан Газар тариалангийн чиглэлээр бараа, ажил, үйлчилгээ хүлээн авах ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан. Энэхүү судалгаанд төлөөлүүлэн дээрх 8 аймгийн 60 сумын тариалангийн талбайн 34392 га талбай хамрагдсан. Хөнөөлт организмын тархалт, тэмцэх арга хэмжээ цаашид анхаарах асуудлын талаар ажлын хэсэгт танилцуулж судалгааны үеэр шинээр илэрсэн хорио цээртэй болон хязгаарлагдмал тархалттай хөнөөлт организмын талаар арга хэмжээ авах, говийн бүсэд төмс, хүнсний ногоо, хүлэмжийн тариалалт ихэссэнтэй холбогдуулан тус аймгуудын газар тариалангийн мэргэжилтнүүд болон тариаланчдыг ургамал хамгааллын арга хэмжээ болон хөрсний үржил шимийг сайжруулах чиглэлээр танхимийн болон талбайн сургалтыг зохион байгуулах, хорио цээртэй хөнөөлт организмыг цаашид тархахгүй байх талаар шаардлагатай арга хэмжээ авах талаар онцлон тэмдэглэсэн. Ажлын хэсгээс ажлын тайланд дэлгэрэнгүй мэдээлэл оруулах талаар санал зөвлөмжийг гаргасан. Тус хүрээлэнгээс санал зөвлөмжийн дагуу мэдээллийг нэгтгэн ирүүлсэн ба хөнөөлт организмыг таних каталоги, тэдгээрийн тархалтын зураг, тэмцэх арга хэмжээг боловсруулан ирүүлсэн тул ажлын хэсгээс гэрээт ажлыг бүрэн хийсэн гэж үзсэн. Мөн Ажлын даалгаварт заасны дагуу тус оны 6 сард таримал ургамлыг хөнөөлт организмоос хамгаалах зорилгоор урьдчилсан зөвлөмжийг ирүүлсний дагуу аймгуудын ХХААГ-т хүргүүлсэн. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 123 | 3.3.5. Махны нөөц бүрдүүлэх | Махны нөөц бүрдүүлэх | Нийтийн хэрэгцээнд нийлүүлэх махны хэмжээг 20.0 мянган тн-д хүргэсэн байна. | - | - | Улсын төсөв | 10,400.0 | Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тогтворжуулах зорилгоор Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас 2022 онд Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, "Гурил, махны үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 174 дүгээр тогтоолыг тус тус баталсан. Уг тогтоолд нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжид шаардлагатай 130.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1 жилийн хугацаатай, жилийн 3 хувь хүүтэй, зээлийн хүүгийн хөнгөлөлтөд улсын төсвөөс олгох татаасыг тухайн зээлийн нийт хүүгийн 10.5 хувьтай тэнцүү хэмжээгээр санхүүжүүлэхийг шийдвэрлэсэн. Түүнчлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголбанк хамтран нөөцийн мах бэлтгэлийн эх үүсвэрийг банкны саналд үндэслэн урт хугацаат репо арилжаагаар Монголбанкнаас 3 арилжааны банк (Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк)-д 63.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, өнөөдрийн байдлаар 10 аж ахуйн нэгж, 50.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгох тухай шийдвэрийг арилжааны банкнаас гаргасан. Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэхэд арилжааны банкны шаардлага хангасан аж ахуйн нэгжтэй холбогдох гэрээг байгуулах, тохиролцох, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 50.0 |
| 124 | 3.3.6. Мал, амьтан, ургамлын гаралтай органик хүнсийг баталгаажуулан худалдааны түнш орнуудад хүлээн зөвшөөрүүлэх | Мал, амьтан, ургамлын гаралтай органик хүнсийг баталгаажуулан худалдааны түнш орнуудад хүлээн зөвшөөрүүлэх | Органик хүнсийг баталгаажуулах байгууллагын тоог 3 болгон нэмэгдүүлсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 100.0 | - | - | 1. Монгол улсад нийтдээ 22 хамтын, 2 хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллага органик хүнсний баталгаажуулалтыг явуулж, 2022.11.23-ны өдрийн байдлаар баталгаажсан 645 органик, шилжилтийн үеийн органик 33, импортын 82 органик хүнс бүртгэлтэй байна. Монгол улсын 500 гаруй үйлдвэрлэгч 932.5 га талбайд органик үйлдвэрлэл эрхэлж, 2022 онд нийт 170 тн хүнсний ногоо, малын гаралтай 8 тн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлжээ. 2. Органик хүнсний бүртгэл мэдээллийн сан www.organic.gov.mn-ий статистик мэдээллээр 2022 онд Сарлагын мах махан, сүү сүүн болон арьс, хөөвөр дайвар бүтээгдэхүүн баталгаажуулах "Чулуут органик" ХББ, уламжлалт хөдөө аж ахуйн сургалт, судалгаа явуулах, мал аж ахуйн органик үйлдвэрлэлийг баталгаажуулах "Хүнс хөдөө аж ахуйн хөгжлийн үндэсний нэгдэл" ХББ, сүү сүүн бүтээгдэхүүн баталгаажуулах "Хорго органик" ХББ зэрэг мал аж ахжйн чиглэлээр 3 хамтын баталагаажуулалтын байгууллага шинээр бүртгэгдсэн байна. 3. "Органик хөгжил" ХББ-ын гишүүн үйлдвэрлэгч хонины ноосон органик бордоо үйлдвэрлэж, АНУ, ЕХ-д хүлээн зөвшөөрүүлж, 240 тн-ыг экспортлоод байна. 4. Олон улсын органик салбарын мэдээллийг гаргадаг FiBL байгууллагад сүүлийн 2 жил мэдээллээ хүргүүлсэн. 5. "Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн YI чуулган"-ыг 2022.10 сарын 18-ны өдөр Органик хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга "Органик бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэгчдийг дэмжих арга зам" хэлэлцүүлэг, чуулган гэсэн 2 үндсэн чиглэлээр танхим ба цахим хэлбэрээр зохион байгуулав. 6. УИХ-ын гишүүн Ч.Ундрам нарын санаачилсан Органик хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалын төслийг Техникийн туслалцаа үзүүлэх ажлын хэсгийн гишүүний хувьд олон улсын органик үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлага, Монгол улсын органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн туршлага, сургамжид үндэслэн боловсруулсан. | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 125 | | 3.3.7. Түүхий сүүний нийлүүлэлтийг сэрүүний улиралд нэмэгдүүлэх | Түүхий сүүний нийлүүлэлтийг сэрүүний улиралд нэмэгдүүлэх | Өвлийн улиралд хүн амын хэрэгцээнд нийлүүлэх үхрийн шингэн сүүг 22.0 сая литр болгон нэмэгдүүлсэн байна. | Улсын төсөв | 2,500.0 | Улсын төсөв | 5,677.1 | "Сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох" журмыг 22022 онд батлуулсан. Уг журмын хэрэгжилтийг хангах зорилгоор шаардлага хангасан сүү боловсруулах 12 үйлдвэрт 2021 оны 11, 12 дугаар сар, 2022 оны 01, 02, 03 дугаар саруудад 10,6 сая.литр түүхий сүү нийлүүлсэн давхардсан тоогоор 8851 малчин, эрчимжсэн аж ахуй эрхлэгч нарт 5,298,268,900 төгрөгийн мөнгөн урамшууллыг Төрийн сангаар дамжуулан олгосон. 2021-2022 оны бэлтгэн нийлүүлэгчдээс нийлүүлсэн түүхий сүүний хэмжээг 2021-2022 онд нийлүүлсэн түүхий сүүний хэмжээтэй харьцуулахад 23.2 хувиар өссөн байна. Сүүний урамшуулал огт эхлээгүй үед өвлийн улиралд (11,12, 1, 2, 3 саруудад) 16.8 сая.литр түүхий сүү нийлүүлж байсан бөгөөд урамшуулал огч эхэлснээр түүхий сүүний нийлүүлэлт 26.5 хувиар нэмэгдсэн. Мөн түүнчлэн урамшууллын шалгуур үзүүлэлт болох мал эмнэлгийн гэрчилгээний мэдээлэл дутуу, татварын е-баримтын баталгаажсан баримтын мэдээлэл дутуу, ҮСХ-ны малын А дансны мэдээлэл дутуу зэрэг шалтгаанаар урамшууллаас хасагдсан 10,080 гаруй малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид өвлийн улиралд (11,12, 1, 2, 3 саруудад) 12.6 сая.литр түүхий сүү үйлдвэрт нийлүүлэгдсэн байна.Нийт 2021-2022 оны 12-р сарын гүйцэтгэлээр урамшуулалд хамрагдсан 10.6 сая.литр, урамшуулалд хамрагдаагүй 12.6 сая.литр түүхий сүү нийлээд 23.2 сая.литр түүхий сүүг сүү боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн. | 100.0 |
| 126 | | 3.3.8. Тослог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх, тосны үйлдвэрийн түүхий эдийн чанар, хангамжийг сайжруулах | Тослог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх, тосны үйлдвэрийн түүхий эдийн чанар, хангамжийг сайжруулах | 70.0 мянган га талбайд тослог ургамал тариалахаас төрийн дэмжлэгээр 230 тн тослог ургамлын үр импортоор нийлүүлж, 38.0 мянган га талбайд тариалах боломжийг бүрдүүлнэ. Нийт 56.0 мянган тн ургац хураан авна. Үйлдвэрийн хэрэгцээний 62 хувийг дотоодын ургацаас хангасан байна. | Улсын төсөв | 1,600.0 | - | - | Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, дотоодын хүнсний үйлдвэрийн түүхий эдийг дотоодоос хангах, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, түүнчлэн тослог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх, тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлэх, дотоодын тосны үйлдвэрийн түүхий эдийн чанар хангамжийг сайжруулах зорилгоор тус яамнаас "Тослог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх" тендерийг 2 удаа зарласан боловч тослог ургамлын үр нийлүүлэх шаардлага хангасан оролцогч шалгараагүй болно. Иймд тарималын тариалалтын технологийн хугацаанд үр нийлүүлэх боломжгүй болсон тул ажлын хэсгээс тус тендерийг хүчингүй болгож, зориулалтыг өөрчлөх санал зөвлөмжийг захиалагчид хүргүүлэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан суулгац үржүүлгийн төв байгуулах тендерийг зарлан гэрээ байгуулан гэрээт ажлыг хүлээн авсан. Аж ахуйн нэгжүүд өөрсдийн санхүүгийн эх үүсвэрээр 2022 оны хаврын тариалалтад шаардлагатай үрийн нөөцийг бүрдүүлж, 124.3 мянган га талбайд тосны ургамал тариалж, 45.7 мянган тонн тосны ургамал хураан авсан. | 70.0 |
| | | 3.3.9. Үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч, Тэвийн бусийн үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх | Үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч, Тэвийн бусийн үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх | Үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч, Тэвийн бусийн үхэр сүргийн 6.6 сая толгой /20.5 хувь/ малыг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлсэн байна. | Улсын төсөв | 200.0 | Улсын төсөв | 200.0 | Малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх систем www.nlis-2.mofa.gov.mn, Хурдан морины бүртгэлийн систем www.horse.mofa.gov.mn, Сүргийн эргэлтийн тооцоолох систем www.herd.mofa.gov.mn, Малын удмын сангийн бүртгэлийн модул, Тэжээлийн тогтвортой менежмент, шийдвэр гаргалтыг дэмжих систем www.fodder.mofa.gov.mn зэрэг мэдээллийн системүүдийг нэгтгэн Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг www.livestock.mofa.gov.mn домайн хаягаар үүсгэж Үндэсний дата төвийн төрийн үйлчилгээний систем төрийн клауд дэд бүтэц рүү шилжүүлэх тасралтгүй ажиллагааг хангаж, мэдээллийн технологи, систем ашиглах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч байна. Малын генетик нөөцийн хэлтэс ҮСХ-ны А данс дээр үндэслэн нэг бүрчлэн эзэмшил бөөн дүнгээр малчин өрх, малын төрөл, удам гарвал нас, хүйс, тоо бүртгэж байна. Мал сүргийг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, олон | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 127 | | | | | | Орон нутгийн төсөв | 199.9 | улсын жишигт нийцүүлэн эрчимжүүлэх зорилгоор газар тариалангийн бүс болох Дархан-Уул аймгийн 4 сум, Сэлэнгэ аймгийн 17 сумын нутагт үржүүлж буй 153.6 мянган малд улсын төсвийн 200.0 сая төгрөгийн санхүүжилтээр үзлэг ангилалт хийж, үзлэг ангилалтаар стандартын шаардлага хангасан үржлийн малыг бүртгэлжүүлэх ажилд 200.0 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулах тухай ХХААХҮСайдын 2022 оны А/68 дугаар тушаал гаргав. Хавар, намрын технологит хугацаанд 2 аймгийн 21 сумын 158.2 мянган үржлийн мал, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 16 аймгийн 71 сумын 271.6 мянган үржлийн малд үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх ажлыг хийж, хавар=намрын=технологит=ажлыг=Мал=үржүүлгийн=технологийн=ажил үйлчилгээний 42 нэгж гэрээгээр гүйцэтгэж, нийт 316 хүн, 87 техник хэрэгсэл ажиллаж, орон нутагт 250 гаруй түр ажлын байр бий болгосон. Технологийн хугацаанд 2022 онд 232.0 мянган малыг (төвийн бүсийн 7 аймгийн 49.7 мянган үхэр) ялган тэмдэглэж, бүртгэлжүүлсэн ба төрлөөр нь авч үзвэл 309 тэмээ, 6.7 мянган адуу, 67.3 мянган үхэр, 93.3 мянган хонь, 64.2 мянган ямаа байна. Өссөн дүнгээр 4.6 сая малын мэдээлэл бүртгэгдсэн. | 90.0 |
| 128 | 3.3.10. Боловсруулах үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх дэвшилтэт технологи, инновац нэвтрүүлэх хөнгөн үйлдвэрийн салбарын лаборатори, төвүүдийн чадавхыг сайжруулах | Боловсруулах үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх дэвшилтэт технологи, инновац нэвтрүүлэх хөнгөн үйлдвэрийн салбарын лаборатори, төвүүдийн чадавхыг сайжруулах | Хөнгөн үйлдвэрийн салбарын 4 лаборатори, төвүүдийн тоног төхөөрөмжийг шинэчилсэн байна. | Улсын төсөв | 100.0 | Гадаадын зээл, тусламж | 440.5 | 1. Итали Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 440.5 сая төгрөгийн үнэ бүхий 8 тоног төхөөрөмжийг Монголын Ноос Ноолуурын Холбооны дэргэд байгуулсан "Итали-Монголын Текстил (нэхмэл)-ийн технологийн төв"-д суурилуулан тохируулж, төвийн үйл ажиллагааг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр албан ёсоор нээсэн. 2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төвд биохимийн шинжилгээ, туршилтын лаборатори байгуулах асуудлаар 1 сая ам.долларын санхүүжилтийг Экспортыг дэмжих төслийн төлөвлөгөөнд тусгуулан батлуулав. НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага (ЮНИДО)-тай хамтран 2022 оны батлагдсан төсөвт өртөг багтаан эхний ээлжинд худалдан авах тоног төхөөрөмжийн жагсаалтыг гарган Дэлхийн банкинд хүргүүлсэн. -Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр биомеханикийн лаборатори, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх болон мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор туршилтын цехийн тоног төхөөрөмжийн санал батлагдсан. 2023 онд худалдан авалт зарлагдахаар төлөвлөгөөнд орж батлагдсан. -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төвд ажиллан, арьс ширэнд хүнд метал тодорхойлох шинжилгээ, туршилтын лаборатори байрлах, шаардлагатай тоног төхөөрөмж суурилуулах өрөө талбайг чөлөөлөх бэлтгэл ажлыг бүрэн хангасан. | 70.0 |
| 129 | 3.3.11. Цахим хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг байгуулж, Хөдөө аж ахуйн биржийн шинэчлэлийг хийж, хоршооны бүтцэд тулгуурлан бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгон загвар хоршоодыг байгуулах | Цахим хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг байгуулж, Хөдөө аж ахуйн биржийн шинэчлэлийг хийж, хоршооны бүтцэд тулгуурлан бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгон загвар хоршоодыг байгуулах | Загвар 10 хоршоотой болсон байна. | Улсын төсөв | 5,000.0 | Гадаадын зээл, тусламж | 258.0 | Хөдөө аж ахуйн бирж нь блокчейн технологид суурилсан арилжаа, клиринг, төлбөр тооцооны шинэ платформыг нэвтрүүлсэн бөгөөд 21 аймагт түүхий эдийн 96 агуулахад итгэмжлэл олгож, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч 22 хоршоог байнгын бус гишүүнээр элсүүлсэн. Хөдөө аж ахуйн бирж нь 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 996 хэлцлээр 1 их наяд 70 тэрбум төгрөгийн 157 удаагийн арилжаа зохион байгуулсан. Арилжааны дийлэнх хувь нь түүхий эдийн боловсруулах үйлдвэрээс экспортлогч компаний хооронд хийгдэж байгаа ба бирж орон нутгийн хоршооноос дотоодын үйлдвэрийн хооронд арилжаа зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна. Энэ хүрээнд 6 аймгийн 32 хоршоог биржийн байнгын бус гишүүнээр бүртгэн гэрээ байгуулан ажиллаж байгаа ба Хэнтий, Төв аймгийн сумдын 3 хоршооноос нийт 230 богц ноолуурын арилжааг 3 удаа амжилттай зохион байгуулсан. Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Сумбэр багт "Баялаг гүрэм" загвар хоршоог 2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан. Бирж нь тус загвар хоршоог чадавхжуулах зорилгоор менежментийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа ба малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг чанараар ангилах, анхан шатны тордолт хийх, түүхий эд бэлтгэлийн мэргэжилтэн бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж, хоршооны гишүүдийн ноолуур, ноосыг стандартын дагуу бэлтгүүлж байна. Мөн тус хоршоонд Японы ОУ-ын хамтын ажиллагааны байгууллага Жайка-ийн хэрэгжүүлж буй төслийн санхүүжилтээр 38.0 сая төгрөгийн хонины ноос хяргах тоног төхөөрөмж хүлээлгэн өгч цаашид ноосыг чанар стандартын дагуу бэлтгүүлэх ажлыг эхлүүлсэн. 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр тус хоршооны биржийн арилжаанд оролцож үндэсний үйлдвэр "Сор кашимер" ХХК-д 100 богц ноолуурыг нийлүүлсэн. | 50.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 130 | | 3.3.12. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зээл, санхүүжилтийн бодлого хэрэгжүүлэх | Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зээл, санхүүжилтийн бодлого хэрэгжүүлэх | Шинээр нэмж 2000 ажлын байр бий болсон байна. | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 40,000.0 | ЖДҮХС ХХС | 19,181.8 | Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2022 онд хөнгөлөлттэй зээл олгох Зээлийн ерөнхий нөхцөл, салбар, чиглэл батлах тухай ХХААХҮСайдын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А-168 дугаар тушаалын хүрээнд нийт 22,5 тэрбум төгрөгийг сангаас шууд олгох бөгөөд 21 аймаг тус бүрт 500 сая төгрөг, нийслэлд 10 тэрбум төгрөг олгоно. ЗГ-ын 113 дугаар тогтоолын дагуу төсөл сонгон шалгаруулах 3 дугаар шат буюу газар дээр нь төсөлтэй танилцаж, төсөл хүлээн авах хугацаанд нийт 867 төслийн 105.4 тэрбум төгрөгийн хүсэлтийг ирүүлснээс цахим системд 571 аж ахуйн нэгж 82.4 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлтээ баталгаажуулсан. ХХААХҮСайдын тушаалын дагуу 22,5 тэрбум төгрөгийн шийдвэр гарах болно. Мөн Өмнөговь аймаг нь өөрийн орон нутгийн эх үүсвэрээс аймгийнхаа жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих зорилгоор 5 тэрбум төгрөгийг батлан 84 төслийн сонгон шалгаруулалтыг амжилттай зохион байгуулж дууссан. Өмнөговь аймгийн хөнгөлөлттэй зээлийн төслийн сонгон шалгаруулалтын дэд хорооны шийдвэрээр 32 төсөлд 3,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн. ЗГ-ын 2021 оны 42, 59, 131, 216 дугаар тогтоол, 2022 оны 117, 144, 175 дугаар тогтоол болон "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хүрээнд хөдөө аж ахуйг дэмжих /ноос, ноолуур, арьс, шир бэлтгэл үйлдвэрлэл, газар тариалангийн үйлдвэрлэл, нөөцийн мах бэлтгэл, гурил тэжээл, ургамлын тосны үйлдвэрлэл, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл/ чиглэлээр арилжааны банкны эх үүсвэрээр 2021 онд олгосон 196.4 тэрбум төгрөгийн зээл, 2022 онд олгосон 261.8 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн ЗГ-ын хариуцан төлөх 10.65 хувийн хүүгийн дэмжлэгт 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 32.6 тэрбум төгрөгийг Монгол Банкаар дамжуулан санхүүжүүлсэн. ЖДҮХСангийн Зээлийн батлан даалтын сангаас 32 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 11,789 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаж, 22.32 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Батлан даалтын үр дүнд 1250 ажлын байр шинээр бий болсон. | 70.0 |
| | | | | | Гадаадын зээл, тусламж | 10,000.0 | Гадаадын зээл, тусламж | 15,624.5 | | |
| 131 | | 3.3.13. Жижиг, дунд үйлдвэрийн бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулах, томруулах бодлогыг боловсронгуй болгох | Жижиг, дунд үйлдвэрийн бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулах, томруулах бодлогыг боловсронгуй болгох | Орон нутгийн нэгдсэн бүтцийг бий болгоно. | Улсын төсөв | 1,400.0 | Улсын төсөв | 1,866.4 | Монголын Бизнес Инкубаторуудын Үндэсний нэгдсэн Холбооноос 2022 онд "Монгол улсын төслийн стандар ISO MNC 21500", "Залуучуудын гарааны бизнесийг дэмжих", "Орон нутагт хоршоо, нөхөрлөл байгуулах иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх", "Хөдөлмөрт бэлтгэх сургалт" зэрэг чиглэлээр 4 сургалт зохион байгуулж нийт 105 хүнийг чадавхжуулж, сургагч багшаар бэлтгээд байна. -ЖДҮҮЭ-ийг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, ажлын байрыг бий болгох замаар экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Төрийн банктай хамтран ажиллаж Төрийн банкны инкубатор төвүүдэд бүртгүүлэх хүсэлтэй ААН, хувь хүмүүсийн мэдээллийг хүргүүлж ажиллаж байна. Төрийн банк нь 21 аймаг, 7 дүүрэгт инкубатор төвийг байгуулж, 1,200 гаруй бизнес эрхлэгчийг сургалт, мэдээллээр хангаж, 4,226 ажлын байрыг хадгалж ажилласан. | 90.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 132 | | 3.3.14. Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх | Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх | 90.0 мянган тн мах экспортолсон байна. | Гадаадын зээл, тусламж | 450.0 | - | - | 1. ХХААХҮС-ын 2022 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/294 дугээр тушаалаар байгуулагдсан Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох боломж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг судалж, экспортыг нэг цонхны бодлогоор хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, мах махан бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагааг цахимжуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2.ГХАН, БНХАУ-ын эрх бүхий байгууллагатай хамтран 2022.10.27-ны өдөр зохион байгуулсан "GIZ-CIQA Хүйтэн хэлхээний менежмент ба Хятад Улсын мах, махан бүтээгдэхүүний импорт" сэдэвт сургалт,-уулзалтад=экспортлогч=19=аж=ахуйн=нэгжийг=хамруулсан.=Тус уулзалтаар БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлоход мөрдөгдөж буй дүрэм журам, тавигдах шаардлагын талаар танилцуулж, санал солилцсон. 3. "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам"-ын дагуу Монгол Улсын 2022 оны 10 дугаар сараас 2023 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд экспортлох, импортлох мах, махан бүтээгдэхүүний тоо хэмжээний саналыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Зөвлөмж гаргуулсан. 4.ХХААХҮС-ын 2022 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/12 тоот тушаалын хүрээнд БНХАУ-ын мах, махан бүтээгдэхүүн экспортыг сэргээх ажлыг эрчимжүүлж, ажлын хэсгийн төлөвлөгөөг батлан ажиллаж, БНХАУ-ын эрх бүхий байгууллагын импортын мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, баталгаажуулах талаар тавьсан шаардлагыг бүрэн хангаж, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газартай "нэмэлт гэрчилгээ"-ний загварыг тохирсны үндсэн дээр 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс Эрээн боомтоор мах, махан бүтээгдэхүүн экспортолж эхэлсэн. Монгол Улс 2018 онд 70.4 мян.тн, 2019 онд 58.6 мян.тн мах, махан бүтээгдэхүүн экспортолсон ба Дэлхийн нийтийн хамарсан Короновируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас дээрх тоо хэмжээ 45% буурч 2020 онд 38.8 мян.тн, 2021 онд 21.8 мян.тн, 2022 оны 11 сарын 17-ны өдрийн байдлаар 6.4 мян.тн мах, махан бүтээгдэхүүн тус тус экспортолсон байна. | 50.0 |
| 133 | | 3.3.15. Дархан хотын арьс ширний үйлдвэрлэл, технологийн паркийн цэвэрлэх байгууламж шинээр барих ажилд дэмжлэг үзүүлэх | Дархан хотын арьс ширний үйлдвэрлэл, технологийн паркийн цэвэрлэх байгууламж шинээр барих ажилд дэмжлэг үзүүлэх | Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 15,950.6 | Улсын төсөв | 318.5 | "Дархан арьс ширний цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд Италийн талтай хамтран цэвэрлэх байгууламжийн ерөнхий схемийг боловсруулан, шаардагдах тоног төхөөрөмжүүдийн тооцоо судалгааг гарган, ТЭЗҮ-д тусгасан. ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу "Цэвэрлэх байгууламжийн барилгын зураг төсөв боловсруулах" зөвлөх үйлчилгээний тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж, гүйцэтгэгчээр "Чанарын түншлэл" ХХК шалгаран, 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн ДАШЦББТӨХХК/202206019 дугаартай гэрээг Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК-тай байгуулан ажлыг эхлүүлсэн. Цэвэрлэх байгууламжийн зураг төсөв боловсруулах ажлын хүрээнд усан сангийн барилгын бүтэц, барилгын архитектурын ажлын зураг хийгдэж дууссан бөгөөд зөвлөх үйлчилгээний ажлын гэрээний хугацааг гүйцэтгэгч компанийн хүсэлтийн дагуу сунгасан. | 50.0 |
| 134 | | 3.3.16. "Шинэ Ховд" үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | "Шинэ Ховд" үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | Дэд бүтэц 90 хувь, бүтээн байгуулалт 30 хувьд хүрсэн байна. | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 10,100.0 | Улсын төсөв | 665.0 | Түлхүүр гардуулах нөхцөлтэй "Шинэ ховд үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв боловсруулах, барих" ХХААХҮЯ/202202143 дугаар бүхий 6 багц нээлттэй тендер шалгаруулалтыг Багц:1 "Авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, инженерийн шугам сүлжээний төлөвлөлт, үерийн усны сувагчлал, хашаа, зогсоолын зураг төсөв боловсруулах, барих" ажлыг Таванбогд оффроуд ХХК, Багц:2. "Саарал ус зайлуулах, усан хангамж, ариутгах татуургын цуглуулах гол шугам сүлжээний зураг төсөв боловсруулах, барих" ажлыг "Воком констракшн" ХХК, Багц:3. "Цахилгаан хангамжийн дэд станц, шугам сүлжээний зураг төсөв боловсруулах, барих" ажлыг "Эм ай эс эс" ХХК, Багц:4 "Мэдээлэл холбооны сүлжээний зураг төсөв боловсруулах, барих" ажлыг "Монкабель системс" ХХК, Багц:5 "Арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн зураг төсөв боловсруулах, барих" ажлыг Жаргалантлуу ХХК, Багц:6 "Уурын дулааны дэд станц, шугам сүлжээний зураг төсөв боловсруулах, барих" ажлыг Жаргалантлуу ХХК-иуд шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. УТП-ийн дэд бүтцийн ажлыг эхлүүлэхэд шаардлагатай зураг төсвийг боловсруулан магадлал хийлгэн батлуулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхэд бэлэн болсон. | 50.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 135 | 3.3.17. Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөренгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх | Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөренгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх | Эрэх, нэхэх, сүлжих хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлснээр 100 орчим ажлын байр шинээр бий болсон байна. | Гадаадын зээл, тусламж | 10,000.0 | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 9,000.0 | 1.Говь ХК 8,0 тэрбум төгрөгийн хөренгө оруулалтаар Итали улсын иж бүрэн 2 самнах машин шинээр суурилуулж, байгнын 10 ажлын байрыг бий болгон ээрэх хүчин чадлыг 350 тонноор нэмэгдүүлснээр улсын хэмжээнд нийт ээрэх хүчин чадал 2970 тн-д хүрсэн. 2."Баялаг Өлзий" ХХК нь 300,0 мянган ам.долларын үнэ бүхий хялгас ялгах 40 тоног төхөөрөмж суурилуулан хүчин чадлаа 40 тн-оор нэмэгдүүлж, 20 ажлын байр бий болгосон. 3.Итали Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар "Итали-Монголын Текстил (нэхмэл)-ийн технологийн төв"-ийг байгуулж, төвийн үйл ажиллагаар 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр албан ёсоор нээсэн. 4.Хөдөө аж ахуйн зээл олгох тухай Засгийн Газрын 2021 оны 42, 2022 оны 117 дугаар тогтоолын дагуу ноолуур бэлтгэл, үйлдвэрлэлд 150.0 тэрбум төгрөг, ноос бэлтгэл, үйлдвэрлэлд 25,0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгохоор батлуулсан. 2022 оны 12 дугаар сарын байдлаар ноолуур бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар 31 аж ахуйн нэгжид 106,96 тэрбум, ноос бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар 8 аж ахуйн нэгжид 8,01 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. | 50.0 |
| 136 | 3.3.18. Газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг эрхлэхэд мах, сүүний цэвэр үүлдрийн өсвөр үхрийг өсгөн үржүүлэх, худалдан авч иргэн, аж ахуйн нэгжүүдэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр зээлээр олгох. Малын тэжээлийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих. Малын тэжээл тариалагч иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, хөнгөлөлт үзүүлэх | Газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг эрхлэхэд мах, сүүний цэвэр үүлдрийн өсвөр үхрийг өсгөн үржүүлэх, худалдан авч иргэн, аж ахуйн нэгжүүдэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр зээлээр олгох. Малын тэжээлийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих. Малын тэжээл тариалагч иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, хөнгөлөлт үзүүлэх | Махны цэвэр үүлдрийн үхрийн тоог 1000 толгойгоор, сүүний цэвэр үүлдрийн үхрийн тоог 1000 толгойгоор тус тус нэмэгдүүлнэ. Тэжээлийн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | Гадаадын зээл, тусламж | 26,400.0 | Улсын төсөв | 4,100.0 | 1."Эрүүл хүнс-Малчны хотноос" хөтөлбөрийн хүрээнд Архангай аймагт улсын төсвийн 1.3 тэрбум төгрөгийн хөренгө оруулалтаар 430 толгой Сэлэнгэ үүлдрийн үхрийг нийлүүлж, махны чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй 9 иргэн, аж ахуй нэгжид түрээсийн гэрээгээр олгов. 2.Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд Говь-Алтай аймагт улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн хөренгө оруулалтаар 160 толгой үржлийн сарлаг нийлүүлж, тус аймгийн сарлаг бүхий сумдын сарлаг үхрийн чанар, үүлдэрлэг байдал, ашиг шимийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, 8 малчин өрхөд түрээсийн гэрээгээр олгов. 3. Мөн дээрх төслийн хүрээнд улсын төсвийн 300.0 сая төгрөгийн санхүүжилтээр Төв аймагт мах-ноосны чиглэлийн Эдельбаев үүлдрийн 60 толгой өсвөр хуц нийлүүлэх ажлыг зохион байгуулав. 4. ЭМАА эрхлэгчдийг дэмжих, малчид, мал аж ахуй эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлэх зорилгоор өндөр ашиг шимт мах, сүү, сүү-махны чиглэлийн хосолмол ашиг шимт үхрийн 11.0 мян.тун, мах-ноосны чиглэлийн хонины 3.0 мян.тун, нийт 14.0 мян.тун гүн хөлдөөсөн үр, 12 төрлийн ороо идэвхижүүлэгч, үр шингэлэгч бодис, шингэн азотын цөхийн шүүлтүүр, хэрэглэлийн мотор, усны сав зэргийг улсын төсвийн 725.0 сая төгрөгийн санхүүжилтээр импортолж, МУСҮТөвд хүлээлгэн өгөв. Үүний үр дүнд 12.8 мянган бод, 4.5 мянган бог, нийт 17.3 мянган малд гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж, хээл авалт 72 хувьтай байна. 5. ADRA ОУБ-ын 47.0 мянган ам.долларын / 160.0 сая төгрөгийн/ санхүүжилтээр Австралын үндэсний генийн сангаас ноосны чиглэлийн 5 үүлдрийн хуцны 6.0 мянган тун үрийг импортолж, генийн сангийн баяжилтыг хийв. 6.Малын тэжээл тариалагч иргэн, ААН-ийг дэмжих зорилгоор Тэжээлийн тогтвортой менежмент төслийн хүрээнд Дархан-Уул, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ аймгуудад тэжээлийн ургамал тариалах сургалт зохион байгуулж, 5.0 мянган тн үрийн дэмжлэг үзүүлэв. 7."Түмэн шувуут" ХХК, "Ажигана" ХХК-ийн тэжээлийн үйлдвэрлэлд зориулж жилийн хугацаатай 3 хувийн 12 тэрбум, Хөвсгөл аймагт хадлангийн 728.0 сая төгрөгийн 4 иж бүрдэл олгосон. | 50.0 |
| | | | | | | Гадаадын зээл, тусламж | 160.0 | | |
| 137 | 3.3.19. Хүнсний ногоог дотооддоо тариалахад дэмжлэг үзүүлэх | Хүнсний ногоог дотооддоо тариалахад дэмжлэг үзүүлэх | Нарийн ногооны дотоодоос хангах хувийг 60 хувьд хүргэнэ. | Гадаадын зээл, тусламж | 17,000.0 | Улсын төсөв | 1,200.0 | Хүнсний ногоог дотооддоо тариалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 118 дугаар тогтоолоор ил талбайн болон хүлэмжийн хүнсний ногооны үрийг 80 хувь хөнгөлөх шийдвэр гарсаны дагуу хүнсний ногооны үр нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж үрийг нийлүүлэн Хүнсний ногооны үрийн хуваарийг ХХААХҮ-н сайдын А-120, А145 дугаар тушаал батлуулан улсын төсвийн 1.3 тэрбум төгрөгөөр 12 нэр төрлийн 81 тонн үрийг ногоочидод аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газруудаар дамжуулан олгосон. 2022 оны Ургац хураалтын урьдчилсан дүнгээр 19.7 мянган га-гаас 215.5 мянган тонн төмс, 11.8 мянган га-гаас 146.8 мянган тонн хүнсний ногоо авсан нь өнгөрсөн онтой харьцуулахад төмс, хүнсний ногооны ургац тус бүр 18-25 хувиар тус тус нэмэгдсэн байна. | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 138 | | 3.3.20. Малын тэжээлийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгох | Малын тэжээлийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгох | Хууль, эрх зүйн орчныг бий болгосон байна. | - | - | - | - | Малын тэжээлийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих хүрээнд тэжээлийн түүхий эдийн тариалалтыг нэмэгдүүлэх, тэжээлийн тарималургамлын үрийн шинэ сорт бий болгох, бүртгэх зорилгоор "Тарималургамлын шинэ сортыг нэрлэх" журам, "Сортыг бүртгэх, бүртгэлээс хасах" журмыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/183 дугаар тушаалаар батлуулсан байна. Ингэснээр шинэ төрлийн тэжээлийн таримлыг бий болгож, дотоодын тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжих боломж бүрдсэн. | 70.0 |
| 139 | 3.4. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | 3.4.1. "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I"-ийг Хөвсгөл, Хэнтий, "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-II"-ыг Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудад хэрэгжүүлэх | "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I"-ийг Хөвсгөл, Хэнтий, "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-II"-ыг Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудад хэрэгжүүлэх | "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл I"-ийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг 50 хувьд хүргэж, төсөл II-ын хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудын зураг, төсвийг батлуулсан байна. | Гадаадын зээл, тусламж | 38,500.0 | Гадаадын зээл, тусламж | 33,900.0 | "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I"-ийг Хөвсгөл, Хэнтий аймгуудад хэрэгжүүлэх хүрээнд 1.Хөвсгөл аймагт 3 чиглэлийн 37.9 км авто зам, 7 авто зогсоолын барилгын ажил 22%, 2.Хөвсгөл нуурын БЦГ-т 15 км явган болон морин аяллын жимийн тохижилтын зураг төсөл боловсруулагдсан. 3.Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх сум, Хэнтий аймгийн Дадал суманд хатуу хог хаягдлын ландфилл байгууламжийн барилгын ажлыг эхлүүлсэн. Барилга угсралтын ажил Дадал суманд 72 %,, Хатгал тосгонд 80 %. 4.Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх суманд Бохир ус цэвэрлэх байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх гэрээг "Хаанзаа" ХХК-тай байгуулж ажлыг эхлүүлсэн. Барилга угсралтын ажил Хатгал тосгонд 95 %. 5.Хөвсгөлийн УТХГ-ын "Хамгаалалтын захиргаа/ жуулчны мэдээллийн төв"-ийн барилгын зураг төсөл боловсруулах ажил 70 %. 6.Ханх сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил 95 % .7.Хэнтий аймгийн Дадал суманд баригдах "Чингис хаан" АЖЦ-ын Мэдээллийн төвийн барилга, орчны тохижилт, бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, бараа нийлүүлэлтийн ажил"-ыг нэг багц тендер зарлагдаад гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. 8.Дадал сумын ЗДТГ-аас ирүүлсэн 7 саналд үндэслэн 4-н ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан бөгөөд ажлын гүйцэтгэл 57.5 %. 9.Дадал сумын аялал жуулчлалын төлөвлөгөөг ИТХ-аар батлуулсан. 10.ХНБЦГ-ын Менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны ТХБНУГ-аар батлуулсан. 11.Хөвсгөл нуурыг хамгаалах эргүүлийн 2 завь худалдаж авах гэрээ байгуулах ажил хийгдэж байна. Хөвсгөл аймаг 4, Хэнтий аймагт 2 бүтээн байгуулалтын ажил 50%. Монгол Улсын Ерөнхий сайдын 106 дугаар захирамжаар "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл II"-ыг санхүүжүүлэхэд зориулсан Монгол Улс, Азийн Хөгжлийн Банк хоорондын зээлийн хэлэлцээр батлагдсан.12 дугаар сард багтаан УИХ-аар соёрхон батлуулахаар хуулийн үзэл баримтлалыг батлуулна. Бүтээн байгуулалтын ажлуудын зураг, төсөв батлагдсан. | 70.0 |
| 140 | | 3.4.2. "Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор"-ын ажлуудыг цогц байдлаар дуусгаж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр холбох ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулах | "Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор"-ын ажлуудыг цогц байдлаар дуусгаж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр холбох ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулах | -"Шихихутаг-Их засаг" цогцолбор, "Их хуралдай" цогцолборыг ашиглалтад оруулсан байна. -"Монголын нууц товчоо" цогцолборын 225 га талбай, "Хүлэг Боорчи-Андлалын өргөө" цогцолборын 20 га талбайд иж бүрэн гадна тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. | Улсын төсөв | 2,800.0 | - | 7,505.7 | 1.Хэнтий аймгийн Норовлин сумын "Шихихутаг-Их засаг" цогцолборын ажлын хүрээнд дараахь 5 багц ажлууд хийгдэж байна. Үүнд: 1.Барилга угсралтын ажил-75%, 2. Гадна цахилгаан гүйцэтгэл-100%, 3. Гадна шугам сүлжээний ажил-100%, 4. Гадна тохижилтын ажил-65%, 5. Барилгын дотор интерьер-30%, 5 багц ажлын гүйцэтгэл 70% байна. 2. "Их хуралдай" цогцолборын гадна тохижилтын ажлыг "Нутгийн баруун мод" ХХК, зоорийн ажлыг" Мөнх өргөө" ХХК тус тус хариуцан гэрээ байгуулан ажиллаж байна. Их хуралдай цогцолборын ажлын гүйцэтгэл: 1. Газар тэгшилсэн 90% 2. Картограмм ажил буюу 3200м3 шороо зөөх ажил 70% 3. 78ш гэрлийн шон цутгах ажил 100% дууссан 4. Гадна гэрэлтүүлэг монтажний ажил 90% 5. Худаг гаргах ажил 100% 6. Худаг, харуулийн байр-70% . 7. Гэрэлтүүлгий ажил 80% 8. Гадна хашаа барих ажил 90% тус тус хийгдээд байна Нийт гүйцэтгэл 80%-тай байна.3 Монголын нууц товчоо цогцолборын үндсэн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг БОАЖЯ Хасу мегаватт ХХК-тай 2020.05.18-2022.11.10-ны хооронд 1,583.6 сая төгрөгөөр хийхээр байгуулсан. Нийт 1,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Гадна тохижилтийн ажлын талаар: Монголын нууц товчоо цогцолборын гадна тохижилт, интерьер, халаалт салхивч, холбоо ажил гүйцэтгэх гэрээг ДИ ЭС ТИ ХХК-тай 2022.10.17-2023.08.31-нд хийхээр 566.5 сая төгрөгөөр байгуулсан. Гадна тохижилтын цахилгаан хангамж 04/10 кВа-ийн КТП угсрах ажил хийгдэж ашиглалтанд оруулсан. | 50.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 141 | 3.4.3. Аялал жуулчлалын мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилгын ажлыг эхлүүлж, ажлын явцыг 80 хувьд хүргэх | Аялал жуулчлалын мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилгын ажлыг эхлүүлж, ажлын явцыг 80 хувьд хүргэх | Барилгын ажлын гүйцэтгэл 80 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 5,000.0 | Гадаадын зээл, тусламж | 5,000.0 | Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хооронд байгуулсан яриа хэлэлцээрийн дагуу Монголын аялал жуулчлалын сургалтын төв байгуулах, салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх төслийг хамтран хэрэгжүүлэхээр 2019 онд санамж бичиг гарын үсэг зурсан. Аялал жуулчлалын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах хүрээнд: 1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх, 2. Газрын инженер геологийн дүгнэлт гаргуулах, 3. Барилгын дэвсгэр зураг боловсруулах, 4. Архитектур төлөвлөлтийн даалгавар авах, 5. Сургалтын төвд цэвэр, бохир, ус холбогдох асуудлыг шийдвэрлэх, 6. ТЭЗҮ, зураг, төсвийг Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газраар батлуулах ажлыг гүйцэтгэж барилгын зураг төслийг Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-аар магадлангаар оруулж батлуулав. БНСУ-д 2022 оны 04 дүгээр сарын 8-ны өдөр Барилгын ажлыг гүйцэтгэх зөвлөх сонгон шалгаруулах тендерийг зарлаж БНСУ-ын Чон Үк Корпораци шалгарч гэрээг байгуулан батлуулав 2022 оны 09 дүгээр сарын 09-ны өдөр барилгын суурийн ажлыг эхлүүлсэн бол 9 дүгээр сарын 26-ны өдөр БОАЖ-ын сайд Б.Бат-Эрдэнэ, БНСУ-ын Элчин сайдын яамны нарийн бичгийн дарга болон КТО байгууллагын дарга Ким Кван Ши нар төвийн барилгын ажил нээгдэж буй зарлан талбай дээр нээлтийн арга хэмжээ зохион байгуулсан. Барилгын ажил төлөвлөсний дагуу хэрэгжиж өвлийн дулаалгын хучилтын ажил хийгдсэн. 11 сарын 20-ны өдрөөр барилгын ажлын зогсоож дотоод зохион байгуулалтын ажлаа явуулж байна. Барилга угсралтын явц 10 хувьтай байна. | 30.0 |
| 142 | 3.4.4. Олон улс, улсын чанартай авто замын дагуу түр зогсох талбайг 100 км тутамд барьж байгуулах ажлыг эхлүүлэх | Олон улс, улсын чанартай авто замын дагуу түр зогсох талбайг 100 км тутамд барьж байгуулах ажлыг эхлүүлэх | 10 байршилд барьсан байна. | Концесс, ТХХТ | 16,000.0 | - | - | 1 Завхан аймгийн Сонгино суманд "Титан Би" ХХК, 2. Архангай аймгийн Цэнхэр суманд "Заяын өгөөж" ХХК, 3. Булган аймгийн Хутаг өндөр суманд "Унътын рашаан" ХХК, 4. Төв аймгийн Баянцагаан суманд "Мандах бадрах булаг" ХХК, 5. Хэнтийн аймгийн Жаргалтхаан суманд "Инсун мод" ХХК өөрийн хөрөнгөөр авто замын дагуу үйлчилгээний цолцолборыг барьж 2022 онд ашиглалтад оруулсан. "Аялал жуулчлалын гол чиглэл, олон улс, улсын чанартай авто замын дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх гэрээг МХАҮТ-аас 14 компанитай байгуулсан. Нийт 19 байршилд 9 тэрбумын хөрөнгө оруулалтаар 12 сарын хугацаанд барьж гүйцэтгэхээр гэрээнд тусгасан. | 70.0 |
| 143 | 3.4.5. НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран цар тахлын дараа аялал жуулчлалын салбарыг сэргээх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх | НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран цар тахлын дараа аялал жуулчлалын салбарыг сэргээх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Жуулчдын тоог нэмэгдүүлж, 600.0 мянгад хүргэсэн байна. | Улсын төсөв | 1,500.0 | - | - | НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран цар тахлын дараа аялал жуулчлалын салбарыг сэргээх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх гэрээний төлбөр цар тахлаас үүдэлтэй хугацаандаа хийгээгүй тул ажлыг НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага хийхгүй болохоо илэрхийлсэн. Монгол Улсын Засгийн газраас 2023, 2024 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан "Монгол Улсын аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө"-г 8 зорилт 28 дэд зорилттойгоор боловсруулж, Ерөнхий сайдын дэргэд байгуулагдсан Аялал жуулчлалын үндэсний хорооны 10 дугаар сарын 27-ны хуралдаанд танилцуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 178 дугаар тогтоолоор БНСУ-ын жуулчдыг визийн шаардлагаас чөлөөлсөн шийдвэрийг гарган, энэ оны хувьд аялал жуулчлалын голлох зах зээлийн орныг Азийн орон гэж тодорхойлсон ба тус зорилтын хүрээнд Монгол Улсын зорин ирж аялсан Солонгос жуулчдын тоо 50 мянгад хүрсэн ба 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр олон улсад хилээ нээснээ зарласнаас хойших 9 сарын хугацаанд Монгол улсад ирсэн жуулчдын тоо 240 мянгад хүрч эдийн засагт 307 сая ам.долларын орлого орсон байна. | 50.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 144 | 3.4.6. "Цайны зам" хил дамнасан аялал жуулчлалын төсөл хэрэгжүүлэх | "Цайны зам" хил дамнасан аялал жуулчлалын төсөл хэрэгжүүлэх | Хил орчмын аялагч, жуулчдын тоо 10 хувиар өссөн байна. | Улсын төсөв | 100.0 | - | - | "ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд ""Цайны зам""-ыг бүртгүүлэх суурь судалгааны ажлыг Монголын аялал жулчлалын холбоо ТББ-аар 30 сая төгрөгийн төсөвтэйгээр гүйцэтгүүлж, тайланг хүлээн авч, төлөвлөлт хийсэн. Хил орчмын аялал жуулчлалын хөтөлбөр болон тур оператор компанид тавих шаардлагыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Өмнөговь аймаг дахь хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад ажиллаж, 72 цагийн жуулчдыг нэвтрүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн боломжийг нягтлан шалгаж, шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх санал боловсруулж, дэд бүтцийн нөхцөлийг сайжруулах ажлыг тодорхойлов. Мөн хоёр талын аялал жуулчлалын байгууллагуудад ойлгомжтой хилээр нэвтрэх процессыг зураглан БНХАУ-ын хил нээгдэх үед хил орчмын жуулчин авах бэлтгэлийн хүрээнд гарын авлага боловсруулаа. ОХУ-аас буюу Монгол Улсын хойд хилээр орж ирэх Орос жуулчдын тоо сар бүр өсөлттэй байгаа байгаа бөгөөд 11 дүгээр сарын байдлаар 150.000 жуулчин Монгол Улсад аялж, 181 сая ам долларын орлого оруулсан байна. ОХУ-ын хил орчмоор орж ирсэн 2019 оны 141.000 жуулчинтай харьцуулахад 2022 оны хилээ нээсэн 02 дугаар сарын 14-ний өдрөөс 11 сарын хооронд ирсэн 130.000 жуулчин ирж, 157 сая ам долларын орлого оруулсан байна.Монгол, Орос, Хятад Улсуудын аялал жуулчлалын сайд нарын 7 дугаар хуралдааныг цахимаар зохион байгуулах тухай БНХАУ-ын Соёл, Аялал жуулчлалын сайд Ху Хэпинээс ирүүлсэн захидлыг хүлээн авч,"Их цайны зам"-ийн үйл ажиллагааны 7 дугаар төсөлд БОАЖСайдын 01/6838 тоот албан бичгээр санал хүргүүлсэн. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын виз олгох журам шинэчлэгдэж хил орчмын жуулчдад 72 цагийн виз олгох эрх зүйн орчин бүрдсэн. Засгийн газрын хуралдааны 5 дугаар сарын 4, 11-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээр хилийн боомт дээр цахимаар виз олгох мэдээлэл сурталчилгааны цогц ажлыг шийдвэрлүүлсэн. Монгол, Буриад хоёр улсын төлөөллүүд хамтарч Байгаль нуур-Хөвсгөл нуур чиглэлийн маршрутыг хэлэлцэн батлав. | 50.0 |
| 145 | 3.4.7. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, дэд бүтцийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн дотоодын болон гадаадын аялагч, жуулчдын тоог нэмэгдүүлэх | Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, дэд бүтцийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн дотоодын болон гадаадын аялагч, жуулчдын тоог нэмэгдүүлэх | 30-аас доошгүй арга хэмжээг товлож, зохион байгуулсан байна. 20 отоглох цэгийг нэмж байгуулсан байна. | Улсын төсөв | 1,450.0 | Улсын төсөв | 90.0 | Баян-Өлгий аймгийн Улаанхус, Цэнгэл сумдад Алтай таван богд Байгалийн цогцолбор газарт "Альпиниад-2022" их наадам, "Бүргэдийн баяр", Хөвсгөл аймагт "Хөх сувд" мөсний баяр, "Цаатангуудын баяр, Булган аймгийн Орхон сумын "Өрмийн цагаан нуур"-ын эрэгт "Айргийн баяр" арга хэмжээ, Ховд аймгийн Мөст суманд Захчин түмний өв соёлыг сурталчилсан "Тонжоо" наадам, Өмнөговь аймагт "Тэмээний баяр", "Элсэн манхны баяр", Төв аймагт "Хонины найр", "Төр түмний цэнгэл" баяр наадам, Улаанбаатар хотод "Дээлтэй монгол" наадам, "Хүрээ цам" даншиг наадам, "Нүүдэлчин Монгол" наадам, "Наадам найт" арга хэмжээ, Плэй тайм арга хэмжээ, Өвөрхангай аймагт "Сарлагийн баяр", "Монгол эсгий урлалын баяр", "Монголын уламжлалт биет бус өв соёл дэмбээ наадгай", "Адууны өв соёлын баяр", спорт аялал жуулчлалыг дэмжсэн " UJ спорт фестиваль, " Хаадын хаан - Чингис хаан " НҮБ -ийн төлөөлөгчдөд зориулсан морин шоу үзүүлбэр, АйТиЭм олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, Шинэ сэргэлт ба Аялал жуулчлал 2022, Хаадын хаан морин шоу олон улсын төлөөлөгчдөд зориулсан арга хэмжээ, Хорека Монголиа 2022 зочлох үйлчилгээний үзэсгэлэн, Их эзэн Чингис хааны мэндэлсний 860 жилийн ойд зориулсан "Зүүн бүсийн аялал жуулчлалын зөвлөгөөн" арга хэмжээ, "Талын түмэн адуу" нийт 30 гаруй арга хэмжээнд 90 сая төгрөгийн санхүүгийн болон удирдлагын дэмжлэг үзүүлээ. МУ-ын ЗГ-аас 2023 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан маркетингийн бэлтгэл ажил болгож УБ хотод Сүхбаатарын талбай дээр 12 дугаар сарын 1-12 дугаар сарын 31 - ийг хүртэл "Хайлахгүй" /Green fest-2022/ эвент арга хэмжээг зохион байгуулахаар ажиллаж байна. Дорнод аймгийн аялал жуулчлалын зөвлөгөөн, Өмнөговь аймгийн Тэмээн соёл, аялал жуулчлал хөгжүүлэх бүсийн зөвлөгөөнүүдэд оролцож Монголд зочлох жил болон бодлогын үйл ажиллагааг танилцуулсан. 2022 онд 17 цэгт отоглох цэгийг байгуулахаар төлөвлөснөөс 9 отоглох цэг баригдсан үлдсэн 8 отоглох цэг Засгийн газрын хэмнэлтийн хуулиар хойшлогдсон. | 70.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 146 | | 3.4.8. Аялал жуулчлалын гадаад, дотоод сурталчилгааг идэвхжүүлэх | Аялал жуулчлалын гадаад, дотоод сурталчилгааг идэвхжүүлэх | -Голлох зах зээлийн орнуудад аялал жуулчлалын томоохон 10 үзэсгэлэнд оролцоно. -Цахим сурталчилгааны хандалтын тоог 20-иос доошгүй хувиар нэмэгдүүлсэн байна. | Улсын төсөв | 2,000.0 | Улсын төсөв | 200.0 | 1.БОАЖЯ,НАЖГ, МАЖХ-ноос "МИАТ" ХК, "Аэромонголиа" ХХК, "Говь" ХК-иудын дэмжлэгтэйгээр Токио, Осака,Сөүл, Бусан хотуудад Монгол Улсыг сурталчлах "Монголын аялал жуулчлалын форум"-ыг нэгэн зэрэг зохион байгуулж, нийт 143 аж ахуйн нэгжийн төлөөлөл, БНСУ-ын Сөүл, Пусан хотуудад зохион байгуулагдсан форумд БНСУ-ын аялал жуулчлалын 101 аж ахуйн нэгжийн төлөөлөл, нийт 244 аж ахуйн нэгж оролсон. 2. 2019, 2020, 2021 оны өр төлбөр болох 72 мянган ам,долларыг аялал жуулчлалын хөтөлбөрийн зардлаас гаргаж, төлсөн. Мөн 2022.06.21-ний өдөр гадаадын 6 хэл дээр Монгол Улсын сурталчлан таниулах дижитал сэтгүүлийг цахим платформ болгон олон улсад сурталчлах ажлыг МАЖХ-ТББ-тай хамтран 100 зочдыг урьж зохион байгуулав. Япон Улсын Жата ОУ-ын үзэсгэлэн, Францын соёлын өдрүүд арга хэмжээнд 60 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн оролцлоо. 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Монгол улсыг гадаадад сурталчлах mongoliatravel.guide цахим платформ нээлттэй хийж, уг цахим платформыг олон нийтэд сурталчлах зорилгоор Монгол Улсад суугаа элчин сайд, төлөөлөгчийн газарт албан бичиг явуулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Соёлын яам, Гадаад харилцааны яам хамтран Монголын соёлын өдрүүд олон улсын үзэсгэлэнг Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотод 9 дүгээр сарын 20-ноос 23-ны өдрүүдэд зохион байгуулсан. "JATA-2022" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн Япон улсын Токио хотод 2022 оны 09 сарын 22-25ны өдрүүдэд зохиогдсон тус арга хэмжээнд АЖХ хариуцан ажиллаж, БОАЖЯ, НАЖГазар, МИАТ ТӨХК хамтран оролцож дэмжин ажилсан. Монголын аялал жуулчлалын "АЙТИЭМ" олон улсын үзэсгэлэн 2022 оны 10 дугаар сарын 28-30өдрүүдэд зохиозн байгуулагдсан. БОАЖЯ 21 аймгийн аялал жуулчлалын газрууд, аялал жуулчлалын холбоод оролцсон. | 70.0 |
| 147 | | 3.4.9. "Гандангийн дэнж" шинэ аялал жуулчлалын төвийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх | "Гандангийн дэнж" шинэ аялал жуулчлалын төвийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх | Барилгын ажлын гүйцэтгэл 40 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 24,000.0 | - | - | Соёлын яамны 2022 оны 03-р сарын 15-ны өдрийн 1/614 дугаартай албан бичгийн дагуу БГД-ийн 16-р хорооны нутаг дэвсгэрт байрлах "Гандан тэгчэнлин хийд" орчмыг соёл, аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаварт тусгуулах саналаа 2022 оны 03-р сарын 30-ны өдрийн НХБХГ-ын 02/02/940 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. - "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулиар "Гандангийн дэнж" шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажилд 590.0 сая төгрөг батлагдсан. Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын даргын 2022 оны 10-р сарын 21-ний өдрийн А/55 дугаар тушаалаар тус худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдсан. Үнэлгээний хорооны эхний хурлыг 2022 оны 11-р сарын 09-ний өдөр зохион байгуулж, тус ажлыг бацлах тухай саналыг Нийслэлийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Тус ажлын тендерийн баримт бичгийг боловсруулан 2022 оны 11-р сарын 11-ний өдөр дахин зарласан. 2022 оны 12-р сарын 12-ны өдөр нээсэн. Багц 1 "Гадна дулаан, цэвэр ус, ариутгах татуурга, зам талбайн тохижилт, Мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилга угсралтын ажил" Бумбод" ХХК; Багц 2 "Гудамж дундын чулуун замын зураг төсөв, гүйцэтгэл" Фючерпрогресс ХХК шалгарч зөвлөмж хүргүүлэх шатанд явж байна. | 75.0 |
| | 3.5. Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана. | 3.5.1. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх | Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх | Төслийн гүйцэтгэл 15 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 12,277.5 | Улсын төсөв | 3,786.9 | БНХАУ-ын Эксим банктай Тусгайлсан зээлийн хэлэлцээрийг байгуулахаар тус банкны төлөөлөл, Эрчим хүчний яам (Захиалагч); БНХАУ-ын Экспорт-Импорт банк (Санхүүжүүлэгч)-ны хооронд санал солилцох уулзалтуудыг 2022.03.10-ны өдрөөс эхлэн 7 удаагийн хурал уулзалтыг хийж, 26 удаагийн асуулга, тодруулга, тайлбар мэдээлэл, мэргэжлийн байгууллагуудын зөвлөмж, дүгнэлтийг бэлтгэн хүргүүлж ажилласны дүнд Монгол Улсын талаас Тусгайлсан зээлийн хэлэлцээр байгуулах нөхцөлийг бүрэн хангасан. Тус банкны зүгээс зээлийн хэлэлцээрийн судалгааны явц удаашралтай, санхүүжүүлэгч банкнаас зээлийн судалгааг хийх, уг судалгааг БНХАУ-ын хөндлөнгийн хараат бус үнэлгээ хийх, түүний дараа БНХАУ-ын төрийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 148 | | | | Гадаадын зээл, тусламж | 233,272.5 | | | өмчийн хороо буюу Худалдааны яам хянаж үзсэний үндсэн дээр тус улсын Төрийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэх үе шатаар дамждаг байна. Банкны зүгээс судалгаа хийсэн, хөндлөнгийн хяналтын шатанд байгаа талаар мэдэгдсэн. Нөлөөлөлд өртөж буй Увс аймгийн Өмнөговь сумын 125, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 145 өрхийн биет бус сэтгэл санааны хохирлын нөхөн олговор олгох асуудлыг ЗГ-ын 2022.04.06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоол гарсан. Төслийн нөлөөлөлд өртөх газар, орон зайд оршин суугч айл, өрхүүдийг нүүлгэн шилжүүлэхээр бэлтгэж ажлуудыг хангаж нөхөн олговрын гэрээ байгуулах ажил хийгдэж байна. Тус ажлын хүрээнд Баян-Өлгий, Ховд, Увс аймгуудын нутгийн удирдлагатай хамтран тус орон нутгийн 800 орчим иргэдтэй 6 удаагийн өргөтгөсөн хурлыг зохион байгуулсан. БНХАУ-ын GB, DL, NB стандартуудыг Монгол Улсын болон Олон улсын ижил төстэй стандартуудтай харьцуулалт болон дүйцүүлэх аргачлалаар хянан баталгаажуулсан. Төслийн нийт хэрэгжилт 16 хувьтай байна. | 100.0 |
| 149 | 3.5.2. Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх | Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх | Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 6,000.0 | Улсын төсөв | 12,108.8 | Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх 2022/Д-17 тоот "Эрчим хүчний барилга байгууламж барих ажил үргэлжлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээ"-г 03 дугаар сарын 29-ний өдөр олгосон. Хил гаалийн хорио цээрийн улмаас 2020-2021 онуудад барилга угсралтын ажлыг хэвийн гүйцэтгэх боломжгүй хязгаарлагдмал нөхцөл байдалд ажиллаж, төслийн хэрэгжилт удааширч гэрээт хугацаандаа хэрэгжих боломжгүй болсон тул гүйцэтгэгчтэй байгуулсан ЭХА-012/2019 тоот гэрээг сунгасан. БНХАУ-ын 0 ковид бодлогын хүрээнд хилийн боомтуудын үйл ажиллагаа хэвийн горимд орохгүй байгаагаас төслийн бараа материал, тоног төхөөрөмжийн тээвэрлэлт удаашралтай байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар 300 гаруй машин тоног төхөөрөмж үйлдвэр дээр, 120 гаруй машин тоног төхөөрөмж БНХАУ-ын Эрээн хотод тээвэрлэгдэн ирсэн. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 58.3 хувьтай байна. | 53.6 |
| | | | | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 101,996.0 | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 36,326.4 | | |
| 150 | 3.5.3. Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх | Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх | Төслийн гүйцэтгэл 15 хувьд хүрсэн байна. | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 427,500.0 | - | - | Байгаль орчны үнэлгээ хийсэн зөвлөх компани төслийн БОННҮ-г боловсруулж, орон нутгийн иргэд нийтийн хурлаар хэлэлцүүлэн үнэлгээний тайланг 2022.02.22-ны өдрийн мэргэжлийн зөвлөлийн хуралд хэлэлцүүлж, батлагдсан. Батлагдсан үнэлгээг БОАЖЯ-ны мэдээллийн санд байршуулсан. Тавантолгой ДЦС барих төслийн талбайг эзэмших 34044, 34045 дугаартай газар эзэмших гэрчилгээ гарсан. ОТ уурхайн эрчим хүчний хэрэглээг МУ-ын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс хангах гэрээний хэлцлийг хийж, Оюу толгой ХК-тай цахилгаан эрчим хүчээр хангах урт хугацааны гэрээг 2022.01.26-ны өдөр байгуулсан. Мөн тус төслийн 30 хувийн хувьцаа эзэмшигч "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс нүүрс баяжуулах үйлдвэрийн ус хангамжийн шугамын төлөвлөлтөд Тавантолгой дулааны цахилгаан станцын ус хангамжийн хэрэглээг нэмж тооцож, цахилгаан станцын усны хэрэглээг Загийн усны хоолой, Цагаан цавын усны орд газраас хангахаар шийдвэрлэсэн. Тавантолгойн ДЦС-аас нийлүүлэх ЦЭХ-ний гараааны үнийн тарифын саналыг аргачлалын дагуу тооцож, ЭХЗХ-нд хүргүүлсэн. Эрчим хүчний сайдын тушаалаар "Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ" байгуулах эрхийг "ДҮТ" ХХК, "ӨБЦТС" ТӨХК болон ТТДЦС ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлуудад олгосон ба Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдан олон улсын нээлттэй тендерийг 2 удаа зарласан боловч тендерт оролцсон компани тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй. Хуулийн дагуу дараагийн шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Төслийн бэлтгэл ажлын хүрээнд "Эрдэнэс тавантолгой" ХК-тай хувьцаа эзэмшигчдийн гэрээ, нүүрс нийлүүлэлтийн гэрээ байгуулагдсан. Хөрөнгө оруулалтын гэрээ, санхүүжилтийн гэрээний төслүүдэд 2 талаас хамтран ажиллаж байна. Төслийн нийт хэрэгжилт 10 хувьтай байна. | 66.6 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 151 | 3.5.4. Дулааны хоёрдугаар цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн хийн цахилгаан станц барих суурь судалгааг хийх | Дулааны хоёрдугаар цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн хийн цахилгаан станц барих суурь судалгааг хийх | Суурь судалгаа хийгдсэн байна. | Концесс, ТХХТ | - | - | - | Монгол Улсын эрчим хүчний системд түргэн маневрлах чадвартай турбингенератортой болох зорилгын хүрээнд 50*2 МВт-ын хийн генератор бүхий 100 МВт-ын цахилгаан станцыг ДЦС-2-ыг түшиглэн барьж байгуулах ТЭЗҮ-ийг ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн дэмжсэн. Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр гадаадын хөрөнгө оруулагч хэд хэдэн байгууллагад хүсэлт хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна. Энэхүү төслийг төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгаж концесс эзэмшигчийг сонгон шалгаруулж өгөх тухай хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт, мөн Төрийн өмчийн хорооны 2010 оны 153 дугаар тогтоолын-хавсралтаар батлагдсан-"Концессын зүйлийн зардал, үр ашгийн тооцоо хийх түр аргачлал"-ын дагуу төслийн суурь судалгааны тооцооллыг хийж ЭЗХЯ-нд хүргүүлж, холбогдох мэдээллүүдийг 3, 5, 6 дугаар саруудад хүргүүлсэн. ЭЗХЯ-наас чиг үүргийн дагуу 2022.08.17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд "ДЦС-2" ТӨХК-ийн дэд бүтцийг түшиглэн барих 100 МВт-ын хийн цахилгаан станц төсөл"-ийг "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д тусгуулах саналыг танилцуулсан ба Засгийн газрын 2022 оны 309 дүгээр тогтоолоор концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан. "ДЦС-2" ТӨХК-ийн дэд бүтцийг түшиглэн барих 100 МВт-ын хийн цахилгаан станцын төслийн концесс эзэмшигчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах холбогдох албан тушаалтны нэрсийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. | 100.0 |
| 152 | 3.5.5. Чойр-Сайншанд чиглэлийн 230 км урттай, 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих ажлыг эхлүүлж, ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэх | Чойр-Сайншанд чиглэлийн 230 км урттай, 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих ажлыг эхлүүлж, ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэх | Төслийн гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл тусламж | 72,186.8 | - | - | МУЗГ, ЕСБХБ хоорондын "Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр"-ийн хүрээнд 300 сая ам.долларын санхүүгийн эх үүсвэрээс 56,6 сая ам.доллараар Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийг санхүүжүүлэхийг ЗГ-ын 2019.09.18-ны өдрийн 356 дугаар тогтоолоор баталсан. Төсөвт өртөг дутагдаж байсан санхүүжилт болох 13,8 сая ам.долларын 8 сая ам.долларыг нь ЕСБХБ-аас, 5 сая ам долларыг Европын холбооны буцалтгүй тусламжаар шийдвэрлэхээр уг төслийн зээлийн гэрээний хэлцэл 2022.08.26-ны өдөр амжилттай хийгдсэн. Төслийн ТЭЗҮ-ийг Mercados Aries International компани болон "Мон-Энержи консалт" ХХК, Байгаль орчин, нийгмийн судалгааны ажлыг Sustainability East Asia болон Atkins компаниуд, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг "Эко трейд" ХХК тус тус хийж гүйцэтгэж, тайлангууд баталгаажсан. Говьсүмбэр, Дорноговь аймгуудын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх 220,04 км урттай ЦДАШ-ын трассын дагуух газрыг баталгаажуулан Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээллийн санд бүртгүүлж, орон нутгаас газрын гэрчилгээнүүд албажсан. ЕСБХБ-наас төслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд "Work shop" өдөрлөгийг 2022.06.09-ний өдөр зохион байгуулсан. Төслийн зээлийн гэрээний хэлцэл амжилттай хийгдэж, зээлийн гэрээнд ЕСБХБ, МУ-ын Сангийн яам гарын үсэг зурсан. "Төсөл хэрэгжүүлэх нэгж"-ийг байгуулах тухай саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Төслийн БУА-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн бичиг баримтуудыг банкны шаардлагын дагуу боловсруулах "Хувь зөвлөхүүд"-ийг төслийн техникийн туслалцааны хүрээнд авч ажиллуулах саналтай байгаагаа тус яамны зүгээс ЕСБХБ-д хүргүүлсэн. | 30.0 |
| 153 | 3.5.6. Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийг /салхины цахилгаан станцын 2 төсөл 15 МВт, нарны цахилгаан станцын 4 төсөл 35 МВт/ хэрэгжүүлэх | Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийг /салхины цахилгаан станцын 2 төсөл 15 МВт, нарны цахилгаан станцын 4 төсөл 35 МВт/ хэрэгжүүлэх | 10 МВт-ын эх үүсвэр ашиглалтад орсон байна. | Гадаадын зээл, тусламж | 77,700.0 | Гадаадын зээл, тусламж | 36,649.6 | - Говь-Алтай аймгийн Алтай сумын нарны цахилгаан станцын 0,8 МВт-ын өргөтгөл дууссч, 2022.08.01-ны өдөр ашиглалтад хүлээн авснаар Алтай сум 24 цаг тасралтгүй цахилгаан эрчим хүчээр хангагдаж байна. Завхан аймгийн Алдархаан суманд 5 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц, Улиастай суманд 3.6 МВт*ц-ийн цэнэг хуримтлуур суурилуулах ажлын гүйцэтгэл 100%-тай, 2022 оны 11 дүгээр сарын 25-нд ашиглалтад хүлээн авсан. Нийлбэр дүнгээр 9,4 МВт ашиглалтад орсон. - Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд 10 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцын барилга угсралтын ажил 70%, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцын барилга угсралтын ажил 20%-тай байна. - Увс аймгийн Өмнөговь, Завхан аймгийн Тэлмэнд суманд барихаар төлөвлөж байгаа 15 МВт-ын нийлбэр хүчин чадалтай хоёр салхины цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэх газруудад салхины хэмжилтийг хийж байна. | 94.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 154 | 3.5.7. Багануурын 400 МВт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх | Багануурын 400 МВт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх | Төслийн гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна. | Концесс, ТХХТ | 611,000.0 | - | - | "Багануур пауэр" ХХК-тай байгуулсан концессын гэрээнд 2021.05.14-ний өдөр нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдон дагалдах гэрээнүүдэд өөрчлөлт оруулж "ДҮТ" ТӨХХК, "ЦДҮС" ТӨХК болон "Багануур Пауэр" ХХК хооронд "ЦЭХХХАГ"-ний нэмэлт гэрээ №2-г байгуулсан. ЭХЯ-наас станцыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох техникийн нөхцөлийг олгосон. Усны газраас Усны дүгнэлт гарсан. БОНБНҮ-ний тодотголын тайлан БОАЖЯ-ны холбогдох мэргэжлийн зөвлөлийн 2022.02.22-ны өдрийн хурлаар баталгаажсан. Мөн станцын нүүрс дамжуулах туузан дамжуурга, ус татах шугам хоолой, өргөтгөлийн насосын станц болон ус хангамжийн шугамын нийт 20 га газрын ашиглах эрхийг 5 жилийн хугацаатай авсан. Концессын гэрээний нэмэлт, өөрчлөлтийн дагуу "Багануур Пауэр" ХХК-иас төслийн шинэчилсэн техникийн шийдлийг БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэтгэлийн хороонд бүртгүүлэх шаардлагатай бөгөөд энэхүү ажлын хүрээнд ГХЯ, ЭХЯ-наас дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. "Багануур Пауэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигч БНХАУ-ын "Цөмийн аж үйлдвэрийн барилга" ТӨХК-иас тус улсын "нүүрсний станцуудад хөрөнгө оруулалт хийх болон хүлэмжийн хийн ялгаруулалт ихтэй төслүүдийг дэмжихгүй байх" гэрийн бодлого, шийдвэртэй холбогдуулан хувьцаагаа шилжүүлэх албан хүсэлтийг 2022.08.01-ний өдөр МУ-ын ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Энэхүү асуудал шийдвэрлэгдэх хүртэл төсөл үргэлжлэх хугацаа тодорхойгүй байдлаар хойшилж байна. Эрчим хүчний сайдаас "Багануур Пауэр" ХХК-ийн эрх бүхий этгээдийг төслийн талаар ажлын уулзалт хийхийг 2022.10.18-ны өдрийн 21/2022 тоот албан бичгээр "Жунхе" групп-д хүргүүлсэн. | 50.0 |
| 155 | 3.5.8. 160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барих | 160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барих | Төслийн гүйцэтгэл 80 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 146,363.0 | Гадаадын зээл, тусламж | 27,236.3 | Зөвлөх үйлчилгээний тендерийг зохион байгуулж, ХБНГУ-ын "RWE Technology International GmbH" компани болон МУ-ын "Мон-Энержи-Консалт" ХХК-ийн баг шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. Байгаль орчны мониторинг хийх, жендэрийн чиглэлээрх ажлуудыг хэрэгжүүлэх компаниудыг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. ЭХХЗХС-ийн нэгдсэн сүлжээнд үзүүлэх туслах үйлчилгээний үнэ тариф, зах зээлийн дүрмийг эхний байдлаар боловсруулсан. Шинээр баригдах том чадлын цэнэг хураагуурын станцыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох Техникийн нөхцөлийг олгосон. 2021-2022 онд БУА-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2 удаа зохион байгуулсан. АХБ-наас үл татгалзах хариу ирүүлснээр 2022.06.09-ний өдөр Үнэлгээний хороо төслийн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах зөвлөмжийг өгсөн. Дэлхийн зах зээл дээрх цэнэг хураагуурын түүхий эдийн үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан тендер ирүүлсэн компаниуд үнээ нэмэх нөхцөл тавьж, АХБ-ны зөвлөмжөөр эхний тендер хүчингүй болж, дахин зарлагдсан. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын ZTT-ZEST консорциум шалгарч, 2022 оны 7 дугаар сард гэрээнд гарын үсэг зурсан ба АХБ-ны зөвлөмжийн дагуу гэрээнд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Барилга угсралтын ажлыг 2022.08.04-ний өдөр эхлүүлсэн ба төслийн ажлын зураг хийгдэж байна. Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл эхэлсэн. Ерөнхий зураг төслийн ажлын хүрээнд ДҮТ ТӨХХК, ЦДҮС ТӨХК, Төслийн менежментийн зөвлөх компани (ТМЗК) зэрэг талуудын хамтарсан хурлыг 2022.10.26-ны өдөр зохион байгуулж шийдлүүд дээр саналуудаа нэгтгэв. Төслийн хүрээнд "Эрчим хүчний салбарт ажиллаж буй 120 эмэгтэй инженерүүдийг чадавхжуулах сургалт"-ыг 2022.10.24-28-нд 3 үе шаттайгаар зохион байгуулсан. Төслийн нийт хэрэгжилт 20.0 хувьтай байна. | 25.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 156 | 3.5.9. Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах төслийг хэрэгжүүлэх /Эрчим хүчний төсөл-2/ | Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах төслийг хэрэгжүүлэх /Эрчим хүчний төсөл-2/ | Төслийн гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 24,000.0 | Гадаадын зээл, тусламж | 40,200.0 | "ЭБЦТС" ТӨХК, "БЗӨБЦТС" ТӨХК-ийн хангах, түгээх үйл ажиллагаа явуулдаг Архангай, Өвөрхангай, Орхон, Булган, Хэнтий, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Багануур дүүрэг, Өвөрхангай аймгийн Хархорин, Дорноговь аймгийн Замын-Үүд, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын төвийн цахилгаан түгээх, дамжуулах шугам сүлжээг шинэчлэх, Багануур дүүрэг, Хэнтий аймаг, Говьсүмбэр аймгийн төвд хаалттай хуваарилах байгууламж барих, Ховд аймгийн Мянгад сумын дэд станцыг түшиглэн 10МВ-ын нарны ЦС барих, мөн сумын дэд станцыг шинэчлэх ажлууд тус төслийн хүрээнд хийгдэж байна. Төслийн 2022 оны жилийн эцсийн байдлаарх хэрэгжилт: 1. 10МВт-ын нарны цахилгаан станцыг барьж Улсын комиссоор хүлээлгэн өгч Баруун бүсийн эрчим хүчний системд ЦЭХ нийлүүлж байна. Хэрэгжилт 100%. 2. Түгээх сүлжээний шинэчлэлтийн ажил 87,5%-тай. Төслийн хүрээнд 0.4-10кВ-ын 879,5 км цахилгаан дамжуулах шугам, 6,10/0.4кВ-ын 100-400кВа чадалтай 33 дэд станц, 35/10кВ-ын 10МВА, 35/6кВ-ын 2*10МВА чадалтай дэд станц шинээр барьж, ашиглалтад оруулсан. Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ, Багануур Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээнд нийт 41086 хэрэглэгчид 1 болон 3 фазын ухаалаг тоолуур суурилуулж системд холбосон. Төслийн нийт хэрэгжилт 94,8 хувьтай байна. | 93.5 |
| 157 | 3.5.10. Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийг эхлүүлэх | Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийг эхлүүлэх | Төслийн гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 30,000.0 | Гадаадын зээл, тусламж | 346.1 | Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 20,45 сая еврогийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл"-ийн хүрээнд 220, 110 кВ-ын дэд станцуудад ашиглагдаж буй ашиглалтын хугацаа дууссан, насжилт болон элэгдэл ихтэй 110 кВ-ын тосон болон хуурай таслуурыг гүйдлийн трансформатор, реле хамгаалалт удирдлагын хамтын шинэчлэх, төвийн бүсийн эрчим хүчний системийн гол зангилаа 220 кВ-ын 4 дэд станцын реле хамгаалалт, автоматик, хяналт, удирдлагын системийг бүрэн шинэчилж, өргөтгөх ажил хийгдэнэ. Төслийн зөвлөхөөр шалгарсан Герман Улсын Integration Umwelt& Energie компанитай гэрээ байгуулсан. Олон улсын төслийн удирдагч нар Монгол Улсад ирж төсөл хэрэгжих 24 дэд станцад газар дээр нь ажиллаж төслийн ажлын ээлэхүүнийг тодорхойлон шаардлагатай өгөгдөл мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэсэн. Ажлын зэлэхүүнд нэмэлтээр 35 кВ-ын 45 ширхэг тосон таслуур, 135 ширхэг гүйдлийн трансформатор, 25 ширхэг РХА-ыг шинэчлэх, мөн 220 кВ-ын 4 дэд станцын 220,110 кВ-ын хүчдлийн трансформатор шинэчлэх ажлыг нэмж оруулахаар Зөвлөх компанитай хамтран төслийн нэгдсэн ажлын зэлэхүүн, анхдагч болон хоёрдогч хэлхээний тоноглолуудын техникийн тодорхойлолт, схем зургийг бэлтгэн түлхүүр гардуулах нөхцөл бүхий төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийн баримт бичгийг боловсруулж 2022.11.04-ний өдөр төслийн санхүүжүүлэгч Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-д хүргүүлж "Үл татгалзах зөвшөөрөл" авах хүсэлт гаргасан. KfW банк тендерийн баримт бичгийг хянаж, шалгах ажил хийгдэж байна. Төслийн нийт хэрэгжилт 10 хувьтай байна. | 20.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 158 | 3.5.11. Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих | Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих | Төслийн гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 4,700.0 | Улсын төсөв | 4,700.0 | Тайширын УЦС–аас аймгийн төв уруу татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/ төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр 2019 онд эхлүүлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2019 онд уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан боловч тендерт оролцогчдоос маргаан үүсэж шүүхэд шилжсэн ба шүүхийн маргаан оны 4 дүгээр улиралд эцэслэгдсэнээр Худалдан авах ажиллагааны газраас дахин нээлттэй тендерийг 2020.12.12-нд зарласан. Эрчим хүчний сайдын 2021.02.10-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар байгуулагдсан гэрээний хэлэлцээр хийх ажлын хэсэг Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу тендерт шалгарсан "Биндэгноров" ХХК-тай гэрээний хэлцэл хийж, 2021.02.10-ны өдрийн ЭХА-001/2021 дугаартай гэрээг байгуулсан. Төслийн барилга угсралтын 2021.03.11-ний өдрийн 2021/Ц-34 тоот Ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээг олгож, ажлыг эхлүүлсэн боловч Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол ирсэнтэй холбоотойгоор ажил түр зогсож, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан тул хэргийг хэрэгсэхгүй болгож захирамж гарсан. Цар тахалтай холбоотойгоор тулгуурын захиалга болон нийлүүлэлт оройтсон мөн ажлын зурагт өөрчлөлт орох болсон зэрэг шалтгааны улмаас тус төслийн ажил удааширсан бөгөөд төслийн БУА-ыг 2022 оны 06 дугаар сард эхлүүлсэн. Төслийн хүрээнд баригдах 110/35/6 кВ-ын 10 МВт-ын хүчин чадалтай дэд станцын газрыг өөрчилж дахин геодезийн дүгнэлт хийлгэж, шинээр газар сонгон талбайг тэгшилж дэд станцын барилгын суурийн ажлыг эхлүүлсэн. Шугамын болон бусад тоног төхөөрөмжүүдийг 100 хувь захиалсан, дэд станцын газар шороонь ажлууд хийгдсэн. Станцын газардуулга болон хашаа барьсан. Дэд станцын тоноглолын суурь УСО босгож дуусгасан. 110кВ-ын ЦДАШ-ын тулгуур гагнах, тулгуурын ажил хийгдэж байна. Төслийн хэрэгжилт 20 хувьтай байна. | 20.0 |
| 159 | 3.5.12. Газрын гүний дулааны эх үүсвэрийг ашиглах загвар төслүүдийг хэрэгжүүлэх | Газрын гүний дулааны эх үүсвэрийг ашиглах загвар төслүүдийг хэрэгжүүлэх | 180 кВт-ын загвар төсөл хэрэгжүүлсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 1,083.0 | Гадаадын зээл, тусламж | 543.0 | Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд газрын гүний дулааны эх үүсвэрийг ашиглах загвар төслүүдийг 5 байршилд хэрэгжүүлэхээс 2022 онд 1 төслийг ашиглалтад оруулж, 1 төсөл дуусах үе шатанд, 3 төсөл худалдан авалтын шатанд байна. - Ховд аймгийн Жаргалант сумын 1,500 м2 талбайтай Нэгдүгээр цэцэрлэгийн барилгын дулаан хангамжид 135 кВт-ын хүчин чадал бүхий газрын гүний дулааны насосыг суурилуулан байнгын ашиглалтад оруулсан. - Завхан аймгийн Улиастай сумын 2-р сургуулийн өргөтгөлийн барилгын дулаан хангамжид 110 кВт-ын хөрсний дулааны насосын систем суурилуулах ажлын гүйцэтгэл 85%-тай. Баянхонгор аймгийн Өлзийт, Говь-Алтайн Алтай, Увсын Өмнөговь сумдад хэрэгжүүлэх газрын гүний дулааны систем суурилуулах төслүүдийн тендерийг 2022.12.09-ний өдөр нээсэн, үнэлгээ хийж байна. | 70.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 160 | | 3.5.13. Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих | Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих | Төслийн гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 30,000.0 | - | - | Тус төслийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажил хийгдэж баталгаажсан. Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор АХБ болон ЕСБХБ-тай хамтран ажилласан ба ЗГ-ын 2022.02.30-ны өдрийн 18 дугаар тэмдэглэлээр АХБ-ны санхүүжилтээр дэмжигдсэн. ЦДАШ-ын 468.3 км урт трассыг баталгаажуулах асуудлаар Ховд, Завхан аймгуудын ИТХ-ын дарга болон Засаг дарга нартай хамтран ажиллаж орон нутгийн газрын албаны мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших гэрээг баталгаажуулсан. АХБ-аас уг төсөл нь санхүүжих төслийн шаардлагыг хангасан талаар болон мөн шувууны нүүдлийн судалгааны дүгнэлт гарсан талаар тус тус мэдэгдсэн. Төслийн зээлийн гэрээг СЯ-наас 2022.06.27,-28-ны өдрийн УИХ-ын байнгын хороодын хуралд танилцуулж дэмжигдсэн. СЯ-наас 2022.07.07-ны өдрийн 03/4858 тоотоор төслийн санхүүжилтийг АХБ-аас 2022-2023 онд авч ашиглах 655 сая ам доллар хүртэлх санхүүжилтийн эх үүсвэрээс 140.0 сая ам доллартай тэнцэх санхүүжилтийг төсөлд хуваарилахаар төлөвлөсөн талаар мэдэгдсэн ба зээлийн ерөнхий хэлэлцээрт 2022.8.26-ны өдөр АХБ болон СЯ гарын үсэг зурсан. Төслийн БОННҮ-ний судалгааг хийж байгаа АХБ-ны Зөвлөхүүд 2022 оны 06 дугаар сараас эхлэн 3 сарын турш Ховд, Завхан аймгуудын нутагт Эрдэнэбүрэн УЦС-ыг барих талбай болон ЦДАШ-ын трасс дагуу ажиллаж, орон нутгийн иргэд, тусгай хамгаалалттай газрын захиргаа, орон нутгийн удирдлагуудтай уулзаж ажилласан. БОННҮ-ний урьдчилсан тайланг 2022.09.21-ний өдөр танилцуулсан бөгөөд төслийн трасс дагуу нүүлгэн шилжүүлэх болон нөлөөлөлд өртөж байгаа айл өрх, өвөлжөө, хаваржаа байхгүй мөн шувуудын нүүдлийн замаас хол учир Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө бага, хэрэгжүүлэх боломжтой гэсэн дүгнэлт гарсан талаар мэдэгдээд байна. Төслийн ТЭЗҮ, зураг төслийг 2022.09.15-ны өдрийн а/3490 тоотоор СЯ-нд хүргүүлсэн. АХБ-ны зүгээс төслийн зээлийн гэрээг 2023 оны 09 дүгээр сард батлуулах төлөвлөгөөтэй байна. Төслийн ХАА-ны төлөвлөгөөг боловсруулж байна. | 30.0 |
| 161 | | 3.5.14. Шинэ нисэх-Зуунмод сумыг холбосон 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 дэд станц байгуулах | Шинэ нисэх-Зуунмод сумыг холбосон 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 дэд станц байгуулах | Дэд станц байгуулна. | Улсын төсөв | 16,775.6 | Улсын төсөв | 1,575.6 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд хэрэгжих "Шинэ нисэх-Зуунмод сумыг холбосон 110 кВ-ын ЦДАШ, 110/35/10 дэд станц барих /Төв, Зуунмод/" төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн. 110/35/10 кВ Зуунмод дэд станцын удирдлагын байрны барилгын ажлын гүйцэтгэл 90%-тай явагдаж байна. 110 кВ-ын ЦДАШ-ын трассын дагуу нийт 42 /5 анкер, 37 тулгуур/ цэгт суурийн ажил хийхээс 34 цэгт ПС баганын суурь суурилуулж булалт хийгдсэн. 4 ширхэг 110 кВ-ын анкер тулгуурын суурь хийгдэж булалт хийгдсэн. Барилга угсралтын ажил графикийн дагуу хийгдэж байна. 18 цэгт газардуулгын ажил хийгдсэн. 35кВ-ын эхний анкер тулгуур суурь байрлуулсан булалт хийгдсэн. 8 ширхэг 35кВ-ын дан тулгуурын ажил хийгдэж байна. | 70.0 |
| 162 | | 3.5.15. Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдийг найдвартай эрчим хүчээр хангах ажлын хүрээнд эрчим хүчинд холбогдоогүй үлдсэн 8338 өрхийг эрчим хүчинд үе шаттайгаар холбох | Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдийг найдвартай эрчим хүчээр хангах ажлын хүрээнд эрчим хүчинд холбогдоогүй үлдсэн 8338 өрхийг эрчим хүчинд үе шаттайгаар холбох | 8338 өрхийг эрчим хүчинд холбосон байна. | Улсын төсөв | 23,781.3 | Улсын төсөв | 5,882.6 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2024 онд "Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж /Улаанбаатар/" төсөл арга хэмжээг Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Багахангай, Налайх дүүргүүдэд хэрэгжүүлж байна. Төсөл арга хэмжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулан, шалгарсан гүйцэтгэгчидтэй гэрээг байгуулан, барилгын ажлыг эхлүүлсэн. 2022 онд батлагдсан төсвийн хүрээнд ажил хийгдэж, санхүүжилт 100 хувь олгогдсон. | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 163 | 3.6. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна. | 3.6.1. Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замыг барих | Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замыг барих | Нийт барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 615,440.0 | - | - | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 233.6 км урт төмөр замын доод бүтцийн барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь, дээд бүтцийн барилга, угсралтын ажлын гүйцэтгэл 100 хувийн биелэлттэй байна. ЗТХС-ын 2021.12.23-ны өдрийн А/196 тоот тушаалаар байгуулагдсан техникийн комисс Тавантолгой өртөөнөөс эхний 63 км-т ажиллаж дүгнэлт гаргасан. ЗТХС-ын 2022 оны А/106 дугаар тушаалаар 63-227 км гол зам, зөрлөгийн зам сум, гүүр хиймэл байгууламжид техникийн комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах комисс ажиллуулах боломжтой гэж дүгнэсэн. ЗТХС-ын 2022.06.06-ны А/152 дугаар тушаалаар ТТ-ГС чиглэлийн төмөр замын төслийн Тавантолгой өртөөнөөс Гашуунсухайт өртөө хүртэлх өртөө зөрлөгүүдийн болон ачилтын тойргийн дохиолол төвлөрүүлэлт хориглол ба холбоо мэдээллийн байгууламж, шилэн кабель, технологийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах, урьдчилсан дүгнэлт гаргах техникийн коммис 2022.06.25-27-ны өрүүдэд ажиллаж үүрэг даалгавар өгсөн. ЗТХС-ын 2022.08.31-ний өдрийн А/239 дугээр тушаалаар ТТ-ГС чиглэлийн төмөр замын Тавантолгой өртөө, 4, 5, 6 дугаар зөрлөгийн дохиолол төвлөрүүлэлт, хориглол ба холбоо мэдээллийн байгууламжийг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд урьдчилсан дүгнэлт гаргах техникийн комисс 2022.09.05-07-ны өдрүүдэд ажиллаж, улсын комисс ажиллах бэлтгэл ажлын хүрээнд урьдчилсан дүгнэлт гаргасан. Гашуунсухайт өртөө 4, 5, 6 дугаар зөрлөгийн дохиолол төвлөрүүлэлт, хориглол ба холбоо мэдээллийн байгууламжид тус тус техникийн комисс ажиллаж дүгнэлт гаргаад байна. Тавантолгой–Гашуунсухайт чиглэлийн үлдэгдэл ажлыг шалган дүгнэлт гаргах техникийн комисс 2022.12.21-23-ны өдрүүдэд ажиллахаар бэлтгэл хангаж байна. | 100.0 |
| 164 | | 3.6.2. Өмнөговь аймгийн Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлыг эхлүүлэх | Өмнөговь аймгийн Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлыг эхлүүлэх | Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна. | Концесс, ТХХТ | 474,154.7 | - | - | Тус чиглэлийн авто замын барилгын ажлын явцын талаар танилцуулга бэлтгэн, 2022.03.09-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 2022.03.10-ны өдөр концесс эзэмшигч, гүйцэтгэгчийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, зам барилгын ажил гүйцэтгэхэд учирч буй саад бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг нь сонсож, мэргэжил арга зүйн зөвлөгөө, чиглэл өгсөн. Зам барилгын ажлыг 2022.03.15-ны өдөр эхлүүлсэн. Талбайд 819 хүн хүч, 582 машин, техник тоног төхөөремж байршин, хэмжилт, далангийн дүүргэлт, суурийн доод үе, хиймэл байгууламж, чулуу бутлах ажил гүйцэтгэж байна. Барилгын ажлын гүйцэтгэл 42 хувьтай байна. | 60.0 |
| 165 | | 3.6.3. Улаанбаатар төмөр замын 50 км гол замд их засвар хийх | Улаанбаатар төмөр замын 50 км гол замд их засвар хийх | 50 км төмөр замын их засварын ажлыг дуусгасан байна. | Төр-хувийн хэвшлийн түншлэл | 40,000.0 | - | - | 2021 онд төлөвлөсөн 50 км төмөр замаас гадна нэмэлтээр 30.7 км төмөр замын их засварын ажил гүйцэтгэсэн ба 2022 онд 6.8 км /Эмээлт зөрлөгийн 2.3 км замын сунгалтын ажил, Цомог зөрлөг 4.5 км замын сунгалтын ажил/-т их засварын ажил хийв. Нийт 44.3 км төмөр замын их засварын ажил гүйцэтгэсэн. | 88.6 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 171 | 3.6.9. Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замыг Мөрөн-Тариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто замыг эхлүүлэх | Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замыг Мөрөн-Тариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто замыг эхлүүлэх | Барилгын ажлын гүйцэтгэл 20 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 22,000.0 | - | - | Улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Санхүүжилт шийдвэрлэгдээгүй. МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт тусгагдаагүй тул дундаж оноогоор үнэлэв. | 78.6 |
| 172 | 3.6.10. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий-Хужирт-Арвайхээр чиглэлийн 101 км хатуу хучилттай авто замыг барих | Өвөрхангай аймгийн Бат-Өлзий-Хужирт-Арвайхээр чиглэлийн 101 км хатуу хучилттай авто замыг барих | Барилгын ажлын гүйцэтгэл 40 хувьд хүрсэн байна. | Концесс, ТХХТ | 150,000.0 | - | - | 2022 оны Улсын төсөвт Хужирт-Бат-Өлзий чиглэлийн 49 км хатуу хучилттай авто замыг барих 11.0 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч тодотголоор хасагдаж, 1.3 тэрбум төгрөг болсон. "Мотор сервис" ХХК Орхон голын 220 у/м гүүрийг барьж улсын комиссын №06/05/21 дугаар дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Тодотголоор хасагдсан дүнтэй уялдуулан барилгын ажлын хүрэх түвшингийн хувийг шинэчлэхгүй бол хөрөнгөөс шалтгаалан барилгын ажил зорилтот түвшинд хүрэх боломжгүй нөхцөл үүссэн. 2022 оны батлагдсан төсөвт өртөг магадлал хийлгэн 2023 оны МУ-ын улсын төсөвт тусгуулсан. Сонгон шалгаруулалт зарлах бэлтгэл ажил хангагдаж байна. | 70.0 |
| 173 | 3.6.11. Олон улс, улсын чанартай авто зам ашигласны төлбөр авах үйл ажиллагааг цахимжуулах | Олон улс, улсын чанартай авто зам ашигласны төлбөр авах үйл ажиллагааг цахимжуулах | 28 төлбөр авах цэг цахимжсан байна. | Улсын төсөв | 4,000.0 | - | - | - Олон улс, улсын чанартай авто замын төлбөр авах цэгийг цахимжуулах ажлын ТЭЗҮ-ийн судалгаа хийх Зөвлөхийг шалгаруулж, гэрээ байгуулсан. Судалгааны ажлын эцсийн шатны тайланг хүлээж авсан. - Нийслэл хотыг тойрсон Эмээлт, Налайх, Хоолтын төлбөр авах цэгт тээврийн хэрэгслийн дугаар таних камер, тоног төхөөрөмжийг суурилуулж, урьдчилж төлөх, төлбөр авах цэгээр нэвтрэх үед төлөх, дараа төлөх гэсэн 3 сонголтоор "Monpay" "Social pay" "E-баримт" үйлчилгээг ашиглан цахимаар төлбөр авах үйл ажиллагааг нэвтрүүлсэн. - Орон нутагт байрлах бусад төлбөр авах цэгийн үйл ажиллагааг цахимжуулах ажлын ТЭЗҮ-ийн судалгааг хийж, 2022.08.03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж 302 дугаар тогтоол гаргуулсан. Цахим системийн тоног төхөөрөмжийг орон нутгийн төлбөр авах цэгүүдэд суурьлуулж программ хангамж холбох ажлыг үе шаттай хийж байна. | 50.0 |
| 174 | 3.6.12. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх | Системийн хөгжүүлэлтийн 70 хувь хийгдсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 500.0 | - | - | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх талаар холбогдох судалгаа хийж зөвлөмж авахаар Цахим, хөгжил, харилцаа холбооны яам, Тагнуулын ерөнхий газарт 12/09 тоот албан бичгээр хүргүүлж. Зөвлөмжийг хүлээж байна. ЗХАБ-ын мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх талаар Дэлхийн банк, Ази, номхон далайн эдийн засаг нийгмийн комиссын замын хөдөлгөөний аюулгүй байдлын ажиглагч байгууллага, БНСУ-ын Койка байгууллагад хүсэлт гаргасны дагуу тээврийн хэрэгслийн мэдээллийн нэгдсэн систем бий болгох 14 сая $-ын төслийг 2023 оноос хэрэгжүүлэхээр шийдвэрлээд байна. Мөн Ази, номхон далайн эдийн засаг нийгмийн комиссын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ажиглагч байгууллага, нэгдсэн системийг бий болгох чиглэлээр чадавхийг сайжруулах төслийг хэрэгжүүлэхээр болсон. Тус төслийг эхлүүлэхээр БНСУ-ын талаас хүсэлт тавьсны дагуу төслийн хамтарсан судалгааг эхлүүлсэн. | 30.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 175 | 3.6.13. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан болон хийн эх үүсвэрээр ажиллах тээврийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, парк шинэчлэлийг хийх | Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан болон хийн эх үүсвэрээр ажиллах тээврийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, парк шинэчлэлийг хийх | 120 тээврийн хэрэгслийг шинэчилсэн байна. | Улсын төсөв | 72,000.0 | - | - | Засгийн газрын 2021 оны 146 тогтоолоор жил бүр 420 тэрбум төгрөгийг Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулахад зарцуулахаар шийдвэрлэсний дагуу нийслэлийн 2022 оны төсөвт нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлт, төлбөрийн системийн шинэчлэлтэд 77260 сая төгрөг зарцуулахаар тусгагдаж 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 145 шинэ тээврийн хэрэгслээр парк шинэчлэлт хийсэн. Үүнээс цахилгаан хөдөлгүүртэй 50, дизель хөдөлгүүртэй 60, цахилгаан хөдөлгүүртэй давхар 10, сургуулийн хүүхдийн 25 автобус байна. Стандартын шаардлага хангасан 24 болон түүнээс дээш хүний суудалтай, 45 болон түүнээс дээш зорчигчийн багтаамжтай, үйлдвэрлэснээс хойш зургаа хүртэл жил ашиглагдсан нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний зориулалт бүхий автобусыг 2024 оныг дуустал гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлснийг 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт хэлэлцэгдэн дэмжигдсэн. Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлд 272 тэрбум төгрөг зарцуулахаар 2022-2023 оны улсын төсөвт тусгагдсан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийтийн тээврийн парк шинэчлэлийн ажлын хүрээнд БНХАУ-аас 2023.01.05-нд 100 автобус, хоёрдугаар сарын эхээр 124 автобус оруулж ирнэ. НЗДТГ: Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолын Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний 3.6.13 дахь төсөл, арга хэмжээний 2022 оны хүрэх түвшинг 120 автобус гэж төлөвлөсөн. - НЗДТГ, Сүлдэрхан минералс ХХК болон "Xiamen golden dragon bus" Co.,Ltd түншлэлтэй Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл (Улаанбаатар) "Нийтийн тээврийн парк шинэчлэлт"-ийн хүрээнд 60 ш их багтаамжийн автобус, "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ нь БНХАУ-аас Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр 10 ш давхар автобус, 1 ш цахилгаан автобус, НЗДТГ, "Моннис Моторс" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу сургуулийн 20 ш автобус нийт 91 автобусыг хүлээн авч, 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн үйлчилгээнд ажиллуулсан. | 100.0 |
| 176 | 3.6.14. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийг цэнэглэх сүлжээг шатахуун түгээх станц, үйлчилгээний газруудыг түшиглэн төр-хувийн хэвшлийн түншлэлээр байгуулах | Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийг цэнэглэх сүлжээг шатахуун түгээх станц, үйлчилгээний газруудыг түшиглэн төр-хувийн хэвшлийн түншлэлээр байгуулах | Цахилгаанаар цэнэглэх 20 цэг, хийгээр цэнэглэх 10 станц байгуулсан байна. | Концесс, ТХХТ | 108,000.0 | - | - | Энэхүү арга хэмжээг ЗТХС, 21 аймаг, нийслэлийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээнд тусгасан. Улсын хэмжээнд 20-60 квт-ын хүчин чадалтай цахилгаан автомашин цэнэглэх 25, өндөр хүчин чадалтай их багтаамжийн цахилгаан автобус цэнэглэх 11, автотээврийн хэрэгслийг хийгээр цэнэглэх станц 21 аймагт 80, Улаанбаатар хотод 54-г үйлчилгээнд ашиглаж байна. Нийслэлийн 8 байршилд шинээр өндөр хүчин чадалтай цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх 25 станц барих санхүүжилтийг 2023 оны Агаар, орчны бохирдлыг бууруулах сангийн хөрөнгөөс шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. | 100.0 |
| 177 | 3.6.15. 3 аймгийн төвд зорчигч тээврийн авто буудал байгуулах | 3 аймгийн төвд зорчигч тээврийн авто буудал байгуулах | 3 аймгийн төвд авто буудал ашиглалтад оруулсан байна. | Концесс, ТХХТ | 7,500.0 | - | - | 1. Улсын төсвийн 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд Орхон аймагт автобуудал барих төсөл хэрэгжиж байна. Автобуудлын барилга угсралтын ажил 20 хувийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөний дагуу хоцрогдолгүй явж байна. 2. "Зорчигч тээврийн Ховд" ХХК нь компанийн өөрийн хөрөнгө оруулалтаар Ховд аймагт автобуудал барьж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 85 хувьтай, энэ онд багтаан ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байна. 3. "Бүрд чандмань" ХХК Хэнтий аймгийн Хэрлэн сумд автобуудал, мөн "Өв хангамж групп" ХХК нь Говьсүмбэр аймагт автобуудал барих хамтран ажиллах гэрээг "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-тай байгуулсан. 2023 оноос барилгын ажил эхлүүлэхээр гэрээг байгуулаад байна. | 50.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 178 | 3.6.16. 4 улстай агаарын харилцааны хэлэлцээр байгуулж, 1 улстай нислэгийн цэг, давтамжийг нэмэгдүүлсэн байх | 4 улстай агаарын харилцааны хэлэлцээр байгуулж, 1 улстай нислэгийн цэг, давтамжийг нэмэгдүүлсэн байх | 43 оронтой агаарын харилцааны хэлэлцээр байгуулсан байна. | - | - | - | - | "Агаарын харилцааны тухай" МУ-ын ЗГ, Бүгд Найрамдах Узбекистан Улсын ЗГ хоорондын хэлэлцээрт Гадаад харилцааны Дэд сайдын 2022 оны 06 дугаар сард БНУзУ-д хийх албан ёсны айлчлалын үеэр гарын үсэг зурж, байгуулах саналыг 2022.05.06-ны өдрийн 01/2120 тоот албан бичгээр ГХЯ-д хүргүүлсэн. "Агаарын харилцааны тухай МУ-ын ЗГ, Бүгд Найрамдах Латви Улсын ЗГ хоорондын хэлэлцээр"-ийн төслийг зөвшилцөн тохирч, Агаарын харилцааны хурал (ICAN 2022)-ын дараа 12 дугаар сард багтаан үзэглэхээр тохиролцсон. "Агаарын харилцааны тухай" МУ-ын ЗГ, Бүгд найрамдах Словени Улсын ЗГ, Бүгд Найрамдах Итали Улсын ЗГ хоорондын хэлэлцээрийн төслийг Словени, Италийн талд тус тус уламжлуулахаар 2022.05.04-ний өдрийн 01/2035 тоот албан бичгээр ГХЯ-д хүргүүлсэн. ГХЯ-аас хэлэлцээрийн төслийг 2022.05.11-ний өдрийн цахим шуудангаар Вена дахь ЭСЯ-нд илгээсэн. -Америкийн талтай зөвшилцөн тохиролцсон "Агаарын тээврийн тухай МУ-ын ЗГ, АНУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авч тусган, 2022.11.30-ны өдрийн 01/5529 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Грекийн талтай үзэглэсэн Агаарын харилцааны хэлэлцээрийн төслийн монгол хэл дээрх албан орчуулгыг хянан баталгаажуулж, Грекийн талд дипломат шугамаар хүргүүлэх хүсэлтийг ГХЯ-д хүргүүлсэн. Нислэгийн цэг, давтамж нэмэгдүүлэх: Монгол-Япон хоорондын нислэгийн давтамж долоо хоногийн 13.5 нэгж буюу 13 хүртэлх давтамж, үүнээс 7 давтамж нь Улаанбаатар-Токио чиглэлд ашиглагдаж байсныг 7 хоногийн 9000 суудлын багтаамж, 30 хүртэлх давтамж болгон нэмэгдүүлсэн. Улаанбаатар-Сөүл-Улаанбаатар чиглэлд томилогдсон агаарын тээвэрлэгчид Солонгосын талаас долоо хоногт 3 удаагийн хуваарьт нислэгийн зөвшөөрөл олгож байсныг 2022 оны 05 дугаар сард 7 болгон нэмэгдүүлсэн. Хятадын талын цар тахлын хязгаарлалтаас шалтгаалан хоёр улсын хооронд 14 хоногт 2 тал 1, 1 удаа нислэг гүйцэтгэж байсныг 7 хоногт 2 тал тус бүр 3 удаа болгон нэмэгдүүлсэн. Ачаа тээврийн нислэгийн давтамжийг 7 хоногт 7 болгон нэмэгдүүлсэн. | 100.0 |
| 179 | 3.6.17. Агаарын навигацийн үйлчилгээний техник, технологийг шинэчлэх | Агаарын навигацийн үйлчилгээний техник, технологийг шинэчлэх | Бүсийн хөдөлгөөний удирдлага /АТМ/-ын тогтолцоог шинэчилж, шинэчлэлийг үргэлжлүүлнэ. | Улсын төсөв | 7,300.0 | - | - | Агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмжүүдийн тэжээлийн системийн батарей 436 ширхэг /УБ,Төв, Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Баянхонгор/ 238.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/202202018/01/01 дугаартай тендерийг 2022.03.01-ний өдөр зарлаж, худалдан авалтыг амжилттай хийсэн. - Нислэгийн ярианы бичлэгийн системийг нийлүүлж, суурилуулах 1 иж бүрдэл /Баянхонгор/, 33.0 сая төгрөгийн өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/202202019/01/01 дугаартай тендерийг 2022.03.01-ний өдөр зарлаж, 2022.04.01-ний өдөр нээж, үнэлсэн. Тендерт "Комплекс сити" ХХК шалгарч, бараа нийлүүлэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 2022.05.09-ний өдрийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан. -Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн аэродромын дадлагажуулагч /Улаанбаатар/-3.0 тэрбум /энэ онд санхүүжих дүн 1.0 тэрбум төгрөг/ төгрөгийн өртөг бүхий ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/202202021/01/01 дугаартай тендерийг 2022.03.02-ны өдөр зарлаж, 2022.04.01-ний өдөр нээж үнэлсэн боловч шаардлага хангасан оролцогч оролцоогүй. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу тендерийг дахин зарлаагүй. - Агаарын навигацийн холбооны станцуудыг баталгаажуулах хэмжүүрийн багаж нийлүүлэх 2 иж бүрдэл /Баруун, зүүн бүс/-240.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/202202020/01/01 дугаартай тендерийг 2022.03.02-ны өдөр зарлаж, 2022.04.04-ний өдөр нээж тендерийг үнэлсэн. Тендерт "BLUE VIEW" ХХК шалгарч, бараа нийлүүлэх гэрээг 2022.04.26-ны өдөр байгуулсан. Хэмжүүрийн багажийг гэрээний хугацаанд хүлээн авсан. Мөн Монгол Улсын агаарын зайн дээд, доод агаарын замуудыг нэгтгэж уламжлалт (чиг шулуун) агаарын зам 33, үзүүлэлтэд тулгуурласан (RNAV-5) агаарын зам 16 нийт 49 агаарын замыг 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс ашиглаж эхэлсэн. Агаарын навигацийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ (VPN)-ний тоног төхөөрөмжийг орон нутаг болон алслагдсан байгууламжуудад нийт 24 байрлалаас 15 байрлалд суурилуулсан. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 180 | 3.6.18. Орон нутаг дахь ашиглагдахгүй болсон нисэх буудал, агаарын хөлөг хөөрч буух зурвас, талбайг сэргээн сайжруулж, ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах | Орон нутаг дахь ашиглагдахгүй болсон нисэх буудал, агаарын хөлөг хөөрч буух зурвас, талбайг сэргээн сайжруулж, ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах | 116 зурвасыг сэргээн сайжруулсан байна. | Улсын төсөв | 1,911.0 | - | - | Орон нутагт нийт 59 байршилд бага оврын агаарын хөлөг хөөрч, буух түр зурвасын талбайг сонгон баталгаажуулсан. Мөн аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу "Скай Резорт" ХХК-ийн цаны бааз, "Интермед" эмнэлэгт нисдэг тэрэг хөөрч, буух талбайн /вертодром/ үзлэг шалгалт хийж мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан. 2022.12.14-ний өдрийн байдлаар ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах бага оврын агаарын хөлөг хөөрч буух түр зурвас талбай 13 аймгийн 55 байршилд цэг сонгосон ба 4 аймгийн 7 байршилд цэг сонгоогүй үлдээд байна. Мөн Бага оврын агаарын хөлөг хөөрч буух түр зурвас талбайг Хөвсгөл аймгийн Ринчэнлхүмбэ сумандэхлүүлсэн, Ховд аймгийн Чандмань суманд байгуулан хүлээн авсан. | 100.0 |
| 181 | 3.6.19. Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөлийн 2 дугаар үе шатны барилгын ажлыг дуусгах | Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөлийн 2 дугаар үе шатны барилгын ажлыг дуусгах | Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 188,350.0 | Гадаадын зээл, тусламж | 177,489.9 | Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.2 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг 2022.03.15-ны өдрөөс эхлүүлсэн. Зам барилгын ажлын талбай дээр 380 гаруй инженер техникийн ажилчид, 250 орчим техник, тоног төхөөрөмж ажиллаж байгаа бөгөөд нийт 5 багц хэсгийн барилгын ажил Багц 1-1 хэсэг 96.16%, Багц 1-2 хэсэг 89%, Багц 1-3 хэсэг 99,5%, Багц 1-4 хэсэг 52,3%, Багц 1-5 хэсэг 99,9%-ийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжиж байна Төслийн ажил 82%-ийн гүйцэтгэлтэй байна. - Европын сэргээн босголтын банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөлийн барилгын ажлыг 2022.03.15-ны өдрөөс эхлүүлсэн. Энэхүү төслийн хүрээнд 2022 онд барилгын ажлын талбай дээр 736 гаруй инженер техникийн ажилчид, 317 техник, тоног төхөөрөмж ажиллаж байгаа бөгөөд нийт 5 багц хэсгийн барилгын ажлын гүйцэтгэл Багц 1 хэсэг 85,7%, Багц 2 хэсэг 47%, Багц 3 хэсэг 45%, Багц 4 хэсэг 60%, Багц 5 хэсэг 62%-ийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжиж байна. Төслийн ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна. | 72.0 |
| 182 | 3.6.20. "Баруун босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх төсөл"-ийн зам барилгын ажлын Багц 1-4 хэсэг буюу Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгэх | "Баруун босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх төсөл"-ийн зам барилгын ажлын Багц 1-4 хэсэг буюу Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгэх | Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 12,600.0 | Гадаадын зээл, тусламж | 20,540.6 | Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто замын барилгын ажил бүрэн дууссч 06/13/22 дугаар дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан. | 100.0 |
| 183 | 3.6.21. "Нутгийн зам төсөл"-ийг хэрэгжүүлж, 554 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг эхлүүлэх | "Нутгийн зам төсөл"-ийг хэрэгжүүлж, 554 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг эхлүүлэх | Төслийн гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 30,065.7 | - | - | Нутгийн зам төслийн хүрээнд 5 сумдын төвийг холбох 155.79 км авто замын төсөл, арга хэмжээ хэрэгжсэн. Үүнд: Архангай аймгийн Өндөр-Улаан сумыг холбох 7 км авто зам 56%, Хөвсгөл аймгийн Тариалан сумын холбох 6.3 км 35.8%, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын төвийг холбох 22.89 км авто зам 100%, Төв аймгийн Мөнгөнморьт сумыг холбох 60 км авто замын барилгын явц 72%-ийн гүйцэтгэлтэй он дамжин хэрэгжиж байна. Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг холбох 59.6 км зам барилгын ажил бүрэн дуусаж улсын ашиглалтад оруулсан. Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр нийт 4 төсөл, арга хэмжээний 89.54 км авто зам: - Архангай аймгийн Булган сумыг холбох 35 км, Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумыг холбох 16 км авто замын төслийг Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр санал хүргүүлсэн. - Ховд аймгийн Ховд сумыг холбох 18.776 км, Эрдэнэбүрэн сумыг холбох 19.78 км авто замын төслийг АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, тухайн төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар /нийт 10 төсөл, арга хэмжээний 566.4 км авто зам: МУ-ын 2022 оны Төсвийн тухай хуульд Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад тусгагдсан дараах барилгын ажлыг шинээр эхлүүлсэн. - Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122.4 км авто замын 4 багц ажил-5-31%, -Ховд аймгийн Чандмань сумыг холбох 56.9 км авто зам-18.2%, -Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумыг холбох 52.5 км-34%, Батноров, Норовлин сумдыг холбох 130 км авто замын 2 багц ажил-52%,- Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумыг холбох 49 км авто зам-6%, - Булган аймгийн Хишиг-Өндөр сумыг холбох 31.08 км авто зам-2%, - Дорнод аймгийн Чойбалсан сумыг холбох 124.5 км авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Төслийн хэрэгжилт: - Хөнгөвчилсөн хучилттай авто зам барих нийт 19 төсөл, арга хэмжээ-21 хувь, - Олон улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу холбогдох нийт 14 төсөл, арга хэмжээ-50 хувьтай байна. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 184 | 3.6.22. Улаанбаатар - Арвайхээр чиглэлийн 57.56 км хатуу хучилттай авто замын их засварын ажил хийх | Улаанбаатар - Арвайхээр чиглэлийн 57.56 км хатуу хучилттай авто замын их засварын ажил хийх | Их засварын ажлын гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 11,280.0 | Гадаадын зээл, тусламж | 32,226.7 | Барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэлийн хүрээнд 2022 оны барилгын ажлын төлөвлөгөөг баталсан. Мөн гадаадаас авах ажиллах хүчний зөвшөөрлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Гадаадын иргэн, харьяатын газраар гаргуулсан. Зам барилгын ажлыг 2022.03.15-ны өдөр эхлүүлсэн Талбай дээр 139 хүн хүч, 47 машин механизм ажилласан. Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 57.2 км авто замын их засвар, шинэчлэлтийн ажил дууcч 2022.11.30-ны өдөр комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан. | 100.0 |
| 185 | 3.6.23. Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замыг барих | Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замыг барих | Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна. | Концесс, ТХХТ | 250,000.0 | - | - | 2019 онд концессын гэрээ хүчин төгөлдөр болсон ч орон нутгаас авто замын зурвас газар эзэмшүүлэх зөвшөөрөл олгогдоогүйгээс зам барилгын ажил гацаанд ороод байсан бөгөөд Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Засаг даргын 2022.01.26-ны өдрийн "Газар эзэмших эрх олгох тухай" А/05 дугаар захирамж гарснаар гүйцэтгэгч компани зам барилгын ажлыг эхлүүлэхээр нүүлгэн шилжүүлэлтийн ажил эхэлсэн боловч нутгийн иргэд, малчдын эсэргүүцэлтэй тулгаран, тодорхойгүй нөхцөл байдал үүссэн. Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар томилогдсон ажлын хэсэг болон ХЗДХ-ийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг 2022 оны 3, 4 сард газар дээр нь ажиллаж, ард иргэдтэй уулзалт хийсэн. Үүний дараа Ерөнхий сайд 2022.05.26-27-ны өдрүүдэд Өмнөговь аймагт ажиллаж, ард иргэдтэй уулзаж, санал хүсэлтийг нь сонссоны үндсэн дээр Цагаандэл-Уул боомт нээхээр шийдвэрлэсэн Засгийн газрын 2014 оны 46 дугаар тогтоолыг түдгэлзүүлэх асуудлыг Засгийн газрын 2022.05.31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Цагаандэл Уул боомтын асуудлыг Өмнийн говийн хөгжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн санал, дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, ЗТХ-ын сайд Л.Халтар нарт даалгасан. Түүнчлэн Ерөнхий сайд 2022.07.20-ны өдөр 107 дугаар захирамж гарган, Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагын дарга нараас бүрдсэн Цагаандэл-Уул боомтыг нээн ажиллуулахад тулгамдаж буй асуудлыг судалж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Мөн ЭЗХЯ дээр уг ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Орон нутгаас авто замын зурвас газар эзэмшүүлэх зөвшөөрөл олгогдоогүйгээс зам барилгын ажил гацаанд ороод байгаа тул хэрэгжилтийг дундаж оноогоор үнэлэв. | 76.8 |
| 186 | 3.6.24. Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг эхлүүлэх | Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг эхлүүлэх | Барилгын ажлын гүйцэтгэл 20 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 26,900.0 | - | - | МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт хасагдаж, 20.8 тэрбум төгрөг төлөвлөснийг 2.5 тэрбум төгрөг болгон баталсан. Төрийн худалдан авах ажиллагааны газар сонгон шалгаруулалтыг 3 удаа зарласан. Сүүлийн тендерийн нээлт 2022.09.13-нд нээсэн нэг ч оролцогч оролцоогүй байна. Тус ажлын төсөвт өртгийг дахин магадлалаар оруулж, 2023 оны улсын төсөвт санхүүжилтийг суулгасан. МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт хасагдсан тул хэрэгжилтийг дундаж оноогоор үнэлэв. | 76.8 |
| 187 | 3.6.25. Хэнтий аймгийн Норовлин Дорнод аймгийн Баян-Уул-Ульхан боомт чиглэлийн 124 км хатуу хучилттай авто замыг барих | Хэнтий аймгийн Норовлин-Дорнод аймгийн Баян-Уул-Ульхан боомт чиглэлийн 124 км хатуу хучилттай авто замыг барих | Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Концесс, ТХХТ | 140,000.0 | - | - | Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн хатуу хучилттай авто зам, 68.3 км /Хэнтий, Норовлин сум, Дорнод, Баян-уул сум/ төслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж 2022.04.28-ны өдөр Монгол зам групп ХХК, Голд өлзийт ХХК-ийн түншлэлтэй гэрээ байгуулсан. Харин Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх хатуу хучилттай авто зам, 50 км /Дорнод, Баян-Уул сум/ төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж 2022.05.23-ний өдөр Түм-Арвижих ХХК-д гэрээ байгуулах эрх олгосон. Гэвч Түм-Арвижих ХХК нь шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгааг тендерийн хүчинтэй хугацаанд багтаан ирүүлээгүй тул хүчингүй болсон. Иймд 2022.06.08-ны өдөр дахин зарласан ба нээхэд 2 оролцогч оролцсон бөгөөд үнэлэхэд шаардлагад нийцээгүй тул дахин 2022.07.20-ны өдөр зарласан. Тендерийг нээхэд мөн адил 2 оролцогч оролцсон ба үнэлэхэд шаардлагад нийцээгүй. Үнэлгээний хорооны шийдвэрт гомдол гарсан бөгөөд Сангийн яамнаас дахин үнэлэх шийдвэр ирүүлсэн ба Үнэлгээг хийж байна. 2022 оны Улсын төсөвт 9.0 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч тодотголоор хасагдаж, 2.5 тэрбум төгрөг тусгагдсан. 2022 онд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 6 удаа зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, тендер амжилтгүй болсон. 2023 онд дахин тендер зарлана. Төсвийг 2023 оны улсын төсөвт нэмэгдүүлж батлуулсан МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт хасагдаж тусгагдсан тул хэрэгжилтийг дундаж оноогоор үнэлэв. | 76.8 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 188 | 3.6.26. Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл 99.7 км авто замыг барьж эхлүүлэх /Булган/ | Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл 99.7 км авто замыг барьж эхлүүлэх /Булган/ | Барилгын ажлын гүйцэтгэл 15 хувьд хүрсэн байна. | Концесс, ТХХТ | 16,400.0 | - | - | Булган аймгийн Орхон-Хишиг-Өндөр чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл 31.08 км авто зам 2022 оны Улсын төсөвт 9.0 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч тодотголоор хасагдаж, 1.2 тэрбум төгрөг тусгагдсан. Тодотголоор хасагдсан дүнтэй уялдуулан барилгын ажлын хүрэх түвшний хувийг шинэчлэхгүй бол хөрөнгөөс шалтгаалан барилгын ажил зорилтот түвшинд хүрэх боломжгүй нөхцөл үүсэж байна. ТХААГ-аас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, 2022.08.09 "РЭС" ХХК-тай гэрээ байгуулсан. МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар төлөвлөсөн хөрөнгийг бүрэн зарцуулж, хөрс хуулах, зөөвөрөөр далан, тохиромжгүй хөрс зайлуулах, хиймэл байгууламж, тэсэлгээний ажил хийгдсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 7.2 хувьтай байна. | 70.0 |
| 189 | 3.6.27. Зүүнбаян-Ханги чиглэлийн 269 км төмөр замын төсөл хэрэгжүүлэх /Дорноговийн Зүүнбаян, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сум/ | Зүүнбаян-Ханги чиглэлийн 269 км төмөр замын төсөл хэрэгжүүлэх /Дорноговийн Зүүнбаян, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сум/ | Техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв боловсруулсан байна. | Концесс, ТХХТ | 300,000.0 | - | - | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 28 тогтоолоор уг төмөр замын төслийг концессын тухай хуулийн дагуу шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт дахь зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэх "Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам" төслийн концессын гэрээг "Монголиан транс лайн" ХХК болон "Монголиан транс ложистик" ХХК–ийн нэгдэлтэй байгуулах эрхийг 2022 оны 3 дугаар сарын Засгийн газрын хуралдаанаар олгосон. 2022.03.11-нд эхлүүлсэн бөгөөд 2022.11.19-ний өдрийн байдлаар дараах гүйцэтгэлтэй байна. Үүнд: Барилгын ажлын явц: Доод бүтцийн ажлын гүйцэтгэл: - Газар шорооны ажил 100%, - Гүүрийн ажил 100%, - Ус өнгөрүүлэх хоолойн ажил 100 хувь, Дээд бүтцийн ажлын гүйцэтгэл: - Дээд бүтцийн угсралтын ажил 95 хувь, - Эрчим хүчний ажил 62%, - Өртөө зөрлөгийн барилга 100 хувь, - Дохиолол холбооны ажил 16 хувь, Төслийн барилгын ажлын нийт гүйцэтгэл 90.4 хувьтай байна. 2022.11.25-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Зүүнбаян- Ханги чиглэлийн 226.9 км төмөр замын тээврийн үйл ажиллагааг нээсэн. | 100.0 |
| 190 | 3.6.28. Уул уурхайн болон бусад ачааг экспортлох төмөр замын дамжлагын тээвэр зохион байгуулалтын тооцоо судалгааг хийх, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх | Уул уурхайн болон бусад ачааг экспортлох төмөр замын дамжлагын тээвэр зохион байгуулалтын тооцоо судалгааг хийх, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх | Шаардлагатай бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байна. | Улсын төсөв | 500.0 | - | - | "Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, нүүрс баяжуулах үйлдвэр"-ийг ашиглалтад оруулсны дараа автотээвэр, төмөр зам руу ачилт хийнэ. Чингэлэгт тээврийн терминал байгуулах тухай Засгийн газрын 2021.07.02-ны өдрийн 185 дугаар тогтоолын хүрээнд "Энержи ресурс" ХХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Тавантолгой" ХК-ийн хөрөнгөөр Гашуунсухайт боомтод үерийн далан, чингэлэг тээвэр, урт болон богины тээврийн зам талбайн ажил хийгдэж, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний бүтээн байгуулалт төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн. Жилдээ 10,0 сая тн чингэлэгтэй нүүрс шилжүүлэн ачих хүчин чадалтай уг терминал 2021.09.20-нд ашиглалтад орсон. Өмнөговь аймгийн Цогтцэций суманд Холимог тээврийн логистикийн төвийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулахад шаардагдах 800 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх саналыг 2021.11.24-ны өдрийн 01/5304 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн. Чингэлэгт тээврийн терминал байгуулах тухай Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 2-ны өдрийн 185 дугаар тогтоолын хүрээнд Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминал байгуулах ажлыг "Монголын Алт" ХХК хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Тавантолгой холимог тээврийн логистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулах хөрөнгө шийдэх чиглэлээр "Эрдэнэс таван толгой" ХК дээр ажлын хэсэг байгуулагдсан. Тавантолгойн холимог тээврийн логистикийн төв байгуулах ТЭЗҮ-г боловсруулж логистикийн төвийн барилгын ажлыг эхлүүлсэн. Барилгын ажлын гүйцэтгэгчээр "Бодь интернэйшнл" ХХК ажиллаж байгаа бөгөөд ажлын явц 40 хувьтай явагдаж байна. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 191 | 3.6.29. Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Эрдэнэцагаан-Бичигт боомт чиглэлийн тусгай зориулалтын авто замын барилгын ажлыг эхлүүлэх | Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Эрдэнэцагаан-Бичигт боомт чиглэлийн тусгай зориулалтын авто замын барилгын ажлыг эхлүүлэх | Авто замын барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна. | Концесс, ТХХТ | - | - | - | Төрийн худалдан авах ажиллагааны газраас уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг байгуулахаар тус яамнаас ажлын хэсэгт ажиллах албан тушаалтны нэрийг авсан. ЗГХЭГ-аас концесс, төрийн хувийн хэвшлийн чиг үүргийг ЭЗХЯ хариуцах болсонтой холбогдуулан ТХААГ-т буй төслүүдийн мэдээллийг хүлээлцэх хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаатай холбогдуулан ажлын хэсэг байгуулах ажил түр хойшлогдсон байна. Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан төслүүдийн явц байдлын талаар хуваарь гарган Засгийн газрын хуралдаанд танилцуулах шийдвэрийн дагуу 2022.03.30-ны өдрийн ЗГ-ын хуралдаанд танилцуулсан. Засгийн газрын хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу "Баруун-Урт-Бичигт чиглэлийн авто зам төсөл"-ийн зардал, үр ашгийн тооцоог 2 хувилбараар боловсруулж, товч танилцуулга, мэдээллийн хамт 2022.05.11-ний 03/2161 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Засгийн газрын 2022.05.04-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор БУ-Бичигт чиглэлийн замын концесс олгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахыг ТХААГ-т даалгасан. ТХААГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу 2020.06.22-ны өдөр концесс олгох ажлын хэсэгт ажиллах албан тушаалтны нэрсийг хүргүүлсэн бөгөөд ажлын хэсэг байгуулагдсан боловч тус газраас өнөөдрийг хүртэл ажлын хэсгийн хуралдааныг зарлах ажлыг зохион байгуулаагүй, хүлээгдэж байна. Тус яамнаас шалтгаалахгүй хүлээгдэж байгаа тул хэрэгжилтийг дундаж оноогоор үнэлэв. | 76.8 |
| 192 | 3.6.30. Арц суурь-Шивээ хүрэн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах | Арц суурь-Шивээ хүрэн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах | Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулж, трасс батлагдсан байна. | Концесс, ТХХТ | 12,000.0 | - | - | Засгийн газрын 2022 оны 105 дугаар тогтоолоор тус чиглэлийн төмөр замыг зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэхээр концессын зүйлийн жагсаалтад оруулсан. Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолоор Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замыг төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын "Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн" ХХК байгуулан Концессын "зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулах, хамтран ажиллах сонирхол бүхий гадаад, дотоодын хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх, сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг "Монголын төмөр зам" ТӨХК-д даалгасан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Монголын төмөр зам" ТӨХК-аас Төсийн тусгай зориулалтын компанид хөрөнгө оруулж хамтран ажиллах сонирхол бүхий этгээдийг сонгон шалгаруулалт хийсэн. Оролцогч байгууллагаас шүүхэд гомдол гаргасан тул хүлээгдэж байна. Тус яамнаас шалтгаалахгүй хүлээгдэж байгаа тул хэрэгжилтийг дундаж оноогоор үнэлэв. | 76.8 |
| 193 | 3.6.31. Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барих | Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барих | Барилгын ажлын гүйцэтгэл 40 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 62,054.0 | - | - | 2022 оны улсын төсөвт хөрөнгө тусгагдаагүй. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр тус яамтай хамтран хэрэгжүүлж буй "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн 3 дугаар шатны хүрээнд Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барих хөрөнгийн асуудлын хүрээнд АХБ-ны зүгээс төслийн өмнөх урьдчилсан судалгааг (PPTA) эхлүүлсэн. Зөвлөхөөр ХБНГУ-ын "Kocks consult GMBH" компани шалгарч судалгааны ажлыг эхлүүлсэн. Ажлын явцын талаар АХБ,ЗТХЯ, Зөвлөх компани хамтарсан ажлын хэсгийн уулзалтыг 2022.09.13-ны өдрөөс эхлэн зохион байгуулсан. Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулагдсан. Зээлийн хэлэлцээрийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил хангагдсан. Азийн хөгжлийн банкны захирлуудын зөвлөлөөр хэлэлцэгдэж дэмжигдсэн. | 30.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 194 | 3.6.32. Дорнод аймгийн "Чойбалсан" нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох теслийг хэрэгжүүлэх | Дорнод аймгийн "Чойбалсан" нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох теслийг хэрэгжүүлэх | Аэродромтой болгон нислэгийн дэд бүтэц өргөжиж, орлого өснө. Зүүн бүсийн ачаа тээврийн логистик төв болгон экспортыг нэмэгдүүлнэ. | Концесс, ТХХТ | 22,070.2 | - | - | Чойбалсан нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах теслийг "Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлтийг 2022.01.13-ны өдрийн 01/133 тоотоор ТХААГ-т, 2022.02.23-ны өдрийн 01/875 тоотоор ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн. Теслийн зардал, үр ашгийн тооцоог 2022.04.29-ний өдрийн 01/1978 тоотоор ЗГХЭГ-т, хувийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Чойбалсан нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах теслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх асуудлыг Зам, тээврийн хөгжлийн яамнаас Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Чойбалсан нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн 4С ангиллын болгох теслийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг батлуулсан, "Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж байна. Мөн "Жайка" ОУХАБ-аас хэрэгжүүлж буй "Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд "Чойбалсан" нисэх буудлыг 4С ангиллын болгож, ашиглалтыг сайжруулах теслийн нисэхийн бус орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран судалгаа хийж байна. Теслийн ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлт СЯ-нд хүргүүлсэн (2022.10.04-ний 01/4549). Теслийг "зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж, бэлтгэл ажлыг хангуулахаар Иргэний нисэхийн ерөнхий газарт 2022.12.06-ны өдрийн 09/5622 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 30.0 |
| 195 | 3.6.33. Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох теслийг хэрэгжүүлэх | Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох теслийг хэрэгжүүлэх | Зорчигч үйлчилгээний шинэ цогцолбор, нислэг хөдөлгөөний цамхаг бүхий нийт 9000 м2 барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ. Хөөрч буух хучилттай зурвасыг 2850x45 метр хэмжээтэй болгон өргөтгөж хучилт хийнэ. | Концесс, ТХХТ | 24,950.0 | - | - | Ховд нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах теслийг "Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлтийг 2022.01.13-ны өдрийн 01/133 тоотоор ТХААГ-т, 2022.02.23-ны өдрийн 01/875 тоотоор ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн. Теслийн зардал, үр ашгийн тооцоог 2022.04.29-ний өдрийн 01/1978 тоотоор ЗГХЭГ-т, хувийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Ховд нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах теслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх асуудлыг Засгийн газрын 2022.03.02, 2022.05.25-ны өдрийн хуралдаанд тус тус танилцуулсан. Ховд нисэх буудлыг Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-ээр 2022.03.14-ний өдөр олон улсын нисэх буудал гэж зарласан. Ховд нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн 4С ангиллын болгох теслийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг батлуулсан, "Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж байна. Теслийн ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлт СЯ-нд 2022.10.04-ний өдрийн 01/4549 тоот албан бичгээр хүргүүлсэн. Теслийг "зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж, бэлтгэл ажлыг хангуулахаар Иргэний нисэхийн ерөнхий газарт 2022.12.06-ны өдрийн 09/5622 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 30.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 196 | 3.6.34. Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж, олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх | Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж, олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх | Хөөрч буух хүчилттай зурвасыг 2850х45 метр хэмжээтэй болгон өргөтгөж хүчитгэл хийнэ. | Концесс, ТХХТ | 18,898.9 | - | - | Хөвсгөл аймгийн Мөрөн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг "Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлтийг 2022.01.13-ны өдрийн 01/133 тоотоор ТХААГ-т, 2022.02.23-ны өдрийн 01/875 тоотоор ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн. Концессын зүйлийн жагсаалтад тусгах бэлтгэл ажлыг хангах хүрээнд төслийн зардал, үр ашгийн тооцоог боловсруулж, 2022.04.29-ний өдрийн 01/1978 тоот албан бичгээр ЗГХЭГ-т, хувийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Мөн Мөрөн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх асуудлыг Зам, тээврийн хөгжлийн сайд Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Мөрөн нисэх буудлыг Нисэхийн мэдээллийн эмхтгэл (AIP)-ээр 2022.04.07-ны өдөр олон улсын нисэх буудал хэмээн зарласан. Мөрөн нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн 4С ангиллын болгох төслийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг батлуулсан, "Зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж байна. Төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлт СЯ-нд 2022.10.04-ний өдрийн 01/4549 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төслийг "зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж, бэлтгэл ажлыг хангуулахаар ИНЕГ-т 2022.12.06-ны өдрийн 09/5622 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 30.0 |
| 197 | 3.6.35. Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан чиглэлийн 667 км төмөр замын төслийг эхлүүлэх | Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан чиглэлийн 667 км төмөр замын төслийг эхлүүлэх | Төмөр замын зураг төслийг хийж, төслийг эхлүүлсэн байна. | Концесс, ТХХТ | 40,000.0 | - | - | Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын төслийг Засгийн газрын 2022 оны 105 дугаар тогтоолоор Концессын зүйлийн жагсаалтад шууд гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэхээр нэмэлтээр оруулсан. Концессын шийд гэрээ байгуулах сонгон шалгаруулалтыг зарлуулах саналыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээд байна. БНСУ-ын хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд нэг хэсэг болох тус чиглэлийн төмөр замын техник-эдийн засгийн судалгаа хийхээр Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Солонгосын Газар, дэд бүтэц, тээврийн яамтай Санамж бичиг байгуулсан. Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын техник-эдийн засгийн судалгааны ажил эхлүүлсэн. - Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 105 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулсан ба Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолоор Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын "Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам" ХХК байгуулан Концессын "зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр төслийг хэрэгжүүлэх хэрэнгө оруулах, хамтран ажиллах сонирхол бүхий гадаад, дотоодын хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх, сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг "Монголын төмөр зам" ТӨХК-д даалгасан. Үүний дагуу ЗүүнЯ чиглэлийн төсөлд "Ийст коридор рэйлреуд" ХХК, "Бодь интернэшнл" ХХК-ууд сонгогдож, гэрээ байгуулах хэлэлцээр хийгдэж байна. Хилийн Бичигт-Зүүнхатавч боомтыг холбох төмөр замын техникийн асуудлыг Хятад талтай яриа хэлэлцээ хийхээр "Монголын төмөр зам" ТӨХК-ийг сонгож ЗГ-ын 2022 оны 446 дугаар тогтоол гарсан. Үүний үр дүнд хэлэлцээ хийх, техникийн шийдлүүд тодорхой болсоноор ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын явцад зэрэгцээр нөлөөлөх юм. Тухайн төслийн Концессын гэрээний төсөл боловсруулж байна. Барилгын ажлын нээлтийг 2022 оны 07 дугаар сарын 02-нд хийж Ерөнхий сайд оролцсон. | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 198 | 3.7. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. | 3.7.1. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх | Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх | Зураг төслийг батлуулж, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна. | Орон нутгийн төсөв | 72,000.0 | - | - | "Эрдэс плазма" ХХК-ийн Багахангай дүүрэгт байгуулах шилний үйлдвэрийн төсөлд дэмжлэг үзүүлж, Засгийн газрын 2021.08.04-ний өдөр 227 дугаар тогтоолоор УТП-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгосон. Үйлдвэрийн зураг төслийг урьдчилан байдлаар 220 мянган ам.доллараар боловсруулсан. Тус яамнаас Хөгжлийн банканд хандан, шилний үйлдвэр байгуулах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг удаа дараа хүргүүлсэн. Хөгжлийн банк энэ асуудлыг судалж үзээд, төслийн судалгааг зогсоосон тул Дэлхийн банкны олон улсын санхүүгийн корпорацид хүсэлт гарган төслөө судлуулж байна. ОУСК-аас түүхий эдийн ордуудыг ашиглаж эхлэх шаардлага тавьсан тул үндсэн түүхий эдийн нэг болох Дундговийн Өлзийтийн кварцын ордод хийсэн хайгуулын ажлыг 2021.12.01-ний өдөр УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, нөөцийн тайланг улсын бүртгэлд бүртгүүлсэн. Налайхын Элстэйн цахиурын элсний ордын ТЭЗҮ-ийг 2022.3.22-ны өдөр дээрх Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж, төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг БОАЖЯ-ны БОҮ-ний комиссын хурлаар 2022.6.07-нд хэлэлцүүлэн батлуулсан. Энэ ордыг ашиглахад шаардагдах цахилгаан эрчим хүчний техникийн нөхцөл олгох тухай хүсэлтийг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д 2022.6.15-ны өдрийн 3/2885 тоотоор хүргүүлсэн. Дорноговийн Сайхандулааны кварцын ордын нөөцийн тайланг 2022 онд хэлэлцүүлэхээр УУХҮЯаман дээр хүлээгдэж байна. төслийг дэмжсэн хүсэлтийг дахин Хөгжлийн банканд 2022.10.06-ны өдрийн 3/4622 тоотоор хүргүүлсэн. Шилний үйлдвэр нь стратегийн ач холбогдол бүхий хүнд үйлдвэр тул хамтран ажиллах тухай саналыг УУХҮ-ийн сайдад 2022.10.12-ны өдрийн 1/4717 тоотоор, Эдийн засаг, хөгжлийн сайдад 2022.10.12-ны өдрийн 1/4720 тоотоор хүргүүлж, дэмжлэг хүсч, хамтран ажиллаж байна. Шилний үйлдвэрийн зураг төслийг урьдчилсан байдлаар 220 мянган ам.доллараар боловсруулж, батлуулсан. | 50.0 |
| 199 | | 3.7.2. Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах | Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах | Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулсан байна. | Улсын төсөв | 24,093.0 | - | - | Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлын ТЭЗҮ-ийг 2017 онд боловсруулсан бөгөөд ТЭЗҮ-ээр нийт төсөвт өртөг нь 87,650.0 сая төгрөг байх тооцоо судалгаа гарсан. Уг ажлын хүрээнд нийт 10914 хуудас 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулахаар тогтоогдсон. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр ээлжит хуралдаанд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах асуудлыг танилцуулахад "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл /ҮАБЗ/-өөр энэхүү асуудлыг хэлэлцүүлэн зөвлөмж авах нь зүйтэй" гэсэн шийдвэр гарсан. Энэхүү шийдвэрийн дагуу уг арга хэмжээг дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн дагуу энэхүү төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг 2020, 2021, 2022 оны улсын төсөвт тусгуулах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Тус яамнаас энэхүү төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг шинэчлэн боловсруулж, 24,093.0 сая төгрөг /3000 хуудас 1:25000-ны масштабтай байр зүйн зураг/-ийг 2023 оны улсын төсөвт тусгуулах санал бэлтгэн холбогдох мэдээллийн хамт БХБСайдын 2022.05.31-ний өдрийн 1/2486 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Хэдийгээр санхүүжилтийн асуудал хүндрэлтэй байсан боловч БХБЯ-аас дараах ажлуудыг хэсэгчлэн болон бусад төсөл арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлэх санал, тооцоолпыг хийж, холбогдох ажлыг зохион байгуулсан. Үүнд: -"Геодези, зураг зүйн салбарт хамтран ажиллах тухай" Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /нууцын зэрэглэлтэй/-ийг боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу Засгийн газрын гишүүдээс санал авч тусган, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгээд байна. Энэхүү хэлэлцээрийн төсөлд байр зүйн зураг зохиох чиглэлээр хоёр улсын холбогдох байгууллагууд хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг тусгасан. | 50.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 200 | 3.7.3. Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа барилга байгууламжийг паспортжуулан, насжилтыг тодорхойлж, цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулах | Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа барилга байгууламжийг паспортжуулан, насжилтыг тодорхойлж, цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулах | Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг аймаг, нийслэлд үргэлжлүүлэн хийнэ /405 барилга/. | Улсын төсөв | 820.0 | - | - | Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам"-ыг шинэчлэн боловсруулж, БХБСайдын 2021.12.18-ны өдрийн 127 дугаар тушаалаар батлуулсан. Барилга байгууламжийг паспортжуулах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр, төрөлд багтаан БХБСайдын 2022.04.11-ний өдрийн 83-р тушаалаар батлуулсан. Нийслэлийн 988 олон нийтийн барилга байгууламжийг паспортжуулахад 6,9 тэрбум төгрөг, аймаг орон нутгийн сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн 2142 барилга байгууламжийг паспортжуулахад 14,9 тэрбум төгрөг тус тус шаардлагатай байгаа талаарх танилцуулгыг Засгийн газрын 2021.11.03-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Эрх шилжүүлэх тухай" А/171 дүгээр захирамж, Газрын даргын 2022 оны "Үнэлгээний хороо байгуулах тухай" А/04 дүгээр тушаалын дагуу 172 барилгын бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргаж, паспортжуулах 5 багц ажил тендерийг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2 удаа зарлаж, 1 аж ахуй нэгж үнийн санал ирүүлсэн боловч тендерийн баримт бичгийн иж бүрдэл дутуу, шаардлага хангаагүй учир тендер амжилттүй болж, төсвийн тодотголоор хөрөнгө нь татагдсан. Нийслэлийн хэмжээнд 2011-2022 онд нийт 906 барилгад дүгнэлт гарган паспортжуулсан. 2022 онд Сэлэнгэ аймаг 28, Баянхонгор аймаг 23, Өвөрхангай 7, Булган 11, Ховд 2, Өмнөговь 20, Завхан 2, Сүхбаатар 9 барилга байгууламжийг паспортжуулсан. 2023 оны төсөвт барилга байгууламжийг паспортжуулах ажилд зарцуулах зориулалтаар Дорноговь аймаг 100 сая төгрөг, Булган аймаг 60 сая төгрөгийг тусгаад байна. 2023 оны улсын төсөвт барилга байгууламжийг паспортжуулахад шаардагдах 1 тэрбум 620 сая төгрөгийг тусгах саналыг БХБСайдын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 1/3787 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр улсын хэмжээнд 1002 барилгыг паспортжуулж, энэ арга хэмжээ 100 хувь биелсэн байна. | 90.0 |
| 201 | 3.7.4. Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлэн хяналт тавих | Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлэн хяналт тавих | Мониторингийн сүлжээний 3000 цэгт газрын төлөв байдал, чанарын судалгааг хийж, хөрсний хяналт-шинжилгээний улсын 1 лабораторийг Төвийн бүсэд байгуулсан байна. | Улсын төсөв | 920.0 | - | - | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Цаг уур орчны хяналт шинжилгээний газарт харьяалагдаж байгаа газрын доройтлыг тогтоох чиг үүрэг бүхий 1512 цэгийн мэдээлэл /www.eic.mn/, Хүнс хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны /www.Monsoil.mn/ цахим системээр дамжуулан тариалангийн газрын хяналт, мониторингийн 300 цэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэндийн хяналтын газарт харьяалагдах хөрсний эрүүл ахуйн хяналтын 74 цэгийн мэдээллийг нэгтгэн дундын мэдээллийн сан үүсгэсэн. Хөрсний хяналт-шинжилгээний лаборатори байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. 21 аймгийн 320 сумын бэлчээрийн 102 сая.га газарт бэлчээрийн фотомониторингийн байнгын ажиллагаатай 5166 цэгт мониторинг судалгааг гүйцэтгэн үр дүнг нэгтгэн, Цаг уур орчны хяналт шинжилгээний газарт харьяалагдаж байгаа газрын доройтлыг тогтоох чиг үүрэг бүхий 1512 цэгийн мэдээлэлтэй харьцуулалт хийж бэлчээрийн газрын доройтлын зураглал гарган хөрс хамгаалах, нөхөн сэргээлт хийх ажлыг 21 аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган ажилласан ба 2022 онд улсын хэмжээнд нийт 8'985'045 га талбайд бэлчээрийн хөрс хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан. Газрын нэгдмэл сангийн хөдөө аж ахуйн газрын бэлчээрийн ангиллын 6778 цэг, тариалангийн ангиллын газрын 100, хот суурин газрын ангиллын 300 цэг нийт 7178 цэгт судалгаа мониторингийн ажлыг улсын хэмжээнд гүйцэтгэн 2 журам, 3 аргачлалын төсөл боловсруулан, тухайн журам аргачлалын хүрээнд системийн хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэсэн. | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 202 | | 3.7.5. Хот, суурин газрын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Хот, суурин газрын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох арга хэмжээний хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 1,500.0 | Улсын төсөв | 5,800.0 | 1.УБ хотын БГД-ийн ус түгээх байруудыг усны нөөц санд холбох зураг төслийг боловсруулсан, батлагдах шатандаа байна. Гүйцэтгэл 100%; 2.Сумын хөгжил төсөл: Увс аймгийн Зүүнхангай, Наранбулаг сум, Архангайн Хангай, Жаргалант, Тариат, Цахир сум, УБ хотын БЗД-т ухаалаг ус түгээх байр барих ажлын гүйцэтгэл 100%; 3.Ус хангамжийн шугам сүлжээ: Дорноговь, Говь-Алтай, Хөвсгөл, Төв, Завхан, Сүхбаатар, Баян-Өлгий аймгуудын төв болон Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд цэвэр усны 17 км шугам сүлжээ, усан сан, гүний худаг шинээр барих автоматжуулалтын ажлын гүйцэтгэл 100%; 4.АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Өвөрхангай аймгийн Хужирт, Дундговь аймгийн Эрдэнэдалай хэрэгжиж буй цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл, ухаалаг ус түгээх байр шинээр, Дундговь, Хөвсгөл, Сүхбаатар аймгийн төвд ундны усны чанар сайжруулах төхөөрөмжийг суурилуулсан, гүйцэтгэл 100%; 5.БНСУ-ын санхүүжилтээр "Хот, суурин газрын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох" төслийг хэрэгжүүлэхээр санал хүргүүлсний дагуу БНСУ-ын Инчоны Үндэсний Их сургуулийн болон Инчоны олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны төвийн 7 хүний бүрэлдэхүүнтэй баг 2022.10.27-нд тус яамны холбогдох газар, хэлтсийн дарга нар мэргэжилтнүүдтэй уулзалт хийж, санал солилцсон. Уулзалтын үеэр Монгол улсын ус хангамжийн хууль, эрх зүйн орчин, өнөөгийн байдал, төслийн хэрэгцээ шаардлага, мөн Солонгос улсын ус хангамжийн ухаалаг технологийн талаар харилцан мэдээлэл солилцсон. 6.АНУ-ын МСК-ын буцалтгүй тусламжаар УБ хотын гэр хорооллын шугамд холбогдсон 180 орчим ус түгээх байрыг автоматжуулах тоног төхөөрөмжийг нийлүүлж, суурилуулах ажлын гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулсан. | 100.0 |
| 203 | | 3.7.6. Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг эхлүүлэх | Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг эхлүүлэх | Үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн дэд бүтцийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 2,000.0 | - | - | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолын Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний 3.7.6 дахь төсөл, арга хэмжээний 2022 оны хүрэх түвшинг Үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн дэд бүтцийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна. гэж төлөвлөсөн. Нийслэлийн 2022 оны төсөвт Паркийн цахилгаан хангамжийн эхний ээлжийн барилга угсралтын ажилд 497.4 сая төгрөг, цахилгаан хангамжийн 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажилд 2,080.8 сая төгрөг тусгагдсан. - Үндсэн цахилгаан хангамжийн ажлыг гүйцэтгэгч "Вилл вест" ХХК нь 10 кВ-ын хуваарилах байгууламжийн тоноглолын угсралт, суурилуулалтын ажлыг бүрэн дуусгаж, хүчдэлд холбон, туршилт тохируулгын ажлыг хийсэн ба 1,000.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, материалын захиалга хийн татан авалтын ажлуудыг хийж байна. - Цахилгаан хангамжийн эхний ээлжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч "Хасу Эрчим" ХХК тоноглол угсралтын ажлыг дуусгасан. 2 дугаар ээлжийн ажилтай уялдуулж, ашиглалтад өгнө. Ажлын дундаж гүйцэтгэл 90%. - "Таван толгой түлш" ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрийг усаар хангах усан хангамжийн байгууламж, усан сан, гүний худгийн барилга байгууламж, шугам хоолойн угсралтын ажлын бүтээн байгуулалтыг эхлүүлэх ажлын хүрээнд паркийн 120 га газар дээр байгуулах 2 ширхэг гүний худгийн өрөмдлөгийн ажил хийгдэж дууссан. 2 худгийн барилгын ажил хийгдэж байна. "ТТТ" ХХК руу татах 6.3 км шугам хоолойн газар шорооны ажил хийгдэж байгаа бөгөөд өвлийн улирал эхэлсэнтэй холбогдуулан ажил зогссон. - Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 169 дүгээр тушаалын дагуу паркийн өргөтгөл 130 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад шалгарсан "Өрх" ХХК 2021/47 дугаар гэрээний дагуу гүйцэтгэл дууссан ба мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт болон магадлал хийлгэх ажлууд хийгдэж байна. | 100.0 |
| | | | **Бодлогын дундаж үнэлгээ** | | | **8,145,123.8** | | **2,170,848.9** | | **72.0** |
| **4. Засаглалын бодлого** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 204 | 4.1. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ. | 4.1.1. Төрийн цахим үйлчилгээний e-mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, төрийн үйлчилгээний төрөл, тоог нэмэгдүүлж хөгжүүлэх, иргэдэд хүргэх арга хэмжээг зохион байгуулах | Төрийн цахим үйлчилгээний e-mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, төрийн үйлчилгээний төрөл, тоог нэмэгдүүлж хөгжүүлэх, иргэдэд хүргэх арга хэмжээг зохион байгуулах | Тус системээр үйлчилгээ авч байгаа иргэдийн тоог 200000-аар нэмэгдүүлсэн байна. Төрийн болон хувийн хэвшлийн 20 байгууллагын үйлчилгээг нэгдсэн системд холбосон байна. | Улсын төсөв | 200.0 | - | - | Албан бичиг солилцооны дундын систем нь дэмжих системийн нэг төрөл бөгөөд хүн, хуулийн этгээд нь үндсэн болон дэмжих системийг ашиглан үйлчилгээ үзүүлэхэд тавигдах техникийн ерөнхий шаардлага /"Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал батлах тухай"/-ыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын А/64 дугаар тушаалаар батлуулсан. 2. Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (erp.e-mongolia.mn) -д 1'384 төрийн байгууллага, түүний салбар нэгжийг холбож, нийт 20'390 хэрэглэгч тус системээр дамжуулан байгууллага хооронд 167'707 албан бичгийг цахим хэлбэрээр солилцсон байна. 3. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 45 дугаар тэмдэглэлээр Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтөд цахим хэлбэрээр баримт бичиг солилцох нөхцөл бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах асуудлыг судалж, зохих арга хэмжээ авах саналаа танилцуулахыг даалгасны дагуу "Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтөд цахим хэлбэрээр баримт бичиг солилцох нөхцөл бүрдүүлсэн тухай" арга хэмжээний танилцуулга 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулагдсан. Албан бичиг солилцооны дундын системд 2022 оны 12 дугаар сарын байдлаар 4302 байгууллагын ашиглалдаг 15 систем холбогдсон бөгөөд нийт 8116 бичиг солилцсон байна. | 100.0 |
| 205 | | 4.1.2. Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформыг хөгжүүлж нэвтрүүлэх | Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформыг хөгжүүлж нэвтрүүлэх | Иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ шинээр бий болсон байна. Нэн шаардлагатай төрийн үйлчилгээний 5 системийг мэдэгдэл хүргэх нэгдсэн системд холбосон байна. | Улсын төсөв | 500.0 | - | - | 1.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 30 дугаар тэмдэглэлээр Үндэсний цахим шуудангийн хэрэглээг нэвтрүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах талаар хугацаатай үүрэг даалгаврыг Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн. Уг ажлын хүрээнд "Үндэсний цахим шуудангийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Монгол Улсын Шадар сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, 15 яамд албан бичгээр хандаж, саналыг нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/1028 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үндэсний цахим шуудан нэвтэрснээр төрийн албан хаагчид жиргэдтэй цахим шуудангаар шууд харилцах болом ба 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр "Үндэсний цахим шуудангийн үйлчилгээ"-г нэвтрүүлсэн. 2.Үндэсний цахим шуудан нэвтрүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Монгол Улсын Шадар сайд болон 15 яамны сайд нарт иргэд олон нийттэй харилцахдаа ашиглаж буй цахим шуудангийн хаягийг ирүүлэх тухай 2022 оны 05 дугаар сарын 27-ны 01/900 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Үүний дагуу яамд, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд болон харьяаны байгууллагуудын нийт 193 цахим шуудангийн хаягийг нэгтгэн үндэсний цахим шуудангийн и-мэйлийн жагсаалтад нэгтгэсэн. Ингэснээр иргэд төрийн байгууллагатай цахим шуудангаар шууд харилцах боломж бүрдсэн. 2. Төрийн байгууллагаас иргэдэд мэдэгдэл, мэдээлэл хүргэх зорилготой "Мэдэгдэл хүргэх систем"-ээр дамжуулан нийт 12.363.002 мэдэгдлийг иргэдэд хүргэсэн. 3. Хүн, хуулийн этгээд үндсэн систем ашиглан үйлчилгээ үзүүлэхдээ мэдээллийн эзний зөвшөөрөлд үндэслэн хязгаарлалттай мэдээлэлд хандах, төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарах лавлагаа, тодорхойлолтыг файл (pdf) хэлбэрээр авах боломжийг бүрдүүлэх зорилгоор lavlagaa.e-mongolia.mn системийг хөгжүүлсэн. Мөн "Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний 8.2 дахь заалтыг үндэслэн "Үндсэн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх нэмэлт гэрээ"-ний төслийг боловсруулсан. | 100.0 |
| 206 | | 4.1.3. Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний тоог нэмэгдүүлэх | Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний тоог нэмэгдүүлэх | Нэмж цахимжуулах үйлчилгээний тоо- 26. | - | - | - | - | Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр бүртгэх, бүртгүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, цахим системийн чанарыг дээшлүүлж төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia/-д 88 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Дээрх үйлчилгээнүүдээс төрсний бүртгэлийн, гэрлэлт, гэрлэлт цуцалсны, гэрлэлт дуусгавар болсны, иргэний үнэмлэхийн лавлагаануудыг Англи хэл дээр авах боломжийг бүрдүүлж Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia/-д сервес гаргаж өгсөн. Иргэн, хуулийн этгээдээс Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /EMongolia/ системээр дамжуулан иргэн, хуулийн этгээдээс 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 93,220 улсын бүртгэлийг цахим хэлбэрээр бүртгэж, 2,275,851 улсын бүртгэлийн лавлагаа үйлчилгээг системээр дамжуулан цахим хэлбэрээр авсан байна. Үүнээс иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 1,715,252, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 502,802, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 57,797 лавлагаа, үйлчилгээг авсан байна. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 207 | 4.1.4. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн санд холбох | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн санд холбох | | Улсын төсөв | 1,000.0 | - | - | Улсын бүртгэлийн ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын хамтарсан 2022 оны А/118, А/462 дугаар тушаалаар байгуулагдсан "Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан" байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд 2022.10.12-ны өдөр ЭХЭУБГ-ын дарга болон МТГ-ын программ хангамжийн хэлтсийн дарга нар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт очин хаягийн мэдээллийн нэгдсэн системтэй биечлэн танилцаж, систем хөгжүүлэгч болон ГЗБГЗЗГ-ын холбогдох удирдлагуудтай уулзалт зохион байгуулж цаашид хийгдэх ажлын талаар санал солилцсон. Мөн "Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан" үүсгэхтэй холбоотой ажлын танилцуулга, гарч болзошгүй зардлын тооцоог бэлтгэж ажлын хэсэгт хүргүүлсэн. ГЗБГЗЗГ-ын зүгээс 10 дугаар сарын 19-ний өдөр Хаягийн мэдээллийн нэгдсэн сангаа УБЕГ-т илгээсэн, тус мэдээллийн санг ЭХЭУБ-ийн мэдээллийн сантай тулгалт хийх ажлыг МТГ хариуцан ажиллаж байна. Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан" –г хэрэглээнд нэвтрүүлэх ажлын эрчимжүүлэхээр Барилга, хот байгуулалтын яамны сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайд нарын хамтарсан ажлын хэсэг байгуулагсан бөгөөд уг ажлын хэсэгт Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга нар оролцон ажлын төлөвлөгөөнд санал хүргүүлэн ажиллаж байна. | 50.0 |
| 208 | 4.1.5. "Нэг иргэн-Нэг бүртгэл" арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх | "Нэг иргэн-Нэг бүртгэл" арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх | Хэрэгжилт 85 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 5,000.0 | - | - | "Нэг иргэн-Нэг бүртгэл" хөтөлбөрийн үр нөлөөг үнэлж, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээний 2022 оны эхний хагас жилийн байдлаарх хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг гаргаж удирдлагад танилцуулсан . Нэг иргэн – Нэг бүртгэл үндэсний хөтөлбөрийн зорилт 3 "дэд бүтцийг шинэчлэн зохион байгуулж, иргэний бичиг баримтын үйлдвэрийг өргөтгөх;"- ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр иргэний үнэмлэхийн хэвлэх үйлдвэрийн 1 ш тоног төхөөрөмжийг худалдан авсан бөгөөд суурилуулалтын ажил бүрэн хийгдэж, ашиглалтад оруулсан. | 100.0 |
| 209 | 4.1.6. Тоон бичиг үсэгтэн болгох сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулж, түгээх | Тоон бичиг үсэгтэн болгох сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулж, түгээх | Монгол Улсын хэмжээнд мэдээлэл, харилцаа, холбооны технологи ашиглах иргэдийн чадварын түвшин 50 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 500.0 | - | - | 1.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 30 дугаар тэмдэглэлээр Үндэсний цахим шуудангийн хэрэглээг нэвтрүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах талаар хугацаатай үүрэг даалгаврыг Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн. Уг ажлын хүрээнд "Үндэсний цахим шуудангийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Монгол Улсын Шадар сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, 15 яамд албан бичгээр хандаж, саналыг нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/1028 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үндэсний цахим шуудан нэвтэрснээр төрийн албан хаагчид жиргэдтэй цахим шуудангаар шууд харилцах болом ба 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр "Үндэсний цахим шуудангийн үйлчилгээ"-г нэвтрүүлсэн. 2.Үндэсний цахим шуудан нэвтрүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Монгол Улсын Шадар сайд болон 15 яамны сайд нарт иргэд олон нийттэй харилцахдаа ашиглаж буй цахим шуудангийн хаягийг ирүүлэх тухай 2022 оны 05 дугаар сарын 27-ны 01/900 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Үүний дагуу яамд, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд болон харьяаны байгууллагуудын нийт 193 цахим шуудангийн хаягийг нэгтгэн үндэсний цахим шуудангийн и-мэйлийн жагсаалтад нэгтгэсэн. Ингэснээр иргэд төрийн байгууллагатай цахим шуудангаар шууд харилцах боломж бүрдсэн. 2. Төрийн байгууллагаас иргэдэд мэдээлэл, мэдээлэл хүргэх зорилготой "Мэдэгдэл хүргэх систем"-ээр дамжуулан нийт 12.363.002 мэдэгдлийг иргэдэд хүргэсэн. 3. Хүн, хуулийн этгээд үндсэн систем ашиглан үйлчилгээ үзүүлэхдээ мэдээллийн эзний зөвшөөрөлд үндэслэн хязгаарлалттай мэдээлэлд хандах, төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарах лавлагаа, тодорхойлолтыг файл (pdf) хэлбэрээр авах боломжийг бүрдүүлэх зорилгоор lavlagaa.e-mongolia.mn системийг хөгжүүлсэн. Мөн "Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний 8.2 дахь заалтыг үндэслэн "Үндсэн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх нэмэлт гэрээ"-ний төслийг боловсруулсан. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 210 | 4.1.7. "Цахим архив албан хэрэг хөтлөлт" арга хэмжээний төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах, архивын нэгжийн цахимжуулалтыг эрчимжүүлэх | "Цахим архив албан хэрэг хөтлөлт" арга хэмжээний төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах, архивын нэгжийн цахимжуулалтыг эрчимжүүлэх | Боловсруулсан төслийн тоо-1; Шинээр цахимжуулах архивын нэгжийн тоо-100000. | Улсын төсөв | 2,384.5 | - | - | Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэл" боловсруулж, Архивын ерөнхий газрын 2022.11.10-ны өдрийн 01/842 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Төрийн 37 архивт хадгалагдаж буй цаасан болон тусгай суурьтай баримтаас 2022 онд 727 хөмрөгийн 1,106 дансны 21,377 хадгаламжийн нэгжийн 1,260,542 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, үүссэн мэдээллийн сангаас архивын лавлагаа, мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд шуурхай олгож байна. | 100.0 |
| 211 | 4.1.8. Иргэдэд тоон гарын үсэг олгож, цахим харилцаанд оролцох боломжийг бүрдүүлэх | Иргэдэд тоон гарын үсэг олгож, цахим харилцаанд оролцох боломжийг бүрдүүлэх | Шинээр 22.0 мянган иргэнд тоон гарын үсэг олгосон байна. | Улсын төсөв | 1,000.0 | - | - | Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Улсын бүртгэлийн байгууллагаас иргэнд тоон гарын үсэг олгох талаарх зохицуулалтыг тусгасан. Хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор Төрийн албан хаагчид гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг тус яамны сайдын А/28 , Нийтийн түлхүүрийг гэрчилгээжүүлэх, гэрчилгээ олгосон, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тухай мэдээллийг агуулсан гэрчилгээний үндсэний сан бүрдүүлэх журмыг тус яамны сайдын А/30 дугаар тушаалаар тус тус баталж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Улсын бүртгэлийн байгууллагаас 21 аймаг, 330 сум, 9 дүүрэг, 171 хорооны бүртгэлийн нэгжээр дамжуулан нийт 313,384 иргэнд, тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас нийт 82,242 хуулийн этгээдэд, "Үндэсний дата төв" УТҮГ-аас 14,288 төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээ олгоод байна. Иргэн, хуулийн этгээд тоон гарын үсэг ашиглан танилт, нэвтрэлтийн систем ашигладаг төрийн 89 байгууллага, хувийн хэвшлийн 111 байгууллагын системээр дамжуулан цахим хэлбэрээр үйлчилгээ авах боломжтой болсон. | 100.0 |
| 212 | 4.1.9. Үндэсний хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын тогтолцоог бий болгох | Үндэсний хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын тогтолцоог бий болгох | Мэдээллийн аюулгүй байдлыг хангах аргачлалыг боловсруулж боловсон хүчнийг бэлтгэх лаборатори бэлэн болсон байна | Улсын төсөв | 250.0 | - | - | Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Улсын бүртгэлийн байгууллагаас иргэнд тоон гарын үсэг олгох талаарх зохицуулалтыг тусгасан. Хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор Төрийн албан хаагчид гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг тус яамны сайдын А/28 , Нийтийн түлхүүрийг гэрчилгээжүүлэх, гэрчилгээ олгосон, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тухай мэдээллийг агуулсан гэрчилгээний үндсэний сан бүрдүүлэх журмыг тус яамны сайдын А/30 дугаар тушаалаар тус тус баталж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Улсын бүртгэлийн байгууллагаас 21 аймаг, 330 сум, 9 дүүрэг, 171 хорооны бүртгэлийн нэгжээр дамжуулан нийт 313,384 иргэнд, тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас нийт 82,242 хуулийн этгээдэд, "Үндэсний дата төв" УТҮГ-аас 14,288 төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээ олгоод байна. Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс иргэнийг цахим харилцаанд таньж баталгаажуулах, төрийн үйлчилгээний системд нэвтрэхэд тоон гарын үсэг ашиглах боломжийг бүрдүүлсэн. Иргэн, хуулийн этгээд тоон гарын үсэг ашиглан танилт, нэвтрэлтийн систем ашигладаг төрийн 89 байгууллага, хувийн хэвшлийн 111 байгууллагын системээр дамжуулан цахим хэлбэрээр үйлчилгээ авах боломжтой болсон. | 30.0 |
| 213 | 4.1.10. Нэгдүгээр эшелоны тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авч, Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт, удирдлагын нэгдсэн төв /үндэсний CERT/-ийн үйл ажиллагааг эхлүүлэх | Нэгдүгээр эшелоны тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авч, Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт, удирдлагын нэгдсэн төв /үндэсний CERT/-ийн үйл ажиллагааг эхлүүлэх | Бусад төв болон онц чухал мэдээллийн дэд бүтэц бүхий байгууллагуудыг холбосон нэгдсэн төв байгуулагдсан байна. | Улсын төсөв | 4,500.0 | - | - | Тайлан ирүүлээгүй. | 0.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 214 | 4.1.11. Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим системийг хөгжүүлэх | Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим системийг хөгжүүлэх | Албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим системийг хөгжүүлсэн байна. | Улсын төсөв | 500.0 | - | - | 1. Албан бичиг солилцооны дундын систем нь дэмжих системийн нэг төрөл бөгөөд хүн, хуулийн этгээд нь үндсэн болон дэмжих системийг ашиглан үйлчилгээ үзүүлэхэд тавигдах техникийн ерөнхий шаардлага ("Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал батлах тухай")-ыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалаар батлуулсан. 2. Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (erp.e-mongolia.mn) -ийг хөгжүүлэн төрийн 1'384 байгууллага, түүний салбар нэгжийг холбож, нийт 20'390 хэрэглэгч тус системээр дамжуулан байгууллага хооронд 167'707 (Ирсэн бичиг+Явсан бичиг) албан бичгийг цахим хэлбэрээр солилцсон байна. 3. Албан бичиг солилцооны дундын системийг Аблесофт, erp.e-mongolia.mn, ЗГХЭГ -ийн системд холбосон бөгөөд нийт 163 байгууллага холбогдон, 6601 бичиг дамжсан байна. Түүнчлэн төрийн болон хувийн хэвшлийн нийт 15+ erp системийг албан бичиг солилцооны дундын системд холбоод байгаа ба Тоон гарын үсгийн Safenet, epass2003 төхөөрөмжийг уншдаг болгосон. Одоогоор Monpass, newcompass, tridum ХХК-ний тоон гарын үсгийн төхөөрөмж дээр туршилтыг хийж байна. Албан бичиг солилцооны дундын системд 2022 оны 12 дугээр сарын 22-ны өдрийн байдлаар 4302 байгууллагын ашигладаг 15 систем холбогдсон бөгөөд нийт 8116 бичиг солилцсон байна. | 100.0 |
| 215 | 4.1.12. Сум, суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбох /Дорнод аймгийн Дашбалбар, Чулуунхороот, Төв аймгийн Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Дундговь аймгийн Баянжаргалан, Хөвсгөл аймгийн Ханх/ | Сум, суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбох /Дорнод аймгийн Дашбалбар, Чулуунхороот, Төв аймгийн Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Дундговь аймгийн Баянжаргалан, Хөвсгөл аймгийн Ханх/ | Шилэн кабельд холбогдоогүй 6 суманд шилэн кабелийн сүлжээ татаж, өндөр хурдны интернэтийн үйлчилгээ авах дэд бүтцийг бий болгосноор бүх 330 сум, суурин холбосон байна. | Улсын төсөв | 1,170.0 | - | - | Тайлант хугацаанд 6 сумыг шинээр шилэн кабелийн сүлжээнд холбож, дахин 6 сумыг шинээр шилэн кабелийн сүлжээнд холбох ажил хийгдэж эхлээд байна. 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтээр Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Гурван-Баян Улаан, Дэлгэрхаан сумын Хэрлэн-Баян Улаан, Булган аймгийн Хангал сум, Хялганат тосгоныг, Архангай аймгийн Хашаат сумыг тус тус шилэн кабелийн сүлжээнд холбосон. 2021-2022 онд "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ний хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймгийн Алтай сум, Дорнод аймгийн Халх гол сумыг шилэн кабелийн сүлжээнд холбосон. 2022 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх "Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл" -ийн хүрээнд Дорнод аймгийн Дашбалбар сум, Чулуунхороот сум, Төв аймгийн Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Дундговь аймгийн Баянжаргалан, Хөвсгөл аймгийн Ханх зэрэг 6 сумыг шилэн кабелийн сүлжээнд холбох ажлын хийгдэх ба Бүгд Найрамдах Хятад Ард Улсын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж дууссаны дараа шилэн кабелийн суурилуулалт эхэлнэ. Энэхүү ажил хийгдэж дууссанаар Монгол улсын 330 сум бүгд шилэн кабелийн сүлжээнд холбогдож дуусахаар байна. | 50.0 |
| 216 | 4.1.13. Хүн ам олноор суурьшсан, аялал жуулчлалын бүс нутгуудыг шилэн кабелийн сүлжээнд холбох | Хүн ам олноор суурьшсан, аялал жуулчлалын бүс нутгуудыг шилэн кабелийн сүлжээнд холбох | Шилэн кабельд холбогдоогүй 23 багт шилэн кабелийн сүлжээг татаж, өндөр хурдны интернэтийн үйлчилгээ авах дэд бүтцийг бий болгосон байна. | Улсын төсөв | 7,330.0 | - | - | Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нэг аймгийн нэг багт 60км урт шилэн кабель, 3500 амжиргааны түвшин доогуур өрхэд суурин интернэт үйлчилгээгээ хүргэх зорилгоор 154 км урт шилэн кабель тус тус суурилуулж өндөр хурдны өргөн зурвасын суурин интернэт сүлжээг байгуулсан. Мөн алслагдсан 238 багт үүрэн холбооны 4G сүлжээ нэвтрүүлсэн ба нийт 300 мянга орчим иргэн өндөр хурдны хөдөлгөөнт интернэтэд холбогдох, мэдээ, мэдээлэл шуурхай авах, аялагч амрагчид харилцаа холбооны бусад үйлчилгээг саадгүй, шуурхай авах боломжийг бүрдүүлсэн. | 80.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 217 | 4.1.14. Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системийн туршилт хийж 5G сүлжээний туршилтын бүс үүсгэх | Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системийн туршилт хийж 5G сүлжээний туршилтын бүс үүсгэх | Монгол Улсад 2023 оноос хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системийг нэвтрүүлж эхэлсэн байна. Улаанбаатар хотод хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн туршилтын орчныг үүсгэсэн байна. | Улсын төсөв | 250.0 | - | - | Монгол Улсад хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн (5G) системийг 2023 онд нэвтрүүлэхтэй холбогдуулан уг технологийн онцлог болох өндөр хурдны хөдөлгөөнт холбоо, машин хоорондын холбоо, юмсын интернэтийн үйлчилгээний талаарх судалгаа хийж, эдгээрийг турших туршилтын үйл ажиллагааг аж ахуйн нэгжүүд үе шаттай хэрэгжүүлсэн: 1. Анхны туршилтыг 2021 онд "Digital Nation" арга хэмжээний үеэр амжилттай зохион байгуулсан ба туршилтад Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Зэт Ти И" компанийн хөгжүүлсэн харилцаа холбоо, дэд бүтэц, автоматжуулалт, IoT-д тулгуурласан 8 бүтээгдэхүүнийг, үүрэн холбооны Мобиком корпораци ХХК, Юнител ХХК-иуд 5G технологид тулгуурласан IoT бүтээгдэхүүн, мөн "Анд Глобал" ХХК автоматжуулалт болон интернэтийн үйлчилгээний "Ондо" брэнд бүтээгдэхүүнээ тус тус олон нийтэд танилцуулсан. 2. 2022 онд Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг, Хан-Уул дүүрэг, Чингэлтэй дүүрэгт Мобиком корпораци ХХК, Юнител ХХК, Ай Эн Мобайл ХХК, Скайтел ХХК хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн (5G) системийн туршилтын бүсийг тус тус үүсгэж, туршилтын амжилттай хэрэгжүүлж 2023 онд 5G технологийг Монгол Улсад нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангасан. Радио давтамжийн дунд хугацааны төлөвлөлтийг шинэчлэх ажил Дэлхийн радио холбооны их хуралтай уялдаж 2023 онд хийгдэхээр төлөвлөгдсөн. | 100.0 |
| 218 | 4.1.15. Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг байгуулах | Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг байгуулах | Улаанбаатар хотын Хонхорын станцыг тоон технологид шилжүүлсэн байна. | Улсын төсөв | 12,100.0 | - | - | Барилгын хөгжлийн төвийн захиалгаар "Барилгын мэдээлэл холбооны болон менежментийн системийн сүлжээний зураг төслийн төлөвлөлтийн норм ба дүрэм"-ийг шинээр боловсруулах ажлыг "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК болон "Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци"-ийн хамтарсан баг гүйцэтгэн Барилгын хөгжлийн төвийн дэргэдэх Инженерийн байгууламж, шугам сүлжээний инженерийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар танилцуулан, гишүүдийн саналаар дэмжигдсэн боловч Барилга хот байгуулалтын яамны дэргэдэх Шинэлэх ухаан техник технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулахаар төлөвлөж байна. Мөн Газрын тухай хууль болон Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж Барилга хот байгуулалтын яаманд 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 01/1319 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хуулийн төслийг байнгын хороодоор хэлэлцүүлэх ажлыг Барилга, хот байгуулалтын яамаас зохион байгуулж байна. Дээрх хуулиудад өөрчлөлт орсноор харилцаа холбооны дэд бүтцийн бүтээн байгуулалт нь бусад инженерийн дэд бүтэцтэй уялдах юм. | 30.0 |
| 219 | 4.1.16. Худаг сувагчлалын багтаамжийг оновчтой ашиглах үүднээс том оврын физик болон ашиглахгүй байгаа шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулах | Худаг сувагчлалын багтаамжийг оновчтой ашиглах үүднээс том оврын физик болон ашиглахгүй байгаа шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулах | 617 км физик кабелийг чөлөөлж, 75.2 км шилэн кабель татсан байна. | Улсын төсөв | 1,690.0 | - | - | Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн худаг сувагчлалын зураглалын дагуу чөлөөлөх шаардлагатай зэс кабель, шинээр татах шилэн кабелийн тооцоог гаргаж, санал боловсруулан 2023 оны урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн хязгаарын саналд суулгуулан Сангийн яаманд хүргүүлсэн. Энэ ажилд "Мэдээлэл холбооны сүлжээ" Хязгаарлагдмал хариуцлагатай компани, "Монголын цахилгаан холбоо" Хувьцаат компани хамтран оролцож байгаа бөгөөд одоогоор "Мэдээлэл холбооны сүлжээ" Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ажил эхэлж хотын төв зам дагуу Наран станцаас зүүн тийш Офицеруудын ордон чиглэлд, КШ-32 оор Бага тойруугаас их тойруу чиглэлд, КШ-68 аар, КШ-45 чиглэлд нийт 54,769 м кабель чөлөөлөх ажил явагдаж байна. | 30.0 |
| 220 | 4.1.17. Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох | Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох | Шуудангийн үндсэн сүлжээнд өрсөлдөөний орчин бүрдсэн байна. | Улсын төсөв | 50.0 | - | - | 1.Шуудангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д заасны дагуу "Шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журам"-ын төслийг боловсруулах, шуудангийн үндсэн сүлжээний өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/30 дугаар тушаалаар байгуулж, ажиллах удирдамжийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг 4 удаа зохион байгуулж, улс хоорондын болон дотоодын шуудан, ачаа тээврийн өнөөгийн нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл солилцож, журмын төслийг боловсруулах үндэслэлийг танилцуулсан. Мөн Монгол Улсын 21 аймаг, 30 сумдын Засаг даргын тамгын газраас шуудангийн үйлчилгээний талаарх судалгааг авч нэгтгэсэн ба шуудангийн үндсэн сүлжээний эзэмшигчийн орлого, зарлагын шинжилгээг хийж, олон улсын туршлагаас судалсны дүнд журмын төслийг эхний байдлаар боловсруулан, ажлын хэсгийн гишүүдээс санал авсан. | 50.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 221 | | 4.1.18. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах | Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах | Шинэ санаа, дэвшилтэт технологид суурилсан бизнесийг хөгжүүлж, холбогдох суурь судалгааг хийж, энтрепренёр болон гарааны бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх талаар иж бүрэн төлөвлөгөөг боловсруулсан байна. | Улсын төсөв | 300.0 | - | - | 1.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн А/303 дугаар тушаалаар байгуулагдсан "Технологи дамжуулах төв болон хамтын оффист бүртгүүлсэн гарааны компани болон програм хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг татвараас татварын бодлогоор дэмжих тухай" журам боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж журмын төсөл боловсруулсан. Журмын төслийг БШУЯ-наас 2022 оны 12 дугаар сард баггаан Засгийн газраар батлуулах тогтоолын төслийн жагсаалтад оруулсан. 2.Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын шилдэг программ хангамж үйлдвэрлэгч болон стартап компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг Төв азийн бүс нутгийн улсууд болох Узбекистан, Казахстан, Киргиз, Туркменистан, Тажикстан зэрэг орнуудад сурталчлах, мэдээллийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг нэмэгдүүлэх, стартап компаниудыг бизнесээ тогтвортой эрхэлж, өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/738 дугаар албан бичгийг аяллын төлөвлөгөө болон 7 компанийн танилцуулгын хамт Гадаад харилцааны яаманд хүргүүлж хамтран ажилласан. 3.ХХМТ-ийн салбарын инновацын эко системийг бүрдүүлэх, мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх чиглэлээр төлөвлөгөөний төсөл боловсруулсан. | 70.0 |
| 222 | | 4.1.19. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх | Хууль батлагдсан байна. 3 журмын төслийг баталж мөрдүүлсэн байна. Компанийн засаглалын дундаж үнэлгээ 65-70 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 46.0 | - | - | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15,16-ны өдрийн чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг хэлэлцээд Үзэл баримтлалын хүрээнд дэмжин анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ЭЗБХ-нд шилжүүлсэн.Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж, журам, дүрмийг боловсронгуй болгоход чиглэсэн арга хэмжээг авч, холбогдох зохицуулалтыг шинээр мөрдөгдөж буй бусад хууль тогтоомжтой нийцүүлэн дараах ажлуудыг хийв:Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрын захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам"-ыг ТӨБЗГ-ын 2022.02.22-ны өдрийн 184 дүгээр тогтоолоор, Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажилд ашиглагдах аргачлал маягтыг ТӨБЗГ-ын 2022.02.22-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор, Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журмыг ТӨБЗГ-ын 2022.02.22-ны өдрийн 65 дугаар тогтоолоор тус тус шинэчлэн баталж, мөрдүүлэв.ЗГ-ын 2022 оны "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 203, 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Автомашины дуудлага үйлчилгээний нийтлэг журам"-ын төслийг ЗГХЭГ-т, Автомашины дуудлагын үйлчилгээний тариф, зардлын норм, нормативд тусгах саналыг СЯ-нд хүргүүлсэн. УИХ-ын ЭЗБХ-нд дэргэд байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай анхдагч хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэгт төлөөлөл ажиллаж байна.Компанийн засаглалын ОУ-ын туршлагыг судлах, нэвтрүүлэх хүрээнд Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, МУ-д нэвтрүүлэх, тус улсын Темасек холдинг корпорацтай холбох асуудлаар яриа хэлцэлийн дагуу тус байгууллагатай цахимаар холбогдох бэлтгэл ажлыг хангах, санал солилцох чиглэлээр ажиллав.Төрийн өмчит 9 компанид хийсэн компанийн засаглалын 2022 оны үнэлгээ дунджаар 69.0 хувьтай байна. | 90.0 |
| 223 | 4.2. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно | 4.2.1. Ёс зүйн болон сахилгын зөрчлийн талаарх нэгдсэн бүртгэлийн системийг бий болгох | Ёс зүйн болон сахилгын зөрчлийн талаарх нэгдсэн бүртгэлийн системийг бий болгох | Ёс зүйн болон сахилгын зөрчлийн талаарх нэгдсэн бүртгэлийн системийг бий болгож, хөтөлж эхэлсэн байна. | - | - | - | - | Тайлан ирүүлээгүй. | 0.0 |
| 224 | | 4.2.2. Орчин үеийн шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдын сургалтын орчин, дэд бүтцийг сайжруулж, цахим сургалтыг нэвтрүүлэх зорилгоор мэдээллийн технологийн төвийг байгуулах | Орчин үеийн шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдын сургалтын орчин, дэд бүтцийг сайжруулж, цахим сургалтыг нэвтрүүлэх зорилгоор мэдээллийн технологийн төвийг байгуулах | Сургалт судалгаа, зөвлөх үйлчилгээний чанарын индекс нэмэгдсэн байна. | - | - | - | - | Тайлан ирүүлээгүй. | 0.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 225 | болгоно. | 4.2.3. Ямдын жендэрийн салбар зөвлөлийн жендэрийн бодлогын хэрэгжилтийг хангах | Яамдын жендэрийн салбар зөвлөлийн жендэрийн бодлогын хэрэгжилтийг хангах | Хэрэгжилт 50 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв<br>Гадаадын зээл, тусламж | 10.0<br>20.0 | -<br>- | -<br>- | БОАЖЯ, БХБЯ, БХЯ, БШУЯ, Сангийн яам, УУХҮЯ, ХНХЯ, ХХААХҮЯ, ХЗДХЯ, ЗТХЯ, ГХЯ, ЭМЯ зэрэг 12 яамны жендэрийн талаар салбарт баримтлах бодлогоо батлан хэрэгжүүлж байна. Нийт 12 салбарт хэрэгжиж байгаа бодлогын хэрэгжилтийг үнэлж үзэхэд дундаж 40 хувийн хэрэгжилттэй байна. Батлан хамгаалах салбар- 85,4, Уул уурхай, хүнд үйлдвэр, эрүүл мэнд, сан, барилга, хүнс, хөдөө аж ахуйн салбарын жендэрийн бодлогын хэрэгжилт 50%, гадаад харилцаа, хууль зүй, зам тээвэр, байгаль орчин, хөдөлмөр нийгмийн хамгаалал, боловсролын салбарын жендэрийн бодлогын хэрэгжилт 30-40 хувьтай, дунджаар 40 орчим хувьтай хэрэгжиж байна. Энэ онд ХЗДХЯ, ХНХЯ, ХХААХҮСалбарын жендэрийн бодлогуудад ХШҮ хийх ажлыг улсын болон олон улсын хөгжлийн түншлэгч байгууллагын төсвөөр хийж гүйцэтгүүлэхээр төлөвлөгдсөн байна. Эрчим хүч, соёл болон цахим хөгжил, харилцаа холбооны салбарт жендэрийн бодлого стратеги боловсруулах ажлын хэсгүүд байгууллагдаж, оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийх суурь судалгааны ажил эхэлсэн. | 90.0 |
| 226 | | 4.2.4. Аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд жендэрийн бодлогын хэрэгжилтийг хангах | Аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд жендэрийн бодлогын хэрэгжилтийг хангах | Хэрэгжилт 45 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв<br>Гадаадын зээл, тусламж | 10.0<br>20.0 | -<br>- | -<br>- | Жендэрийн салбар хороо 21 аймаг, нийслэл, 8 дүүрэг женпэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг батлуулан ажилалж байна. ХУД харахаан батлуулаагүй, ЖЭТБХангах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Холбогдох жендэрийн салбар хорооноос ирүүлсэн дэд хөтөлбөр, арга хэмжээний 2021 оны хэрэгжилт (дундаж) 80.6 хувьтай байна. | 90.0 |
| 227 | 4.3. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана. | 4.3.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж, ФАТФ, Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн стандартыг хангаж, 2023 онд хийгдэх үнэлгээний бэлтгэл ажлыг хангах | Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж, ФАТФ, Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн стандартыг хангаж, 2023 онд хийгдэх үнэлгээний бэлтгэл ажлыг хангах | Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж, ФАТФ, Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн стандартыг хангасан байна. | - | - | - | - | Тайлан ирүүлээгүй. | 0.0 |
| 228 | | 4.3.2. Хууль, эрх зүйн орчныг ФАТФ-ын зөвлөмжтэй нийцүүлэн шинэчилж, хэрэгжилтийг хангах | Хууль, эрх зүйн орчныг ФАТФ-ын зөвлөмжтэй нийцүүлэн шинэчилж, хэрэгжилтийг хангах | Гүйцэтгэл 80 хувьд хүрсэн байна. | - | - | - | - | Тайлан ирүүлээгүй. | 0.0 |
| 229 | | 4.3.3. Худалдаан дахь тарифын бус саад тотгорыг бууруулахад олон улсын стандартыг нутагшуулах | Худалдаан дахь тарифын бус саад тотгорыг бууруулахад олон улсын стандартыг нутагшуулах | Олон улсын стандартын түвшинийг 41 хувьд хүргэнэ. | Улсын төсөв | 300.0 | - | - | Стандарт, хэмжил зүйн газраас Худалдаан дахь тарифын бус саад тотгорыг бууруулахад олон улсын стандартыг нутагшуулах, Үндэсний стандартаар батлуулах, Олон улсын стандартын түвшинийг ахиулах зорилт тавин ажиллаж байна. 2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт Монгол Улсад нийт 6536 стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаагаас олон улс, бүс нутаг, гадаад орны 2810 стандартыг үндэсний стандартаар мөрдөхөөр баталсан бөгөөд нийт стандартын 43 хувь нь олон улсын түвшинд хүрсэн байна. | 100.0 |
| 230 | | 4.3.4. Дорнод аймгийн Чулуунхороот сум дахь хилийн 0275 дугаар ангийн "Эрээнцав" шалган нэвтрүүлэх салбарыг өргөтгөх ажлыг дуусгах | Дорнод аймгийн Чулуунхороот сум дахь хилийн 0275 дугаар ангийн "Эрээнцав" шалган нэвтрүүлэх салбарыг өргөтгөх ажлыг дуусгах | Өргөтгөлийн ажлын гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 4,700.0 | Улсын төсөв | 4,700.0 | Эрээнцавын хилийн ангийн штабын барилгын гадна фасад, цэргийн байр, хүн эмнэлэг, агуулах, уурын зуух, тавиулангийн барилгын гадна инженерийн шугам, сүлжээний угсралтын ажлууд дууссан. 2022 оны барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь хийгдсэн | 100.0 |
| 231 | | 4.3.5. Хилийн боомтуудыг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбох | Хилийн боомтуудыг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбох | 21 боомтыг сүлжээнд холбосон байна. | Улсын төсөв | 1,500.0 | - | - | Хил хамгаалах байгууллагын шилэн кабелийн дэд бүтцийг байгуулах, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор "Мэдээлэл холбооны сүлжээ", "Юнител", "Мобиком" ХХК-уудтай хамтран 42 цэгийн холболтыг шилжүүлэн, шинээр агаарын замын 5 боомт (Өлгий, Ховд, Даланзадгад, Чойбалсан, Мөрөн)-ыг шилэн кабелийн сүлжээнд холбох ажил хийгдэж байна Байнгын ажиллагаатай хилийн 24 боомтоос 18 боомт шилэн кабель, 6 боомт сансарын холбооны Всат системийн сүлжээнд холбогдсон. | 100.0 |
| 232 | | 4.3.6. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум дахь хилийн 0243 дугаар ангийн нэгдсэн цогц барилгын ажлыг дуусгах /нийт 8 барилга байгууламж/ | Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум дахь хилийн 0243 дугаар ангийн нэгдсэн цогц барилгын ажлыг дуусгах /нийт 8 барилга байгууламж/ | Шинээр ашиглалтад оруулах барилга байгууламжийн тоо - 5. | Улсын төсөв | 4,000.0 | Улсын төсөв | 1,150.0 | Хилийн цэргийн 0243 дугаар ангийн цэргийн байр, хүн эмнэлэг, зочид буудлын барилгын суурь, 1, 2 дугаар давхрын каркас зангидаж, цутгалт хийж дууссан. 2022 оны барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь хийгдсэн. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 233 | 4.3.7. Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламжийг шинэчлэх | Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламжийг шинэчлэх | Шинээр барих: хянах цамхгийн тоо - 8, харуулын байрны тоо - 30, хамгаалалтын хашааны урт - 4 км. | Улсын төсөв | 2,000.0 | Улсын төсөв | 2,553.0 | Хилийн цэргийн 4 анги (0243, 0245, 0277, 0287)-ийн хариуцсан хэсэгт 514.4 км шороон зурвас сэргээж, 0101, 0275 дугаар ангиудын хариуцсан хэсэгт 171.6 км шороон зурвас шинээр байгуулсан -Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн хариуцсан хэсэгт 1 хянах цамхаг шинээр байгуулж, 2 анги (0198, 0275)-ийн хариуцсан хэсэгт 2 хянах цамхаг засварласан -Хилийн цэргийн 0287 дугаар ангийн хариуцсан хэсэгт 16 км төмөр саадын байгууламж байгуулсан -Хилийн цэргийн 0130 дугаар ангийн хариуцсан хэсэгт 19.2 км нүхэн саад шинээр байгуулсан -Хилийн цэргийн 10 анги (0130, 0146, 0165, 0184, 0198, 0214, 0245, 0257, 0287, 0311)-ийн 21 хилийн харуулын байранд засвар хийсэн -Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн хариуцсан хэсэгт 13.1 км хамгаалалтын хашаа байгуулсан. | 90.0 |
| 234 | 4.3.8. Хилийн 10 салбарыг төвлөрсөн эрчим хүчинд холбох | Хилийн 10 салбарыг төвлөрсөн эрчим хүчинд холбох | Шинээр төвлөрсөн эрчим хүчинд холбох салбарын тоо - 10. | Улсын төсөв | 2,500.0 | Улсын төсөв | 476.3 | Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн төвийг Говь-Алтай аймгийн Алтай сумын сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрт; -Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн 0154 дүгээр салбар (Гашуунсухайт)-ыг төвлөрсөн эрчим хүчний системд холбосон. -Увс аймаг дахь хилийн цэргийн 0245 дугаар ангийн "Давст"-ын салбарыг 17 км төвлөрсөн эрчим хүчний системд холбохоор шугамын төмөр бетон тулгуурыг суурилуулж, өндөр хүчдэлийн шугамын угсралтын ажлыг хийж дуусгасан -Дорнод аймаг дахь хилийн цэргийн 0198 дугаар ангийн "Дэгээ гол" салбарыг эрчим хүчинд холбох зураг төсвийг батлуулж, ажлын зурвын дагуу 20 км шугамын 310 ширхэг төмөр бетон тулгуурыг босгосон -Хилийн цэргийн 0303 дугаар ангийн 1, 0286 дугаар ангийн 2, 0287 дугаар ангийн 2, нийт 5 салбарт 5 кВт-ын сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр шинээр угсарч ашиглалтад оруулсан. | 90.0 |
| 235 | 4.3.9. Хилийн 4 боомтыг дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системээр тоноглох | Хилийн 4 боомтыг дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системээр тоноглох | Шинээр нэгдсэн системд холбох боомтын тоо - 4. | Улсын төсөв | 2,000.0 | - | - | Хилийн "Гашуунсухайт", "Ханги", "Хавирга", "Замын-Үүд" боомтуудыг дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системээр тоноглох тооцоо судалгааг 2023 оны төсвийн төсөөлөлд тусгуулах саналыг ирүүлсэн. -Хилийн "Замын-Үүд" боомтод шилэн кабелийн дохиолол хяналтын системээр тоноглох шийдэл боловсруулах зорилгоор "Мобинет" ОХУ-ын "Оргэнергострой" ХХК-уудтай хамтран ажилласан. | 30.0 |
| 236 | 4.3.10. Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй дулааны цахилгаан станц, стратегийн орд, ус хангамжийн эх үүсвэрийн объектыг хамгаалалтад авах | Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй дулааны цахилгаан станц, стратегийн орд, ус хангамжийн эх үүсвэрийн объектыг хамгаалалтад авах | Шинээр хамгаалалтад авах объектын тоо- 7 /усны эх үүсвэрийн 4, цахилгаан станцын 1, стратегийн ордын 2/. | Улсын төсөв | 4,000.0 | - | - | Улаанбаатар хотын ус хангамжийн Дамбадаржаагийн усан сан, Толгойтын усны эх үүсвэр, Яармагийн усны насос станц, Говь-Алтай аймгийн Алтай хотын ус хангамжийн эх үүсвэр, Тайширын усан цахилгаан станц, Дулааны хоёрдугаар цахилгаан станц, Дарханы "Үндэсний дата төвийн нөөц төв" стратегийн орд, нийт 6 объектыг Дотоодын цэргийн хамгаалалтад авсан. Эрдэнэтийн дулааны цахилгаан станцыг 2023 онд дотоодын цэргийн хамгаалалтад авахад шаардагдах орон тоо, зардлыг шийдвэрлүүлэхээр удирдлагад танилцуулсан. | 90.0 |
| 237 | 4.3.11. Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа гадаадын иргэний хурууны хээ, био мэдээллийн сангаас мэдээлэл уншиж, оршин суух үнэмлэх олгох системийг хөгжүүлэх, бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сантай холбох | Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа гадаадын иргэний хурууны хээ, био мэдээллийн сангаас мэдээлэл уншиж, оршин суух үнэмлэх олгох системийг хөгжүүлэх, бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сантай холбох | Шинээр хөгжүүлэх программ хангамжийн тоо - 1; Тоног төхөөрөмж - 1 багц. | Улсын төсөв | 470.0 | - | - | Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа гадаадын иргэний хурууны хээ, био мэдээллийн сангаас мэдээлэл уншиж, оршин суух үнэмлэх олгох системийг хөгжүүлэх, бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сантай холбох "Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан" системийг нэвтрүүлэх арга хэмжээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын "Тоног төхөөрөмж" багцаас 470.0 сая төгрөгийг гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлэхээр төлөвлөн хөгжүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр 04 дүгээр сарын 12-ны өдөр гэрээ байгуулж, хөгжүүлэлтийг эхлүүлсэн боловч, гүйцэтгэлийн үр дүнгээр систем хөгжүүлэлт хангалтгүй үндэслэлээр 08 дугаар сарын 11-ний өдрийн 01/1391 дугаар албан бичгээр "Гэрэгэ системс ХХК"-д мэдэгдэл хүргүүлж, гэрээг цуцалсан. Тус программ хангамжийн гүйцэтгэгчийг дахин сонгон шалгаруулж, 10 дугаар сард захиалагч, гүйцэтгэгч 2 талын харилцан тохиролцсоноор ажил гүйцэтгэх гэрээг байгуулан 11 дүгээр сарын 18-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлж 12 дугаар сарын 17-ны өдөр баталгаажуулж ирүүлжээ. Байгууллагын даргын тушаалаар байгуулсан "Ажлын хэсэг"-ээс "Гадаадын иргэний оршин суух бүртгэл, хяналт, үнэмлэх хэвлэх программ хангамжийн ажил гүйцэтгэх" 01/10-74 дүгээр гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлд үнэлгээ хийж, гэрээний хавсралтад заасан ажлын даалгаврын дагуу программ хангамжийг хүлээн авснаар санхүүжилтийг 100 хувь олгож, тус программ хангамжийг туршилтаар нэвтрүүлээд байна. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 238 | 4.3.12. Нийслэл, 21 аймгийн онцгой байдлын шуурхай удирдлага, зарлан мэдээлэх тевийг байгуулж, нэгдсэн системд холбох; "Монгол Улсад гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь" төслийн төсөл хэрэгжүүлж эхлэх | Нийслэл, 21 аймгийн онцгой байдлын шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвийг байгуулж, нэгдсэн системд холбох; "Монгол Улсад гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь" төслийн төсөл хэрэгжүүлж эхлэх | Төсөл хэрэгжүүлэх нэгж болон төслийг удирдах хороо байгуулагдсан байна. Зээлийн төслийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулсан байна. Төслийн хүрээнд нийлүүлэгдэх техник, тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг эхлүүлсэн байна. Шаардлагатай сургалтууд зохион байгуулагдсан байна. | Гадаадын зээл, тусламж | 94,050.0 | - | - | Гамшгийн аюулыг зарлан мэдээлэл нэгдсэн системийг улсын хэмжээнд байгуулах, гамшгаас хамгаалах, бэлэн байдлын чадавхыг бэхжүүлж, гамшгийн улмаас учрах хохиролыг бууруулах зорилгоор Онцгой байдлын ерөнхий газраас Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 2020-2022 онд "Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь" техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлж, Азийн хөгжлийн банкны 33 сая доллар /30 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 3 сая ам.долларын буцалтгүй тусламж/-ын санхүүжилтээр хэрэгжих "Монгол Улсад гамшгийн аюулыг эрт зарлан мэдээллэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь" зээлийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, төслийн ерөнхий загвар, төслийн удирдлагын гарын авлага, техникийн тодорхойлолтууд болон холбогдох бусад баримт бичгүүдийг боловсруулсан. Тус төслийг 2023 онд хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Шадар сайдаар уламжлуулахаар 2022.11.25-ны өдрийн 1/2479 дугаар бичгээр Монгол Улсын Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд хүсэлт хүргүүлсэн. | 30.0 |
| 239 | 4.3.13. Хоригдлыг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх тогтолцоог орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх | Хоригдлыг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх тогтолцоог орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх | Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 419 дүгээр нээлттэй хорих ангийг түшиглэн "Нөхөн сэргээх байр"-ыг туршилтаар байгуулсан байна. | Улсын төсөв | - | - | - | Хорих ялын хугацаа дуусахаас өмнө хоригдлыг нийгэмд гаргахад бэлтгэх, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, суралцах, ажил хөдөлмөр эрхлэх дадал хэвшүүлэх, гэр бүлийн харилцааг бэлтгэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн "Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр"-ийг Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын тэнхимтэй хамтран боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022.08.30-ны өдрийн А/167, А/233 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан. Нэгдсэн Үндэстний Байгууллагын /Ерөнхий ассамблейн/ 2021.12.16-ны өдөр баталсан "Нийгэмшүүлэх болон нийгэмд эргэн нэгтгэх замаар давтан гэмт хэргийг бууруулах" тогтоол, "Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай үүргийг аймаг, нийслэл дэх ШШГГ, хэлтэс, хорих анги, байгууллагад хүргүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022.08.30-ны өдрийн хамтарсан А/167, А/233 тушаалаар батлагдсан "Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр"ийн хүрээнд ЦЕГ, УБЕГ-с төлөвлөгөөнд тусгах саналыг авч, удирдлагад танилцуулсан. Хоригдлыг суллагдахад бэлтгэх зорилгоор 417, 419, 439 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангиуд нь тусгайлсан нийгэмшүүлэх байр болон өрөөг бэлтгэн тохижуулж, нийгмийн харилцаа, амьдралд гарахад бэлтгэх, дадлага олгох сургалтыг зохион байгуулж байна. Тухайлбал суллагдахын өмнөх сургалтаар хууль эрх зүйн мэдлэг олгохоос гадна нийгэмд хэрэглэгдэж буй техник технологийг /АТМ, ТҮЦ, ухаалаг утас, автобусны картыг хэрхэн ашиглах, "Нэг цонхны үйлчилгээ"-ний талаар/ танилцуулах үзүүлэн, загвар, гарын авлага, товхимлыг байршуулан сургалтад ашигласан. "Дахин гэм хэрэг үйлдсэн хоригдлуудын харилцааны түвшинг нийгэмшүүлэх үйл ажиллагаатай холбон судлах" судалгааны ажлыг гарын авлагын эхийг бэлтгэн, хэвлүүлэхэд бэлэн болгосон. | 70.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 240 | 4.3.14. Криминалистик, шүүх эмнэлэг, тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник технологийн дэвшлийг нэвтрүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулах | Криминалистик, шүүх эмнэлэг, тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник технологийн дэвшлийг нэвтрүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулах | Төслийн хэрэгжилт 80 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 17,200.0 | - | - | БНСУ-ын Экзим банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх "Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл"-ийн хүрээнд Шүүх эмнэлгийн шинжилгээний лабораторийн болон цогцос хадгалах барилгыг Нийслэлийн баруун талд барихаар төлөвлөн ажиллаж Техник эдийн засгийн үндэслэлийг хийж дуусгасан. Барилга барих 1 га газрыг Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Архивын ерөнхий газрын баруун урд талд шийдвэрлүүлж, холбогдох техникийн нөхцөл, зөвшөөрлүүдийг авсан байгаа бөгөөд барилгын зургийг "Зуун найм" ХХК-аар, барилга угсралтын төсвийг "Өрх" ХХК-аар хийлгүүлсэн. ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга БНСУ-ын зөвлөх үйлчилгээний тендерт оролцох тухай урилгыг БНСУ-ын талд хүргүүлсэн. Ийнхүү Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/162 дугаар тушаалаар "Үнэлгээний хороо"-г шинэчлэн баталсан бөгөөд ажлын хэсэг хуралдаад зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр санал өгсөн 3 компаниас сонгон шалгаруулалт үнэлгээ хийж, 2 компанийг шалгаруулж холбогдох бичиг баримтыг БНСУ-ын Экзим банк руу хүргүүлсэн. Мөн Шүүх эмнэлгийн цогцос хадгалах барилга барих газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн газрын албаны дарга, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад санал, хүсэлт уламжлан ажилласны үр дүнд Самбалхүндэв /70 давхар/-ийн оршуулгын газрын 10 га талбайд хэрэгжүүлж буй "Дурсгал, хүндэтгэлийн цэцэрлэгт хүрээлэн" байгуулах төслийн хүрээнд чөлөөлөгдсөн газраас шарил түр хадгалах байр барих зориулалт бүхий 1 га талбайг зохих журмын дагуу хүлээн авахаар шийдвэрлүүлж, 3 талт санамж бичиг байгуулахаар ажиллаж байна. Барилгын зургийг "Зуун найм" ХХК-иар, барилга угсралтын төсвийг "Өрх" ХХК-иар хийлгэсэн. | 100.0 |
| 241 | 4.3.15. Хилийн боомт дахь улсын байцаагчдыг хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох түргэвчилсэн багаж хэрэгслээр хангаж, эрсдэл өндөртэй бараа, бүтээгдэхүүний илрүүлэлтийг нэмэгдүүлэх | Хилийн боомт дахь улсын байцаагчдыг хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох түргэвчилсэн багаж хэрэгслээр хангаж, эрсдэл өндөртэй бараа, бүтээгдэхүүний илрүүлэлтийг нэмэгдүүлэх | 9 боомт, 17 терминалыг түргэвчилсэн шинжилгээний багаж хэрэгслээр хангасан байна. | Улсын төсөв | 1,000.0 | - | - | Тайлан ирүүлээгүй | 0.0 |
| 242 | 4.3.16. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадварыг нэмэгдүүлэхийн тулд лабораторийн 350 багаж, тоног төхөөрөмж авч, хүнсний аюулгүй байдлыг хангуулах | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадварыг нэмэгдүүлэхийн тулд лабораторийн 350 багаж, тоног төхөөрөмж авч, хүнсний аюулгүй байдлыг хангуулах | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн 74.3 хувийг тодорхойлох хүчин чадалтай болсон байна. | Улсын төсөв | 800.0 | - | - | Тайлан ирүүлээгүй | 0.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 243 | | 4.3.17. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх /Улаанбаатар хот, орон нутгийн бүх камер/ | Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх /Улаанбаатар хот, орон нутгийн бүх камер/ | 60 цэг | Гадаадын зээл, тусламж | 42,308.5 | - | - | Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын нэгдсэн "Дата төв", "Видео аналитик, платформ систем", "Хянан дэлгэцийн систем", Дата төвийн сервер, сүлжээний тоног төхөөрөмж" болон "Орон нутгийн хатуу хучилттай автозам дагуу байрлах байнгын хяналтын 40 цэг /пост/-ийг камерын систем бүхий "Нэгдсэн удирдлага, хяналтын төв"-ийг байгуулах төслийн барилгын зураг, төслийг хийхэд шаардагдах 350.0 сая төгрөгийн зардлыг Барилга хот, байгуулалтын сайдын багцаас шийдвэрлүүлж, тус яамнаас зарласан тендерт тэнцсэн "Барилга байгууламж" ХХК-иас барилгын зургийн ажлыг хийж холбогдох байгууллагаар баталгаажуулсан байна. Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбооны шинэчилж, хэт богино долгионы тоон Р-25 системийн 75,1 тэрбум төгрөгийг 2023 оны төсвийн төсөлд тусгуулах саналыг удирдлагад танилцуулахаар хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр төслийг Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар, "Моторола сольюшн" компанитай хамтран хэрэгжүүлэх, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газраас олгох 10,0 сая ам.долларын санхүүжилтээр эхний ээлжид Улаанбаатар хотод үндсэн дэд бүтцийн суурийг 60 хувьтай байгуулж, цагдаагийн байгууллагын хэрэгцээт станцын 30 хувьд нөхөн хангалт хийхээр төлөвлөснийг мэдэгдсэн ба Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зохион байгуулсан "Сэргэ-2022" стратегийн нэгдсэн команд штабын сургуулилтын үеэр Хууль зүй, дотоод хэргийн сайдын байгуулсан тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын радио холбооны нэгдсэн системийг байгуулахад шаардагдах зардлын тооцоог гаргаж, танилцуулах үүрэг бүхий Дэд сайдаар ахлуулсан Ажлын хэсэгт алба хаагчид ажиллаж байна. Олон улс, улсын чанартай авто замын 62 цэгт камерын хяналтын систем суурилуулахаар төлөвлөснөөс улсын төсөв болон орон нутгийн төсвийн 448 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, Говьсүмбэр, Дорноговь, Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь, Завхан, Баянхонгор аймгийн 9 сумдын 13 постод 68 ширхэг хяналтын камерыг суурилуулсан. | 100.0 |
| 244 | | 4.3.18. Ус, цаг уурын хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, техник, технологийн шинэчлэл хийж, чадавхыг бэхжүүлэх | Ус, цаг уурын хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, техник, технологийн шинэчлэл хийж, чадавхыг бэхжүүлэх | Автомат станц, хэмжих хэрэгсэл 50 ширхгийг худалдан авч цаг уурын өртөөг 100 хувь, харуулын 30 хувийг хангасан байна. | Улсын төсөв | 3,250.0 | - | - | Тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардал 2022 оны Монгол улсын төсөвт тусгагдаагүй тул тус газраас хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд Бүгд найрамдах Солонгос улсын Цаг уурын байгууллагад цаг уурын автомат станц суурилуулах төсөл хэрэгжүүлэх санал тавьсаны дагуу БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2023 онд 20 ш автомат станц Өвөрхангай, Дундговь аймгуудад суурилуулах төсөл хэрэгжүүлэх болсныг албан бичгээр мэдэгдсэн. Энэ ажлын хүрээнд 2022 оны 8 болон 11-р сард Солонгосын цаг уурын байгууллагын мэргэжилтэнүүд Монгол улсад ирж төслийн урьдчилсан судалгаа хийсэн бөгөөд төсөл хэрэгжихэд бэлэн болсон. | 30.0 |
| 245 | | 4.3.19. Хилийн заставуудын барилга объектуудын шинэчлэл хийх | Хилийн заставуудын барилга объектуудын шинэчлэл хийх | Гүйцэтгэл 40 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 14,000.0 | Улсын төсөв | 1,220.1 | Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2022 оны А/132 дугаар тушаалаар Хил хамгаалах байгууллагын "Барилга байгууламжийн шинэчлэл хөтөлбөр"-ийг батлуулж, хилийн цэргийн 0214, 0166, 0198, 0285, 0311, 0275 анги, 0267 дугаар тусгай салбарт 34 айлын нэгдсэн халаалт, цэвэр, бохир усны системтэй орон сууц, 0245, 0277, 0286, 0287, 0275 дугаар ангийн төв болон хилийн салбарт ердийн галлагаатай 20 айлын орон сууц, 0166, 0131 дүгээр ангиуд гэрээт цэргийн байр шинээр барьж, 0214, 0306 дугаар ангийн 9 салбарын гэрээт цэргийн байранд засвар хийж, ашиглалтад оруулсан. | 100.0 |
| 246 | | 4.3.20. Хилийн заставын авто паркийн шинэчлэл хийх | Хилийн заставын авто паркийн шинэчлэл хийх | Гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 10,000.0 | - | - | "Моннис" ХХК-тай 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр автомашин санхүүгийн түрээсээр ашиглах тухай н/36-мм-а-2022-101 дугаартай гэрээ байгуулж, "Nissan patrol V61" маркийн 18 нэгж автомашиныг хүлээн авч, хилийн цэргийн ангиудад хангасан. | 50.0 |
| 247 | | 4.3.21. Хилийн боомтын нэвтрүүлэх үйл ажиллагаанд ухаалаг гарцын систем нэвтрүүлэх | Хилийн боомтын нэвтрүүлэх үйл ажиллагаанд ухаалаг гарцын систем нэвтрүүлэх | Шинээр нэвтрүүлсэн боомтын тоо-2 | Улсын төсөв | 2,000.0 | - | - | Засгийн газрын 2022 оны 228 дугаар тогтоолоор агаарын замын хилийн "Чингис хаан" боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, агаарын тээврийг хялбаршуулах зорилгоор хүний биеийн давхцахгүй өгөгдөлд суурилсан цахим гарц 8, зорчигчийн гар тээш шалгах рентген төхөөрөмж 2-ыг тус тус худалдан авч, суурилуулахад шаардагдах хөрөнгийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгуулсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор ажлын хэсэг байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. БНСУ-ын цахим гарцын төхөөрөмж үйлдвэрлэгч "Cubox" компанитай уулзалт зохион байгуулж, техникийн шийдлийг судалж байна. | 50.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 248 | 4.4. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлнэ. | 4.4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэл хийж, хяналт тавих | Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэл хийж, хяналт тавих | Улсын үзлэг, тооллого зохион байгуулсан байна. | Улсын төсөв | 25.0 | Улсын төсөв | 300.3 | Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай" 9 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажил 2022 оны турш зохион байгуулагдав. Улсын үзлэг, тооллого явуулахад шаардлагатай нийт 301.0 сая төгрөгийн төсөв 2022 оны улсын төсөвт тусгагдан батлагдсан бөгөөд 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 300.3 сая төгрөгийг тоног төхөөрөмж, программ хангамж, түүний зөвшөөрөл, томилолтын зардал, хэвлэлийн үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна. Улсын үзлэг, тооллогын мэдээллийн системийн техник болон программ хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд нийт 29.6 сая төгрөгийн төсвийг зарцуулж, бүртгэл, дүн мэдээ нэгтгэх боломжийг бүрдүүлснээр төрийн болон орон нутгийн өмчит 6613 хуулийн этгээдийн улсын үзлэг, тооллогын дүн мэдээг хянан баталгаажуулах ажлыг хийж дууссан. Улсын үзлэг, тооллогод нийт 91.7 их наяд төгрөгийн хөрөнгө хамрагдсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг, тооллогын нэгдсэн дүнг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэсэн. Нийслэл болон 21 аймагт байгаа төрийн өмчит нийт 1030 хуулийн этгээдтэй байгуулсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2021 оны биелэлтийг дүгнэв. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх аргачлал"-ын 4.1-д заасны дагуу Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн дүн, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний талаарх танилцуулгыг бэлтгэж, 12 дугаар сарын 27-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвлөх хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. | 100.0 |
| 249 | 4.5. Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ. | 4.5.1. "Дэлхийн Монголчууд II" цогц арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх | "Дэлхийн Монголчууд II" цогц арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх | Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг 70-аас дээш хувьтай хэрэгжүүлсэн байна. | Улсын төсөв | 100.0 | Улсын төсөв | 40.0 | Цогц арга хэмжээг ГХС-ын 2021 оны А/51 тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Үүнд 7 зорилтын хүрээнд 97 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөснөөс 2022.11 сарын байдлаар 56 арга хэмжээ 100 хувь, 5 арга хэмжээ 90 хувь, 7 арга хэмжээ 70 хувь, 10 арга хэмжээ 50 хувь, 9 арга хэмжээ 30 хувийн гүйцэтгэлтэй байна. Хилийн чанадад байгаа 11 улсын 25 хотод 44 монгол сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ГХС Б.Батцэцэг холбогдох төрийн байгууллагуудыг оролцуулан 2022.3.11-нд цахим уулзалт хийв. ГХЯ-наас МУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх ХБУЗ-тэй хамтран заах арга зүйн цуврал цахим сургалтыг 3 сард эхлүүлж, 16 удаагийн сургалтыг зохион байгуулав. Сургалтад 100 орчим багш хамрагдсан ба ХБУЗ өөс багш нарт сертификат олгоно. ХБУЗ-тэй хамтран "Үндэсний бичиг эхлэн хялбар хурдан сурах дэвтэр"-ийн эхний хэсгийг сургуулиудад хүргүүлэв. Сургалтын материал бэлтгэх ажлын хүрээнд БСҮХ-тэй хамтран 4 цахим сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэн хүргүүлэв. Мөн сургууль тус бүрд "Хүүхдийн эх хэлний боловсролд" эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Мал аж ахуйн соёл, Би Монгол хүн, Монгол ярианы сурах бичиг, Монгол хэлний дүрмийн заах арга зүйн эмхэтгэл зэрэг 350 гаруй номыг хүргүүлэв. "Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл", "Төгс билэгт" сургалтын төвийн хүсэлтээр "Анхаа, Адам хоёрын аялал-1" үлгэрийн ном 400 ширхгийг Стокхолмд хүргүүлэв. Хилийн чанадад байгаа Алдарт эхийн одонгоор 75, төрийн дээд одон медаль, салбарын тэргүүний ажилтны хүндэт тэмдгээр 32 иргэнийг шагнуулав. "Хилийн чанад дахь Монголчуудын нэгдсэн чуулга уулзалт"-ыг 2022.07.05-нд, "Хилийн чанад дахь Монголчуудын Зөвлөл" НҮТББ-ын IV чуулга уулзалтыг 2022.07.04-нд зохион байгуулав. Хилийн чанад дахь монголчуудын дунд "Миний Монгол наадам-2022" уралдааныг шалгаруулалтыг зохион байгуулж, АНУ, БНФУ, БНСУ дахь Монголчуудын холбоодод олгох өргөмжлөл, цом, мөнгөн шагналыг холбогдох ДТГ-уудад хүргүүлэв. "Монголын бүх ард түмний XV наадам", "Монгол Үндэсний спортын VII наадам"-ын тэмцээнийг АНУ, БНФУ, БНСУ-д зохион байгуулав. | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 250 | | 4.5.2. Хилийн чанадад байгаа иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх | Хилийн чанадад байгаа иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх | Гүйцэтгэл 60 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 75.0 | Улсын төсөв | 0.7 | Хилийн чанадад 90-ээс дээш хоног оршин суугаа иргэдийг бүртгэх www.citizen.gov.mn цахим хуудасны хэвийн ажиллагаа, хөгжүүлэлтийн асуудлаар 2022.02.15-ны өдөр ГХЯ, УСХороо, УБЕГ, ХХЕГ-ын хамтарсан уулзалт зохион байгуулж, мөрөөр нь ажиллаж байна. 2018 онд ашиглалтад оруулсан тус программын хандалтын эрх цуцлагдсан байсныг сэргээж, 2023 оныг дуустал хугацааг сунган, хилийн чанадад байгаа ДТГ-уудаар дамжуулан иргэдэд сурталчлах, уриалах ажлыг хэрэгжүүлж байна. Бүртгэлийн хэсгийг төрийн үйлчилгээний "E-Mongolia" нэгдсэн системд холбож нэгтгэсэн. Тус системд 2022 оны байдлаар 31,000 орчим иргэн бүртгэгдсэн байна. Гэвч дэлхий нийтийг хамарсан "Ковид-19" цар тахал, Украин-ОХУ-ын нөхцөл байдал, "E-Mongolia" системд гадаадаас холбогдоход тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд ЦХХХЯ, УБЕГ-тай хамтран ажиллаж байна. Гадаадад оршин сууж буй монгол иргэдийн нэвтрэх асуудлыг хялбаршуулж, Lime цахим утасны дугаар нэвтрүүлсэн талаар ЦХХХЯ-ны заавар-мэдээллийг нийт ДТГ-уудад 2022.11.16-ны өдрийн Е/10/22/1570 шуудангаар хүргүүлж, сурталчлав. Иргэд цахим гарын үсгээр нэвтрэх ажлыг эрчимжүүлэх, иргэдийн нийгмийн даатгал, халамжийн асуудлыг шийдвэрлэх саналыг ХНХЯ, "И-Монгол Академи" УТҮГ-т 2022.10.17-ны өдөр 10/5413 албан бичгээр хүргүүлсэн. Хилийн чанадад байгаа иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх ажлын явц 50 хувьтай байна. Шалтгаан нь: Гадаадад оршин сууж буй монгол иргэдийн бүртгэлийг сайжруулахад төрийн үйлчилгээний "E-Mongolia" порталд гадаадаас нэвтрэх асуудал хүндрэлтэй (Монгол дахь гар утасны дугаар, эсхүл банкны эрхээр нэвтрэх шаардлагатай) байгаагаас хэрэгжилт удааширсан. Уг асуудлыг шийдвэрлэх саналыг ХНХЯ, "И-Монгол Академи" УТҮГ-т 2022.10.17-ны өдөр 10/5413 албан бичгээр хүргүүлсэн боловч өнөөг хүртэл хариу ирүүлээгүй байна. | 50.0 |
| 251 | | 4.5.3. Хилийн чанад дахь иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, цахим үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлэх | Хилийн чанад дахь иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, цахим үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлэх | Цахим апостиль систем, цахим гарын үсгийн системийг дипломат төлөөлөгчийн газарт нэвтрүүлсэн байна. | Улсын төсөв | 550.0 | Улсын төсөв | 3.5 | 1. "Цахим Апостиль" санг 2022 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс нэвтрүүлж, компьютер, өндөр хурдны сканерыг ашиглан цахим архивыг бүрдүүлэн ажиллаж байна. 2022 онд олгосон 28800 апостиль гэрчилгээний цахим санг үүсгэсэн. Мөн "Баримт бичиг баталгаажуулж, Апостиль гэрчилгээ олгох журам"-ыг шинэчлэн боловсруулж, ГХСайдын 2022.11.04-ний өдрийн А/86 тушаалаар батлуулав. Ингэхдээ, Захиргааны ерөнхий хуулийн дагуу уг журмын төсөлд иргэд, олон нийтээс санал авахаар ГХЯ-ны цахим хуудаст байршуулж, зохих журмын дагуу Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Шинэ журамд Апостиль гэрчилгээг олгосон эсэхийг дэлхийн хаанаас ч хянан шалгах боломжтой, иргэд цахимаар хүсэлтээ гарган шийдвэрлүүлэх боломжтой e-apostille.consul.mn цахим порталыг бий болгох, бүртгэл хяналтыг сайжруулж цахим сан үүсгэх, иргэдийн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх, цахим болон цаасан баримтыг хадгалах хугацааг шинэчлэн тогтоосон. 2. Цахим нотариат" системийг нийт ДТГ-т нэвтрүүлэх хүрээнд ГХЯ, МНТанхим, Интерактив ХХК-ийн хурлыг 8 удаа зохион байгуулж, нийт 49 ДТГ-т 3 үе шаттайгаар туршилтаар нэвтрүүлсэн. Цахим нотариат системийн сургалтыг 06.15, 09.22, 10.11, 10.28, 11.18-19-ний өдөр нийт ДТГ-т цахимаар зохион байгуулав. www.e-notary.mn системийг 2022.08.25-ны өдрөөс Австрали, Австри, Швед, АНУ (Чикаго), БНТУ (Истанбул) дахь ДТГ-уудад, 2022.09.15-наас нийт 35 ДТГ-т туршилтаар нэвтрүүлж, хөгжүүлэлтийг хийж байна. Заавар-чиглэлийг нийт ДТГ-т 2022.08.31-ний өдрийн Е/10/22/1177, 2022.06.16-ны Е10/22/0833, 2022.09.14-ний өдрийн Е/10/22/1254 цахим шуудангаар хүргүүлэв. Цахим нотариатын системд 12 дугаар сарын 01-ний өдрөөс нийт 49 ДТГ-уудын нотариатын үйлчилгээг бүрэн шилжүүлэв. Уг систем нэвтэрснээр иргэд ГХЯ-нд заавал ирэхгүйгээр өөрт ойр байрлах нотариатчаас итгэмжлэл, баримт бичгийг хүлээн авч эхлэв. Энэ талаар төрийн байгууллагууд, Монголын банкуудын холбоонд албан ёсоор мэдэгдэж, олон нийтэд зарлан сурталчлав. (https://consul.mn/news/c/156) | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 252 | 4.6. Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ. | 4.6.1. Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх | Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагаар өргөжүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх | Гадаад хамтын ажиллагаатай орны тоог 2-оор нэмэгдүүлсэн байна. | - | - | - | - | Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад 2022 оны 12 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд айлчлах үеэр Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор "Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах болон айлчлал солилцооны тухай" Батлан хамгаалах яамд хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг Сайд нар гарын үсэг зурж баталгаажуулсан. Сингапур Улсад 2022 оны 06 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 19 дэх удаагийн "Шангри-Ла яриа хэлэлцээ" дээд хэмжээний уулзалтын үеэр батлан хамгаалахын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, Бүгд Найрамдах Филиппин Улсын Үндэсний батлан хамгаалах яамд хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт хоёр улсын Батлан хамгаалахын сайд нар гарын үсэг зурж баталгаажуулсан. | 100.0 |
| 253 | | 4.6.2. Цэргийн II шатны эмнэлгийг байгуулах бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх | Цэргийн II шатны эмнэлгийг байгуулах бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх | Гүйцэтгэл 100 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 5,300.0 | - | - | Хэрэгжилтийн явцын тайланг Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 247 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2018 оны нууц тушаалаар нууцын зэрэглэлд хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1. "Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэсний дагуу мэдээлэх боломжгүй болно. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу тайланг албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. | 50.0 |
| 254 | | 4.6.3. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд инженерийн рот, тусгай хүчний ротыг бэлтгэж оролцуулах | НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд инженерийн рот, тусгай хүчний ротыг бэлтгэж оролцуулах | Инженерийн рот, тусгай хүчний ротыг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах бэлтгэлийг 50 хувьд хүргэсэн байна. | Улсын төсөв | 2,000.0 | - | - | Хэрэгжилтийн явцын тайланг Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 247 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2018 оны нууц тушаалаар нууцын зэрэглэлд хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1. "Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэсний дагуу мэдээлэх боломжгүй болно. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу тайланг албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. | 100.0 |
| 255 | | 4.6.4. Цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж, технологи, инновацыг нэвтрүүлэх замаар батлан хамгаалах аж үйлдвэрлэлийн эхлэлийг тавих | Цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж, технологи, инновацыг нэвтрүүлэх замаар батлан хамгаалах аж үйлдвэрлэлийн эхлэлийг тавих | Батлан хамгаалахын шинжлэх ухаан, технологи, инновацыг 2020-2024 онд хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 35 хувь хэрэгжсэн байна. | Улсын төсөв | 8,730.0 | - | - | Хэрэгжилтийн явцын тайланг Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 247 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2018 оны нууц тушаалаар нууцын зэрэглэлд хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1. "Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэсний дагуу мэдээлэх боломжгүй болно. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу тайланг албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. | 100.0 |
| 256 | | 4.6.5. Кибер аюулгүй байдлын төвийн чадавхыг дээшлүүлэх | Кибер аюулгүй байдлын төвийн чадавхыг дээшлүүлэх | Барилга байгууламж, тусгай техник, тоног төхөөрөмжөөр 50 хувь хангана. | Гадаадын зээл, тусламж | 6,800.0 | - | - | Хэрэгжилтийн явцын тайланг Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 247 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2018 оны нууц тушаалаар нууцын зэрэглэлд хамаарч байгаа тул Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1. "Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэсний дагуу мэдээлэх боломжгүй болно. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу тайланг албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. | 70.0 |
| | | | **Бодлогын дундаж үнэлгээ** | | | **268,489.0** | **-** | **10,443.9** | | **69.1** |
| | | | | **5. Ногоон хөгжлийн бодлого** | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 257 | 5.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | 5.1.1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна. | Концесс, ТХХТ | 40,000.0 | Концесс, ТХХТ | 40,000.0 | 2022 оны уул уурхайн компаниудын ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 507.7 га-д, биологийн нөхөн сэргээлтийг 306.2 га-д, дүйцүүлэх хамгаалах ажлыг 1388.8 га-д нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн. "Оюу толгой" ХХК Ялбаг орчмын 334.57 га, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 500 га талбайд нөхөн сэргээлтийн тендер зарлагдаж сонгон шалгаруулалтын ажил хийгдэж байна. Нийслэлийн ЗДТГ-аас Налайх дүүргийн 3-р хороонд нүүрсний олборлолтын улмаас эвдрэлд орсон 40 га газрын нөхөн сэргээх ажлын тендер зарласан. Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.3 дугаар заалтын дагуу 2022 оны уулын ажлын гүйцэтгэлийн тайланг 2023 оны 2-р сард ирүүлдэг. 2022 оны хагас жилийн мэдээлэл гаргах боломжгүй байна. | 90.0 |
| 258 | | 5.1.2. Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж байгуулах ажлын бэлтгэл хангах | Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж байгуулах ажлын бэлтгэл хангах | Концессын төсөл сонгон шалгаруулалтыг зарласан байна. | Концесс, ТХХТ | 100,000.0 | - | - | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар "Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламжийн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах" талаар хэлэлцэж, Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 377 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газрын зориулалтаар 20 газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-ын 41-д туссан "Аюултай хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл"-д тусгагдаж батлагдсан. Иймээс Концессын тухай хуулийн дагуу концессын уралдаант шалгаруулалт зарлах эрх нь Эдийн Засаг хөгжлийн яаманд байдаг тул "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" Концессын төрлөөр Уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах талаар хүсэлтийг Эдийн засгийн хөгжлийн сайдад 01/6440 тоот албан бичгээр хүргүүлж, манай яамны эрхлэх асуудал 100 хувь хэрэгжсэн байна. | 70.0 |
| 259 | | 5.1.3. Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Онги, Хэрлэн усан цогцолборын төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж бүтээн байгуулалтыг эхлүүлэх | Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Онги, Хэрлэн усан цогцолборын төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж бүтээн байгуулалтыг эхлүүлэх | Хэрлэн голоос ус татаж, Хэрлэн-Тооно хөндлүүрт хуримтлуулах байгууламж, Онгийн голын Цагаан бургастай хөндлүүрт урсац тохируулах зориулалттай боомтын байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. | Улсын төсөв | 33,400.0 | - | - | "Орхон Онги, Хэрлэн-Тооно төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ТЭЗҮ-ийг боловсруулсан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 20 дугаар захирамжаар Монгол орны голууд дээр урсацын тохируулга, усан цахилгаан станц байгуулах, шилжүүлэн ашиглах боломжийн талаар холбогдох судалгааг хийж, боломжтой газруудад зураг төсөл зохиох барьж байгуулах бэлтгэл ажил хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Тухайн ажлын хүрээнд Франц, Герман, Унгар, Япон, Англи болон Европын холбооны элчин сайдуудтай тухайн төслүүдэд хамтран ажиллах хөрөнгө оруулах талаар уулзалтуудыг зохион байгуулсан. Гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх "Орхон-Онги" төслийн ажлын зураг, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхэд шаардагдах санхүүжилтийн тооцооллыг хийж, Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яаманд танилцуулж, холбогдох материалыг хүргүүлсэн. Мөн Израиль улсын "Баран интернэйшинл" ХХК, БНХАУ-ын "Повер чайна констракшн корпорейшн" компаниуд тус төслийг хэрэгжүүлэх хүсэлтээ илэрхийлж, БОАЖ-ын Сайд, Усны газартай уулзалт хийсэн. "Хөх морь" төслийн үйл ажиллагаар эрчимжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, шийдвэр гаргах түвшний бэлтгэл ажлыг хангуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг БОАЖ-ын Сайдын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/196 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. "Орхон-Онги" төслийн ажлын зураг, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхэд шаардагдах төсвийг Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны төсөвт хэрэгжүүлэхээр тусгуулан. Монгол улсын гадаргын усны нөөц бүхий Сэлэнгэ мөрний сав газарт гадаргын усыг хуримтлуулж, шилжүүлэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой Сэлэнгэ мөрний сав газрын бүс нутгийн үнэлгээний ажлыг хэрэгжүүлэхээр 7.6 тэрбум төгрөгийг тусгуулан ажилласан. | 50.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 260 | 5.1.4. Улаанбаатар хотын агаарын чанарын хяналтын системийг сайжруулах, усан халаалтын зуухны түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар халах, инженерийн дэд бүтцийн бичил төвүүдийг байгуулах, Евро 5 ангиллын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэх, цахилгаан хөдөлгүүртэй автобусаар нийтийн тээврийн парк шинэчлэл хийх зэрэг агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх | Улаанбаатар хотын агаарын чанарын хяналтын системийг сайжруулах, усан халаалтын зуухны түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар халах, инженерийн дэд бүтцийн бичил төвүүдийг байгуулах, Евро 5 ангиллын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэх, цахилгаан хөдөлгүүртэй автобусаар нийтийн тээврийн парк шинэчлэл хийх зэрэг агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх | Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламжийг 50 мкг/м3, PM10 тоосонцрын агууламжийг 107 мкг/м3-д хүргэж бууруулсан байна. | Улсын төсөв | 77,000.0 | Улсын төсөв | 24,935.6 | ОББҮХ-ны 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан нийт 47 арга хэмжээний хүрээнд Нийслэл болон 17 аймагт арга хэмжээ хэрэгжүүлж байна. ХАА-ны төлөвлөгөөний дагуу эрх шилжсэн 18, ажил гүйцэтгэх, бараа нийлүүлэх, зөвлөх үйлчилгээний нийт 26 гэрээ байгуулагдсан байна. Үүнээс 100% хэрэгжилттэй 29, 70-90% хэрэгжилттэй 4, 30-50% хэрэгжилттэй 4, хэрэгжээгүй 10 арга хэмжээ байна. Дундаж гүйцэтгэл 70,2% байна. Он дамнасан гэрээт 28 ажлаас 100% хэрэгжилттэй 21, 70-90% хэрэгжилттэй 7 гэрээт ажил байна. Дундаж гүйцэтгэл 94% байна. Арга хэмжээний төлөвлөгөөнд сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах зорилгоор PM2.5 нарийн ширхэгт тоосонцор шүүх чадвартай, нано технологийн цонхны шүүлтүүр суурилуулах, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчны бохирдлыг тодорхойлох судалгаа хийх зэрэг арга хэмжээ нэмэлтээр батлагдсан бөгөөд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн дүнд 2022 оны 52 дахь 7 хоногийн дундаж үзүүлэлтийг 2021 оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламж 3мкг/м3-ээр нэмэгдсэн буюу 97мкг/м3, PM10 тоосонцрын агууламж 10мкг/м3-ээр бага буюу 119мкг/м3 байна. (Агаарын чанарын хэмжилтийн мэдээллийн эх сурвалж ) | 50.0 |
| 261 | 5.1.5. Томоохон хот, суурин газруудад агаарын чанарыг 5-аас доошгүй үзүүлэлтээр хянах боломжийг бүрдүүлэх | Томоохон хот, суурин газруудад агаарын чанарыг 5-аас доошгүй үзүүлэлтээр хянах боломжийг бүрдүүлэх | Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгийн агаарын чанарыг NO2, SO2, CO, PM2.5, PM10 үзүүлэлтээр тасралтгүй, автоматаар хянах боломжийг бүрдүүлсэн байна. | - | - | Улсын төсөв | 1,099.9 | Улаанбаатар хотын агаарын чанарын мэдээллийг иргэд, олон нийтэд түгээх зориулалттай гадна орчинд байрлуулсан лед дэлгэцэнд шаардлагатай 25 ширхэг тэжээлийн блок, 150 ширхэг лед гэрэл, 4 ширхэг төв процессорыг шинэчлэх, нэмэлт цахилгааны болон кабелийн утсыг сольж хэвийн тасралтгүй ажиллагаагаар хангасан. Завхан, Баянхонгор, Өмнөговь, Хөвсгөл, Архангай, Төв аймгуудад агаар дахь PM2.5 нарийн ширхэгт тоосонцор, PM10 том ширхэгт тоосонцорын агууламжийг хянах боломж бүрдсэн. Мөн Нийслэлд байрлах УБ-1, УБ-2, УБ-3, УБ-4, УБ-5, УБ-7, УБ-8, УБ-11, УБ-12, УБ 13 агаарын чанарын автомат суурин харуулуудыг шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангаж, хэвийн тасралтгүй ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлсэн. Аймгийн төв, 10000-аас дээш хүн амтай томоохон төв суурин газарт нийт 4 ширхэг агаарын чанарын иж бүрэн автомат суурин харуул суурилуулж агаарын чанарын хяналтын сүлжээнд холбох ажлын тендерийг үнэлэн, зөвлөмжийг хүргүүлсэн боловч Сангийн яамнаас тендер шалгаруулалтын 1, 2 дугаар багцад оролцсон "Эм Ай Эс Эс" ХХК-аас гомдол гаргасан тухай мэдэгдэл ирсний дагуу холбогдох материалыг Сангийн яаманд хүргүүлснээр гомдлыг үндэслэлгүй тухай хариу ирүүлсэн боловч дахин гомдол гаргаснаар уг худалдан авах ажиллагаа амжилтгүй болгосон. | 50.0 |
| 262 | 5.1.6. Хүн амын унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлыг үргэлжлүүлэх | Хүн амын унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлыг үргэлжлүүлэх | 5 сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааг хийж, нөөцийг тогтоосон байна. Гидрогеологийн 1:200000-ны хураангуйлалтай зураглалын ажлыг өргөжүүлж, нийт нутаг дэвсгэрийн 16 хувьд хүргэсэн байна. | Улсын төсөв | 1,800.0 | Улсын төсөв | 960.0 | Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын төвийн хүн амын унд ахуйн ус хангамжийн зориулалттай газрын доорх усны хайгуул судалгааны ажлыг бүрэн хийж дууссан бөгөөд ажлын гүйцэтгэлийн тайланг хүлээн авч 2022 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. Говь-Алтай аймгийн Төгрөг, Өмнөговь аймгийн Сэврэй, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумдын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж "Алтайн их ус" ХХК, "Охь ус" ХХК, "Ташырын хүрээ" ХХК шалгарсан хэдий ч төсвийн тодотголоор санхүүжилт хасагдсан. 2022 онд Гидрогеологийн дунд масштаб зураглал хийсэн газар нутгийн хэмжээг 0.5 хувиар нэмэгдүүлж, (14.8% байсныг) 15.3 хувьд хүргэх зорилтын хүрээнд Дорноговь аймгийн Дэлгэрэх, Өргөн сум, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр Уулбаян, Халзан, Түвшинширээ, Асгат, Онгон, Баруун-Урт сумдын нутагт зураглалын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Ерөнхий тайланг эцсийн байдлаар 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хүлээн авч, 2022 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. | 50.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 263 | 5.1.7. Газрын доорх усны хяналт-шинжилгээний цооног өрөмдөж, мониторингийн тоног төхөөрөмж суурилуулан газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээнд холбох | Газрын доорх усны хяналт-шинжилгээний цооног өрөмдөж, мониторингийн тоног төхөөрөмж суурилуулан газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээнд холбох | Газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээг 20 цэгээр өргөжүүлж, тоноглосон байна. | Улсын төсөв | 1,000.0 | Улсын төсөв | 478.0 | Газрын доорх усны хяналт-шинжилгээний цооног өрөмдөж, мониторингийн тоног төхөөрөмж суурилуулан газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээнд холбох ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, "КАРСТ" ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр УГ/202201002/ дугаар гэрээг байгуулж ажилласан бөгөөд ажлын тайланг хүлээн авч, 2022 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. Ингэснээр газрын доорх усны түвшин, температур, цахилгаан дамжуулах чанар, агаарын даралтыг 6 цаг тутам хянаж, бүртгэдэг 309 мониторингийн хяналт-шинжилгээний цэгийг 2022 онд Өмнөговь аймгийн Ноён суманд 2, Баяндалай суманд 1, Дорноговь аймгийн Сайхандулаан суманд 2, Мандах суманд 2, Өргөн суманд 2 цооног, Айраг суманд 1 цооног нийт 10 мониторингийн цооногоор сүлжээг өргөтгөж 319-д хүргэсэн. | 70.0 |
| 264 | 5.1.8. Цаг уурын бодит болон цаг агаарын урьдчилсан мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлэх | Цаг уурын бодит болон цаг агаарын урьдчилсан мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлэх | Хэнтий аймагт радарын станц байгуулсан байна. | Улсын төсөв | 5,900.0 | - | - | Монгол Улсын 2022 оны төсөвт холбогдох зардал тусгагдаж батлагдаагүй тул хэрэгжүүлэх боломжгүй байна. | 0.0 |
| 265 | 5.1.9. Ойжуулалт, нөхөн сэргээлтийг чанаржуулан, ойн хомстол, доройтлыг бууруулж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх | Ойжуулалт, нөхөн сэргээлтийг чанаржуулан, ойн хомстол, доройтлыг бууруулж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх | 8.0 мянган га талбайг ойжуулж, нөхөн сэргээсэн байна. Ойн хөнөөлт, шавж өвчний голомттой 200.0 мянган га талбайд тэмцлийн ажил явуулсан байна. Шатсан ойн талбайг өмнөх жилийнхээс 5 хувиар бууруулна. Ой зохион байгуулалтыг 1,600.0 мянган га-д явуулсан байна. 34.0 мянган га талбайн ойд арчилгаа, цэвэрлэгээ хийсэн байна. | Улсын төсөв<br>Орон нутгийн төсөв<br>Концесс, ТХХТ | 5,700.0<br>3,640.0<br>1,390.0 | Улсын төсөв | 4,790.3 | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/166 дугаар тушаалаар 8,7 тэрбум төгрөгийг баталж, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлыг 1664.8 га талбайд хийхээр зардалд 7,2 тэрбум төгрөг, ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажилд 696.7 сая төг, ойг түймрээс хамгаалахад 185.6 сая төг, ой зохион байгуулалтын ажилд 630.0 сая төгрөг тусгасан. Улсын хэмжээнд 2946.6 га талбайд ойжуулалт, 168 га талбайд байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажил, 668.4 га талбайд хамгаалалтын ойн зурвас, 445.4 га талбайд ногоон байгууламж, нийт 4228 га талбайд ойжуулалт нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн ажлыг хэрэгжүүлсэн. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 532 га талбайд, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 1153.1 га талбайд, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр 2192.7 га талбайд, төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр 203.2 га талбайд хэрэгжүүлсэн. Мод тарих ажилд 355923 иргэн, 16104 аж ахуйн нэгж, байгууллага оролцож, нийт 10129.0 мян.ширхэг мод, сөөгийг тарьсан.Нийт модны тоо хэмжээг 1 га талбайд тарих модны дундаж тоо буюу 1200 ширхэгт харьцуулахад 8440 га талбайд мод, сөөг тарьсан. Улсын төсвийн хөрөнгөөр ойн хөнөөлт шавжийн судалгааны ажлыг 16 аймгийн 110 сум, Нийслэлийн ногоон бүс, Богдхан-Уулын ДЦГ-ын 2.2 сая га ойн сангийн талбайд гүйцэтгэж, тэмцлийн ажлыг 10 аймгийн 82.0 мянган га ойн сангийн талбайд зохион байгуулж, хөнөөлийн голомтыг хязгаарласан. 5 аймгийн хилийн бүс зурваст нийт 187.6 км урт түймрээс хамгаалах шороон зурвас шинээр байгуулж, 782.2 км шороон зурвасыг сэргээсэн. Түймрийн зурвасыг шинээр байгуулж, хуучин зурвасыг сэргээснээр хил дамжин орж ирэх түймрийн эрчим, тархалтын хурдыг 50 хүртэл хувиар бууруулж чадсан. Ойн арчилгааг 3343 га талбайд, ойн цэвэрлэгээний огтлолтыг 11020 га талбайд, ойн цэвэрлэгээний ажлыг 16498 га талбайд, нийт 31.0 мянган га талбайд хэрэгжүүлсэн.Ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 2019 оны үзүүлэлттэй харьцуулахад 167.4 мян.га-аар нэмэгдэж, ойрхог чанарын эзлэх хувь 8.0 хувь болж, 0.1 хувиар өссөн байна. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 266 | 5.1.10. Цөлжилтөд нэн хүчтэй, хүчтэй өртсөн Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь, Төв аймгийн зарим сумдын 200-аас доошгүй га талбайд цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах ногоон хэрэм байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх | Цөлжилтөд нэн хүчтэй, хүчтэй өртсөн Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь, Төв аймгийн зарим сумдын 200-аас доошгүй га талбайд цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах ногоон хэрэм байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх | 200-аас доошгүй га талбайд цөлжилтийг сааруулах, хамгаалалын арга хэмжээг авсан байна. | Улсын төсөв | 800.0 | Улсын төсөв | 347.5 | Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээх зорилгоор цөлжилтөд нэн хүчтэй, дунд зэрэг өртсөн Дундговь, Дорноговь, Өвөрхангай, Баянхонгор аймагт цөлжилт, газрын доройтлыг бууруулах, элсний нүүлтийг сааруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/233 дугаар тушаалаар нийт 32 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулахад зориулан 370.1 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Дундговь 8 га , Дорноговь 6 га, Өвөрхангай 8 га, Баянхонгор 5 га талбайд цөлжилтийг сааруулах, хамгаалалын арга хэмжээ авах ажлын хүрээнд нийт 27 га талбайд хамгаалалтын зурвас, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/166 дугаар тушаалаар Дорноговь аймаг Мандах сум 9 га, Дорноговь аймаг Хатанбулаг сум 8 га, Завхан аймаг 50 га, Сүхбаатар аймаг 20 га нийт 87 га талбайд ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авч санхүүжилтийг олгосон.БНСУ-ын "Ногоон Ази" төслийн хүрээнд Төв аймгийн Баянхангай суманд "Хамтын төгөл" ойжуулалтын 100 га талбайд ойжуулалт, нөхөн сэргээх төслийн хүрээнд худаг, хашааны усалгааны төхөөрөмж, хүлэмж, ил талбайн мод үржүүлэг, зоорь зэрэг ажлыг гүйцэтгэсэн."Ногоон хэрэм" төслийн хүрээнд Өвөрхангай аймаг Арвайхээр хотод "Цөлжилтийг бууруулах, шар шороон шуурга, элсний нүүдлээс байгаль орчныг хамгаалах" зорилгоор 15 га газарт агро ойг байгуулна. Нийт 229 га талбайд цөлжилтийг сааруулсан. | 90.0 |
| 267 | 5.1.11. Нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, хадгалах арга хэмжээг хэрэгжүүлэх | Нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, хадгалах арга хэмжээг хэрэгжүүлэх | Халиун буга, хар сүүлт гэсэн 2 зүйл амьтны нөөцийн нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, сэлгэн нутагшуулах, улаан гоёо, хармаг гэсэн 2 зүйл ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | Улсын төсөв | 120.0 | - | - | "Монголын унаган байгалийн хулцэл, тогтворжилтыг хангах нь" ENSURE төслийн санхүүжилтээр "Дэлгэр Консалтинг" ХХК нь Улаан гоёо, чонон хармагийн байгалийн сэргээн ургалтыг дэмжих, эх ургамлын плантаци байгуулах ажлыг Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой багийн нутаг Хаягийн худагт 2 хэсэг газар 120 м урттай байгуулан үрийн нөөц бүрдүүлэн ажиллаж байна. Мөн улаан гоёог In vitro орчинд өсгөвөрлөх ажлыг хийж байна. Ховор ургамлын жагсаалтад орсон дэрэвгэр жиргэрүү, чихэр өвс, их шүүдэргэнэ зэрэг ургамлыг 10 гаруй аж ахуйн нэгж, байгууллага 500 гаруй га талбайд тарималжуулж байна. Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилгаар Мазаалай баавгай хамгаалах үндэсний зөвлөгөөнийг 2022.04.14-ний өдөр зохион байгуулсан. Нэн ховор амьтан болох Мазаалай баавгайг хамгаалах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад судалгаа шинжилгээний байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, мэдээлэл солилцох зорилгоор ""Алтайн өвөр говь, цөлийн экосистемийн судалгаа ба хамгаалал"" эрдэм шинжилгээний хурлыг 2022 оны 11 дүгээр сарын 18-нд зохион байгууллаа. Монгол Улс болон БНХАУ-ын эрдэмтэн судлаачид 2 талаасаа судалгаа шинжилгээний ажлынхаа үр дүнг хэлэлцсэн. | 70.0 |
| 268 | 5.1.12. Ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны тархац нөөцийг тогтоох | Ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны тархац нөөцийг тогтоох | Дундад халхын хуурай хээр, Дорнод монголын хээрийн ургамал газар зүйн 2 тойргийн ургамалжил, тархац, нөөцийн судалгаа, 3-аас доошгүй амьтны тархац, нөөцийг тогтоож, 300-аас доошгүй зүйл амьтан, ургамлыг нарийвчлан үнэлж, ховордлын шалтгааныг тодорхойлсон байна. | Улсын төсөв | 100.0 | Улсын төсөв | 85.0 | "Монгол Алтай болон Ховдын ургамал газарзүйн 2 тойргийн уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг нэн ховор, ховор, мэдрэг зүйлийн суурь судалгааны ажлыг хийж, судалгаагаар 4 зүйл ургамлыг ургамлын аймагт шинээр бүртгэж, 2 тойргийн нэн ховор, ховор, мэдрэг 200 зүйлийг олон улсын улаан дансны үнэлгээгээр үнэлж 15 зүйл устаж байгаа, 68 зүйл устаж болзошгүйг нэн ховор ургамлын жагсаалтад, 116 зүйл эмзэг ургамлыг ховор ургамлын жагсаалтын төсөлд оруулаа. 2 тойргийн ургамлын зүйлийн жагсаалтыг шинэчлэн гаргаж, 200 зүйл ургамлын хамгааллын төлөвлөгөө боловсруулсан. 1000 зүйл ургамлын улаан дансны үнэлгээ хийж 22 зүйл ургамлыг нэн ховор, 83 зүйл ургамлыг ховор ургамлын жагсаалтад шинээр оруулж, 1000 зүйл ургамлын хамгааллын төлөвлөгөө боловсруулсан. "Халиун бугын тархац, нөөц, зохистой ашиглах хэмжээг тогтоох, хамгааллын статусыг тодорхойлох" судалгааг хийсэн. Уг судалгааны дүнгээр сүүлийн жилүүдэд манай орны 15 аймгийн 192150.7 км2, голомт нутгийн хэмжээ 77596.7 км2 талбайд тархсан бугын нийт тоо толгойг 55215 гэж тогтоосон нь 2010 оны хамгийн сүүлд хийсэн судалгааны дүнтэй харьцуулахад халиун бугын ерөнхий нутаг 70000 орчим км2-ээр, тоо толгой 3 дахин өссөн. | 90.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 269 | 5.1.13. Химийн хорт болон аюултай бодисын цахим бүртгэл, мэдээллийн системийг бий болгох | Химийн хорт болон аюултай бодисын цахим бүртгэл, мэдээллийн системийг бий болгох | Химийн хорт болон аюултай бодисын нэршлийг цэгцэлж, бүртгэл мэдээллийн өгөгдлийн санг бий болгох ажлын явцыг 80 хувьд хүргэсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 1,200.0 | - | - | "Төслийн шугамаар ирсэн сервер, мэдээлэл хадгалах төхөөрөмжийг яамны харьяа Байгаль орчны мэдээллийн санд хүлээлгэн өгсөн. Химийн хорт болон аюултай бодисын цахим бүртгэл, мэдээллийн системийн хөгжүүлэлт хийгдэж дууссан. Үүнд: Монгол Улсад ашиглахыг хязгаарласан болон импортлох боломжтой химийн хорт болон аюултай бодисын олон улсын нэршил, монгол нэр, томъёо, CAS дугаар зэрэг хор аюулын мэдээллийг агуулсан модулийн хөгжүүлэлт, химийн хорт болон аюултай бодисын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргахад шаардлагатай баримт бичиг, химийн хорт болон аюултай бодистой холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагын авсан тусгай зөвшөөрлийн мэдээлэл, тусгай зөвшөөрөл шаардахгүй химийн бодис, химийн бодис агуулсан бүтээгдэхүүний жагсаалтын модулийн хөгжүүлэлт хийгдэж дууссан. Химийн хорт болон аюултай бодисын удирдлагын системийн Мобайл апплейкшны загвар гаргах ажил, програм хөгжүүлэлт, аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулсан хэсэгт аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийг Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас шалган сервисээр дуудах, хариуцсан ажилтан, агуулахын мэдээлэл, тусгай зөвшөөрлийн мэдээлэл, хилээр оруулж ирсэн бодисын импорт бүртгэх, химийн хорт болон аюултай бодисын ашиглалт зарцуулалт, түүний сав, баглаа боодлын тайланг гаргах модулиудын хөгжүүлэлт хийгдэж дууссан. Мөн иргэн аж ахуйн нэгж байгууллагад химийн хорт болон аюултай бодисын бүртгэл мэдээллийн системд хэрхэн ажиллах, химийн бодис, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг хэрхэн бүртгүүлэх талаар сургалтыг 2022 оны 9-р сарын 08-ны өдөр 34 аж ахуйн нэгж, байгууллага, 2022 оны 9-р сарын 16-ны өдөр 34 аж ахуйн нэгж, байгууллага, 2022 оны 10-р сарын 26-ны өдөр 45 аж ахуйн нэгж, байгууллага тус тус оролцуулсан сургалтыг Интерактив ХХК-ийн төслийн баг, БОАЖЯ-ны харьяа Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийн төлөөллийн хамт зохион байгуулсан. Одоогоор Гаалийн системтэй интеграци хийх, тус мэдээллийн системийн хэвийн ажиллагаа хангах тохируулга хийх, хянаж, засвар хийх ажлууд явагдаж байна. | 90.0 |
| 270 | 5.1.14. Туул голын хамгаалалтын бүсэд орших түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоож, аж ахуйн нэгжээр нөхөн сэргээлт хийлгэх | Туул голын хамгаалалтын бүсэд орших түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоож, аж ахуйн нэгжээр нөхөн сэргээлт хийлгэх | Туул голын хамгаалалтын бүсэд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг 30-аас доошгүй хувьд хийлгэсэн байна. | Улсын төсөв | 50.0 | - | - | Тайлан ирүүлээгүй. | 0.0 |
| 271 | 5.1.15. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарт хэрэгжүүлэх | Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарт хэрэгжүүлэх | Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх 2022 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 80 хувьд хүргэсэн байна. | - | - | - | - | Эрчим хүч, барилга, зам тээвэр, хөдөө аж ахуйн салбаруудын биелэлт 100 хувь, хог хаягдлын салбарын биелэлт 70 хувь байна. Ус, ойн, гамшиг, биологийн олон янз байдал, мал аж ахуй, газар тариалан зэрэг салбарын хэрэгжилт 95 хувь байна. ЭХЯ болон ЭХЗХ-ны хариуцсан" Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглан эрчим хүчний үйлдвэрлэлээс ялгарах хүлэмжийн хийг бууруулах", "Эрчим хүчний хангамжийн үр ашгийг сайжруулах замаар хүлэмжийн хийг бууруулах" зорилтуудын хүрээнд төлөвлөгдсөн 19 арга хэмжээний биелэлт 95 хувь байна. Эрчим хүчний салбарын арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт урт хугацаанд дүгнэгдэх боломжтой тул 2022 оны биелэлтээр харьцуулан дүгнэсэн болно. ЗТХЯ-ны хариуцаж буй Нүүрс экспортлох тээврийг автотээврээс төмөр замын тээвэрт шилжүүлэх ажлын хүрээнд 2022 онд "Таван толгой–Гашуунсухайт"-ын барилгын гүйцэтгэл дуусаж ашиглалтад орсон. Улаанбаатар хотод "Иргэдийн худалдан авах чадварт нийцсэн, эко орон сууц байгуулах" төслийн хүрээнд 10,000 айлын орон сууц, Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороонд эрчим хүч, дулааны хэмнэлттэй "Цайз эко хотхон" 712 өрхийн орон сууцыг тус тус барьж байгуулах арга хэмжээний хүрээнд 2022 онд 2730 айл өрхийн орон сууц норм стандартад нийцүүлэх ажлыг гүйцэтгэж байна. 10 аймгийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр байгуулах ажлын гүйцэтгэл 95 хувь байна. Нийгмийн эрүүл мэнд болон нийгмийн халамж үйлчилгээний чиглэлээр малчдыг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, "Байгальд ээлтэй малчин" нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, хүүхэд, залуучуудын уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдлын сулжээ санаачлан, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд дэмжих зэрэх ажлын олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд гүйцэтгэл 100 хувь хийгдсэн. | 70.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 272 | 5.1.16. Байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, үйл ажиллагааг дэмжих ногоон зээлийн эх үүсвэрийг бүрдүүлж, 1000-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг уг зээлд хамруулах | Байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, үйл ажиллагааг дэмжих ногоон зээлийн эх үүсвэрийг бүрдүүлж, 1000-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг уг зээлд хамруулах | 1000-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгж ногоон зээлд хамрагдсан байна. | Улсын төсөв | 18,500.0 | Улсын төсөв | 1,700.0 | Байгаль орчинд ээлтэй, ногоон тодотголтой бүтээгдэхүүн худалдан авахад нь зориулж иргэд, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олголтыг 2022 оноос эрчимжүүлэх ажлыг зохион байгуулсан. Байгаль орчинд ээлтэй, ногоон тодотголтой бүтээгдэхүүн худалдан авахад нь зориулж иргэд, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй ногоон зээлийг 2019 оноос олгож эхэлсэн. Орчны бохирдлыг бууруулах, ногоон төсөл хөтөлбөрийг дэмжих, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж, 2021 оныхтой харьцуулахад ногоон зээлд хамрагдах бүтээгдэхүүний тоог 9-өөр нэмэгдүүлж нийт 34 бүтээгдэхүүн болгосон. Бүтээгдэхүүн бүрт шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, Төрийн банк, Хаан банк, Хасбанктай 2022 оны 4 дүгээр сард гэрээг шинэчлэн байгуулсан. Ногоон зээлийг дэмжих чиглэлээр 2022 онд 1.7 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаасын эх үүсвэрийг төсөвлөн иргэн, аж ахуйн нэгжид жилийн 3-8 хувийн хүүтэй ногоон зээл олгож байна. 2022 оны 11 дүгээр сарын 28-ны байдлаар нийт 23 байгууллагад 442,7 сая төгрөг, 330 иргэнд 697,7 сая төгрөгийн зээлийн хүүний санхүүжилт олгосон байна. 2022.12.31-ний өдрийн хүртэл зээл авсан иргэн, ААН тоо өсөх ба жилийн гүйцэтгэл 2023 оны 1 дүгээр сарын 15-нд гарна. 2019-2022 онд нийт 1083 иргэн, ААН байгууллага ногоон зээл олгож, зээлийн хүүний санхүүжилтэд 2.8 тэрбум төгрөг олгосон байна. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлж байгаа "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь" төслийн хүрээнд байгаль орчны бичил зээл, "Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь" төслийн хүрээнд орчны бүсийн эргэлтийн сангийн зээл олгох ажлын бодлогын удирдамжаар хангаж ажиллаж, 2022 оны байдлаар нийт 400 гаруй иргэн, аж ахуйн нэгж хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. | 100.0 |
| 273 | 5.1.17. Хөвсгөл нуурт живсэн машин, техникийг татаж гаргах ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулах | Хөвсгөл нуурт живсэн машин, техникийг татаж гаргах ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулах | Нуурт живсэн машин, техникийг татаж гаргах ажлыг бүрэн хэрэгжүүлж, бохирдлын эрсдэлийг бууруулсан байна. | Улсын төсөв | 5,000.0 | Улсын төсөв | 1,200.0 | "1. "Хөвсгөл нуурын бохирдлыг бууруулах талаар авах арга хэмжээ"-ний тухай Засгийн газрын 2020 оны 193 дугаар тогтоол, БОАЖСайдын 2021 оны А/74 дүгээр тушаал, "Хөвсгөл нуурын экосистемийг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилгоор нуурт живсэн машин техникийг илрүүлэх татаж гаргах" Ажлын хэсгийн хүрээнд ОБЕГ Сүхбаатар хөлгийг 2021.08.02-ноос 2021.11.18-ны хооронд 99 хоног газар дээр нь ажиллаж татаж гаргасан. 2. Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаатай хамтран 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр "Сүхбаатар хөлөг" живсэн хэсэг болон байршуулсан хэсгийн уснаас нийт 4 сорьц авч БОХЖТЛ, Хөвсгөл аймгийн БОШЛ-д шинжлүүлсэн шинжилгээний дүнд үндэслэн усны чанар найрлагад өгсөн үнэлгээ, дүгнэлтийг 2021.11.18-ны өдрийн 01/1009 тоот албан бичгээр хүргүүлсэн. 3. Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл доор ""Хөвсгөл нуурыг хамгаалах үндэсний чуулган"-ыг 2022 оны 02 дугаар сарын 24, 25-ны өдөр зохион байгуулсан. Тус чуулганаас 4 үндсэн чиглэлээр нийт 26 арга хэмжээг хэрэгжүүлэх зөвлөмж гаргасан. 4. Хөвсгөл нуурыг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилгоор нуурт живсэн машин, техникийг илрүүлэх суурь судалгаа хийж, татаж гаргах ажлыг эрсдэлгүй зохион байгуулах талаар нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажиллах чиг үүрэг бүхий Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 117 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлыг 2022 оны 4, 5, 7, 11 дүгээр саруудад тус тус зохион байгуулсан. Хурлын шийдвэрийн дагуу Япон улстай уг асуудлаар хамтарч ажиллах төлөвлөгөөг боловсруулж, Батлан хамгаалахын Сайд Г.Сайханбаярт хүргүүлсэн. БОАЖЯ Япон улсын "Ниппон салвайж" компанийн удирдлагуудтай тохиролцон тус компани судалгааны ажлын төлөөлөгч Араки Ватару Монгол улсад 2022 оны 05 дугаар сарын 27-ноос 06 дугаар сарын 01-ний өдрүүдэд ажиллаж урьдчилсан тандан судалгаа хийсэн. 2023 онд Нуураас машин, техник хэрэгсэл татан гаргах 2023 оны хэрэгжүүлэх асуудлаар ОБЕГ-ын дарга, хошууч генерал Г.Ариунбуянд 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/7201 тоот албан бичгийг хүргүүлэн ажилласан. | 70.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 274 | | 5.1.18. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлэх | Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлэх | Улаанбаатар хот болон төв суурин газрын 2000-аас доошгүй жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлсэн байна. | Улсын төсөв | 5,000.0 | Улсын төсөв | 4,245.9 | 2022 онд нийт 2000 айлын нүхэн жорлонг стандартын шаардлагад нийцүүлэх ажил бүрэн хийгдсэн. Багц-1 буюу Улаанбаатар хотын СБД, ЧД, БЗД-ийн гэр хорооллын 1000 ширхэг нүхэн жорлонг шинэчлэх ажилд ""Улстуярах"" ХХК шалгарч гэрээ байгуулсан. 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 1000 нүхэн жорлонгийн нүхийг ухаж, ул болон кольцо, агааржуулалт болон бүхээг суурилуулалтыг хийсэн. Багц-2 буюу Орхон аймгийн Баян-Өндөр сумын 1000 ширхэг нүхэн жорлонг шинэчлэх ажилд ""Н Эй Би"" ХХК шалгарч гэрээ байгуулсан. 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 1000 нүхэн жорлонгийн нүхийг ухаж, ул болон кольцо, агааржуулалт болон бүхээг суурилуулалтыг хийсэн. | 90.0 |
| 275 | | 5.1.19. Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах судалгааг хийж, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх | Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах судалгааг хийж, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх | Цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 51.5-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авч, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 23 хувьд хүргэсэн байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадын 30 хувьд материаллаг баазыг сайжруулж, шинээр 1 хамгаалалтын захиргаа байгуулсан байна. | Улсын төсөв | 80.0 | Гадаадын зээл, тусламж | 4,300.00 | "1.БОАЖЯ-ны ТНБД-ын 2022.02.24-ний А/45 дугаар тушаалаар "Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах суурь судалгаа хийх, үндэслэл боловсруулах" зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж, 2022.03.02-ны өдөр ажлын даалгаврыг батлуулсан. 2. 6 аймгийн 25 сумдын нутаг дэвсгэрийг хамарсан 2,1 сая га талбай бүхий 14 газар нутгийг улсын тусгай хамгаалалтад аваахаар ""Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай"" УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГ-ын гишүүдээс санал авч, 13 яам санал ирүүлээд байна. Дээрхи 14 газрыг шинээр улсын тусгай хамгаалалтад авснаар Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 22,3 хувьд хүрч 34,9 сая га талбай хамгаалагдаж, Цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 51.32 хувийг улсын тусгай хамгаалалтад хамруулах юм.3.УИХ-ын 2019 оны 41 дүгээр тогтоолоор 14 газрыг байгалийн нөөц газрын ангиллаар, 1 газрыг байгалийн дурсгалт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсантай холбогдуулан "Байгалийн нөөц болон дурсгалт газрын хилийн заагийг тогтоох тухай" ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан БОАЖ-ын сайдын 2022.04.13-ны 01/1937 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. 4. БОАЖ-ын сайдын 2022.03.24-ний А/72 дугаар тушаалаар Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа Хэнтий аймгийн Биндэр сумандбайгуулсан. 5. Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь төслийн I, II үе шатны хүрээнд УТХГН-ийн хамгаалалтын захиргаанд техник хэрэгсэл, хамгаалалтын захиргааны барилгын өргөтгөлийн ариун цэврийн байгууламжийг барих, төслийг дэмжих, хувцас хэрэгслээр хангахаар 2022 оны 02 дугаар улиралд багтаан ажиллахаар гэрээ байгуулсан. УТХГ-ын 57 хамгаалалтын захиргаанд материаллаг баазыг сайжруулж, 4,3 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалт хийсэн. | 70.0 |
| 276 | | 5.1.20. Бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах | Бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах | Дорнод аймгийн Баяндун сумын нутагт Улз голын урсцыг нэмэгдүүлэх 9 метрийн өндөр, 672 метрийн урт, 26.9 сая.м3-ийн багтаамжтай шороон боомтын барилгын ажлыг дуусгасан байна. Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Ходон голын голдирлыг шилжүүлж, Цойцон нуурыг сэргээх барилга угсралтын ажлыг дуусгасан байна. | Улсын төсөв<br>Орон нутгийн төсөв | 3,613.7<br>650.0 | Улсын төсөв | 560.0 | "Дорнод аймгийн Баяндун сумын нутагт Улз гол дээр байгуулах шороон боомт нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO/ЮНЕСКО)-ын Дэлхийн өвд орсон хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутаг болох Монгол Дагуурын Дархан цаазат газарт хамрагдаж байгаа учраас ЮНЕСКО-ын Дэлхийн өвийн хорооны шаардлагаар Улз голын Тэгийн боомтын байгаль орчны нарийвчилсан судалгаар 2022 онд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн. Судалгааны ажлын тайлаг нарийвчилсэн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна. Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын нутагт "Дархадын хотгорын цөлжилтийг бууруулах, Цойцон нуурыг нөхөн сэргээх ажил"-ыг 2022 онд хэрэгжүүлж дууссан бөгөөд ажлын үр дүнд Ходон голын үндсэн голдирол холбох 1019м-ийн урттай суваг, 403м-ийн урттай, 5м-ийн өргөнтэй урсгал чиглүүлэх даланг барьж Цойцон нуурт ус хүргэж, нуурыг сэргээсэн. Аймгийн ажил хүлээж авах комисс ажиллуулж, ажлыг хүлээн авсан. | 70.0 |
| | | | Дундаж үнэлгээ | | | 304,943.7 | - | 84,702.1 | | 67.0 |
| 6. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 277 | 6.1. Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ. | 6.1.1. "Дэнжийн мянга дэд төв", "Дамбадаржаа дэд төв" төслийг хэрэгжүүлэх | "Дэнжийн мянга дэд төв", "Дамбадаржаа дэд төв" төслийг хэрэгжүүлэх | Төслийн гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна. | Орон нутгийн төсөв | 20,000.0 | Гадаадын зээл, тусламж | 139,506.3 | Дэнжийн мянга дэд төв: Төслийн хүрээнд 93МВт хүчин чадалтай хийн түлшээр ажиллах дулааны станц, автозам 11 км, цахилгаан дамжуулах 20 км, дулаан, ус хангамжийн 20,6 км, ариутгах татуургын 5,7 км шугам сүлжээ, үерийн хамгаалалтын 3,5 км далан барихаар ажлын зураг төсөл боловсруулж байна. Зураг төслийн боловсруулалт 50%-тай. Дамбадаржаа дэд төв: АХБ-ны зээлээр НЗДТГ-аас хэрэгжүүлж буй "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд СБД-ийн 16, 17-р хорооны нутаг дэвсгэрт 70.7 га газарт 2 эгнээ авто зам 2,8 км, ус дулаан дамжуулах 6 төв, дулааны 2,6 км, цэвэр усны 2,3 км, бохир усны 3 км, цахилгааны 6,6 км, холбооны 5,9 км шугам сүлжээ, үерийн далан 2,1 км, хөрсний ус доошлуулах шугам 1,5 км, цахилгаан хангамжийн 10/0,4квт хаалттай дэд өртөө 2ш, дулааны станц 63МВт шинээр барина. Дэд төвийн ТЭЗҮ батлагдсан, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийгдсэн, ажлын зураг төслийг боловсруулсан. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт 92 хувь, худалдан авах ажиллагаа 55,5 хувь, барилгын ажил 55,25 хувьтай. Төслийн хэрэгжилт 50 хувьтай байна. | 100.0 |
| 278 | | 6.1.2. Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх | Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх | Төслийн гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 37,764.5 | Гадаадын зээл, тусламж | 26,935.7 | МУ-ын ЗГ болон ОУ-ын хөгжлийн ассоциаци хооронд 2020.04.27-ны өдөр Санхүүжилтийн хэлэлцээр байгуулагдаж, мөн оны 4-р сард Дэлхийн банкны Захирлуудын зөвлөлөөс Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төслийг хэрэгжүүлэх зөвшөөрөл олгосон. Төслийн эхний үе шатанд 5а магистраль, 3г магистраль шугамуудыг өргөтгөж, шинэчлэх, уурын түр шугам барих ажлуудыг 2021-2022 онд хэрэгжүүлж байна. - 5а магистраль шугамын 1, 2, 3, 4-р багц, 3г магистраль шугам, уурын түр шугамын угсралтын барилгын ажил 2022.05.05-2022.09.17-ны хугацаанд хийгдэж угаалт, шахалт хийж 2022.09.20-нд дулаан залгасан. Багц-1, 2, 3 ажлын техникийн комисс 2022.11.18-ны өдөр, багц-4 ажлын техникийн комисс 2022.11.14-ний өдөр тус тус ажиллан, гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа Улсын комиссыг ажиллуулахаар бэлтгэл ажиллыг ханган ажиллаж байна. 3г магистраль шугамын Улсын комиссыг 2022.11.14-ний өдөр ажиллан ашиглалтад хүлээн авсан. - Уурын түр шугамын ажил бүрэн дууcч 2022.06.14-ний өдөр Улсын комиссыг ажиллуулан ашиглалтад хүлээн авсан. - Төслийн дараагийн үе шатны ажлын бэлтгэл хангах хүрээнд, Дэнжийн 1000 болон МҮОНРТ орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлын зураг, төсөв боловсруулах гүйцэтгэгчээр "Сээмий" ХХК шалгарсан, ажлын гүйцэтгэл 90%-тай байна. Сангийн яамнаас гэрээ байгуулаагүй ажлуудын санхүүжилтийг 2022 оны төсвөөс хасах чиглэл өгсөнтэй холбогдуулан 2022 онд шинээр эхлэх өргөтгөл, шинэчлэлийн БУА-уудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн хугацааг хойшлуулан 2023 онд угсралтын ажлыг хийхээр төлөвлөсөн. Шинээр хийгдэх 4 ажлын техникийн тодорхойлолтыг бэлтгэн Дэлхийн банкаар хянуулж, төсвийг тодотгон худалдан авах ажиллагааг зарлахад бэлэн болсон байна. Төслийн нийт хэрэгжилт 35.3 хувьтай байна. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 279 | 6.1.3. Улаанбаатарын хотын дулаан хангамж төслийг хэрэгжүүлэх | Улаанбаатарын хотын дулаан хангамж төслийг хэрэгжүүлэх | Төслийн гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 4,263.0 | Гадаадын зээл, тусламж | 8,148.6 | МУЗГ, ЕСБХБ-тай байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд "Улаанбаатарын дулаан хангамж" төслийг санхүүжүүлэхээр хамруулж, зээлийн 10 сая.ам долларын тусгайлсан гэрээнд Сангийн сайд 2020.01.10-ны өдөр гарын үсэг зурсан. Төслийн хүрээнд: Багц-4 (8г магистраль) БУА 2022.05.19-ний өдрөөс эхэлж нийт 682 хос.м шугамын угсралтын ажил бүрэн дууссан, Техникийн комиссыг 2022.11.21-ний өдөр ажиллуулсан, гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа Улсын комиссыг ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Багц-6 (Даралт өргөх насос станц 2)-ын ажлыг хийж дуусган Техникийн комиссыг 2022.11.18-ны өдөр ажиллуулсан, гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа Улсын комиссыг ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Шинэ төлөвлөлтийн бүсүүд рүү дулааны шугам шинээр татах (2x400мм, 7.6 хос.км шугам, 5,6 сая ам. доллар): Бичил хорооллыг хангах 2Ф400мм голчтой 620 хос.м дулааны шугам шинээр татах багц-1, 2Ф400мм голчтой 670 хос.м дулааны шугам шинээр татах багц-2 ажлын тендерийг 2022.05.18, 2022.07.04-ний өдрүүдэд нээсэн боловч санал ирээгүй. Төсвийг тодотгож дахин зарлахаар төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний өөрчлөлтийг ЕСБХБ-нд хүргүүлсэн, төсөвт тодотгол хийгдэж дууссан бөгөөд худалдан авах ажиллагааг зарлах бэлтгэл ажлыг хангаж байна. Дулааны сүлжээний томоохон зангилаа цэгүүдийн хяналт удирдлагыг алсын зайн SCADA системд шилжүүлэх 1 багц (Горим ажиллагаанд байнга ашиглагддаг 11 зангилаа цэг 1,1 сая ам. доллар): Ажлын даалгавар, техникийн шаардлага боловсруулж дууссан. Ажлын зураг төсвийн магадлалын ерөнхий дүгнэлт гарсан. Зөвлөх компани тендерийн баримт бичгийг боловсруулж байна. Төслийн нийт гүйцэтгэл 50 хувьтай байна. | 100.0 |
| 280 | 6.1.4. АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг барих төслийг хэрэгжүүлэх | АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг барих төслийг хэрэгжүүлэх | Төслийн гүйцэтгэл 15 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 33,317.3 | Улсын төсөв | 112.0 | АНУ-ын МСК-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй "Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр барих" төслийн гүйцэтгэл 20 хувьтай байна. Үүнд: 1.Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын нийт ажлын явц 26 хувь. Үүнд: үйлдвэрийн газар шорооны ажил 65%, гадна талбайн ажлын нийт гүйцэтгэл 31,8 хувь, цэвэршүүлэх барилгын угсралтын ажил 21%, урвуу осмосын барилгын ажил 22 хувь, цэвэршүүлсэн усны сан болон насосны станцын барилгын ажил 47 хувь, багана болон хучилтын барилгын ажил 85%, шугам хоолойн угсралт 23хувь, цахилгааны газардуулга 45 хувьтай; 2.Шувуун фабрик орчмын газрын доорх усны эх үүсвэрийн талбайд 16, Биокомбинатын эх үүсвэрийн талбайд 14 цооногийн өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэсэн; 3.Усны эх үүсвэрийн талбайн газар чөлөөлөлт 100%, цэвэршүүлсэн ус дамжуулах шугам хоолойн трассын дагуух газар чөлөөлөлт 95 хувь. Төслийн дулаан хангамжийн зураг төслийг "Анготранс" ХХК боловсруулж, батлуулсан. | 100.0 |
| | | | | Гадаадын зээл, тусламж | 39,799.7 | | | | |
| 281 | 6.1.5. Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд "Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл"-ийг хэрэгжүүлэх | Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд "Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл"-ийг хэрэгжүүлэх | Төслийн гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 2,818.0 | Улсын төсөв | 1,200.0 | Төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголын талын хариуцах бэлтгэл ажлыг 100% хангасан. Эхний ээлжийн барилгажих талбайн газрыг бүрэн чөлөөлж, барилгын талбайг цэвэрлэж, барилгын түр хашаа, инженер техникийн ажилчдын түр байр болон талбай доторх түр зам барьж, барилгын ажил эхлүүлэхэд бэлэн болгосон. Мөн цахилгаан, дулаан, ус хангамж зэрэг инженерийн дэд бүтцээр хангах техникийн нөхцлүүдийг холбогдох байгууллагуудаас авсан. 2022 оны байдлаар улсын төсвийн 784,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 11 айлын газрыг чөлөөлж, барилгажих талбайн газрыг бүрэн чөлөөлж, барилгын материал, тоног төхөөрөмжийн татан авалтыг хийж, төслийг хэрэгжүүлж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар төслийн хүрээнд баригдах 8 блок барилгын хавтан суурь 100%, хайрцган суурь 100%, хайрцган суурийн хучилт /8-1 үлдсэн/ 90%, 1,2-р блокын зоорийн давхрын ханын арматурчлалын ажил 80%, 1-8 дугаар блокын хайрцган суурийн хайргын чигжээсийн ажил-100% хийгдээд байна. Төслийн хүрээнд баригдах 240 ортой цэцэрлэгийн барилгын загвар зургийг батлуулсан. 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт 91%-тай байна.Орон сууцны 8 блокын суурийн ажил бүрэн дууссан. Нэгдсэн грашийн ажил дууссан. 5 блок орон сууцны 1 дүгээр давхрын цутгалт хийгдэж дууссан. Энэ онд ашиглагдах барилгын материалыг талбайд бүрэн татсан. Барилгын 5 ширхэг цамхагт кран угсарч суурилуулсан. Улирлаас хамаарч барилгын ажил зогссон бөгөөд хамгаалалтын горимд шилжиж шаардлагатай арга хэмжээг авсан. 2022 оны жилийн эцсийн байдлаар төслийн хэрэгжилт 50 хувьтай байна. | 90.0 |
| | | | | Гадаадын зээл, тусламж | 33,682.0 | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 282 | 6.1.6. Төр-хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд 30000 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх | Төр-хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд 30000 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх | Зураг төсөл, инженерийн бэлтгэл арга хэмжээг бүрэн дуусгаж, төр-хувийн хэвшлийн түншлэлээр бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байна. | Улсын төсөв | - | Улсын төсөв | 4,500.0 | Энэхүү төслийн хүрээнд 2022 оны улсын төсөвт гадна инженерийн шугам сүлжээний ажлын 3.6 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. Уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулж, нийт 5 багц ажлаас 5 багц ажлын гэрээг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 07 дугаар сарын 08-ны өдрийн хооронд байгуулж, ажилласан. Санхүүжилтийг гүйцэтгэлээр 100 хувь олгосон. Үүнд: - Ус хангамж болон ариутгах татуургын шугам сүлжээний ажлуудын хүрээнд "Алтайн үндэс констракшн" ХХК төслийн талбайд нийт Ф400мм-ийн 490м бохир усны гол шугамын ажил, Ф250мм-ийн 245м болон Ф200мм-ийн 235м бохир усны шугамын ажил, Цэвэр усны Ф200мм-ийн 266м шугам ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн. - Дулаан хангамжийн шугам сүлжээний ажлын хүрээнд "Одкон холдинг" ХХК нийт 900м газар шорооны ажил, 450м лотки угсрах ажил, ДХ-9-13 худаг цутгах, 640м шугам угсрах, хийгээр шахах, 400м лоткины таг суулгах, УДДТ-1 барилгын суурь цутгах, дотор узелийн зангидах ажлуудыг тус тус гүйцэтгэсэн. - Хонгилын системийн ажлын хүрээнд "Биг монголиа билдинг" ХХК Төслийн талбайд нийт 120м хонгилын цутгалт, 60м хонгилын суурийн ул бетон цутгалт, суурь болон ханын арматур боох ажлыг тус тус гүйцэтгэсэн. Нэмэлтээр 200м газар шорооны ажил гүйцэтгэсэн. - Цахилгаан хангамжийн ажлын хүрээнд "Би Эс Би Энержи" ХХК 200м кабелийн шуудуу ухах, 12,000м 10кВ-ын шугамын кабельнуудыг 450ш кабелийн лоткины ажлуудыг тус тус гүйцэтгэсэн бөгөөд 2022 оны төлөвлөгөөт ажлыг бүрэн хэрэгжүүлж дууссан. Мөн "Залуус-1" төслийн хүрээнд тус яамнаас Улсын 2023 оны төсвийн төсөлд үлдэгдэл санхүүжилт 26.3 тэрбум төгрөг, шинээр хэрэгжүүлэх 37.3 тэрбум төгрөг, нийт 53.6 тэрбум төгрөгийн дэд бүтэц, шугам сүлжээний ажлын санхүүжилтийг тусгуулахаар Сангийн яаманд санал хүргүүлсэн. | 100.0 |
| 283 | 6.1.7. Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | -Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө батлуулж, хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна. -Үерийн 1.7 км далан /Сүхбаатар дүүрэг, 13, 14 дүгээр хороо/-г барьж ашиглалтад оруулсан байна. -Хайлаастын авто замын ус зайлуулах 1.5 км цутгамал төмөр бетон суваг /Чингэлтэй дүүрэг, 13 дугаар хороо/-ийг барьж ашиглалтад оруулсан байна. | Улсын төсөв | 10,000.0 | Улсын төсөв | 517.9 | 1."УБ хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө" боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын улсын экспертүүд хянаж, ЭЗ-0001/2022-р магадлалын ерөнхий дүгнэлт гарч, баталгаажуулсан. Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний талаар мэдээлэл, санал, зөвлөмж солилцох зорилгоор БХБЯ, БОАЖЯ, Усны газар, Туул голын сав газрын захиргаа, нийслэлийн байгууллагууд болон усны салбарын эрдэмтэн, судлаач, мэргэжилтнүүдийн дунд олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг цахимаар болон танхимаар 2 удаа зохион байгуулсан. Мөн Нийслэлийн Засаг даргын тамгын газрын мэргэжлийн зөвлөлийн 2022.06.09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжигдсэн. БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 12 дугаар сарын ээлжит хурлаар хэлэлцүүлж, Нийслэлийн ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Гүйцэтгэл: 100%. Нийт төсөвт өртөг: 1,069 сая төгрөг, үүнээс 912 сая.төгрөгийн санхүүжилт олгосон. 2.Үерийн 1.7 км далан /Сүхбаатар дүүрэг, 13, 14 дүгээр хороо/: Төсөвт өртөг - 2,6 тэрбум төгрөг. Барилга угсралтын ажил 100 хувь; 3.Хайлаастын /Чингэлтэй дүүрэг, 13 дугаар хороо/ авто замын ус зайлуулах 1.5 км цутгамал төмөр бетон сувгийн барилга угсралтын ажил 100 хувь хийгдэж ашиглалтад оруулсан. Төсөвт өртөг - 799,3 сая.төгрөг. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 284 | 6.1.8. "Богдхан төмөр зам" төслийн техник, эдийн засгийн үндэслэл, судалгаа, зураг төслийг гүйцэтгэх | "Богдхан төмөр зам" төслийн техник, эдийн засгийн үндэслэл, судалгаа, зураг төслийг гүйцэтгэх | Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг дуусгана. | Гадаадын зээл, тусламж | 1,750.0 | - | - | АХБ-ны техникийн туслалцааны үлдэгдэл 1,250,000 ам.долларын хөрөнгөөр "Богдхан төмөр зам" төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгааг гүйцэтгүүлэхээр АХБ-тай хамтран ажиллаж байна. - Богдхан төмөр замын шугамын ерөнхий чигийг ЗТХЯ, БХБЯ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, "УБТЗ" ХНН, "МТЗ" ТӨХК-тай хамтран шинэчлэн судалж, барилга байгууламжийн байршлын давхардлыг бууруулсан, техникийн шийдлийг сайжруулсан, хот төлөвлөлт, тээвэр, логистикийн хөгжүүлэлттэй уялдсан хоёр хувилбарыг боловсруулаад байна. Богдхан төмөр замын ТЭЗҮ-ийн ажлын даалгаврыг 2021.08.27-ны өдөр ЗТХЯ-ны ТНБД-аар батлуулсан бөгөөд ТЭЗҮ-ийг Тавантолгой төмөр зам" ХХК боловсруулж дуусcан. Магадлагдсан ТЭЗҮ-ийн судалгааны тайланг Төмөр замын салбарын Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлөөр 2022-01-07-ны өдөр, Зам, тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн Зөвлөлийн 2022-01-11-ний өдрийн өргөтгөсөн хурлаар тус тус хэлэлцүүлж дэмжигдсэн. Засгийн газрын 2022.01.19-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор төмөр замын чигийг баталсан. Батлагдсан Ажлын даалгаврын дагуу "Тавантолгой төмөр зам" ХХК нь ТЭЗҮ-ийг боловсруулан магадлуулж, магадлагдсан ТЭЗҮ-ийн судалгааны тайланг Төмөр замын салбарын Шинжлэх ухаан, технологийн Дэд зөвлөлөөр 2022-05-06-ны өдөр, Зам, тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн Зөвлөлийн 2022-05-17-ны өдрийн өргөтгөсөн хурлаар тус тус хэлэлцүүлсэн. Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар төслийн ажлыг эрчимжүүлэх зарим асуудлыг хэлэлцүүлэн, 22 дугаар тэмдэглэл гарсан. Тэмдэглэлийн дагуу Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн сайд, Батлан хамгаалахын сайд нарын "Тогтоолын хэрэгжилт хангах тухай" 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хамтарсан тушаал гарсан. Төмөр замын доод бүтцийн 37.5км замын нарийвчилсан зураг төсөл бэлэн болж ЗХЖШ-ын 341 дүгээр анги 2022.08.31-ний өдрөөс төслийн талбайд гарч хөрс хуулалт, далан байгуулах барилгын ажил эхэлсэн. | 100.0 |
| 285 | 6.1.9. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх | Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх | Хотын шинэ тойрог зам 71.5 км зам, шинэ тойргийн холбоос 12 км замыг барьж ашиглалтад оруулна. 6 байршилд нүхэн гарц, 4 байршилд гүүр барьсан байна. Яармагийн хурдны зам болон Наадамчдын замыг Эрчим хүчний гудамж, Энхтайваны өргөн чөлөөтэй холбох зам, гүүрэн байгууламж зэрэг шинэ тойрог, тойргийн холбоос замыг барьж түгжрэлийг 15-аас доошгүй хувиар бууруулсан байна. | Улсын төсөв<br>Төр-хувийн хэвшлийн түншлэл | 420,000.0<br>659,775.0 | Улсын төсөв | 170,694.0 | Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлэх зорилгын хүрээнд; Гол гудамж зам шинээр барих, Туслах гудамж зам шинээр барих, Газар чөлөөлөлт, Уулзваруудын дахин инженерчлэл, Явган болон дугуйн гудамж зам, Замын хөдөлгөөний ухаалаг систем нэвтрүүлэх, Их багтаамжтай зогсоолуудыг байгуулах, Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлт, Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх, "Агаарын дүүжин замын тээврийн төсөл", Өндөр хүчин чадалтай нийтийн тээврийн төслийг хэрэгжүүлэх LRT) зэрэг 12 багц ажлыг хэрэгжүүлж ажилласан. Тайланг файлаар хавсаргав. | 56.3 |
| 286 | 6.1.10. Улаанбаатар хотод олон улсын логистикийн төв байгуулах | Улаанбаатар хотод олон улсын логистикийн төв байгуулах | Олон улсын логистикийн төв байгуулсан байна. | Улсын төсөв | 5,000.0 | - | - | Улаанбаатар хотын баруун бүсийн тээвэр, логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх зорилгоор уг төслийг "Нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д тусган Сангийн яам руу зөвшөөрөл авах тухай албан бичгийг 2022.11.21-ний өдөр Улаанбаатар хөгжлийн корпораци ХК-аас хүргүүлсэн. Зүүн бүсийн тээвэр, логистикийн хувьд нийслэлийн зүгээс 2022.03.11-ний өдөр Туушин ХХК-тай Хамтран ажиллах гэрээг байгуулсан. "Нийслэл хотод ачаа тээврийн логистикийн төвд тавигдах стандарт"-ыг боловсруулах ажлыг Хотын стандартын хяналтын газар, холбогдох байгууллагууд хамтарч зохион байгуулж байна. Улаанбаатар хотын баруун хэсгийн тээвэр, логистикийн төв болох "Олон улсын худалдаа логистикийн төв" ХК-ийн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд нийслэлийн төсвөөс тус төвийн дэд бүтцийн II дугаар ээлжийн ажлын хөрөнгийг баталж, гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлыг эхлүүлсэн. | 30.0 |
| | 6.1.11. Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн 2475 айлын гадна инженерийн шугам сүлжээг барих | Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн 2475 айлын гадна инженерийн шугам сүлжээг барих | 2475 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээ | Улсын төсөв<br>Орон нутгийн төсөв | 10,000.0<br>10,000.0 | -<br>Орон нутгийн төсөв | -<br>29,000.0 | 1.Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд БЗД-ийн 12-р хороо, Амгалан орчмын нийт 236 нэгж талбар бүхий 15.2 га талбайд 49 блок 3138 айлын орон сууц, 1800 хүүхдийн сургууль, 800 хүүхдийн цэцэрлэг барих, дэд бүтцийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ажил 80%-тай хэрэгжиж байна. 2."Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд: -Орлогод нийцсэн 20 айлын орон сууцны барилга Хэрэгжилт 100%; Зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх цэвэр ус дамжуулах гол шугам болон бохир усны шугамын ажил. Хэрэгжилт 67.45%; Тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх цэвэр ус дамжуулах гол шугамын ажил. Хэрэгжилт 86.7%; Баянхошуу дэд төвд түрээсийн 2 блок 126 айлын орон | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 287 | | | | | | Гадаадын зээл, тусламж | 19,040.9 | Гадаадын зээл, тусламж | 82,000.0 | сууцны барилга. Хэрэгжилт 90%; Морингийн даваа орчмын шинэ суурьшлын бүсийг инженерийн шугам сүлжээгээр хангах ажил. Хэрэгжилт 91%; Баянхошуу дэд төв дэх нийгмийн барилга байгууламжийн ус, дулаан хангамж, ариутгах татуургын шугамын угсралт. Хэрэгжилт 60.25%; Сэлбэ дэд төвийн 2-р хэлхээний инженерийн шугам сүлжээний угсралтын ажил. Хэрэгжилт 100%; Дамбадаржаа дэд төвийн 1973 өрхийг ус хангамж, ариутгах татуургын шугамд холбох.Хэрэгжилт 10%; Дамбадаржаа дэд төвийн үерийн хамгаалалтын далан. Хэрэгжилт 68,39%; Толгойт дэд төвийн үерийн хамгаалалтын далан. Хэрэгжилт 69.4%-тай. Төслийн нийт хэрэгжилт 73,4%. Дээрх төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэний үр дүнд 2022 онд нийтдээ 4600 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээ ашиглалтад орсон. | 100.0 |
| 288 | | | 6.1.12. Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх | Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх | Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, төслийн зээлийн гэрээг байгуулж, санхүүжилтийг шийдвэрлүүлж, төслийг эхлүүлсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 3,565.0 | - | - | Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор баталсан "150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн СХД-ийн 6-р хороонд 740 айлын орон сууц хэрэгжүүлэхээр туссан. Энэ хүрээнд төслийн ТЭЗҮ-г "Эм Эй Ди Урбан" ХХК /MAD Urban/-аар гүйцэтгүүлж, 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. ТЭЗҮ-ээр төслийн нийт санхүүжилтэд 15.0 сая ам.доллар шаардагдахаар тооцоо гарсан. Уг санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлтийг олон улсын хөгжлийн хөрөнгө оруулалтын байгууллагад хүргүүлсний дүнд Европын сэргээн босголт, хөгжлийн банк /ЕСБХБ/-наас санхүүжүүлэх боломжтой талаар мэдэгдсэн. Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яам, НЗДТГазрын төлөөллүүдийг байлцуулан 2022.09.26-ны өдөр төслийн тооцоо, судалгаа, хэрэгжүүлэх аргачлалыг эцэслэн тохирч, Монгол Улс болон ЕСБХБ хооронд 2019 онд байгуулсан Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрээр баталсан 300.0 сая ам.долларын хөрөнгөөр төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг 2022.12.07-ны өдрийн Засгийн газрын 442 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан. | 90.0 |
| 289 | | | 6.1.13. "Шинэ Зуунмод" хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх | "Шинэ Зуунмод" хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн дэд бүтцийн зураг төслийг боловсруулсан байна. | Улсын төсөв | 3,277.7 | Улсын төсөв | 6,200.0 | Дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгээд байна. - Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 143-р тогтоолоор батлуулсан. - Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх "Чингис хаан" шинэ нисэх буудлыг түшиглэн 1000 га газарт Хөшигийн хөндийн Эдийн засгийн чөлөөт бүсийг УИХ-ын 2022.04.07-ны өдрийн 10 дугаар тогтоолоор байгуулсан; - Төрийн захиргааны зарим байгууллагын ажиллах нэгдсэн байрыг Төв аймгийн Хөшигийн хөндий рүү нүүлгэн шилжүүлэх тухай ЗГ-ын 2022.03.09-ний өдрийн 98-р тогтоол гарсан. ЗГ-аар батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу үе шатны баримт бичиг болох дараах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулан ажилласан. Үүнд: - "Эдийн засгийн чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө" /234.0 сая төг/, "Тээвэр, логистикийн төвийн ТЭЗҮ, эхний ээлжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө" /339.6 сая төг/-г боловсруулах ажлын зөвлөхөөр "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ сонгон шалгарч, зөвлөхийн 2021/45 тоот гэрээг байгуулсан. Уг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 2022.12.12-ны өдрийн БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗХ-аар хэлэлцүүлэн, дэмжигдэж эксперт хийгдсэн. -"Орон сууц, олон нийт, худалдаа, үйлчилгээний бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" ажлын зөвлөхөөр "Некст степ инженеринг"-ХХК /200.0 сая төг/ шалгаран, улсын экспертизийн ЕТ 1418/2022 тоот дүгнэлт гарсан.-"Хөшигийн хөндий орчмын шинэ дагуул хотын дэд бүтэц" төслийн хүрээнд "Шинэ Зуунмод" хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ болон инженерийн шугам сүлжээний 2,173.3 сая төгрөгийн 6 төрлийн ажлын зураг төслийг захиалж боловсруулан, инженерийн бэлтгэл арга хэмжээ, дулаан, цахилгаан хангамж, ус хангамж, мэдээлэл холбооны зураг төслүүдэд магадлалын нэгдсэн дүгнэлт гарсан. | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 290 | 6.2. Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ. | 6.2.1. 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв шинээр барих /Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Төв/ | 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв шинээр барих /Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Төв/ | Төслийн гүйцэтгэл 80 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 158,477.0 | Гадаадын зээл, тусламж | 109,275.5 | Багц-1 /Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Говь-Алтай/, Багц-3 /Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр аймаг/-ын гүйцэтгэгчээр шалгарсан Бюксан Инженеринг компанитай 2021.12.27-ны өдөр гэрээ байгуулсан. Дээрх 7 аймгийн төвд 2022.05.06- наас 23-ны өдрүүдэд БУА-ыг эхлүүлсэн ба 22 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ. Багц-2 /Төв, Дундговь аймаг/-ын тендерт оролцогч шаардлага хангаагүй тул тендерээс татгалзаж, дахин зарласан. Мөн Бьюксан Инженеринг компани шалгарч, 2022.07.06-нд ЭХЯ-тай гэрээний хэлцэл хийж, БНСУ-ын ЭКСИМ банк зөвшөөрснөөр 2022.08.25-ны өдөр албажсан. Төслийн явц: Бүх аймгуудад түр цахилгааны хангамж, ажилчдын түр байр, усан хангамжийн асуудлууд шийдвэрлэгдсэн. Станцын үндсэн, туслах тоног төхөөрөмжийн захиалга өгөгдөж, үйлдвэрлэж байна. 9 аймгийн /Сүхбаатар, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв/ дулааны станцын үндсэн барилгын болон зуухны суурийн ажлыг хийж дуусгасан. Архангай аймгийн "Эх голомтын илч" ХХК төслийн хэрэгжилтийг эсэргүүцэж шүүхэд гомдол гаргасан. Нийслэлийн захиргааны хэргийн шүүхээс Архангай аймагт төсөл хэрэгжүүлэх асуудлыг түр зогсоох мэдэгдлийг ЭХЯ-нд ирүүлснээр төслийг тодорхойгүй хугацаагаар зогсоосон. Дээд шүүхийн шийдвэр 2022 оны 9-р сард гарч төслийг үргэлжлүүлэхээр болсон. 2023 онд тендерийг зарлахаар гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичгийг боловсруулж байна. Төсөл хэрэгжиж буй 9 аймгийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг гаргасан. | 70.0 |
| 291 | | 6.2.2. 10 аймгийн төвд баригдах дулааны станцын дэд бүтцийг байгуулах, дулаан түгээх сүлжээг шинэчилж, шинээр барих | 10 аймгийн төвд баригдах дулааны станцын дэд бүтцийг байгуулах, дулаан түгээх сүлжээг шинэчилж, шинээр барих | Төслийн гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 40,000.0 | Улсын төсөв | 6,420.0 | БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 10 аймгийн дулааны станц, дулаан дамжуулах 67 км урт хос шугам, 88 дулаан дамжуулах төв барьж байгуулах төслийн зээлийн хэлэлцээрт Монгол Улсын Засгийн газраас дулааны станц, дулаан дамжуулах төвүүдийн цахилгаан хангамж, цэвэр, бохир усны шугам сүлжээ, мэдээлэл, холбооны сүлжээ, дулаан дамжуулах 2 дугаар хэлхээг шинэчлэх, сайжруулах барилга угсралтын ажил зэрэг дэд бүтэцтэй холбоотой ажлуудыг хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжих аймгуудын Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын хариуцсан ажлын зураг төслийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийж, батлуулсан. Хэнтий аймагт I-р үе шатны хүрээнд дулаан шугамын шинэчлэлийг орон нутгаас зохион байгуулж, хийж хэрэгжүүлсэн. II-р үе шатны хүрээнд 2019 оны Улсын төсвийн 610.1 сая төгрөгийн санхүүжилтээр дулааны шугам сүлжээний ажил хийгдсэн. III-р үе шатны хүрээнд 2021-2023 оны Улсын төсвийн 5,970.2 сая төгрөгийн санхүүжилтээр дулааны шугам сүлжээний ажил хийгдэж байна. Барилга угсралтын ажил 85%-тай, гэрээгээр 2023.07.01-ний өдөр хүртэл үргэлжилнэ. Төв аймагт 2022-2023 оны Улсын төсвийн 11,632.5 сая төгрөгийн санхүүжилтээр дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлийн төсөл арга хэмжээ, Баянхонгор аймагт дэд станцын арга хэмжээ тус тус хэрэгжиж байна. 2023 оны Улсын төсөвт дулааны станц, дулаан дамжуулах төвүүдийн цахилгаан хангамжийн ажилд 51.24 тэрбум, дулааны 2 дугаар хэлхээний өргөтгөл шинэчлэлийн ажилд 113.53 тэрбум, нийт 164.77 тэрбум төгрөгийн санал хүргүүлсэн хэдий ч 16.9 тэрбум төгрөг батлагдсан. | 70.0 |
| 292 | | 6.2.3. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд 11 аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд 11 аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Төслийн гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 41,667.2 | Гадаадын зээл, тусламж | 21,400.0 | Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Өмнөговь, Хэнтий аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг 2021 онд ашиглалтанд оруулсан. Дорноговь аймагт 2022.08.08-ны УКД-10/2022, Дундговь аймагт 2022.10.07-ны №26/2022, Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд №27/2022 тоот актаар байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Өвөрхангай аймгийн Хужирт суманд 2022.11.23-нд улсын комисс ажиллан байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн акт нь баталгаажиж байна. Гүйцэтгэл 100 хувьтай; Сүхбаатар аймгийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил бүрэн дууссан. 2022.12.21-нд техникийн комисс ажилласан. Гүйцэтгэл 95 хувьтай. Төслийн хэрэгжилт 97,5 хувьтай байна. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Дархан хотын цэвэрлэх байгууламжийн МОН-3244/3245 төслийн ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцалсан тул тендерийг дахин зарлаж, "Байгууламж" ХХК-тай 2022.10.26-нд А1-1/2022/499 тоот гэрээ байгуулсан. Төслийн нийт гүйцэтгэл 88,6 хувьтай байна. | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 293 | 6.2.4. Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн хэрэгжилтийг 10 хувьд хүргэх /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын төв болон Улаанбаатар хотын Багануур дүүрэг/ | Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн хэрэгжилтийг 10 хувьд хүргэх /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын төв болон Улаанбаатар хотын Багануур дүүрэг/ | Төслийн гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 32,000.0 | Гадаадын зээл, тусламж | 12,531.3 | 1.Бүгд Найрамдах Польш Улс (БНПУ)-ын Засгийн газрын зээлээр "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"-ийн хүрээнд Баян-Өлгий, Увс, Завхан, Говьсүмбэр аймгийн төвд цэвэрлэх байгууламж барих ажлыг AB Industry , Smart Waste Technologies компанийн түншлэл, Дорнод аймагт цэвэрлэх байгууламж барих ажлыг "Мелиорекс" ХХК гүйцэтгэж байна. Баян-Өлгий, Увс, Завхан, Говьсүмбэр аймгийн цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулж дууссан. Дорнод аймгийн цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулж байна. Төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг БХБСайдын 2021.11.25-ны А/139-р тушаалаар байгуулан ажиллаж байна. Төслийн нэгжийг Сангийн сайдын 2022.01.10-ны өдрийн 6 тоот тушаалаар байгуулсан. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагчийг ТНБД-ын 2022.05.24-ний А/56-р тушаалаар томилсон. Төслийн хэрэгжилт 10%-тай байна. 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг "Наран рашаан" ХХК-тай 2022.04.18-ны 2022/155 тоот гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Говь-Алтай аймгийн цэвэрлэх байгууламжийн зураг төсвийг боловсруулж дуусган, магадлалаар хянуулж байна. 2022 онд хийхээр төлөвлөсөн ажлуудын гүйцэтгэл 100%. УБ хотын Багануур дүүргийн бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг "Хайдродизайн прожект" ХХК-тай 2022.04.18-ны 2022/146 тоот гэрээ байгуулан гүйцэтгүүлж магадлалаар хянуулж байна. | 100.0 |
| | | | | | | Улсын төсөв | 501.7 | | |
| 294 | 6.2.5. Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга байгууламжийг барих ажлыг үе шаттай эхлүүлэх | Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга байгууламжийг барих ажлыг үе шаттай эхлүүлэх | -Хэнтий аймгийн Хэрлэн сумандүерийн хамгаалалтын 1000 у/м даланг барьж ашиглалтад оруулсан байна. -Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд үерийн хамгаалалтын 1539.8 у/м сувгийг барьж ашиглалтад оруулсан байна. -Баянхонгор аймгийн төвд ус хүлээн авах 3400 у/м цуттамал төмөр бетон сувгийг барьж ашиглалтад оруулсан байна. -Баян-Өлгий аймгийн төвийн 11735 у/м үерийн хамгаалалтын далан сувгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна. | Улсын төсөв | 10,000.0 | Улсын төсөв | 6,000.0 | 1. Хэнтий аймгийн Хэрлэн суманд 11,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 14,7 км урттай үерийн далан барих ажлаас 9 км урт сувгийн ажлыг гүйцэтгэсэн. Тус ажил нь 2023 он дамжин хэрэгжих бөгөөд 2021-2022 онд батлагдсан төсвийн дагуу 5,6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдоод байна. Гүйцэтгэл 95 хувь; 2.Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд 580,9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 1519м урттай үерийн далан барих ажлаас 940 м урт сувгийн ёроолын бетон цутгалт хийж, 1840ш сувгийн хананы хавтан угсарсан. 2020-2021 онд нийт 418,8 сая төгрөгийн санхүүжилт олгогдоод байна. Гүйцэтгэл - 100 хувь; 3.Баянхонгор аймгийн төвд ус хүлээн авах 3400 у/м цутгамал төмөр бетон сувгийг барьж ашиглалтад оруулсан. Гүйцэтгэл 100%; 4.Баян-Өлгий аймгийн Өлгий суманд 12,5 тэрбум төгрөгийн гэрээний дүн бүхий 11.7 км үерийн хамгаалалтын далан барих ажлын гүйцэтгэл 80 хувь. 2020-2022 онд нийт 6,6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдоод байна. | 100.0 |
| 295 | 6.2.6. Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвүүдийн хог хаягдлын менежментийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх | Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвүүдийн хог хаягдлын менежментийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх | Төслийн хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна. | Гадаадын зээл, тусламж | 5,700.0 | Гадаадын зээл, тусламж | 6,889.2 | Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвд хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл 100% хэрэгжиж дууссан. Төслийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Үүнд: 1.Говь-Алтай аймагт хог хаягдлын хяналттай шинэ төвлөрсөн цэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл-100% /Комиссын дүгнэлт 2021.12.16, КД-48/2021/, хог хаягдал нягтруулан тээвэрлэх байгууламж, автопүү ба дахивар хүлээн авах цэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100%-тай; /Комиссын дүгнэлт 2022.12.02 КД-51/2022/ 2.Сүхбаатар аймагт хог хаягдлын хяналттай шинэ төвлөрсөн цэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл-100% /Комиссын дүгнэлт 2021.12.09, СҮ-018/21/, хог хаягдал нягтруулан тээвэрлэх байгууламж, автопүү ба дахивар хүлээн авах цэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл-100%-тай /Комиссын дүгнэлт 2022.09.06, СҮ-007/22/; 3.Дархан-Уул аймгийн төвд дахивар хүлээн авах цэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100%-тай; 4.Өвөрхангай аймагт автопүү, дахивар хүлээн авах цэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100%-тай. /Комиссын дүгнэлт 2022.07.07, БУ-11/2022/; 5. Олон нийтийн дадал бий болгох нөлөөллийн ажил-100%-тай; 6.Дахивар хаягдал боловсруулах бичил тэтгэлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж нийт 14 төсөлд тоног төхөөрөмж нийлүүлж, үйлдвэрлэлийн туршилтыг эхлүүлж 7 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулж байна; 7.Төсөлд хамрагдсан 4 аймгийн тохижилт үйлчилгээний байгууллага тус бүрд машин механизм 1, 1-ийг нийлүүлж хүлээлгэн өгсөн. Төслийн хэрэгжилт 100 хувь. | 100.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 296 | | 6.2.7. Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулах | Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулах | Түрээсийн орон сууц барих ажлыг үргэлжлүүлнэ. | Орон нутгийн төсөв | 20,000.0 | - | - | Сайдын 2022.05.30-ны өдрийн 1/2638 тоот бичгээр "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд хөдөө, орон нутагт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтцээр хангагдсан, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төслүүдийг хэрэгжүүлэхэд нь газар, дэд бүтэц болон бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах чиглэлийг аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн. Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд тус аймгийн Цогтцэций суманд эрчим хүчний хэмнэлттэй 10 айлын амины орон сууцны төслийн урьдчилсан тооцоолол, зураг төслийг боловсруулж, төслийн санхүүжилтийг сумын төсвийн хөрөнгөөр барьсан. Мөн тус аймгийн Даланзадгад суманд хэрэгжих эрчим хүчний хэмнэлттэй 90 айлын амины орон сууцны хотхоны эхний ээлжийн 10 айлын орон сууцыг хувийн хэвшлийн байгууллагатай хамтран барьсан. Архангай, Сүхбаатар, Хэнтий, Ховд, Хөвсгөл аймгууд дахь өөрийн эзэмшлийн газар дээр орон сууцны төсөл шинээр хамтран хэрэгжүүлэх, хөрөнгө оруулах хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар Увс, Архангай, Хөвсгөл, Булган, Сүхбаатар зэрэг аймгуудад нийт 863 түрээсийн орон сууц барьж, ашиглаж байна. /дэлгэрэнгүйг хавсаргав./ | 100.0 |
| 297 | | 6.2.8. Бүс нутгийн томоохон уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, бодлогын дэмжлэг үзүүлэх /5 газар/ | Бүс нутгийн томоохон уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, бодлогын дэмжлэг үзүүлэх /5 газар/ | Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр холбогдох газар хандсан байна. | Улсын төсөв | - | - | - | Бүс нутгийн томоохон уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, бодлогын дэмжлэг үзүүлэх /5 газар/ ажлын хүрээнд "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ-аас 7 байршилд ТЭЗҮ боловсруулж, ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн баталсан. ТЭЗҮ батлагдсантай холбогдуулан орон нутагт сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барьж байгуулах санхүүжилтийг шийдвэрлэх талаар Увс, Хөвсгөл, Булган, Дархан-Уул, Дорнод, Дорноговь аймаг, Багануур дүүргийн Засаг дарга нарт албан бичиг хүргүүлсэн. Мөн "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ-аас боловсруулж ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэгдэн дэмжигдсэн Хөшөөтийн чулуун нүүрсний уурхайг түшиглэн сайжруулан шахмал түлшний үйлдвэр барих ТЭЗҮ-ийн дагуу сайжруулсан шахмал түлшний үйлдвэрт шаардагдах 6.0 тэрбум төгрөгийг 2022 оны Улсын төсөвт тусгуулах саналыг хүргүүлсний дагуу барилга угсралтын ажилд 2022 оны төсөвт 2.1 тэрбум төгрөг батлагдсан. Төслийн гүйцэтгэгч барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг гүйцэтгэж байна. Барилгын ажил 50 хувьтай, тоног төхөөрөмжийн угсралтын ажил 90 хувьтай үргэлжилж байна. | 100.0 |
| 298 | | 6.2.9. "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 18 суманд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах | "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 18 суманд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах | Төслийг 18 сумын төвд хэрэгжүүлнэ. | Улсын төсөв | 72,000.0 | Улсын төсөв | 23,000.0 | Сумын хөгжил" төсөл, арга хэмжээг 9 аймгийн 18 сумын төвд амжилттай хэрэгжсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг гаргавал. Үүнд: Архангайн Ихтамир, Говь-Алтайн Алтай, Дорнодын Дашбалбар, Дундговийн Луус, Өвөрхангайн Бат-Өлзий, Хужирт, Төв аймгийн Баянчандмань, Борнуур, Дэлгэрхаан, Сэргэлэн, Эрдэнэ, Хэнтийн Галшар, Дэлгэрхаан зэрэг 7 аймгийн 13 сум 100 хувь, Баянхонгорын Баацагаан, Галуут, Эрдэнэцогт, Өвөрхангайн Уянга, Сэлэнгийн Алтанбулаг зэрэг 3 аймгийн 5 сум 70-90 хувийн хэрэгжилттэй, ашиглалтад оруулахад бэлэн болоод байна. | 100.0 |
| 299 | | 6.2.10. Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Барилга угсралтын ажлыг үе шаттайгаар гүйцэтгэсэн байна. | Улсын төсөв | 90,000.0 | Улсын төсөв | 58,600.0 | Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021-2022 онд дараах төсөл, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: 1.Сумын хөгжил:Инженерийн дэд бүтцийн төсөл, арга хэмжээг 18 сумын төвд хэрэгжүүлж байгаа бөгөөд 13 сум-100%, 5 сум 70%-87%-ийн хэрэгжилттэй; 2.Төвийн болон гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний төсөл, арга хэмжээг Төв аймгийн Эрдэнэ, Сэргэлэн, Борнуур суманд 10-20 хувийн гүйцэтгэлтэй; 3.Инженерийн шугам сүлжээг шинээр барих, өргөтгөн шинэчлэх ажлыг УБ, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Говь-Алтай, Дундговь, Хөвсгөл, Төв, Хэнтий, Завхан аймгийн төв болон 11 сумын 15 байршилд 10-100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж байна. | 100.0 |
| | | 6.2.11. Хангайн бүсийн төв Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын зарим орон сууцны барилгыг дахин төлөвлөлтөд оруулах /Арвайхээр, Хужирт, Хархорин сумдын гэр хорооллын | Хангайн бүсийн төв Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын зарим орон сууцны барилгыг дахин төлөвлөлтөд оруулах /Арвайхээр, Хужирт, Хархорин сумдын гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, | "Сумын хөгжил" арга хэмжээнд 2 сумыг хамруулсан байна. | Улсын төсөв | 50,000.0 | Улсын төсөв | 2,500.0 | "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээнд Өвөрхангай аймгийн Бат-Өлзий Уянга, Хужирт сумдыг хамруулсан. 1.Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын төвийн инженерийн дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Юу зэт эрдэнэ" ХХК, "Дуутын нуруу" ХХК түншлэл ажиллаж байна. Ажил гүйцэтгэх гэрээг 2022.06.30-нд байгуулсан, 2022 онд төлөвлөсөн ажлын | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 300 | | дэд бүтцийг сайжруулах, шинэчлэх, Уянга, Бат-Өлзий сумдыг "Сумын хөгжил" арга хэмжээнд хамруулах/ | шинэчлэх, Уянга, Бат-Өлзий сумдыг "Сумын хөгжил" арга хэмжээнд хамруулах/ | | Гадаадын зээл, тусламж | 10,000.0 | | | гүйцэтгэл 100%; 2.Өвөрхангай аймгийн Уянга сумын төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Аум алт" ХХК, "Жинст прамид" ХХК түншлэл ажиллаж байна. Ажил гүйцэтгэх гэрээг 2022.10.16-нд байгуулсан, 2022 онд төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100%; 3.Өвөрхангай аймгийн Хужирт сумыг дээрх төсөл арга хэмжээнд хамруулж, гүйцэтгэгчээр "Хэмжил зүй" ХХК ажиллаж байна. Ажил гүйцэтгэх гэрээг 2022.06.30-нд байгуулан ажиллаж дууссан. | 100.0 |
| | | | **Дундаж үнэлгээ** | | | **1,843,897.3** | | **715,932.2** | | **91.9** |
| | | | **НИЙТ ДҮН** | | | **11,714,001.1** | | **4,141,276.3** | | **73.45** |